



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

199 I оны II
сарын 14 өдөр

Дугаар 4

Улаанбаатар
хот

Ардын Их Хурлын II хуралдааны 4 дэх өдрийн ажиллагаа өглөөний 9⁰⁰ цагт Ардын Их Хурлын танхимд эхлэв. Хуралдааныг Ардын Их Хурлын дарга Ж. Уртнасан даргалав. Депутатуудын ирц 405/95%/ байв. /Ирцийг хавсаргав/

Депутат Г. Чингэл, Г. Батмөнх, Ц. Охинтогтох, Н. Сампилноров нар өвчтэй, депутат Г. Сүрэнжаргал гадаадад ажлаар явсан байв.

Өчигдөр нээлттэй орхисон депутатуудын хороог байгуулах тухай асуудлаа эхэлж хэлэлцэв.

Ардын Их Хурлын орлогч дарга Д. Моондой байгууллага, хамт олон, иргэдээс хуралдааны нэр дээр ирсэн санал, хүсэлт, утас, цахилгааныг 9⁰⁵ цагт уншиж танилцуулав.

56-р тойргийн депутат, Дэд ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын дарга Р. Гончигдорж депутатуудын асуултад хариулав. 207-р тойргийн депутат М. Моёор, 375-р тойргийн депутат Д. Баяндалай, 158-р тойргийн депутат Г. Банди, 403-р тойргийн депутат Н. Дариймаа, 201-р тойргийн депутат Б. Батмөнх, 402-р тойргийн депутат Ц. Батчулуун, 255-р тойргийн депутат С. Пүрэвдорж, 169-р тойргийн депутат Б. Шагдар, 80-р тойргийн депутат Д. Зарыккан, 265-р тойргийн депутат Б. Зандраа, 418-р тойргийн депутат Ж. Оросоо, 375-р тойргийн депутат Х. Түмэндэмбэрэл, 357-р тойргийн депутат Л. Шархүү, 324-р тойргийн депутат Б. Манал, 351-р тойргийн депутат Б. Мөнгөн, 26-р тойргийн депутат Д. Сүрэнхорлоо, 180-р тойргийн депутат Д. Жумдаанбаатар, 181-р тойргийн депутат Б. Жадамбаа, 40-р тойргийн депутат Б. Дагвадорж, 27-р тойргийн депутат Л. Пүрэвдорж/асуулт, хариултыг зогсооё гэв/, 120-р тойргийн депутат Б. Норжин, 121-р тойргийн депутат С. Банзрагч, 344-р тойргийн депутат С. Намсрайжав, 188-р тойргийн депутат Б. Буян-дэлгэр, 89-р тойргийн депутат Л. Пүрэвгял нар бичгээр асуулт асуув.

Хуралдаан II⁰⁰ цагт завсарлаж II²³ цагаас үргэлжлэв.

БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч Р. Гончигдорж Ардын Их Хурлын 409, 141, 351, 182, 74, 78, 38, 35, 268, 77, 112, 220, 113, 7, 128, 204, 228, 415, 54, 21-р

тойргуудын депутат Ц.Ишцэрэн, Ж.Авхиа, Б.Мөнгөн, Г.Батболд, К.Мизимхан, С.Исхан, Д.Чойжамц, В.Бямбаа, Ш.Цэнджаргал, Ж.Сейтмурат М.Могойтар, Д.Цогтбаяр, Ж.Гүррагчаа, Ц.Балдорж, Д.Пүрэвдорж, Б.Энх-амгалан, Н.Адъяажав, Н.Ганбямба, Б.Гомборагчаа, П.Мөнхдорж нарын бичгээр тавьсан асуултад хариулав.

Хуралдаан 13⁰⁰ цагт завсарлаж 15⁰⁰ цагаас үргэлжлэв.

Дэд ерөнхийлөгч Р.Гончигдорж асуултад үргэлжлүүлэн хариулав.

185-р тойргийн депутат Ч.Намсрай, 29-р тойргийн депутат Б.Чимид-хишиг, 283-р тойргийн депутат Б.Нямдорж, 372-р тойргийн депутат Н.Хавал, 346-р тойргийн депутат Ч.Дэмбэрэлням, 136-р тойргийн депутат Ч.Найдан, 374-р тойргийн депутат Т.Санжаа, 268-р тойргийн депутат Ш.Цэнджаргал, 75-р тойргийн депутат Я.Хүрлээ, 107-р тойргийн депутат Л.Баяндалай, 290-р тойргийн депутат С.Цэвээндорж, 108-р тойргийн депутат Т.Ширмэн, 282-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 200-р тойргийн депутат С.Халзанхүү, 378-р тойргийн депутат Л.Шагдар, 327-р тойргийн депутат П.Энхсайхан, 158-р тойргийн депутат Л.Одончимэд, 370-р тойргийн депутат В.Цамба, 96-р тойргийн депутат Н.Сэндэнжав, 320-р тойргийн депутат Ч.Хишигдалай, 67-р тойргийн депутат Г.Дашдэндэв, 227-р тойргийн депутат Б.Баасанхүү, 54-р тойргийн депутат Б.Гомборагчаа, 32-р тойргийн депутат Д.Мандах, 58-р тойргийн депутат С.Рэнцэнбал, 71-р тойргийн депутат Т.Ядамсүрэн, 211-р тойргийн депутат Д.Дагвадорж, 101-р тойргийн депутат Р.Доржбат, 118-р тойргийн депутат Ж.Жамбалдорж, 391-р тойргийн депутат Ш.Лхагва, 309-р тойргийн депутат Д.Батбаяр, 152-р А.Рашитхан 395-р тойргийн депутат Б.Баярсайхан, 420-р тойргийн депутат Д.Вомбожав, 392-р тойргийн депутат Н.Сандуй, 198-р тойргийн депутат С.Батмөнх, 297-р тойргийн депутат Д.Тангад, 170-р тойргийн депутат Д.Лхагвасүрэн, 410-р тойргийн депутат Л.Баатарсүрэн, 177-р тойргийн депутат Б.Буянмөнх, 74-р тойргийн депутат К.Мизамхан, 171-р тойргийн депутат Ж.Лхагважав, 415-р тойргийн депутат Н.Ганбямба, 173-р тойргийн депутат Д.Лхамсүрэн, 186-р тойргийн депутат Р.Чойжинням, 159-р тойргийн депутат Б.Эрхэмбаяр, 384-р тойргийн депутат М.Санжаа нарын бичгээр ирүүлсэн асуултад 16²² цагт хариулж дуусав.

396-р тойргийн депутат Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга В.Чимид, 13-р тойргийн депутат, Улсын Бага Хурлын Байнгын хорооны дарга Л.Цог нар зарим асуултад нэмэлт тайлбар хийв. Өөрт нь нэр зааж ирсэн асуултад Ерөнхийлөгч П.Очирбат 16³³ цагаас хариулж эхлэв.

244-р тойргийн депутат Б.Доржхорлоо, 353-р тойргийн депутат Б.Шинэн, 64-р тойргийн депутат Ч.Молом, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 89-р тойргийн депутат Д.Пүрэвгял, 59-р тойргийн депутат Ч.Пүрэвдорж, 245-р тойргийн депутат Ч.Чинбат, 368-р тойргийн депутат Н.Баасанжав, 74-р тойргийн депутат К.Мизамхан нарын асуултад 16⁴⁴ цагт хариулж дуусав.

22-р тойргийн депутат Л.Дашням /ерөнхий хэлэлцүүлэгт орох/, Улсын Бага Хурлын гишүүн Д.Маам, 71-р тойргийн депутат Т.Ядамсүрэн нарын асуултад Р.Гончигдорж товч хариулав.

Хуралдаан 17⁰⁰ цагт завсарлаж 17²⁰ цагт үргэлжлэв. Асуулт, хариулт явагдав.

89-р тойргийн депутат Л.Пүрэвгял, 57-р тойргийн депутат Баасанжав, 413-р тойргийн депутат Н.Насан-Очир, 215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн/өргөн санал, шүүмжлэлд орох/, 430-р тойргийн депутат Д.Тогооч, 250-р тойргийн депутат Г.Дамдиндорж, 47-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 281-р тойргийн депутат Н.Цэрэнхүү, 130-р тойргийн депутат Б.Авирмэд, 54-р тойргийн депутат Б.Гомборагчаа, 179-р тойргийн депутат Ж.Лхагважав, 186-р тойргийн депутат Р.Чойжинням, 157-р тойргийн депутат Л.Одончимэд нарын асуултад 56-р тойргийн депутат, Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдорж хариулав.

Асуулт, хариултыг таслах санал хураалт явуулав. зөвшөөрсөн 304/88%/, татгалзсан 35/10%/, түдгэлзсэн 6/2%/, бүгд 345/81%/

Асуулт, хариултыг таслав.

18⁴⁴ цагт Ардын Их Хурлын орлогч дарга Н.Батбаяр байгууллага, хамт олон, хөдөлмөрчдөөс ирсэн санал, утас, цахилгааныг уншиж танилцуулав.

18⁵² цагт ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлөөс Ардын Их Хурлын дарга

Ж.Уртнасанд баярын цахилгаан ирүүлснийг уншиж сонсгоход депутатууд алга ташиж хүлээж авав.

167-р тойргийн депутат Ш.Гүрбазарын нэр дээр ирсэн бичгийг уншихгүй Ш.Гүрбазарын тайлбарыг сонсоод маргааш Ардын Их Хурлын нэг орлогч даргын хамт Ш.Гүрбазар тэр хүмүүстэй очиж уулзах болов. Ж.Уртнасан депутатуудын хүсэлтийн дагуу Төрийн хүндэтгэлийн өргөөг сонирхох графикийг уншиж танилцуулав.

Үүгээр хуралдаан 19⁰⁰ цагт дуусав./Хурлын явцын соронзон бичлэгийг хавсаргав/

АРДЫН ИХ ХУРЛЫН ДАРГА *Н. Уртнасан* Ж.УРТНАСАН

ОРЛОГЧ ДАРГА *Х. Батбаяр* Н.БАТБАЯР

Г. Жагай Г.ЖАГАЙ

Ц. Лоохууз Ц.ЛООХУУЗ

Д. Моондой Д.МООНДОЙ

ТЭМДЭГЛЭСЭН:

Г. Хурэлбаатар Г.ХУРЭЛБААТАР

А. Юндэндорж А.ЮНДЭНДОРЖ

АРЛЫН ИХ ХУРЛЫН 1991 ОНЫ II ДҮГЭЭР
САРЫН 14-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ИРЦИЙН
БАЙДАЛ

Ирвэл зохих: 427

Хуралдаанд ирээгүй /шалтгааныг дурдана/: Депутат
Г.Чингэл /339/, Т.Батмөнх /376/, Ц.Охинтогтох /254/, Н.Сампилноров
/199/, С.Баяр /1/, Дэлгэрмөрөн /306/ нар өвчтэй.

Депутат Г.Сүрэнжаргал / 299/ гадаадад ажлаар яваа.

Хуралдаанд хоцорч ирсэн:

Депутат Х.Сүхбаатар /344/, Ч.Нүүрэй /407/, Ц.Ишцэрэн/409/
нар II цагийн завсарлагаас хойш ирээгүй. Э.Бат-Үүл/52 / үдээс
хойш суудалдаа суугаагүй. Л.Дашням /22/ 40 минут, Алтай /16/,
20 мин, Г.Зуунай /143/ 30 минут

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

Ж.Уртнасан: Эрхэм депутатуудын өглөөний амгаланг айлтгая. Хуралдааныхаа ажиллагааг эхэлье. Уламжлал ёсоор бид ирцээ бүртгэхэд бэлтгэнэ үү.

Баярлалаа. Нийт ирвэл зохих 427 депутатаас 405 депутат буюу 95 хувь нь ирсэн байна. Ийм учраас Хурлын ажиллагаа эхлэхэд хүчин төгөлдөр гэж үзэж байна.

Та бид өчигдөр нээлттэй орхисон нэг асуудал байгаа юм. Депутатуудын ажлын хороо байгуулах тухай. Энэ дээр депутатуудын орон нутгийн бүлэг, намуудаас нэр дэвшүүлсэн 29 хүний нэрийг бидэнд ирүүлсэн байна. Энэ хүмүүсийн ажил мэргэжлийн сүлжээг манай хуульчид тодотгож байна. Ингээд та бүхэнд танилцуулна.

Өчигдөр үдийн үед бид батлагдсан эвсэл холбоод, өөрөөр хэлбэл 10-нд жагсаал цуглаан хийж, хөдөлмөрчдийн цуглаан хийсэн холбоодын удирдлага биднийг уулзъя гэсэн учраас бид уулзлаа. Худалдаа нийтийн хоолны холбооны дарга Доржсүрэн, Тээвэрчдийн холбооны дарга Ганбаяр, Ажилчдын холбооны дарга Пүрэвээ, Ажилчдын холбооны Борхуу, Барилгачдын холбооны дарга Буриад зэрэг эвсэл, холбоодын дарга нартай бид албан ёсоор уулзсан. 10-ны өдрийн цуглаанаас та бидний нэр дээр ирүүлсэн сонордуулах бичгийн хариуг биднээс шаардсан юм. Бид анхныхаа уулзалтаар ямар ч болов тохиролцоонд хүрсэн гэж үзэж болохоор байна. Яагаад вэ гэвэл хэрвээ бид энэ шаардлагыг биелүүлэхгүй бол бид сануулах ажил хаялт хийнэ гэсэн ийм программтай байсан. Эвсэл холбоод. Бид байдлыг ойлголцож ярьсан, энэ хоёрдугаар чуулганы уур амьсгалыг бид танилцуулсан. Ингээд бид зөв зүйтэй юмаа, хуулийн ажиллагаа хэлэлцэхэд бид анхааралтай оролцье, Энэ хурлын ажиллагаанд бид урилгаар оролцож, байя гэсэн хүсэлт тавьсан. Үүнийг бид зөвшөөрлөө. Ингээд ямар ч гэсэн сануулах ажил хаялтыг зогсоллоо. Энд нэг хугацаа хожиж байгаа хэрэг юм.

Бид хуулиа хэлэлцэж байна. Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланг тэртэй, тэргүй бид хэлэлцэнэ.

Хоёр дахь : тавьсан асуудал бол энэ эвсэл холбоодоос бид батлагдсан эвсэл холбоод, ард түмэнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрийнхөө үзэл бодлыг таниулах ийм боломж олгож өгөөч гэсэн. Үүнийг бид хэвлэл, мэдээллийн нөхдүүдтэй ярьж байна.

Одоо манай орлогч дарга Моондой энэ өнгөрсөн хугацаанд ирсэн хөдөлмөрчдийн санал, хүсэлт, мэдээллийг та бүхэнд сонсоно.

Ардын Их Хурлын орлогч дарга Моондой:

1991 оны II дүгээр сарын 13-ны өдөр иргэдээс бичгээр 18, цахилгаанаар 3, утсаар 15, хүлээн авах байгууллагаар 7 хүн ирж санал, хүсэлт тавьсан байна.

Санал хүсэлтийг ангилсан байдлаар нь уншъя. Октябрийн районы 26 дугаар хорооны иргэн Баасанжав, 36 дугаар хорооны иргэн Пунцагнамжил, Хэнтий аймгийн Өндөрхаан хотын иргэн Наваанбалдан утсаар Ардын Их Хурлын ажиллагаанд амжилт хүсч байна. Сэтгүүлч, орчуулагч Доржготов II дүгээр сарын 12-нд радиогоор 173 дугаар тойргийн депутат Дхамсүрэнгийн хэлсэн үгийг дэмжиж байгааг Ардын Их Хурлын хуралдаанд дамжуулж өгөөч гэсэн ийм санал ирсэн байна.

Хөдөөгийн депутатууд ард түмний нэр бариад, өөрсдийн бодлогыг яриад байна. Уламжлал гээд 70-ханы жилийн юмыг яриад урьдах олон жилийн уламжлалын тухай ярихгүй байна. Үүнийг та бүхэн болгоож анхаарна уу гэсэн байна.

Октябрийн районы 29 дүгээр хорооны иргэн Дхамсүрэн Үндсэн хуулийн дараа Засгийн газрын тайлан, Улсын Бага Хурлын тайланг хэлэлцүүлэх, үүнийг радио, телевизээр дамжуулах гэсэн. Ийм санал

бол их олон ирсэн байна. Барилгын зургийн институтийн ажилтан Дорждагва утсаар, Ардын Их Хурлын хуралдаан 2 өдөр болоход дэгээ хэлэлцэж чадсангүй. Ер нь депутатуудын нэр хүндэд муугаар нөлөөлж байгааг анхаарах. Алтны асуудалтай холбогдуулан нөхөр Ганболдоор депутатуудын өмнө уг хэлүүлэх гэсэн санал ирсэн байна.

Архангай аймгийн Цэцэрлэг хотын иргэн Доржготов утсаар: Депутатууд ард түмний нэрийг барьж, өөрийн саналыг ярьж байна гэж зарим хүмүүс ойлгоод байх шиг байна. Энэ тийм бишээ. Бид депутатдаа захиа даалгавар өгч явуулсан. Бидний санал бодлыг ярьж байгаа нь үнэн шүү гэдгийг дамжуулж өгнө үү. гэсэн байна.

Сүхбаатарын районы 33 дугаар хорооны иргэн Хадбаатар утсаар: Ардын Их Хурлын зарим депутат сонгогчдын саналыг сонсоогүй, Ардын Их Хурлын хуралдаанд очсоныг анхаараач, жишээ нь манай депутат Лхамсүрэн бидний 120 хүний саналыг сонсоогүй.

Найрамдлын районы 11 дүгээр хорооны иргэн Тогмид: Санал хураалтанд түдгэлзэнэ гэсэн үгийг хэрэглэж байгааг хасъя гэсэн саналтай байна.

Октябрийн районы 26 дугаар хорооны иргэн Баасанжав утсаар: Одоогийн хуралдааны явцыг харахад хэт маргалдаад байна. Депутатуудынхаа саналыг харгалзаж үзэхийг хүсье гэсэн байна.

Октябрийн районы 25 дугаар хорооны иргэн ахмад зүтгэлтэн Зундуй, Хурлын ажиллагаа замбараагүй байна. Ийм байдлаар хэлэлцээд санаанд тохирох шийдвэр гаргана гэдэгт итгэхгүй байна.

Говь-Алтай аймгийн Халиун сумын хүний их эмч Батбилэг: Манай сумын депутат Л. Түдэв Ардын Их Хурлын хуралдааны өмнө сонгогчидтойгоо уулзаж бидний санал хүсэлтийг авсангүй.

4.

Иймд хуралдааныхаа дараа сонгогчидтойгоо ирж уулзана уу.

Октябрийн районы ОСГ-ны 32 дугаар хорооны иргэн Бадам хүлээн авах байраар ирж уулзсан. Депутатууд төр, засгийн удирдлагууд энэ хуралдаанд хөдөлмөрчдөөс тавьсан санал, хүсэлт бүрийг тунгаан үзэж, Хурлын үйл ажиллагаа, шийдвэрт тусгаж байх.

Завхан аймгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны хянан байцаах газрын дарга Батцэцэг:

Ардын Их Хурлын II хуралдааны үйл ажиллагааг телевизээр хэдэн минут харуулж байгаа ньхангалтгүй байна. Хуралдааны шууд бичлэгийг үдийн өмнө ба хойно хоёр удаа тус бүр I цагийн хугацаатай нэвтрүүлж байх.

Үүнтэй давхардсан санал их олон ирсэн байгаа. Их цаазын төслийн талаар давхардсан их олон санал ирсэн. Энд Баянхонгор хотын ОСГ-ны I дүгээр хорооны иргэн, өндөр настан Зундуй, БНМАУ гэж нэрлэе, газрыг хувьд өмчлөхгүй байх, төрийн сүлдийг махчин шувуугаар дүрслэх шаардлагагүй; Октябрийн районы 27 дугаар хорооны иргэн Цэдэнпунцаг Үндсэн хууль нэрийг өөрчлөх шаардлагагүй, ийм санаанууд бас их олон байгаа.

Үндсэн хуулийн улсын нэрийг өөрчилье, туг, далбаа, тэмдгийг өөрчилье гэсэн саналууд их олон байна. Энэ бүгдийг уншаад байвал ихээхэн цаг барах байхаа. Давхардсан санал их олон байна.

Ж.Уртнасан: Одоо дэгийнхээ дагуу Үндсэн хуулийн шинэ төсөл дээр асуулт, хариултаа үргэлжлүүлье. Бага Хурлын эрхэм гишүүд, дарга нараас өчигдрийн асуултуудад хариулахыг хүсч байна.

Р.Гончигдорж: /Улсын Бага Хурлын дарга, 56 дугаар тойргийн депутат/
Эрхэм депутатуудын өглөөний амгаланг айлтгая.

5.

Өнөөдөр энэ асуудлуудад эндээсээ товчхон, товчхон хариулах нь зүйтэй юм шиг байна. Өчигдрийн байдлаар цаг, хугацаагаа тооцоод үзвэл энэ хариултууд ~~хэц~~ өдөр авч магадгүй шинжтэй байна.

60 дугаар тойргийн депутат Давааням гуай, 17 дугаар зүйлийн I, 4-д амьд явах эрхтэй, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй гэжээ. Энэ эрхүүд яаж баталгаатай хангагдах юм бэ? Эмнэлгийн тусламж авч чадахгүй, амь насаа алдаж байна. Конкурсын шалгалт өгч таарсан сургуульдаа орж, хүссэн мэргэжлээ эзэмшиж чадахгүй байгаа дээр жишээ татна уу гэж. Тэгэхээр амьд явах эрхтэй гэдгийг эрхэм депутат ажил мэргэжлээ чөлөөтэй сонгохыг бүрнээ ойлгосон байна. Үүнийг төрөөс иргэнийхээ өмнө хүлээсэн үүрэг болохын хувьд зайлшгүй авч байх ёстой, ийм л иргэний түгээмэл эрхийн эдгээр хэсэг. Тийм учраас ийм ардчилсан Үндсэн хуульдаа оруулахаас өөр огт арга байхгүй. Цаашид харин энэ эрхийг хэр зэрэг баталгаатай болгох вэ гэдэг асуудал бол манай цаашдаа иргэнийхээ төлөө төрөөс явуулах бодлогын хэмжээ, хүрээгээр тодорхойлогдож явах, ийм л асуудал байх.

Хүний эрх, эрх чөлөөний бүлэгт 207 дугаар тойргийн депутат Моёор гуай асуусан байна. Хүний эрх, эрх чөлөөний бүлэгт хүний амьдрал, эдийн засгийн баталгааг яагаад заагаагүй юм бэ? Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг түрээсээр эзэмшүүлэхгүй байвал ямар сөрөг нөлөө гарах вэ? Монгол улсын иргэнийг газар өмчлөх эрхгүй болговол ямар сөрөг явдал гарах вэ гэсэн байна.

Энд хүний эрх, эрх чөлөөний бүлэгт бол хүний амьдралын эдийн засгийн баталгаануудыг нэлээд хэмжээгээр заасан байгаа. Үүнийг зүйл зүйл дээр нь хэлж болно. Хамгийн энгийн эрхэд нь манай иргэд, эдийн тусламж авна гэж байгаа. Хамгийн наад зах нь, тэгээд өөрөө өөртөө эдийн засгийн баталгаа бий болгоход нь төрөөс туслах олон заалтууд бий. Энэ түрээсээр эзэмшүүлэхгүй байвал ямар сөрөг нөлөө үзүүлэх вэ гэж байна. Өнөөдөр манай улс гадаадтай нээлттэй харилцаа, гадаад харилцаандаа

нээлттэй бодлогыг явуулж, дэлхийн олон нийтийн хөдөлмөрийн болон зах зээлийн харилцаанд чөлөөтэй оролцох, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах гэх мэтчилэн олон зүйлүүд байгаа. Үүнтэй холбогдуулаад эрхийн хэмжээнд Үндсэн хуулинд аа энэ заалтыг нээлттэй оруулж байгаа бөгөөд, цаашаагаа ер нь ямар журмаар түрээслэх, эзэмшүүлэх энэ асуудлууд бол зохих хуулиуддаа нарийвчлан тусгагдах бөгөөд эдгээр дээр үнэхээр өөрийн үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, нутаг орны бүрэн бүтэн байдлынхаа үүднээс тавих нэлээд хэмжээний хязгаарлалтууд байх ёстой байгаа.

Монгол улсын иргэнийг газар өмчлүүлэхгүй байвал явах вэ гэдэг талаар манай Ерөнхийлөгчийн тавьсан илтгэлд тун тодорхой байгаа.

375 дугаар тойргийн депутат Баяндалай гуай асуусан байна. Ямар үндэслэлтэйгээр газрыг хувь хүнд өмчлүүлэх заалт оруулсан бэ? Зөвхөн манай улсын иргэнд өмчлүүлж байгаа, худалдсан гэдгийг ямар шалгуураар тогтоох юм бэ? гэж түрүүн хэллээ. Газар өмчлүүлэх заалтыг оруулсан тайлбар бол байгаа. Эндээс гарах сөрөг үр дагаврын тухай асуудлууд бий. Нэгэнт олон асуудлууд давхардаж гарч байгаа учраас эрхэм гишүүд хэрэв ард нийтээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлэг, энд өргөн барьсан хэлэлцүүлэг хоёрын хооронд, газрыг хувьд өмчлүүлэхэд тогтоох хязгаарлалтууд, тэгээд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал газар гэдэг маань улс орны тусгаар тогтнолтой салшгүй холбоотой байдгийнхаа үүднээс чухамхүү ямар ангиллын газрыг ямар шаардлагын үүднээс ямар хэмжээгээр өгөх вэ гэдэг асуудал дээр нэлээд их хэмжээний хязгаарлалтууд бий болгосон байгаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ц.БАЯРМАА

Кассет 20
1991-ХI-14
9.15-9.30

Р.Гончигдорж: -Түүнээс гадна зөвхөн монголын иргэдэд өмчлүүлэх бөгөөд мөн энэнийг өмчлөгч цаашид энэ газраа эзэмших, өмчлөх, өвлүүлэх асуудлууд байхаас гадна шаардлагатай үед энэ иргэнээс газраа түр буцааж авах нөхөн төлбөртэйгээр, түүнээс гадна хэрэвтэр иргэн энэ газраа өмчлөх эрхээ шилжүүлэх тухай асуудал үүсэхэд хамгийн эхний ээлжинд тэр өөрөө эзэмшигч болж авах энэ хязгаарлалт бол цаашдын хуулинд тогтоогдох учиртай. Энэ утгаараа аливаа шилжилт гарах болгонд тэр оролцож байх ийм зүйл бол, тухайлбал одоо манайхаар хэлэлцэж байгаа Газрын тухай хуулинд ийм баталгаажуулсан заалтууд нэлээд бий.

За энэ түрүүн хариулагдсан асуудал байна. Эрхэм депутат Намсрайжав гуай/304 дүгээр тойргийн/тэр сүлд далбаа тухай асуудал, энэний үүднээс гарах үнэлгээ, мөнгөний асуудал байна.

Монголын анхдугаар Үндсэн хуулийг батлахад оролцсон ахмадуудаас зөвлөмж авсан хичнээн хүн байсан вэ гэж. Зүгээр яг өнөөдөр энэнийг, анхдугаар Үндсэн хуулийг батлахад оролцож байсан ахмадууд байхгүй байх шиг байна. Харин энэ Үндсэн хуулиас нэлээд зүйлийг уншиж судалсан, манай түүхчид, ажлын хэсэг бол. Түүгээрээ дамжиж бид анхны Үндсэн хуультай хүйн холбоотой байх шиг байна.

Улсын нийслэл Улаанбаатар хэвээрээ байх уу, өөр газар шилжүүлэх бодлого байна уу гэж эрхэм депутат Банди гуай 158 дугаар тойрог асуусан байна. Тэгэхлээр зэрэг нийслэл гэдгийнхээ үндсэн тодорхойлолтыг өгсөн. Төрийн захиргааны төв байгууллага оршин байгаа энэ хотоо нийслэл гэнэ ээ гэж. Тэгээд шилжилтийн Хавсралт хуулинд байгаа Улаанбаатар хот бол өнөөдөр манай улсын нийслэл гэдгийгээ тодорхойлсон. Үндсэн хуулиа бид бодохдоо бол ер нь олон жилийн настай, хатуу Үндсэн хууль байх чиглэлээр, өөрөөр хэлбэл энэ Үндсэн хуулийн заалтууд

өөрчлөгдөхгүй, шаардлагатай үед нэмэлт хэлбэртэйгээр заалтууд гарч ирэх, энэ утгаар нь авч үзээд магадгүй бас манай ард нийтийн дунд ч зарим нэг хэмжээгээр яриа байдаг. Нийслэлийг өөр газар байрлуулах нь зүйтэй гэх мэтчилэн. Энэнийг хүн ам зүй, нутаг төвлөлийн бодлого, цаашлаад түүх уламжлалаасаа иш татсан ийм үндэслэлүүд байдаг. Юмыг яаж мэдэх вэ, шинэ төв байгуулах, шилжих тухай асуудал гарахад Үндсэн хуулинд нэрээр хязгаарласан хязгаарлалт байхгүй, түүнийг дагалдан гарах хуулинд Улаанбаатар хот улсын нийслэл гэж ингэж томъёолсон байгаа.

Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын эрхийн хугацаа хэр зэрэг зохицож байна вэ гэсэн ийм асуулт байна. За энэ бусад улсуудын асуудал бий. Ерөнхийлөгчийг дөрвөн жилээр, Засгийн газрыг зургаан жилээр байгаад гэхдээ зургаа гэвэл гурав дээр нь нэмэх нь гурав гэсэн ойлголттой байгаа бөгөөд Их Хурлын гишүүдийн бүрэн эрх бол зургаан жилээр сонгогдож, Их Хурлын гишүүдийн сонгууль нь бол сонгогдох тойргуудаар гурав гурван жилээр ээлжлэн сонгогдох хэлбэрээр ингэж Их Хурал нь сэлгээтэй байгаад, энэ сэлгээ нь Их Хурлын депутатуудыг, Их Хурлын гишүүдийг сонгох сонгуулийн тойргийн нэг тал хувь дээр нь гурван жил болгонд шинээр сонгууль явагдаж байна гэсэн үг. Ингэж Их Хурлын бүрэлдэхүүн шинэчлэгдэж, сэлбэгдэх бүрт Засгийн газарт итгэж байгаа тухай асуудлаар Их Хурал авч үзээд Засгийн газарт итгэж байгаагаа илэрхийлэхэд уг Засгийн газар цаашаа дахин гурван жилийн хугацаатайгаар бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Ингээд нийлбэртээ зургаан жилийн бүрэн эрхтэй бөгөөд энэ бол гурван жил тутамд сэлбэгдэх болгонд бүрэн эрхийн тухай асуудлыг нь бол итгэх итгэхгүйн тухай асуудлыг нь бол Их Хурлаар яригдаж байх ийм байцлаар хоорондоо зохицсон байгаа юм. Ерөнхийлөгчийн сонгууль бол дөрвөн жилээрээ, ингэж сөөлжүү байх нь бол ач холбогдолтой бөгөөд ерөнхий төрийн нийтлэг тогтолцооны харилцан уламжлагдах, харилцан шүтэлцээтэй байхыг бас хугацааных нь хувьд ингэж авч үзсэн байгаа юм.

Монгол Улсын нэр, сүлд, далбааг өөрчлөхгүй байхад олон улсын харилцаанд өөрчлөлт орох зөрчил байна уу гэж зүгээр

3.

олон улсаас монгол улс ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, улс орныхоо төрийн тогтолцоо, өөрийн цаашдын хөгжил дэвшлийнхээ бодлогыг Үндсэн хуульд ингэж тунхаглаж, ингээд улсынхаа бэлгэ тэмдэг болсон төрийн сүлд, далбааг үүнтэйгээ уялдуулж хэрхэн авч үзэж вэ гэдэг талаасаа олон улсын анхаарал мэтгэж хэрэг байж таарна. Тухайлбал, одоо хуучин Үндсэн хуульд байгаа сүлд, тэмдэг, далбааны агуулгын тодорхойлолтууд байгаа. Энэ агуулгын тодорхойлолтуудыг өнөөдөр манай иргэд ч, гадаадын хүмүүсүүд ч өнөөдөр Монгол ардчилсан шинэ тогтолцоонд орж байна гэхэд тэр тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Тодорхойлолтыг нь өөрчлөөд хэлбэрийг нь үлдээхэд бас монгол хүний их сонин занж юм байна гэж л бодох байх л даа. Нэг зүйлийг хэд хэдэн агуулгаар тайлбарлаж болдог юм байна аа л гэж. Тийм л байдлаар хандах болов уу. Энэнийг би хэлж мэдэхгүй юм. Зүгээр, ингэхгүй гэхийн газаргүй юм.

Их цаазын төсөлд орон нутгийн засаг захиргаа, нутгийн Засаг даргыг гүйцэтгэх дээд байгууллагаас томилохоор заасны учир юу вэ гэж. Энд бол Засаг даргыг төсөлд гаргахдаа тухайн орон нутгийн иргэдээс сонгуулийн насны иргэдээс нэр дэвшүүлж гаргаж ирээд түүнийг нь зохих дээд шатных нь Засаг даргаас юм уу Засгийн газраас, Ерөнхий сайдаас томилно гэсэн байгаад өөрөө нөгөө орон нутаг дахь өнөөдрийн удирдлагын энэ Үндсэн хуулиар байж байгаа удирдлагын үндсэн утга санаатай нийцэж байгаа юм. Нэг талаас энэ хүн өөрөө удирдах ёсны хурлын шийдвэрийг гүйцэтгэх ажлыг зохион байгуулагч утгаараа доод талдаа хариуцлагатай байх ёстой, нөгөө талаас энэ төрийн бодлогыг тухайн орон нутагт хэрэгжүүлэхийнхээ хувьд дээрээсээ хариуцлагатай байх ёстой. Энэ хоёр хариуцлагын тогтолцоог тэр хүнийг сонгон шалгаруулж томилох энэ хувилбар дээр нь уяж өгч байгаа энэ л уялдаа.

403 дугаар тойргийн депутат Дэрийлаа гуай асуусан байна. Улсын Бага Хурлаас баталж гаргасан эрх зүйн холбогдол бүхий олон хуулиуд одоо бидний батлан гаргах Үндсэн хуультай зөрчилдвөл

цаашид яаж зохицуулах вэ? За энэнийг бол бид та бүхэнд тараасан Монгол улсын Их цаазын Хавералт хуулиндаа тодорхой хэлсэн байгаа. Ерөөсөө зөвхөн энэ Улсын Бага Хурлаас баталсан хуулиуд төдийгүй ерөөсөө өмнө нь байгаа бүх хуулиудыг хэрхэн шинэ Үндсэн хуультайгаа нийцүүлэх вэ, энэ ажлыг ямар хугацаанд гүйцээн дуусгах вэ гэдгээр энэ бүрэн хариулт байгаа. Үндсэн хуулийн төсөлд тусгасан улсын нэр, улсын Үндсэн хуулийн нэр, сүлд, далбааг өөрчлөх тухай, за энэ дахиад гарч байгаа асуудал.

Ер нь та бүхэнд түрүүн хэлсэн шүү дээ. Энэ шинэ далбаа, шинэ сүлдийн талаар төсөл оруулж байгаа Тэнгисболд болон энэ ажлын хэсэг дээр ажилласан улсуудын дэлгэрэнгүй тайлбарыг та бүхэндээ олон хэлбэрээр өгнө. Киноны хэлбэрээр ч, ярилцлагын хэлбэрээр ч, тайлбарын хэлбэрээр өгнө. Энэ үед та бүхэн тодорхойлж асуугаарай.

201 дүгээр тойргийн депутат Батмөнх гуай асуусан байна. Их цаазын төсөлд зааснаар тэр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалан зохицуулах эрх зүйн үндэслэл яаж баталгаажиж хэрэгжих вэ, улсын эдийн засгийн байгуулалтын талаар тодорхой заалт байж болохгүй юу гэж. Энэнийг Ерөнхийлөгчийн тавьсан илтгэлд эдийн засгийн зорилт, агуулгыг одоо хуучин Үндсэн хуулинд томъёолсон тэр агуулгын хэмжээгээр энд шаардлагагүй гэж үзсэн. Зүгээр үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг ханган хамгаалахад зориулах асуудлаар бол энд Үндсэн хуулийн шинэ төсөл Монгол улсын Их цаазад бол нэлээд хэмжээгээр туссан байгаа. Ингэхэд ямар нэг хязгаарлалтын шинжтэй, болоод зохицуулалтын шинжтэй аливаа асуудал дээр үндэсний аюулгүй байдал, түүн дотроо үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын талаар бол энд туссан зүйлүүд бий. Тэрнийг зүйл зүйл болгон дээр, тухайлбал үндэсний аюулгүй байдлын талаар юу бодсон юм, тодорхой хэлбэл эдийн засгийн аюулгүй байдлын талаар юу хэлсэн юм бэ гэдгийг тус тусад нь энэ дотор гарч ирэх ёстой бөгөөд, цаашид үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдлын талаар зохицуулагдах нарийвчилсан бодлого, тийм бодлогууд гарахад энд л түүнд саад болсон зүйл байхгүй байхаар дээд хуулийнхаа агуулгаар энд тэр зүйлүү-

5.

дийг тусгасан болов уу гэж бодож байгаа. Энэ талаар Бага Хурал дээр анхаарч байсан гол зүйлүүдийн нэг мөн бөгөөд манай иргэдийн санаа зовж байгаа үндсэн асуудал юм. Төслийн 27 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт бусад байгууллага, иргэд хууль санаачлах эрхгүй, харин уламжлах^л эрх эдэлнэ гэж ойлгож болох уу? Хүний эрхийг хязгаарлаж байгаа бус уу гэж байна. Тэгэхлээр зэрэг хууль санаачлах эрхийг бол энд эрхийн субъектүүдийг тодорхойлсон байгаа. Хуулийн талаар санал гаргах эрх бол аливаа иргэнд болоод аливаа байгууллага, хамт олонд бол байгаа. Хуулийн санал гаргасан субъектүүд, хуулийг санаачлагчуудаар дамжуулж хууль тогтоох байгууллагад оруулж ирнэ. Зүгээр асуудал байдаг. Зарим улсын практикт байна. Төчнөөн иргэн нийлээд хууль санаачлагч байж болно гэж. Энэ тухай хэлсэн депутатууд шаардлагатай гэж үзээд оруулья гэвэл энэ асуудлаа оруулж болох юм. Энэ бол та бүхний анхааралд байгаа зүйл.

Зүгээр хуулийн санал гаргах, санаачилга гаргах гэдгийн ялгаа бол үүндээ байгаа. Одоогийн байгаа, 402 дугаар тойргийн депутат Батчулуун гуай асуусан байна. Одоогийн байгаа засаг захиргааны нэгжийн хуваарийг өөрчилж, нэрийг аймаг, хот, хошуу, баг болгож байгаа юм байна. Үүний үндэслэл юу юм бэ? Хэд хэдэн сумыг нэгтгээд хошуу, одоогийн сумыг хэд хэдэн баг болгох юм уу, зөвхөн нэр солих төдий юм уу, засаг захиргааны нэгжийн хуваарилалтыг томогохгүй бол одоогийн байгаа бодит байдал сумдын захиргаа ард түмэндээ төдийлөн хүрч ажиллаж чадахгүй байгаа шүү дээ гэж. Энэ талаар маш олон асуудлууд байна. Энэ талаар ч гэсэн Их цаазын төсөл, Монгол улсын Их цаазын Хавсралт хууль хоёрыгоо нийлүүлээд бариад үзвэл та бүхний хариултанд нэлээн тодорхой зүйлүүд гарч ирэх байх аа гэж бодож байна. Мөн Ерөнхийлөгчийн тавьсан илтгэлд байгаа. Тэгэхлээр зэрэг өнөөдөр бол манайд нэг талаас төвлөрөл, нөгөө талаас төвлөрлөөс салах, өөрөөр хэлбэл төвөөс зугатаах ийм хоёр зүйл үйлчилж байгаа. Нэг талаас төрийн удирдлагыг өөрөө удирдах ёстой хослуулах зөв механизмыг бий болгох.

6.

Өөр нэг үндсэн тал нь бол төрийг болоод өөрөө удирдах эрхийг нь иргэдэд өөрт нь ойртуулах гэсэн. Энэ хоёр хүчин зүйлийг зүй зохистой болгож чадахын тулд яг өнөөдрийн байгаа засаг захиргааны хуваарилалт өөрчлөлтөнд орох уу үгүй юу гэдэг асуудлын үүднээс авч үзэх юм бол орох шаардлагатай гэдгийг иргэд өөрсдөө хэлж байгаа тэхэд хилсдэхгүй. Өнөөдөр сум иргэдээс холдож байгаа гэдгийг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд сум хэт төвлөрлийн шалтгаан болсон гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа. Энэ үүднээсээ бол сум холдоод байгаа ойлгомжтой учраас баг байх зайлшгүй шаардлага байна. Баг бий болоод ирэхлээр зэрэг сум хэт ойртож жижигрээд өөрөө удирдах ёсны байгууллага болоод төрийн захиргааны удирдлагын нэгжэнэ дээр байхад тэр ажиллах хүчин, гол зорилго чинь бол өөрөө удирдах ёсны гол агуулга нь өөрөө эдийн засаг, засаг захиргаа, мужийн бие даасан байж чадаж байж өөрөө удирдах ёсоо хэрэгжүүлэхийн тулд энд гарцаагүй бас нэг шаардлага үүсч бий болох байх аа. Энэ шаардлагынхаа үүднээс магадгүй сумууд одоогийн байгаагаасаа нутаг дэвсгэрийнхээ хувьд өөрчлөгдөхийм шалтгаан үүсч магадгүй гэсэн ийм байдлыг гаргаж болох юм.

Одоогоор бол хэлж байгаа шүү дээ. Шууд хошуу гэснээс сумыг шууд маргаашнаас эхлээд эмхлэх, задлахын тухай асуудал байхгүй, нэрийн хувьд эхлээд солигцоно. Дараачаар нь 1995, 1997 онуудад энэ засаг захиргааны шинэчилсэн зохион байгуулалтыг явуулах юм гэж. Энэ дээр зардал мөнгө хичнээн байх юм бэ гэсэн асуудал байна лээ. Энэ үнэхээр зардал мөнгөтэй асуудал бөгөөд өнөөдөр манай эрдэм шинжилгээний бөгөөд төрийн захиргааны үүрэг хүлээсэн байгууллагуудаас энэ газрын төлбөр, газрын зохион байгуулалтын асуудал, нутаг, засаг захиргааны хуваарилалтын асуудлаар олон чиглэлээр судалгаанууд хийсэн. Олон хувилбаруудын талаар эрдэм шинжилгээний судалгааны төсөл төвшинд гаргасан хувилбарууд байж байна. Энэний талаар гурван хувилбар байгаа гэнэлээ энэнийгээ танилцуулахгүй юу? гэсэн асуудал байсан, эрхэм депутатууд дараагаар нь, хуралдааныхаа


7.

дараагаар, завсар хооронд зайлшгүй шаардлагатай гэвэл энэнийг үзүүлж болно. Улсын Бага Хурал энэнийг танилцуулсан ийм хувилбарууд бий. Энэ бол дахин хэлэхэд эрдэм шинжилгээ, судалгааны түвшинд хийгдчихээд байж байгаа ийм асуудлууд байж байгаа. Тэр мужууд бол.

255 дугаар тойргийн депутат Пүрэвдорж гуай ярьсан байна. Монгол улсын иргэд цагаачлах эрхээ ямар хуулиар эдлэх юм бол. Үндсэн хуульд тусгах шаардлагагүй юм болов уу гэж. Өнөөдөр ч гэсэн монгол хүн гадаадад зорчих, гадаадын иргэд манайд зорчих төдөрхой зохицуулалт байгаа. Зүгээр манай иргэнийг цагаачийн статустайгаар өөрийнхөө оронд хүлээж авах уу үгүй юу гэдэг асуудал бол манай хуулийн асуудал биш, тэр орных нь өөрийнх нь хуулийн асуудал. Гаднын хүн манайд цагаач болж ирэх үү үгүй юу гэдэг асуудлын зохицуулалт цагаачийн статусын тухай асуудал яривал энэ маань бол манай улсын хууль тогтоомжоор тогтоогдох асуудал. Манай Үндсэн хууль, Их цаазандаа бол иргэдийн гадаадад болоод дотоодод чөлөөтэй зорчих эрхийг нь нээлттэй болгосон бөгөөд энэ бол бусад хуулиудаар, тухайлбал гадаадад манай иргэд зорчих, гадаадын иргэд манайд зорчих тухай асуудлыг зохицуулсан хуулиар энэ нарийвчлагдаж гарах зүйл байх аа.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ

НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л. Хорлоо

Р.Гончигдорж: - За I69-р тойргийн депутат Шагдар гуай асуусан байна. Их цаазын төсөлд нэг танхим бүхий парламентын засаглалтай байхаар заажээ. Энэ Улсын Их Хурал 76 хүнд засаглалын монополь эрх олгосон хэрэг биш үү, Улсын их хурал хэний ч өмнө тайлагнахгүй байгаа нь үүний баталгаа гэж ойлгож байна. Ер нь 2 танхимтай байх нь зөв биш үү. Энэ талаар Улсын бага хурлын тайлбарыг сонсё гэж, өнөөдрийн байгаа Улсын их хурал, Улсын бага хурал бол 2 танхим бишээ. Энэ бол Улсын их хурал өөрөөсөө байнгын хууль тогтоох үйл ажиллагааг явуулах ийм хэсгийг бол ийм хууль тогтоох байгууллагыг өөрөөсөө байгуулсан. Энэ утгаараа бол шууд их хуралдаа бага хурал нь тайлагнах утгаар шууд харьяалагдаж байгаа. Жинэхэн утгаараа 2 парламенттай, 2 танхимтай парламент гэдгийг сонгомол утгаар нь ойлгох юм бол энэ хоёр бие биэндээ ингэж байх, бие биенийхээ шууд юу гэдэг юм бие биэндээ тайлагнадаг байх ийм зүйл бол биш. Энэ бол 2 үе, хамаарч байгуулагддаг, 2 янзын аргачлалаар байгуулагддаг, хууль тогтоох үйл ажиллагаагаа харилцан шүтэлтэйгээр явуулдаг. Энэ утгаараа 2 танхим нь байдаг. Тийм учраас өнөөдрийх 2 танхим биш. I танхимтай байхад монополь байх юм уу үгүй юу гэж, заавал ямар нэгэн газар тайлагнадагаараа монополь биш байна гэдэг шинж чанар илрэхгүй. Хэрэв ямар нэг төлөөллийн байгууллага ямар нэг төлөөллийн байгууллагад тайлагнадаг л байх ёстой бол тэр төлөөллийн байгууллага дээр нэг команд тайлагнадаг байх ёстой гэсээр байгаад бие биэндээ тайлагнадаг төлөөллийн байгууллагуудын гинжин холбоо маш олон дамжлагатай үүсэх ёстой. Эцсийн эцэст өөрөөсөө төлөөллийн байгууллагад тайлагнадаггүй, иргэдээсээ шууд сонгогдож энэ утгаараа бүрэн эрхээ авдаг, сонгууль дээр сонгогдохдоо үйл ажиллагаагаараа өөрөө ямар нэг утгаараа тайлагнадгийн шинж нь илэрч байдаг ийм байгууллага бол байж л таараа. Энэ утгаараа бол I танхимтай байлаа гэдэг бол энэ бол монополь эрх биш. Энэ бол Засгийн эрх ард түмний мэдэлд байгаад энэ мэдлээ ард түмэн өөрсдөө болоод төлөөллөөрөө хэрэгжүүлж байгаа ийм л зүйл. Өөрөөр хэлэх юм бол ард түмний төлөөллийн эрх мэдлийг эндээ хадгалж байгаа гэсэн үг. Тийм учраас энэ учир шалтгаан бол 2 танхимаар тайлбарлагдахгүй зүйл байх. Зүгээр 2 танхимын асуудалд бид хууль тогтоох үйл ажиллагааг хэрхэн сайж-

руулах энэ хууль тогтоох үйл ажиллагаа харилцан шүтэлцээ байх үүднээсээ авч үзээд 2 танхимаа тайлбаралцах байх, эний талаар бол бид бүхний үндсэн саналаа солилцож шийдвэрлэх зарчмын асуудлыг нэг бол энд мөн байгаа. За Их цаазын төсөлд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах механизмыг зааж өгөх хэрэгтэй санагдана. Энэ талаар түрүүн ярилаа тийм ээ, Монгол улсынхаа тусгаар тогтнолыг хангахад иргэн бүр оролцох ёстой, хуучин Үндсэн хууль үүнийг иргэн бүрийн хүндэт үүрэг гэж тодорхойлж байсан, гэтэл Их цаазын I8-р зүйлд хуулийн дагуу цэргийн алба хаах гэж хүчийг нь сулруулж оруулсны учир юу вэ гэж, энэ төсөлд бол улс орноо хамгаалах, байгаль орчноо хамгаалах бол иргэний журамт үүрэг гэж орсон. Хуулийн дагуу цэргийн албыг хаана гэж орсон. Тийм учраас энэ бол нэлээд байх хэмжээндээ иргэд өөрийнхөө тусгаар тогтнолыг хангахад оролцох оролцлогоог хуулийн дагуу хүлээх үүрэг, журамт үүргийн дагуу хүлээх үүрэг гэсэн 2 хэлбэрээр тодорхойлчихсон байгаа.

80 дугаар тойргийн депутат Зарьхан гуай асуусан байна. Их цаазын төсөлд үндэстнүүдийнхээ тэгш эрхийг хангах талаар бараг туссангүй, зарим зүйл дээр их бүрхэг туссан байна, үүнийг юу гэж үзэх вэ гэж энэ асуудал бол Үндсэн хуулийн Их цаазандаа бүрэн туссан гэж үзэж байгаа. Монгол улсын иргэд тийм тийм тийм зүйлийг үл харгалзан эрх тэгш байна гэж тусгаарласан байна. Бид өнөөдөр энд үүсээд байгаа хэт эрх зүйн ялгаатай байдалд байна гэж үзэхгүй байгаа бөгөөд энийг онцолж байгаа мэтээр үзэж энд онцлон тусгах ийм шаардлага байхгүй энд бол тусчихсан гэж үзэж байгаа, хэрэв эрхэм депутатууд ийм ийм зүйлээр ялгаатайгаар тунхагласан байна гэж олж харж байгаа бол тэрнийгээ яриад тэр үедээ бол шийдэгдэх асуудал. Энд бол тийм зүйл байхгүй. Газрыг гадаадын иргэдэд түрээсээр өгнө гэдэг бол гадаадынхныг чөлөөтэй орж ирэхийг дуртай газраа авахыг зөвшөөрч байгаа гэсэн үг үү гэж, тийм гэсэн үг огт биш, харин ийм харилцаа үүсэхэд зохицуулах хуулийн зохицуулалт байж байх. Ёстой гэдгийг хэлж байгаа бөгөөд энэ бол үндсэн хуулийнхээ эрхийн хэмжээнд бол нээлттэй эрхийг бий болгож байгаа гэсэн үг. Парламент ганц амьтай байхад төсөлд орж 2 танхимтай байх нь юугаараа саад болж байгаа юм. Нэг танхимтай байхыг ямар ач холбогдолтойгий нь тодруулж өгнө үү гэж, эерэг, сөрөг талын талаар бол бид цаашдаа зөндөө ярилцаж

таарна. 2 танхим, нэг танхимын талаар, Баян-Өлгий аймаг нь татан буугдах нь энэ нь үндэсний асуудалд анхаарахгүй гэсэн ойлголт төрүүлж байна, би тойргийн сонгогчид, Баян-Өлгий аймгийн хөдөлмөрчдөд ямар хариу өгвөл зохих вэ гэж, Үндсэн хуулийн төсөлд Баян-Өлгий аймаг нь татан буугдахаар тусгагдаагүй юм байна гэсэн хариулт өгвөл зүйтэй байх аа. Хошуу, аймгийн талаар ямар нэгэн тооцоо төсөөлөлгүй бол Үндсэн хуулийн төсөлд юуг баримтлан дээрх асуудлыг оруулсан бэ? Өнөөдөр хэллээ шүү дээ. Эрдэм судлалын төвшинд бол энэ талаар хийж байгаа судалгаанууд байж байгаа юм байна. Төрийнхээ Их цаазын төсөлд бол энэ нэг хөдөлмөрчдөөс иргэдээсээ тоо өгч тоолбол 2 дахь шаты нь хошуу гэж нэрлэе л гэж байгаа юм байна. Ийм л байдалтай байна. Цаашдын хууль тогтоомжийнхоо хувьд бол орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулинд энэ харилцаа нэлээн нарийвчлан тодорхойлогдож байгаа, тэнд нэрийн хэмжээнд хошуу гэж байж байгаа, цааш нь гүйцэтгэх арга хэмжээнийхээ хувьд хэрэгжих арга хэмжээ нь бол өөр асуудал болж байна.

Дараа нь 265-р тойргийн депутат Зандраа гуай асууж: сумыг хошуу болгож өөрчилсний ач холбогдол за энийг ерөөсөө. Одоо манай хэрэглэж байгаа сүлд за энийг больё. Сумын дарга гэдгийг засаг дарга гэж нэрлэсний учир утга нь юунд байна вэ гэж, зөвхөн өнөөдрийн сумын даргыг засаг дарга гэж нэрлээгүй, энэ 2 бол 2 шал өөр үүрэг функцтэй, үүрэг хариуцлагатай, сонгох сонгогдох байдлаараа бол 2 өөр. Өнөөдрийн сумын дарга бол биш. Засаг дарга, зүгээр засаг даргаа өөрөөр нэрлэе гэдэг, энэ Их цаазандаа хэлсэн тэр засаг дарга гэдэг албан тушаалыг өөрөөр нэрлэе гэж байгаа бол энэ дээрээ бид нар ярих зүйл. Тэр бол өнөөдрийн сумын дарга биш.

418-р тойрог Орсоо гуай, 2 дугаар бүлгийн 17-д ямар хөдөлмөрийг албадан хөдөлмөр гэх вэ тодруулж өгнө үү гэж, хуулиар тэр хүнийг хүсэл зоригийх нь дагуу биш хөдөлмөрлөх ийм шаардлага үүсч, хөдөлмөрлүүлэхийг л албадан хөдөлмөр хууль гэж хамгийн энгийн утгаар ойлгож байна. Энэ маань бол албадан хөдөлмөрийн хэлбэрүүд бол манай хуулинд тусгагдсан байгаа, ямар тохиолдолд энэ хүнийг албадан хөдөлмөр хийлгэх вэ гэсэн

III бүлгийн 25-д Улсын их хурал дахь онцгой бүрэн эрхээс ямар ялгаатай юм бэ гэж, тэгэхлээр зэрэг бид нар гурван том бүрэн эрхийн асуудал авч үзэж байгаа. Хууль тогтоох эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдэл, шүүн таслах эрх мэдэл энэ эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа төрийн дээд байгууллагууд өөр өөртөө гэж онцгойлон авсан бүрэн эрхүүд байна. Тэр бүрэн эрхүүдийг нь зааж өгч байгаа утгаар онцгойлон авсан бүрэн эрхүүд. Тэгээд түүнээс гадна бол бусад бүрэн эрхүүд байж болох. Тэр нь бол хоорондын шүтэлцээнээс үүсч бий болж байгаа бусад бүрэн эрхүүд. Тэгээд дараа нь хуулийнхаа зохион байгуулалтаар хэлж байгаа шүү. Энэ онцгойлон авсан бүрэн эрхийнхээ асуудлаар ийм ийм шийдвэрүүд ийм ийм зүйлүүдийг гаргана гэхмэтчилэнгээр тэр нь бол сүүлд хууль хэлэлцэж байхдаа нэлээн тодорч ойлгогдох байх. За Улсын их хурлын бусад бүрэн эрхийг хуулиар тогтооно гэжээ гэж, энд бол тухайлбал бага хурлаас Ерөнхийлөгчийн тухай хууль, засгийн газрын тухай хууль Улсын бага хурлын тухай хууль гэж гаргасан тэр маань үндсэн хуулийн нэмэлтийн хууль. Түүний онцгой бүрэн эрхт нь хамаарч байгаа хууль эрхүүд нь тодорхойлогдсон байгаа, бусад бүрэн эрхүүдийг нь бол тэр үндсэн хуулийн нэмэлтийн хуулийн агуулгад нийцүүлэн УБХ-аас тухайлбал тодорхойлсон байх жишээтэй, ийм байдлаар тодорхойлогдох утгаар нь ойлгогдож байгаа юм. Тийм учраас энийг бол зөвхөн их цаазад бүх бүрэн эрхийг бол өгч чадах боломжгүй,

308-р тойрог Түмэндэмбэрэл гуай асуусан байна.

Улсын нэрийг өөрчлөх ямар нэгэн шалтгаан байгаа юу, тэр тухай бол сүүлд ярилцана гэлээ шүү дээ. Энэ хуулийнхаа нэрийг хэвээр нь үлдээчихэж болохгүй юу гэж энэ тухай бас бид ярилцана гэлээ. Болохгүй юм бол энд огт байхгүй байгаа тийм ээ, зүгээр өнөөдөр бид олонхийнхоо саналаар юу гэж нэрлэх вэ гэдэг асуудлыг тохиролцох гээд л энд цуглараад байна.

350-р тойрог Шархүү гуай асуусан байна.

Засаг захиргааны нэгжийн талаар таны хувийн бодол юу вэ? Энд бол хувийн бодлыг ярихгүй гэж бодож байна. Хувийн бодлоо бол депутатынхаа хувьд надад үг хэлэх эрхий маань үлдээсэнд баярласан. Хэмжээт депутатынхаа хувьд ярихдаа тэр бодлуудаа ярина. Улсын их хурлын 76 гишүүний байх улс төр эдийн засгийн

үндэслэл юу вэ? Их цаазын төсөл парламентын нэг танхимтай тогтоох үндэслэл, 76 гэдэг тооны талаар бол нарийвчилж яривал олон үндэслэлүүд байгаа, тэрнийг ярихын хэрэггүй байх. Тэгш тоотой байгаагийнх нь зайлшгүй шалтгааныг хэлсэн тийм ээ, илтгэлд бол орсон байгаа, 76 дээр бол анхны гаргасан тоо байна. Байнгын ажиллагаатай парламент өөрийнхөө үйл ажиллагааг явуулах, талаар энэ Их цаазад ч байгаа, байнгын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх өөрийн байгууллагуудтай байна, тухайлбал байнгын хороод, түр хороод, тодорхой шаардлагатай асуудлуудаар байгуулагдах асуудлын хороонууд байх ёстой. Эдгээр хороонуудад гишүүний харьяалал нэг гишүүн хичнээн хороод харьяалагдаж болох, нэг асуудал хичнээн хороог байгуулж болох вэ энэ асуудлуудаар авч үзээд хууль тогтоох эрх мэдлийг чадвартай хэрэгжүүлэхийн тулд энэ асуудлуудаар зайлшгүй байх бүрэлдэхүүн тоо хичнээн байх вэ гэдэг энэ асуудлаа авч үзэж байгаа юм. Нэг тал нь, нөгөө тал нь манай төлөөллийн чадвар хичнээн тоо хэмжээтэй байж байж одоо хэрэгжих боломж байна вэ гэдэг ерөнхий статистикийг дэлхийн нийтийн практиктэй бас авч судалсан байгаа юм. Ингээд жишээлэхийн болбол төчнөөн сая хүн амтай нутаг дэвсгэрийн хувьд бол харгалзаж үзсэн нь бага байгаа, энийг харгалзаж үзэх ёстой, ийм улсуудад ямар ямар байдаг вэ тоог шаардлагатай үед та бүхэнд мэдээлэл болгож хэлнэ. Энэ байдлаас авч үзээд УБХ дээр 76 гэдэг тоо бол харьцангуй тоо бүхэндээ оруулаад тавьчихад хэт цөөдчих вий, хэт олдчих вий гэсэн тийм шүүмжлэлээс л харьцангуй хамгийн бага хүртэгдэх тоо бол энэ юм байна л гэж үзсэн. Авч үзэх хүчин зүйлүүд нь саяын хүчин зүйлүүдийг хэллээ.

За Үндсэн хууль, их цаазын төслийн талаар аймаг, хотуудаас комисст болон УБХ-д хэдэн хөдөлмөрчдөөс ирүүлсэн саналын дотор малчин, ажилчин хэд, хичнээн хувийг эзэлж байсан бэ гэж. За Үндсэн хуулийн төслийг энэ бүх статистику бол компьютерт хадгалагдсан байж байгаа. За тэндээс бичиж өгсөн байна. Ажилчин, малчин 4,8 хувь нь, албан хаагч, сэхээтэн 58,3 % нь, өндөр настан 9,5 хувий нь эзэлсэн байна. Үндсэн хуулийн төслийг УБХ-аас эцэслэн боловсруулсны дараа түүнээс хойш хөдөлмөрчдөөс хичнээн санал ирүүлсэн байна вэ гэж байна. 1200-гаад санал ирсэн байна. Үндсэн хуулийн комиссын хурал болон УБХ-ын чуулганаар энэ асууд-

лыг хэлэлцэхэд хөдөлмөрчдөөс оролцсон уу гэсэн ийм асуудал байна. За хөдөлмөрчдийн төлөөлөгчид гэсэн тусгайлсан статустайгаар энд оролцсон км бол байхгүй. За хөдөлмөрчдийн төлөөлөгчид УБХ-д орж ирлээ, зүгээр УБХ-ын практикт бол байгууллагуудаас, иргэдээс УБХ-ыг сонирхоё гэсэн иргэд хөдөлмөрчдийн хүлээн авах байраар дамжаад энд бол хэд хэдэн удаа тодорхой байгууллагууд, тодорхой хамт олон, тодорхой хүмүүсээс бол орж ирж ажиглаад гардаг, зүгээр мэргэжлийн үүрэг, чиглэлийнхээ дагуу бүх асуудлаар ажиллаж байгаа ийм албан тушаалтан эрдэмтэн мэргэд бол байнга сууж оролцож байгаа. Бүрэлдэхүүнд нь ч байгаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш. Бурмаа

Ш. БУРМАА

бичээч

Л. БАТЦЭЦЭГ

Улсын Бага Хурлын дарга, Дэд ерөнхийлөгч Р.Гончигдорж:

324 дүгээр тойргийн депутат Б.Манал гуай асуусан байна. Засаг захиргааны зохион байгуулалтыг нэгтгээд олон сум эзэнгүй хоосон болно. Сумыг татан буулгахад 3 жилийн дотор хүн ч үгүй, мал ч үгүй, барилга ч үгүй байдаг гашуун туршлага бий гэжээ.

Энэ бол өнгөрсөн гашуун туршлага бөгөөд нэгэнт нэг удаа алдсан алдаа хоёр удаагаа давтагдахгүй байх аа гэдэгт нэгдүгээрт найдах ёстой бөгөөд хоёрдугаарт, энэ бол бидний үүрэг болж хувирах ёстой байх. Өнөөдөр төвлөрсөн суурин урьд урьдаас илүү хэрэгцээтэй байгаа учраас энэ төвлөрсөн суурингууд засаг захиргааны нэгжийн болохынхоо хувьд биш гэхэд төвлөрсөн хот суурин болохынхоо хувьд зайлшгүй цаашид байсаар байх бөгөөд энэ бол олшрох ийм зайлшгүй шаардлага манай иргэдээс тавьж байгаа. Сум тарах гэдэг ойлголтыг хэлмээргүй байна. Чухамхүү тийм эмзэглэлээс гаргахын тулд "хошуу" гэж нэрлэх тухай асуудлыг тавьсан юм байгаа юм. Сумууд хэрэв нийлээд хошуу байгуулах тухай асуудал гарахад тэнд байгаа сумын төв болох төвлөрсөн суурин иргэдийн харьцангуй шинжтэй төвлөрсөн хэрэгцээнүүдийг хангах энэ үүргээр байж чадах болов уу гэсэн ийм бодлыг иш үндэс болгож байна.

351 дүгээр тойргийн депутат Б.Мөнгөн гуай асуусан байна. Төсөлд орон нутаг, аймаг, сум Хуралгүй болж иргэдийн төлөөлөгчдийн Хурал бүх асуудлыг шийдэх юм байна. Энэ заалт суманд болох юмаа гэхэд аймагт болох уу?

Эрхэм депутатууд энэ Үндсэн хуулийнхаа төсөлд байгаа орон нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослох гэдэг энэ зүйлийг хичээнгүйлэн ойлгосон байгаасай гэж бодож байна. Энэ Хурал гэдэг маань өмнө нь бүх хурлууд төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг байсан бол одоо орон нутгийн өөрөө удирдах удирдлагыг хэрэгжүүлэх хурлууд, өөрөөр хэлбэл, дороосоо үүсгэлтэй бөгөөд орон нутгийнхаа хувьд энэ эрх хэмжээгээ хэрэгжүүлэх ийм хурлууд шүү.

Тийм учраас аймгийнхаа хувьд ч гэсэн энэ Хурал бол өмнөх хурлаас ондоо, тэгээд төрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд энэ дээр Засаг дарга орж ирж байгаа. Засаг даргын талаар түүрүүн би хэллээ. Энэ бол энэ хурлын шийдвэрийг гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэх ёстой. Энэ бол өөрийн нутагтаа бүрэн эрхтэйгээр асуудлаа хуулинд олгогдсон эрх хэмжээгээр бүрэн эрхтэй, өөртөө мэдэж ажиллах ийм өөрөө удирдах ёсны төлөөллийн байгууллагууд.

Их Хурлын 76 гишүүн бүх ард түмнийг бүрэн төлөөлж чадах уу? Энэ нь нэгдүгээрт, хуучин Улс төрийн Товчооноос том, ард түмний хараа хяналтаас тасарсан төрийн том аппарат болох юм биш үү гэжээ.

Хэрэв сонгогчид, түүнийг сонгосон Их Хурлын гишүүн, иргэдэд байгаа эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэхээр бий болсон төрийн эрх барих дээд байгууллага, эдгээрийн хооронд итгэлцлийг л хичнээн бүрдүүлж чадна, үүгээрээ энэ сөрөг хардлага бол ангижрах ёстой байх. Тийм учраас төлөөллийн байдлыг бид энүүгээр ойлгож, олон болсноор төлөөлөл хэрхэн сайжрах, харьцангуй цөөн байснаар төлөөлөл муудах гэдэг ойлголтон дээр бид бодох ёстой байх аа. Энэ дээрээ бид нар ярилцах зүйлүүд. Юу юуг төлөөлөх ёстой юм бэ гэж. Олон зүйлүүдийг одоо яриад байгаа шүү дээ. Тухайлбал, бид нар энд хурлынхаа депутатуудын бүлгийг байгуулахдаа заавал аймаг, аймгаас төлөөлөх ёстой л гэж байна. Ингэх ёстой юмуу, үгүй юмуу, асуудлын учир шалтгаан энэ төлөөллийг шаардаж байгаа юмуу, үгүй юу. Ингээд төлөөлөл гэдгийн агуулгын цаана бол олон юм бий. Олон юмыг төлөөлнө. Хүн төлөөлөхөөс гадна орон нутгийн ямар ямар онцлогуудыг зайлшгүй төлөөлөх ёстой юм бэ гэж бодоод бид энэ тоогоо олж тогтоож болох байх.

Хоёрдугаарт, энэ нь олон ястан нь цөөнхийн эрх ашигт харшилж байгаа юм биш үү гэсэн асуудал байна. Энэ ястан, үндэстэн төлөөллийн элемент зайлшгүй байх шаардлагатай юу, үгүй юу. Ястан, үндэстний төлөөллийн шинж чанар нь орон нутгийн болон тойргийн төлөөллөөр хэрхэн яаж тусгагдах вэ гэдэг асуудал бол Сонгуулийн хууль, сонгуулийн тойргийн зохион байгуулалт,

олон мандат, цөөн мандаттай байх тухай асуудал болон бусад асуудлуудаар төлөөллийн чадварыг сайжруулах өөр хуулийн механизмууд бас байгаа гэдгийг эрхэм депутатууд бас харгалзаж үзэх болов уу гэж бодож байна.

Аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд сонгоно гэжээ. Ерөнхий сайд томилно гэж байгаа. Энэ нь тухайн аймгийн ард түмнийг эрх мэдэлгүй болгож, дахин шинэ маягийн тойрон хүрээлэгчид бий болгох юм биш үү?

Эндээс үүссэн харилцаа харилцан хариуцлага хүлээх болоод харилцан гүйцэтгэх байдал дээрээ яаж илрэх вэ гэдэг талаар нь бид бодлоо хэлсэн шүү дээ. Тэгээд энэ болж байна уу, болохгүй байна уу гэдэг дээрээ та бүхэн өөрийнхөө саналыг хэлнэ биз дээ.

Бидний монголчууд угаасаа богино настай билээ. Цаашид нас уртсах нь мэдээж. Гэвч Ерөнхийлөгчид 50 хүрч гэж зүтгүүлэх болж байгааг тайлбарлана уу гэж Сүрэнхорлоо гуай асуусан байна.

Энэ дээр би аливаа тайлбар хэлж чадахгүй ээ. Та бүхэн өөрсдөө мэдэх юм. Улсын Бага Хурал дээр олонхийн санал нь 50 нас болгоё гэсэн ийм л санал байгаа. Нас зааглахгүй байна гэсэн санал бий. 40 ч гэж бий, 60 гэж ч бий, 35 ч гарсан байгаа. Энэ болгоноос тэгээд олонхийн саналаар 50 гэж орж ирсэн. Энэ бол та бүхний бас шийдэх асуудлуудын нэг ээ. Насаар юуг илэрхийлэх ёстой вэ гэдгийг бодох асуудал, бидний хувьд.

Төсөлд Парламентын нэг танхимтай байхаар тусгаж, хоёр танхимтай парламент байдаг. Ямар давуу талыг нь харгалзаж, нэг танхимтай сонгов. Энэ хоёрын давуу талыг төвч хэлнэ үү гэсэн байна.

Одоо хэлэх шаардлага байна уу, эрхэм депутатууд аа. Энэ бол Бага Хурал дээр яагаад давуу талтай байв гэдгийг харгалзаж үзээд гэдгээс нь бодож байгаа юм. Өнөөдөр монгол улс төрийн хувьд нэгдмэл улсын хувьд түүнээс гадна монгол

улс цөөн хүн амтайгийн хувьд, түүнээс гадна хууль тогтоох үйл ажиллагаа өнөөдрийн болоод энэ Үндсэн хуулийн хэрэгжих энэ явцад хууль тогтоох үйл ажиллагаан дээр зайлшгүй ирж байгаа шуурхай байх энэ шинж чанар, бидний өмнө маш олон хууль тогтоомжуудыг батлах зайлшгүй шаардлага үүсч байгаа хүчин зүйлүүд. Энэ болгоных нь талаас авч үзээд, мөн парламентын уламжлагдах байдал, парламентын шинэчлэгдэх байдлыг харгалзаж үзэх байдлаа бол хоёр танхимд байдаг эерэг талыг нь бид тэр сэлгээгээр засварлаж, харьцангуй үлдээж болж байна гэж үзэж байгаа. Энэ хүчин зүйлүүдийг харгалзаад хоёр танхимтай байх сөрөг талуудаас нэг танхимтай байх эерэг болоод өнөөдрийн шаардлагын байдлыг ингэж авч үзсэн юм байгаа юм.

Хоёр танхимтай байхад мэдээж хэрэг хууль тогтоох үйл ажиллагаа бол харилцан хяналттай байдаг учраас энэ бол мэдээж хэрэг хууль чанартай байх гэдэг талаасаа мэдээж хэрэг харьцангуй их эерэг талтай, нөгөө талаас харьцангуй их бюрократтай Нэг хууль тогтоох энэ үйл явц бол маш их хэмжээний цаг зарах ёстой, цагаа дагаад хөрөнгө мөнгө, хөрөнгө мөнгийг төрийн байгуулалтынхаа ^{сайжруулах} асуудлыг өргөн ^{өргөж} харж үзээсэй гэж бодож байна. Ийм зүйлүүд бий. Түүнээс гадна энэ хоёр танхим мэдээж хэрэг бие биенээсээ үл хамаарах утгаар нь хоёр танхимыг ярьж байгаа, тэгэхгүй бол хоёр танхим биш.

Энэ хэрхэн ямар төлөөллөөр байгуулагдаж байна өнөөдрийн манай, жишээлбэл, нэг нь өөрөө өөрөөсөө байгуулсан танхимдаа хандах хандлага, итгэлцлийн байдал ямар байна вэ? Тэгэхэд бие биендээ үл хамаарах хоёр танхимын харилцан итгэлцлээс хууль тогтоох ажиллагаа цаашдаа хэр зэрэг саатаж болох болзошгүй байдал байна вэ гэдгийг эрхэм депутатууд өөрсдөө бодох зүйл байх.

Бага Хурлаас баталсан Их цаазын хуулийг ^{үүнийг} төслөөр батлахад улс орны хөгжлийн ямар түвшинд хүртэл үйлчлэх баталгаатай хууль болох вэ? Өөрөөр хэлбэл хэдэн он хүртэл үйлчлэх баримжаатай вэ? Эцэс дугаар тойргийн депутат Г.Сосорбарам.

Өнөөдөр бид нар ямар нэг зүйлийг төчнөөн настай, төчнөөн хугацаатай, тэдэн жилийн дараа тийм түвшинд хүрнэ гэдэг байдлаар хэлэх аргачлалаас татгалзсан гэж бодож байна. Тэр аргачлалынхаа үүднээс энийг хичнээн хэмжээнд явах вэ гэж. Ямар ч байсан энэ Үндсэн хуулиа энд байгаа агуулга, зарчмаар гарсан байхад Монгол улс Үндсэн хуулийнхаа ардчиллын хэлбэрт дэлхийн хөгжлийн явцад ямар ч байсан ойрын 20 жилдээ нүүр улайхгүй явж чадах л байх. Энэ улс ардчиллаараа, Үндсэн хуулийн ардчиллаараа хоцрогдсон улс болчихжээ гэж хэлүүлэх түвшинд ямар ч байсан 20 жилдээ орохгүй л байх. Дэлхий нийтийн ардчиллын хөгжлийн энэ агуулгаар нь эвч үзвэл.

Газрыг гадаадын иргэдэд, харьяалалгүй хүнд түрээсээр заавал өгөх шаардлагатай байгааг тайлбарлана уу?

Өнөөдөр үүсч байгаа бодлогынхоо хэмжээнд гарах талаас нь туруун хэлсэн. Засаг, захиргааны өөрчлөлт зохион байгуулагдсан үед одоогийн сумын бүтэц, зохион байгуулалт ямар байх вэ?

Сумын бүтэц, зохион байгуулалт гэдгийг эрхэм депутат Сосорбарам гуай түүн дэх удирдлагынх нь талаас асуусан байх. Тэр маань Үндсэн хуулийн төсөлд байж байгаа. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага сумын Хуралтай байна. Дээр нь сумын Засаг даргатай байна гэдэг байдлаар байлаа. Сумаа бол "хошуу" гэж нэрлэе гэсэн байдалтайгаар байгаа.

Асуудал давхардаад байна. Би тэр тохиолдолд ерөөсөө асуудлыг хажуу тийшээ тавиад байх уу, эсвэл эрхэм депутат тэр асуудал тавьсан байна гэдгийг дурдаад явах уу? Ингээд тавиад яваад байх уу? За тэгье.

180 дугаар тойргийн депутат Д. Жумдаанбаатарын асуулт давхардсан байна. Б. Жадамбаа гуай 181 дүгээр тойргоос асуусан байна. Давхардаагүй асуулт, орон нутгийн Хурал, захиргааны байгууллагын үүрэг роль есөх үү, эсвэл буурах уу?

6.

Хурал, захиргааны үүрэг шал өөр болно. Хурал, захиргаа төрийг төлөөлсөн байсан бол одоо бүр өөр, нэр нь адилхан болчихоод болохгүй байна, Хурал гэдэг утгаар нь би хэлж байна. Хурал нь орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болно. Захиргааг нь гүйцэтгэх утгаар нь яривал Засаг дарга хэрэгжүүлнэ. Энэ утгаараа шал өөр болно.

Багт хэдэн өрх орохоор тооцоологдож байна вэ гэж байна. Энэ тооцоог өнөөдөр хэлж чадахгүй бөгөөд зүгээр зарчмын асуудлын хувьд бол багийн хэм хэмжээг хоёр хүчин зүйлээр тооцох байх аа гэж бодож байгаа. Нэг талаас иргэддээ хүрэх зай буюу нэг багийн нутаг дэвсгэрийн хэмжээ бол нэг хүчин зүйл болох ёстой. Нөгөө талаас тэнд харьяалагдаж байгаа иргэдийн тоо хоёр дахь хүчин зүйл байх ёстой. Энэ хоёр хүчин зүйлээр яригдана гэж. Энэ утгаараа говьд нутаг дэвсгэрийн хэмжээнд, нэг талаас харьцангуй том байхад хүн амынхаа тооны талаасаа авч үзсэн хангай нутагт хүн ам шигүү суусан тохиолдолд хүн амынхаа тооноос бас харгалзаж. Ингээд хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ авч үзснээр бидний баг байгуулж байгаа зорилго нь үүнтэй уялдаатай юм.

дараачаар 32⁵ дугаар тойргийн депутат Н. Дашзэвэг гуайн эхний асуулт нь давхардаж байна. Түрээслүүлэлтийн талаар тантай харьцангуй санал нэгтэй байна. Тэгэж бодож байгаа. Хэсэг газрыг төрийн мэдлийн газар гэж үзээд төрөөс гадаадын хүмүүс түрээслэх тухай асуудал ярьж байгаа. Хувь хүн өмчийнхөө болж байгаа газрыг түрээслүүлэх харьцааг үүсгэх үү, үгүй юу гэдэг асуудал дээр бол асуудал бий. Гэхдээ энэ газар гэдэг өмч бол онцгой өмч болохынхоо хувьд бусад эд хөрөнгийг өмчлөх өмчийн харьцаанаас нэлээн хязгаарлалтай ийм талууд бий. Энэ бол онолын талаасаа зарим маргаантай асуудал өмчлөх гэдэг асуудлаасаа бий байх. Энэ дээр хэрэв нарийн зайлшгүй шаардлагатай гэх юм бол өмчийн эрхийн асуудлаар нарийн мэргэшсэн улсуудаас хариулах хариултыг сонсож болно.

Энд бол төрийн хамгаалалтад байх энэ утгаараа байж болох нэлээн хэдэн хязгаарлалтууд байгаа. Тухайлбал, өөрийнхөө

өмчилж байгаа газрыг гадаадын иргэдтэй түрээсийн харилцааг үүсгэх үү, үгүй юу гэдэг асуудлыг ярих л асуудал. Гэхдээ өмчийн туйлын эрхийг энд ямар нэгэн хэмжээгээр хөсөрдүүлж байгаа юм. Энэ өмчийн зүйл дээр хязгаарлах асуудлыг ярих уу, үгүй юу гэдэг асуудал. Тэгээд тэр нь Үндсэн хуулийн их цаазын түвшинд хэлэгдэж байж бусад хуулиар зохицуулагдахгүй бол болохгүй гэдэг асуудал яривал эндээ ярих асуудал байгаа байх. Энийг манай өмчийн эрхийн улсууд, бусад улсууд дэлгэрэнгүй хэлж өгөх байх.

40 дүгээр тойргийн депутат Б. Дагвадорж гуай асуусан байна. Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг 3 жил тутамд шинчлэн сонгож сэлбэнэ гэсний үндсийг тайлбарлаж өгнө үү. Энэ нь хоёрны нэг чинь сонгуулийн эрх бүхий иргэдээс 6 жилийн хугацаагаар сонгогдсон Их Хурлын гишүүн шүү дээ гэсэн байна.

Тийм ээ. Энд бол нэг л асуудал байгаа. Бид энэ шилжилтийн хуулийг энэ хавсралт хуулиа яаж тогтоох вэ гэдгээс бас хамаарна. Энэ хуулинд ороогүй, гэхдээ цаана нь байж байгаа зарим хувилбарууд бий. Тэр хувилбаруудаар жишээлбэл, миний хэлэх гэж байгаа энэ зөрчил арилж чадна. Их Хурал гэдэг маань хууль тогтоох дээд байгууллага болохынхоо хувьд бүрэн эрхийнхээ хугацаа гэж байхгүй. Энэ бол ерөөсөө тасралтгүй үргэлжилнэ.

Тэнд байгаа нэг гишүүний хувьд бүрэн эрхийн хугацаа гэж бий. Тэр нь бол 6 жил. Эхлээд бид нар шууд сонгуулиа явуулаад шинэ Үндсэн хуулийнхаа дагуу Их Хурлаа шууд шинэ гишүүдтэйгээр бүгдийг байгуулна гэвэл бүх гишүүд 6 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Тэгээд эхний удаагийн 3 жил дэх шинэчлэлийг хийхэд энд зайлшгүй асуудал үүсч байгаа бөгөөд энэ нь ямар тал гишүүдийнх нь 6 жилийн эрх хэмжээг 3 жилээр өөрчлөх харьцаа үүсч байгаа юм. Энд эхний удаад ийм бэрхшээл гарна. Тэрнээс цааш энэ бэрхшээл гарахгүй болчихно. Энэ бэрхшээлийн хувьд бол нэг талаас азтай байгаа, нэг талаас гомдолтой байна. Тэрийг сонгогч хүн миний тойргийн 6 жилээр сонгогдсон хүнийг 3 жилээр дахин сонгуулахаар боллоо гэж гомдвол тэр

хүн дахиад 6 жилээрээ тэр хүнээ сонгоод өгчих юм бол үнэн хэрэг дээрээ 9 жилийн тасралтгүй эрхтэй харин ч түрүүнийхээ 6-гаас давуу болгоод өгчихөж байгаа юм. Тэр гомдлоо тэгээд тайлчихаж болно гэж ингэж ойлгож байгаа юм.

Тэр хүн энэ явцад энэ сонгосон хүн маань Их Хуралд миний бодсоноор ажиллаж чадахгүй байна гэж бодож байсан бол шууд та бүхэн тэрнийгээ харин ч хугацаанаас нь өмнө та нарын бодсон сонгогчдын эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжийг та бүхэнд өмнө нь тавиад өгчихжээ гээд бас баярлах тал үүснэ. Өөрөөр хэлбэл, сонгогчдын зүгээс гомдох гомдол болоод сонгогдсон Их Хурлын гишүүн 3 жилийн эрх мэдлийгээ хэрэгжүүлж чадсангүй гэдэгтэй холбож үүсэх харьцаа бол харьцангуй гомдол багатай юмуу гэсэн учир шалтгааны тайлбар хэлж болно. Гэхдээ энд ийм зайлшгүй харьцаа бий шүү. Энэ бол эхэнд л үүсэх ёстой.

Ийм байхгүйгээр болгоё гэвэл бид энэ шилжилтийн хууль буюу хавсралт хууль энийг зохицуулж болох хувилбар бий. Сонгогдсон болгон 6 жилийнхээ бүрэн эрхийг гарцаагүйгээр авч чадаж байхаар.

Соронзон хальстай тулгаж нийлсэн:

Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.ОКУНЧИМЭГ

би тэрнийг цааш нь явах нь шаардлагагүй гэж үзэж байна. Сонгуулийн хууль тэндээ холбогдуулаад тэндээ зохицуулж болох асуудал бий. Олон мандаттай тойрог байх уу, ганц мандаттай тойрог байх уу гэдгээр үүнийг зохицуулж болох хувилбар бий. Улсын их хурлын анхдугаар сонгуулийн төсөлд заасан 76 суудал дээр сонгууль явагдах уу, ингэсэн тохиолдолд 3 жилийн дараа дээрх суудлын хагасыг яаж ялгах вэ. Үүний тухай саналаа ярилаа шүү дээ. Их хурлын гишүүн ерөнхийлөгчийн сонгууль байнга цуг явагдах уу гэж. Байнга цуг явагдахгүй шүү дээ. Нэг нь 4 жил, нэг нь 3 жил, 6 жил гэсэн ийм харьцаатай байгаа учраас энэ бол дандаа хугацааны хувьд зөрж байна. Эхнийхийг энэ хуулиндаа хэлсэн байгаа шүү дээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатыг бол их хурлын гишүүдийн сонгуультай нэгэн зэрэг явуулна. Эхний удаагийн сонгуулийг бол.

Гончигдорж -Одоогийн 50 гишүүний Улсын бага хурлын үйл ажиллагааны жилийн зардал төсөв хэд байна? 76 болж нэмэгдэхэд хэрхэн өсөх тооцоо байна, аппаратыг оруулж тооцоод гэсэн асуулт байна. Үүнийг бид Бага хурлынхаа тайланд аа ярина. Бага хурлын тайланд аа хууль боловсруулах ажлыг цаашид боловсронгуй болгох зорилтын талаар ч гэсэн хавсралт болгож энэ асуудлыг ярина. Энд бол та бүхэнтэйгээ санал бодлоо солилцох маш олон зүйлүүд бий. Энд маш их олон асуудал байна шүү гэдгийг эхлээд нэг хэлчихье. Ийм замаар л би яваад байх нь шүү гэдгийг хэлчихье. Тэгээд горимын санал байна уу та нарт.

-Эрхэм депутатуудаа.

Уртнасан - Уучлаарай. Пүрэвдорж депутатаа. Энэ чинь асуултанд хариулж байна шүү дээ. Ямар нэг ятгалга явж байгаа хэрэг биш. Энэ депутат та бүгдээс ирсэн асуултад Бага хурлын дарга хариулж байна. Харин депутатууд олонхийн саналаар ер нь асуух асуултын гол нь гарчихлаа гэж үзвэл бид дэгийн дагуу дараагийн асуудалд шилжилж болж байна. Миний ойлгож байгаагаар бол асуултанд одоо хариулж байна. Ямар нэг ятгалга яваагүй байна шүү. Хэрэв асуултыг нэмж авахаа больё гэвэл асуултыг

хязгаарлаад санал хураалт явуулъя.

-Депутатууд аа.Зарим санал гарч байна.Хэрвээ бид ингээд асуултууд нэмж ирээд байх нь л дээ.Иймд гол асуулт гарлаа гэж бодвол бид энд ирсэн асуултаар асуултыг таслая гэсэн санал хураалт явуулах гэж байна.

-Одоо энд бичгээр ирсэн асуултад дэд ерөнхийлөгчид хир олон асуулт байна вэ? Маш олон байна.

Гончигдорж -Хариулсан асуулт энэ байна. Хариулаагүй асуулт энэ байна.Энэ бас байна.

Уртнасан -За баярлалаа депутатууд аа.Энэ асуултанд хариулах явдлыг үргэлжлүүлбэ.Олон асуулт байна.Харин бичгээр авахыг нэгтгэж болох юм.Бидний ойлгож байгаагаар бол.

-Хурал дэгийн дагуу явж байна аа даргаа.Энэ зөв явж байна.Бид сонсох ёстой.Ингэж хажуугаас үймүүлдэгийг больё.

Гончигдорж -За баярлалаа.Эрхэм депутатууд аа.Би хариулж байгаа аргачлалаа ярья.Нэг талаас би дэлгэрэнгүй хариулна гэвэл миний мэдлэг мэргэжил дутна.Тийм учраас би Бага хурал дээрээ олонхийн санал авч байхдаа гол ямар санаа үндэслэл болж байв гэдгийг ярьж байгаа.Түүнээс гадна тэрэн дээр олон янзын тайлбарууд байдаг,олон янзын дэлгэрүүлэх асуудал.Хэт дэлгэрүүлэх дээр зэрэг зарим депутатуудад энэ хэт ухуулгын шинжтэй болчихдог болов уу гэж тооцох учраас ийм болчихоод байгаа.Ийм хоёр хязгаарлалтан дотор байгаа.Ийм байдлаар хариулаад юмуу сүүлдээ бид нар бие биенийгээ ятгах асуудал гишүүн гишүүнийхээ хувьд өөрийнхөө саналыг хэлж болох тэрний хувьд бол эрхэм депутат байгаа эрхэм гишүүддээ найдаад үлдээж байгаа.

-Булгийн 18 дугаар зүйлд иргэний үүрэгт хөдөлмөрлөх үүрэг тусгагдсангүй.Гагцхүү хөдөлмөрлөх эрхээр тусгагдаж хөдөлмөрлөх иргэний үүрэггүйгээр бид эдийн засгийн хямралаас

гарч чадах уу гэсэн асуулт байна. Энэ бол мөн Бага хурал дээр болоод комиссын хурал дээр гарсан асуудал. Үүнийг иргэний үүрэг дотор оруулаагүй, иргэний журамт үүрэг дотор оруулах тухай асуудал гарч байсан. Тэгэхдээ журамт үүрэг дотор үүнийг томъёолж оруулаагүй юм. Зүгээр бусад эрхээсээ үүсэх харилцааны үүднээс хөдөлмөрлөх энэ үүрэг нь иргэнийхээ хувьд гарч ирэх ийм учир шалтгаантай байгаа. Харин Үндсэн хуулинд үүрэг болгоод өгнө гэдэг маань эргээд үүргээ биелүүлээгүй гээд түрүүн асуусан асуулт шиг албадан хөдөлмөрлөх харьцаа үүсэх шалтгаан үүсэхгүй байх учиртай гэдэг талаасаа яг үүрэг дотор нь хөдөлмөрлөхийг үүрэг болгож өгөх асуудлын хууль эгнэ харьцааны хувьд тэгэж л авч үзсэн юм. Журамт үүргийн хэмжээнд байхад үүнийг болохгүй гэх асуудал байхгүй.

-Булгийн 61, 62, 63, 64-рт улсын засаг захиргааны үндсэн нэгж, багийн бүтэц, зохион байгуулалтыг ямар байх, удирдах ёсны хослуулах талаар тусгагдсангүй, тодруулж ярина уу?

-Энд Үндсэн хуулийнхаа хэмжээнд тусгагдсан байж байгаа шүү дээ. Харин орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хууль гэж Улсын бага хурлаас намрын чуулганаар анхалж хэлэлцсэн тэр хуулийн хүрээнд та бүхэнтэй саналаа солилцож болно. Тэрүүнийг ялангуяа Их хурлынхаа дараачаар эрхэм депутатуудаас, ялангуяа орон нутгаас ирсэн депутатуудаас энэ хуулийн талаар та бүхнээс санал авах зүйл бий. Ялангуяа анхны хэлэлцүүлгийн дараачаар Улсын бага хурлаас зарчмын хувьд тохирсон асуудлуудын талаар үйлчилсэн тэр төслөөр магадгүй зарим депутатуудад тарааж саналыг авна. Энэ дээр харьцангуй дэлгэрэнгүй гарч ирж байгаа. Тэргүүлэгч гэдгийг яаж ойлгох юм бэ, түүнээс гадна өөрөө удирдах ёсны хэрэгжүүлэхэд зөвлөл гэж ямар байх юм бэ, ямар үүрэг чигтэй байх энэ асуудлууд энд тусна. Үндсэн хуулийн зохицуулалтын хэмжээнд энэ бол хангалттай. Үүнээс дэлгэрүүлэх шаардлага байхгүй байх аа гэж үзэж байна.

-Улсын хэмжээнд татан буугдсан хичнээн сумын төвүүд эзэнгүй болж хоосорсон. Үүнийг авч үзсэн үү?

Ийм нэг олон статистик асуусан байна лээ. Ямар зардал гарах вэ, хичнээн сумтай болох вэ, хичнээн хошуутай болох гэж байна, зардал мөнгө нь хичнээн гарах юм бэ, өнөөдөр төвлөрлийн үед сумуудыг татан буулгаж нэгдсэнээр хичнээн хохирол гарсан юм бэ гэж. Энэ статистикийг үнэндээ өнөөдөр эрхэм депутатуудад хэлж чадахгүй. Үүнийг зайлшгүй авах ёстой, тэр санал өгөхөд зайлшгүй шалтгаан үүсч байна гэх юм бол үүнийг холбогдох байгууллагуудаар гаргаж болно. Үүнийг судалж байгаа тэр институт, газрууд бий. Эндээс та бүхэнд чуулган дээрээ биш хуралдаан дээрээ биш ямар нэг байдлаар ярилцлага юуны журмаар манай Их хурлын дарга зохион байгуулж өгч болох байх аа гэж бодож байна.

-Газрыг харьяалалгүй хүмүүс гадаадын иргэнд түрээслүүлэхийн учир юу вэ гэсэн асуулт давхардаж байна.

-281 дүгээр тойргийн депутат Бадам гуай, оршилд анх хүнлэг ардчилсан иргэний нийгэм байгуулна гэснийг иргэний ардчилсан гэснийг учрыг хэлнэ үү гэсэн байна. Энэ бол сүүлд манай Зардхан дарга хэлсэн асуултандаа. Энэ одоо нийгэм иргэний нийгэм, хүнлэг ардчилсан нийгэм, бусад ардчилсан нийгэм шударга ёсны энэ асуудлууд бол нэг утгаараа нилээн дэлгэрэнгүй тайлбар шаардлагатай бөгөөд харьцангуй үзэл баримтлалынхаа хувьд бас янз янзын ойлголттой байдаг ийм ойлголцууд. Үүнийхээ хувьд дэлгэрэнгүй шаардлага үүссэн тохиолдолд та бүхэнд ярилцах, хоорондоо санал бодлоо солилцох, тайлбарлах асуудал байгаа байх.

-Иргэдийн оюуны үнэт зүйлс, монгол улсын үндэсний баялаг мөн гэсэн бий. Иймд иргэд бүтээлээ гадаадад зарж болохгүй гэсэн үг үү гэсэн ийм асуулт байгаа юм.

-Иргэдийн оюуны үнэт зүйл нь өөрийнх нь өмч байх бөгөөд монгол улсын үндэсний баялаг мөн гэсэн заалт байгаа. 7-гийн хоёрт. Монгол улсын нутаг дэвсгэр дээр бүтээгдсэн аливаа зүйл бол монгол улсын баялаг мөн. Энэ баялаг өөрийнхөө түүхэн үнэ цэнээр үндэслээд энэ төрийн онцгой хамгаалалтанд


авагдах эсэх тухай асуудал үүсдэг. Энэ ч **утгаараа** хувийн өмчтэй явахад хувийн өмчийг тодорхой нөхцөл байдалд **төрийн** хамгаалалтанд авах, тодорхой төлбөртэйгөөр төрийн хамгаалалтанд авах, төрийн өмчинд авах тухай асуудлын хүрээнд ч ярилаа гэсэн энэ хүний хувийн өмч болж байгаа зүйлийг төрийн зайлшгүй хамгаалалтанд авах, ялангуяа гадаадад, гадаадын өмчлөлийн хэлбэрт шилжүүлэх тухай асуудлуудад төрийнхөө зүгээс хэрэв тэр хүн худалдах харилцаа үүсгэлээ гэхэд л анхны худалдан авагч нь манай төр байх ийм бүх асуудлаар нь цаашдаа бид нар бусад хуулиудаар зохицуулах асуудал гарч ирнэ. Гадаадад зарж болохгүй гэсэн туйлын утга энд байхгүй ээ. Гадаадад зарж болно. Тэр хүн өөрийнхөө хувийн өмчийг, өмчөө захиран зарцуулах энэ эрхийнхээ хувьд бол. Тэр үнэхээр монгол улсын гэсэн зайлшгүй шаардлага үүссэн үндэсний баялаг болж түүх дурсгалын шинжтэй, үндэсний урлагийн үнэт зүйл болохынхоо хувьд байх юм бол үүний хязгаарлалтыг хийж болно гэж төрөөс. Энэ утгаар нь харьцангуй ойлгож болох байх.

—Улсын Их Хурлын 76 гишүүдийн талаар санал давхардаж байна. Их цаазад улс төрийн намын талаар оруулаагүйн учир юу вэ. Улс төрийн тогтолцоонд нам ямар шийдвэрлэх үүрэгтэй байх вэ, тэр нь төр, засагтай яаж харилцах зэрэг асуудал Үндсэн хуульд оруулах асуудлыг та юу гэж үзэж байна вэ?

Гончигдорж —Орсон. Хангалттай орсон. Хаана хаана улс төрийн намын тухай асуудлууд, **түүнтэй** төрөөс харьцах харьцаа, тэдгээрийн өөр хоорондын харьцааг тэднээс иргэдтэй харьцах харьцаа үүсэх вэ, тэр газар болгонд энэ бүгд орсон байгаа. Өөрсдөө **эвлэлдэн** нэгдэх эрх чөлөөнийхөө төлөө талаасаа нам байгуулах тухай асуудлаас нь эхлүүлээд нам иргэн хоёрын, нам намын гишүүн хоёрын харьцаан дээр төрийн харьцаатай үүсээд оролцох харьцаан дээр гарах асуудал нь ч хүртэл туссан байгаа. Зайлшгүй шаардлагатай бол намын гишүүнээсээ түдгэлзэх албан тушаал байж болох тухай асуудлаас үүсээд Дараачаар нь төрийн удирдлаганд төрийн эрх барих үйл ажиллагаанд хэрхэн оролцох вэ гэдэг асуудал дээр байж байгаа. Тухайлбал энд Их хуралд олонхи суудал авсан нам, олонхи суудал аваа-

гүй нам, тэдгээр засгийн газрыг эмхлэн байгуулахад оролцох оролцоо, сонгуульд нэр дэвшүүлэх субъект болохынхоо хувьд байх энэ бүх асуудлууд нь энд бүгдээрээ тусгагдсан байж байгаа шүү эрхэм депутатууд аа.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН



/БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

Р. Гончигдорж /56 дугаар тойргийн депутат/ -Энэ халдашгүй дархан байдал, түүнийг хуулиар хамгаална гэдгийг тухайлбал Улсын Бага Хурлаас гаргасан гурван хуулийн хүрээнд хуулиар зохицуулагдаж байгаа байдал нь энэ юмаа гэдгийг та бүхэнтэндээс харж болно. За энэ хэтэрхий их хэмжээтэй тусаж уу, бага хэмжээтэй тусаж уу гэдэг санаа бодлоор бол та бүхэн сүүлд Улсын Бага Хурлын хууль тогтоох үйл ажиллагаан дээр хийх шүүмжлэлдээ хэлэх байх. За энэ халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэдэгтэй үүсээд тухайлбал энд байгаа Их цаазын цэц, түүний авч үзэх асуудлын хүрээн дотор энэ төрийн дээд удирдлагад байгаа хүмүүсийн онцгойлсон иммунитетын тухай асуудал, түүнийг хэрхэн өөрчлөх тухай асуудал, дараа нь иргэнийх нь шугамаар хэрхэн шүүх, одоо гэмт хэргийн асуудлыг шийдвэрлэх вэ гэдэг энэ бүх харьцаа тусгагдсан байгаа. Энэ одоо агуулгаар нь та бүхэн Үндсэн хуулиа эргээд нэг сайн хараатай. Тэгэхээр зэрэг энэ асуудлууд та бүхэнд нэлээн ойлгомжтой харагдах байх гэж бодож байна.

75 дугаар тойргийн депутат Хүрлээ гуай асуусан байна. Төслийн 46-гийн гуравт намын гишүүн байхыг хуулиар хязгаарлаж болно гэсэн нь парламентад нам үүргээ гүйцэтгэхийг татгалзаж, сонгуульд ялсан нам Засгийн газраа эмхлэн байгуулах эрхгүй болно гэсэн үг үү? 46-гийн гуравт.

46-гийн гурав дээр зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн байгууллагын ажилтан зэрэг зарим албан хаагч намын гишүүн байхыг хуулиар хязгаарлаж болно гэж. Энэ бол нөгөө парламентын гишүүн татгалзах тухай асуудлын тухай огт яриагүй, зүгээр Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч намаасаа түр түдгэлзсэн тухай асуудал дээрээ сонирхсон асуудлууд тавигддаг. Энэний агуулга, шинж чанар, тухайн үед шийдвэрлэсэн байдлын талаар сүүлд шаардлагатай бол Бага Хурлынхаа хууль тогтоох үйл ажиллагааны талаар тавих асуудал дээр бид нар харилцан ярилцаж болно. Энэ бол нэлээн эртхэн Улсын Бага Хурлаас гаргасан намын гишүүнээ түдгэлзүүлэх албан тушаалын жагсаалтаар

гарсан тэр субъектууд энд байж байна шүү дээ. Энэ маань бол намынхаа шинж чанараар сонгогдоогүй ийм субъектууд, албан тушаалтнууд, төрийн жинхэнэ албан тушаалтнууд байгаа шүү дээ. Тийм учраас дараагийн учир шалтгаантай холбоогүй юм.

Нам, засгийн харилцаа ямар байх вэ гэдгийг түрүүн хэлчихлээ. Үндсэн хуулийн хүрээнд Их цаазын 63 дугаар зүйлд... энэ давхардсан асуудал байна. Шүүмжлэл байна, тэр шүүмжлэлээ эрхэм депутат, 305 дугаар тойргийн депутат Бямбажав гуай хөдөлмөрчдийн хооронд хавчигдсан иргэдийн төлөөлөгчдийн хурал байх нь ээ гэж ингэж авч үзэж байгаа юм байна. Энэнийхээ учир шалтгааныг эрхэм депутат сүүлд тэр зүйлийг хэлэлцэж байхад өөрийнхөө саналаар дамжуулж хэлэх байх гэж бодож байна.

За энд Ерөнхийлөгчийн тамгын газар хэдэн хүн ажилладаг, тэдний цалин хэдэн төгрөг байдаг, зарцуулдаг. Улсын Бага Хурлын гишүүд ороод Бага Хурлын Тамгын газар хэдэн хүн ажилладаг вэ? тэдний цалингийн дүн, одоо Их цаазын төсөлд тусгагдаж байгаа хөрөнгө яаж хэмнэгдэх вэ? гэх мэтчилэнгийн ийм асуудлууд байна. Хэвлэлд гарсан зүйл гэж хэлж болно. Гэхдээ хэвлэлд бол тухайлбал хамгийн шинэ сэргэгээсээ Бодлын солбицолд маш буруу тоо гарсан. Улсын Бага Хурлын Тамгын газар 105 хүн байхгүй. Улсын Бага Хурал, Тамгын газартайгаа нийлээд 105 хүн байгаа байх. 105 ч хүрэхгүй байгаа байх. Бага Хурлын нэг гишүүнд нэг тамгын албан хаагч хүрэхгүйгээр байгаа. Энэ бол цаашид ийм байж болохгүй гэдэг талаар бол сонинд өгсөн албан тушаалтнуудын хариултуудаас хэлсэн байгаа. Энийгээ та бүхэнтэй ярина, ийм байж болохгүй, ийм ядуухан байж болохгүй байх.

За хошууг байгуулбал хуучин хошуудыг сэргээж, тэр үеийн нутгаар нь байгуулахаар бодолцсон тал байна уу? Нэр нь бас хуучин нэрээр нь байх уу? Жишээ нь таны нутаг Далай чойнхор вангийн хошуу хуучнаараа байгуулагдах уу? гэсэн асуулт байна. Энэ бол цаашид асуудлууд шүү дээ. Яаж одоо, түүхэн нутаг дэвсгэрээ хэрхэн харгалзах вэ? Одоогийн нөхцөл байдлыг хэрхэн харгалзах вэ? ямар шалтгаан, энэ бол цаашид яригдах зүйлүүд.

3.

298 дугаар тойргийн депутат Жавзандорж асуусан байна. Газрыг хувьд шилжүүлсэн нийгэмлэгийн журмаар эзэмших асуудлыг цаашид яаж шийдэх вэ? Тухайлбал монгол-зөвлөлтийн төмөр замын талаар гэх мэтчилэн байна. Хувьд нийлүүлсэн нийгэмлэгийн шугамаар эзэмших. Тэгэхээр энд бол яг өмчлөгч болохынхоо хувьд зөвхөн эсвэл төр, эсвэл монгол улсын иргэн, иргэдээр дамжсан одоо ямар байдалтай байх, энэ л гэж байгаа шүү дээ. Өмчлөлийн харилцааныхаа хувьд энэ л гарцаагүй. Зүгээр түрээслэх болон бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах. Өмнөх практик, жишээлбэл, концессийн асуудал байдаг байсан. Энэ болгон бол Газрын тухай хууль, Газар эзэмшүүлэх тухай энэ асуудлуудыг цаашид зохицуулах хуулиудаараа яригдах зүйл. Энэ үүднээсээ хуульд нийцүүлэх зохион байгуулалтын асуудлуудаар зайлшгүй үүсэх ийм зүйлүүд бий.

Төслийн 8 дугаар зүйлийн нэгд төрийн албан ёсны бичиг ямар бичиг байхыг заагаагүйн учир юу вэ гэж. За энийг ярилцаж яагаад, одоо монгол бичиг яг 1994 оноос монгол бичгийг төрийн бичиг болгох бэлтгэл ажлыг хангах асуудлыг шийдвэр гаргасан байж байгаа. Энэ утгаараа бол 1994 онд энийг бичиг болгох уу, үгүй юу гэдэг асуудал дахин шийдвэрлэгдэх ёстой. Бэлтгэл хангагдаж уу үгүй юу гэдэг асуудлаа авч үзээд, тэгээд энэ асуудлаа шийднэ. Түүнээс гадна Үндсэн хуульд энийг заавал тунхаглан зарлах ийм асуудал шаардлагатай юм биш байна гэж тухайлбал Бага Хурал дээрээс үзсэн хэрэг. За эрхэм депутатууд юу гэж үзэж асуудал тавих нь энэ манай Ардын Их Хурлын хуралдааны маань асуудал байхаа.

Иргэний боловсрол шашнаас тусгаар байна гэдгийг тайлбарлана уу гэсэн. Иргэний боловсрол, шашны боловсролыг ялгаж хэлнэ үү гэсэн ийм асуудал байна. Зүгээр ер нь Их цааздаа бол хуучин Үндсэн хуулиас зарчмын ялгаатай асуудал нь бол төр, шашин тусгаар байна гэсэн энэнээс бол зарчмын үндсэн өөрчлөлт орсон нь төр, сүм хийд тусгаар байна гэдэг, шашны байгууллага төрийн байгууллага тус тусдаа байна, өөр өөрийнхөө мэдэх, өөр өөрийнхөө хэр хэмжээний асуудлыг өөр өөртөө шийднэ гэсэн ийм

хэлбэрээр оруулсан. Шашин гэдгийг ямар нэг үзэл бодлын тодорхой чиглэл, сүсэг бишрэлийн утгаар нь ярихад энийг бид төрөөс тусгаар байх тухай асуудал ярих юм бол үүнээс шалтгаалаад янз янзын үзэл бодол, үзэл суртал, намын үзэл бодол гэдэг юм уу юу гэдэг юм, олон зүйлийг төрөөс тусгаар байх тухай асуудлыг хольж хутгах асуудал бол, зарчмын асуудал энэ байгаа. Тэгээд шашны сургалтыг, шашны боловсролыг шашны сургалтаар, тэгэхээр иргэний боловсрол гэж юуг ойлгох вэ? Шашны боловсрол гэж юуг ойлгох вэ гэдэг асуудал дээр бол нарийн зүйлүүд бий. Энэнийг бишрэх бишрэлтэй нь холбож авч үзэж ярих тухай асуудалтай холбогдуулж, энэ боловсролыг авч үзэх үү гэж. Тэрнээс зүгээр одоо юу гэдэг юм, зан суртахууны хэм хэмжээ болохынх нь хувьд, танин мэдэхүйн тодорхой аргачлал болохынх нь хувьд, энэ боловсрол гэдэг утгаар нь ярихдаа бол бид энд бие биенээсээ маш олон тийшээ шилжих зүйлүүд бий. Энийг бол энд би ч ярих хэмжээний асуудал биш, зүрхлэх ч асуудал биш. Шаардлагатай бол бидэн дотор одоо депутат, сахил санваартан лам хүн ч байгаа. Эднээсээ тодруулж болно. Энэ асуудлаар судалдаг эрдэмтэд, философичид ч бий. Энэнийхээ хувьд бол. Үндсэн хууль дээрээ бол тодорхой тусгаж өгсөн зүйл нь энэ. Үндсэн хуулийн энэ асуудлуудад Үндсэн хуулийн тайлбар шаардлагатай харьцаа үүссэн тохиолдолд тайлбар өгч болох юм. Албан ёсны тайлбар өгдөг газруудаасаа. Хуулийн тайлбар өгөх шаардлагатай бол хуулийн тайлбараа өгч болох юм.

За дараа нь Үндсэн хуулиас бусад хуулийн биелэлтэд хаанаас хяналт тавих вэ? Прокурорын үүргээс авсан байна гэж ингэж байгаа юм. Ер нь энд өнөөдөр Үндсэн хуулийн энэ Монгол улсын Их цааз гэсэн төсөлд прокурорын тухай туссан, хуучин прокурорын тухай хуучин Үндсэн хуульд туссан байдлын талаарх ялгааны талаар асуудал яриа ч гэсэн асуудал байгаа. Энийг бол миний хариулж дууссаны дараа эрхэм гишүүн Цог энэн дээр товчхон хариулаад өгчих байх гэж бодож байгаа юм.

Сүүлд нэг асуудал гарахаар нь ярина. Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг нь илүү аппарат юм биш үү. Шүүх шүүгчдийн ахуй

ахуй хангамж, ажиллах боломжийг хангах газар гэж ойлгох нь зөв үү гэж. За энэ талаар сүүлд энэ шүүхийн зөвлөлийг байлгах эсэх тухай асуудал дээр ярилцахдаа энэ асуудал нэлээн тодорчих байх. Энд бол харлуулахын шаардлага байхгүй. Шүүхийн биеэ даасан байдлыг хангах үндсэн зорилгын үүднээс шүүхийн зөвлөлийг байгуулж байгаа юм. Шүүхийн биеэ даасан байдал гэдэгт юу юугаар нөлөөлж байж бие даасан байдал гэдэг нь хангагддаг юм, энэ байдлыг нь хангахын тулд шүүхийн зөвлөлийн чиг үүрэг яаж тодорхойлогдох вэ гэдэг нь тэндээсээ үүсэж гарч ирнэ. Тэгээд энэ Үндсэн хууль дээр байгаа чиг үүргүүд бүрэн хангагдаж байна уу үгүй байна уу гэдэг асуудлаар ярина. Эсвэл энэ шаардлагагүй гэвэл энэ бие даасан байдлыг нь хангаж чадах чиг үүргийг юу юу гүйцэтгэх вэ гэдэг дээрээ орлуулах асуудал нь энэ харьцаанд үүснэ. Тийм учраас сүүлд ярих асуудал.

Бүх шатны шүүгчдийн Ерөнхийлөгч томилохоор оржээ. Учир нь юу вэ гэж. За энэн дээр олон юм ярьж болох байх. Ер нь бол бид эрх мэдлийг хуваах зарчмын үндсэн дээр хууль тогтоох, гүйцэтгэх, шүүн таслах эрх мэдлийг харьцангуй бие даасан байдалтайгаар энийгээ гаргаж байгаа бөгөөд эдгээрийн хоорондын уялдаа, шүтэлцээг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал дээрээ авч үзэж байгаа бөгөөд үүндээ тухайлбал, шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үндсэн нэг дээд байгууллага, Дээд шүүх, түүний гишүүдийг парламентаас, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа тэр газраас нь хараат биш байлгах үүднээс харьцангуй хараат биш байгаа Ерөнхийлөгчөөр дамжиж сонгогдох энэ хувилбарыг сонгож авсан юм байгаа юм. Тэгээд энийг та бүхэн мэдэх асуудал.

-Ерөнхий прокурорыг Их Хурлаас сонгож байгаа. Энэ нь бол түүний чиг үүрэг, функцтэй холбоотой. Хууль тогтоох байгууллагаасаа энэ хүн сонгогдох учир зүйн шалтгаан нь илүү юм гэдэг ийм ялгаа бий, ийм байгаа. Нэлээн олон асуудлаар энэ цаашаагаа тодорно.

Улсын нийслэлийг Улаанбаатар гэж тодорхойлохгүйн учир,

за энийг би түрүүн хэлсэн.

Нэрээр нийслэлийг тодорхойлохгүй, агуулгаар нь тодорхойлно гээд, ингээд төрийн төв байгууллага оршин байгаа тэр суурин хотыг улсынх нь нийслэл гэж үзнэ. Улсын нийслэл гэдэг үг Улаанбаатар гэдгээсээ биш юу оршиж байгаа шалтгаанаасаа үүсдэг гэдэг агуулгыг Их цааздаа тусгаж өглөө шүү дээ.

Төслийн хоёрдугаар бүлгийн 19 дүгээр зүйлийн хоёрдугаар заалтыг тайлбарлаж өгнө үү? 19-ийн хоёр, дайны болон онц байдал зарласан Их Хурал Их цаазын журмыг урвуулан ашигласан үед Их цааз, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Ийнхүү хязгаарласан хууль нь хувь хүн нэгжгээд тохиолдлыг үл хамаарна гэж. За би зүгээр товч санаагийг нь хэлье. Энэ дайны болон онц байдал зарласан, зарлах асуудал нь бол энэ Үндсэн хуульд олгосон иргэний үндсэн эрх, эрх чөлөөг зайлшгүй шалтгааны үүднээс хязгаарлах байдалд үүссэн тэр агуулгаараа өөрөө энэ одоо тодорхойлогдож байгаа юм. Ингэж тодорхойлохдоо энийг заавал хуульд урьдчилан заасан байсан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл онц байдлыг тогтоох дэглэмийн тухай хууль юм уу, дайны байдал тогтоох тухай хууль тогтоомжид ийм зарласан үед хүний эрхийг ийм ийм хэмжээгээр хязгаарлаж болно гэдгийг хуулиар тогтоосон байх ёстой. Ингэж хуулиар тогтоосон байж чадаж байж, чухамхүү түүний хязгаарласан хувь хүн нэгжгээдэд зориулагдсан байхгүй байхын баталгаа үүснэ. Энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр зэрэг ер нь хуулийн зарчим бол аливаа нэг хүнд, аливаа нэг нэгжгээдэд асуудал зориулагдсан биш, түгээмэл утгаараа зохицуулагдсан байх хэрэгтэй. Дорж гэдэг хүний эрхийг хязгаарлах асуудал дээр нь зохицуулж тэр хууль байж болохгүй.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Мунда

ЭНХТУЯА

Бичээч Т.Уранчимэг

Р.Гончигдорж /56 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын дарга/ -Тийм учраас урьдаас хуулиар заагдсан тийм хэм хэмжээг энэ эрх зохицуулагдах ёстой л гэж. Ийм зөвхөн тухайн нөхцөл байдалд үүссэнээс шалтгааны нь дотроос нь авч үзээд, тэрэнд тохируулаад хязгаарлалтыг хийж болохгүй. Өмнө нь хуульд заагдсан байх ёстой. Тийм л хэмжээгээр байх ёстой. Хуулиа тогтоохдоо харин байж болох түгээмэл шинж чанартай бүх асуудлуудыг авч үзэж чадсанаараа зайлшгүй хязгаарлагдах эрхийн хэмжээнүүдийг энэ хуулиндаа тусгаж чадсан байх ёстой. Тийм л чадварлаг тухайлбал онц байдлыг тогтоох дэглэмийн тухай хуулийг гаргасан байх учиртай гэсэн ийм утга санааг илэрхийлж байгаа юм. Тэгэхгүй бол өнөөдөр жишээлбэл, Дэд ерөнхийлөгчид дуртай үед нь үг хэлүүлж болох уу үгүй юу гэдэг асуудал ярилаа гэхэд энд бол ерөөсөө л хуулинд Дэд ерөнхийлөгч тэгэх тухай асуудал тусгаж байгаа утгаараа авч үзэх ёстой бөгөөд, эндээ бол Дэд ерөнхийлөгч өнөөдөр Гончигдорж байгаагийнх нь хувьд авч үзэж болохгүй л гэсэн үг байхгүй юу даа. Нэгжгээдэд гэдгийг нь зориулсан байдлаар авч үзэж болохгүй гэдэг ийм л утга санааг илэрхийлж байгаа юм.

За дараачаар нь, төслийн 63 дугаар зүйлийн хоёрт заасан иргэдийн төлөөлөгчдийн хурал, одоогийн Ардын Их Хурлаас ямар ялгаатай вэ гэж байна, энийг түрүүн хэлсэн тиймээ. Нэг нь төрийн үүрэг функцийг, төрийн удирдлагыг хэрэгжүүлж байсан. Нэг нь өөрөө удирдах ёсны удирдлагыг хэрэгжүүлж байгаа.

За дараачаар нь, за ингээд болсон байна. Энэ бол Банзрагч гуайн асуудал байж, Банзрагч гуай, Норжин гуай хоёр, 121, 122 дугаар тойргийн депутатуудын. БНМАУ-ын Үндсэн хуулийн нэрнээс аваад зарчмын гол гол асуудлаар ард түмний саналыг харгалзахгүйгээр харьцангуйгаар харгалзахгүйгээр хуулийн төслийн талаар Улсын Бага Хурлаас гаргасан шийдвэр асуудал хэлэлцэхэд ямараар нөлөөлж байна гэж дүгнэж байна вэ? Асуудлыг хэлэлцэхдээ ард түмнийхээ үзэл бодол, саналыг гол үндэслэл болгох уу? Харин Чимид, Зардыхан депутатын Их цааз, Монгол улс, Тэнгисболдын

сүлд шонхор шувууны талаарх хувь хүмүүсийн санал нь ард түмний ихэнхийн санаа сэтгэлд нийцэхгүй байгааг үндэс болгон хэлэлцэх үү, энэ талаар хариулт өгнө үү гэж. За 346 дугаар тойргийн депутат Намсрайжав гуай асуусан байна. Улсын Бага Хурлаас оруулсан төсөл гэдэг бол тухайн нэг хүний санаа бодол биш, энэ бол Улсын Бага Хурлын дийлэнх олонхиороо шийдвэрлэж, та бүхэндээ өргөн барьж байгаа төсөл. Хэрэв би тэр гишүүн энийг хариулна гэдэг утгаар энийг энэ гишүүн оруулсан юмаа гэж ядууруулан ойлгогдож байгаа бол би өөр аргачлалаар ярьж байна. Энэ бол энэ асуудлын талаар хариулт өгөхөд, надаас асуусан асуултыг би хариулахынхаа хувьд, хариулах эрхээ шилжүүлж байгаа утгаар нь ойлгоорой. Тэрнээс биш энэ улсууд гаргаж байгаа юм биш. Энэ улсууд ч гэсэн Үндсэн хуулийнхаа энэ төсөлд оруулж байгаа зарим юмтай сэтгэл нь нийцэхгүй л байгаа. Ийм л юм байгаа юм. Тийм учраас ингэж хувьчилдаг нь, асуудлыг хувьчилдаг нь зохимжтой биш. Мөн Тэнгисболдын хувьд ч ялгаа байхгүй. Энэ уран бүтээлч өөрийнхөө боловсруулсан төслийг танилцуулж, Улсын Бага Хуралд олонхийн саналаар энэ төслийг Их Хуралдаа өргөн барья гэсэн ийм л юм байгаа юм. Харин уран бүтээлчийнхээ хувьд, авторынх нь хувьд энэ хүнийг зайлшгүй сонсоно биз. Энийг зохион байгуулж байгаа гэж та бүхэндээ хэлсэн шүү дээ. Ер нь ард түмнийхээ олонхийн саналыг авсангүй гэж, ийм асуудал ярьж байгаа юм. Энийг би хоёр томъёоллоор нарийвчилж томъёолохыг хүсэж байгаа юм.

Ард нийтээр хэлэлцүүлэх энэ үед ирсэн саналууд дотроос олонхи нь байсан саналыг тусгаагүй тухай асуудал, ард түмний олонхийн саналыг тусгаагүй гэдэг асуудал хоёр бол хоёулаа өөр зүйл. Ард түмний олонхийн саналд юу байгаа гэдэг асуудлаар бид ярих гэж байгаа гэвэл, ард түмнийхээ дунд санал асуулга явуулаад, тэр санал асуулгынхаа дүнгээр бол бид ард түмний олонхи нь тийм байна, ард түмний цөөнх нь тийм байна гэдэг дүгнэлтийг бүрэн хэлнэ. Зүгээр ард түмнээсээ ирүүлсэн санал, ард түмний дотроос иргэдийн ирсэн саналууд ард түмнийг хэрхэн төлөөлөх вэ гэдэг асуудал, тэр санаа нийтэд байгаа саналыг хэрхэн төлөөлөх вэ гэдэг асуудлаараа бол ямар нэг арга зүйн үүднээс

лалын статусаар авах нь вэ дээ гэдэг нь бараг л нүдэнд тусах гээд л байгаа юм.

4.

МОНГОЛ нэр томъёонхоо хувьд агуулгаа хэрхэн тусгаж байгаа вэ гэдэг дээр нь бүгдээрээ ярилцъя. Тэрнээс биш хэн гаргаснаар нь зөв гэж үзэх, хэн гаргаснаар нь буруу гэж үзэх талаар нь, ерөөсөө ийм хажуугийн хүчин зүйлийг аль болохоор оруулахгүй байхыг хичээцгээе. Аль болохоор оруулахгүй бодоцгоохыг бодъё.

Хоёр их хөрштэй хилийн маргаан бий юу? Байгаа бол яаж нийдэх вэ? Энэ бол ярих асуудал биш. Ер нь манай хэвлэл мэдээллийн төлөөлөгчид ингээд ярихад зарим асуудлууд бид Их Хурлынхаа депутатуудын энэ бүрэн бүрэлдэхүүн дотор ярьж байна. Тухайлбал, бид нар өчигдөр та бүхэндээ тэр мөнгө төгрөг гарах, тэр сүлд, тэмдэг, далбаа солигдсоноор гарах тухай асуудал дээр манай Бага Хурлын гишүүн Товуусүрэн тодорхой мэдээллүүд хийсэн. Энэ мэдээллүүдийн заримыг нь заавал одоо олон нийтэд сонсгох чиг хандлагатай тийм мэдээллүүд биш шүү дээ. Тийм учраас зарим үед энэ талаар бид ард түмнээс хаагдмал байх утгаараа биш, улс орныхоо үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, гадаад бодлогын чиг хандлага, энэнтэйгээ үндэслээд хийх дүгнэлтүүдийн талаар бас бодох зүйлүүд бий шүү.

Хөдөө аж ахуйд хоршооллын өмч байхыг хуульчлан батлахаас Улсын Бага Хурал татгалзаад байдгийн учир юу вэ? Энэ асуулыг би үнэндээ ойлгохгүй байна. Хоршооллын өмч байхыг гэж. Одоо аж ахуйн нэгжийн хуулиар бол аж ахуйн нэгжүүдийг бид ямар ямар байх вэ гэдгийг нь тодорхойлсон. Өмчийнхөө хэлбэрээр бол хувийн өмч, нийтийн өмч, холимог өмч гээд тодорхойлчихсон. Энэнээс огт гадагшаа гарахгүй шүү дээ. Харин аж ахуйн нэгжийн хуулийг гаргаад хоршооллын өмчийг хүчингүй болгосон, хоршооллын хуулийг хүчингүй болгосон, энэ хуулийг яагаад хүчингүй болгочихов, энэ чинь аж ахуйн нэгжээр зохицуулагдахгүй хууль байх ёстой гэдэг юм уу, эсвэл аж ахуйн нэгж дотор гээд тусгай статустай хоршоолол гэж нэг аж ахуйн нэгж байх ёстой гэдэг асуудал тавьж байгаа бол өөр хэрэг. Тэр утгаараа тэр дотроо бид нар энэ хоршоог бол ойлгож, дотор нь багтааж ойлгож байгаа. Энд бол татгалзсан зүйл байхгүй. Өмчийн хэлбэрийн нь хувьд ч гэсэн дундын өмчийн хоёр хэлбэрийн тухай Иргэний хууль дээр

сүлд шонхор шувууны талаарх хувь хүмүүсийн санал нь ард түмний ихэнхийн санаа сэтгэлд нийцэхгүй байгааг үндэс болгон хэлэлцэх үү, энэ талаар хариулт өгнө үү гэж. За 346 дугаар тойргийн депутат Намсрайжав гуай асуусан байна. Улсын Бага Хурлаас оруулсан төсөл гэдэг бол тухайн нэг хүний санаа бодол биш, энэ бол Улсын Бага Хурлын дийлэнх олонхиороо шийдвэрлэж, та бүхэндээ өргөн барьж байгаа төсөл. Хэрэв би тэр гишүүн энийг хариулна гэдэг утгаар энийг энэ гишүүн оруулсан юмаа гэж ядууруулан ойлгогдож байгаа бол би өөр аргачлалаар ярьж байна. Энэ бол энэ асуудлын талаар хариулт өгөхөд, надаас асуусан асуултыг би хариулахынхаа хувьд, хариулах эрхээ шилжүүлж байгаа утгаар нь ойлгоорой. Тэрнээс биш энэ улсууд гаргаж байгаа юм биш. Энэ улсууд ч гэсэн Үндсэн хуулийнхаа энэ төсөлд оруулж байгаа зарим юмтай сэтгэл нь нийцэхгүй л байгаа. Ийм л юм байгаа юм. Тийм учраас ингэж хувьчилдаг нь, асуудлыг хувьчилдаг нь зохимжтой биш. Мөн Тэнгисболдын хувьд ч ялгаа байхгүй. Энэ уран бүтээлч еерийнхөө боловсруулсан төслийг танилцуулж, Улсын Бага Хуралд олонхийн саналаар энэ төслийг Их Хуралдаа өргөн барья гэсэн ийм л юм байгаа юм. Харин уран бүтээлчийнхээ хувьд, авторынх нь хувьд энэ хүнийг зайлшгүй сонсоно биз. Энийг зохион байгуулж байгаа гэж та бүхэндээ хэлсэн шүү дээ. Ер нь ард түмнийхээ олонхийн саналыг авсангүй гэж, ийм асуудал ярьж байгаа юм. Энийг би хоёр томъёоллоор нарийвчилж томъёолохыг хүсэж байгаа юм.

Ард нийтээр хэлэлцүүлэх энэ үед ирсэн саналууд дотроос олонхи нь байсан саналыг тусгаагүй тухай асуудал, ард түмний олонхийн саналыг тусгаагүй гэдэг асуудал хоёр бол хоёулаа өөр зүйл. Ард түмний олонхийн саналд юу байгаа гэдэг асуудлаар бид ярих гэж байгаа гэвэл, ард түмнийхээ дунд санал асуулга явуулаад, тэр санал асуулгынхаа дүнгээр бол бид ард түмний олонхи нь тийм байна, ард түмний цөөнх нь тийм байна гэдэг дүгнэлтийг бүрэн хэлнэ. Зүгээр ард түмнээсээ ирүүлсэн санал, ард түмний дотроос иргэдийн ирсэн саналууд ард түмнийг хэрхэн төлөөлөх вэ гэдэг асуудал, тэр санаа нийтэд байгаа саналыг хэрхэн төлөөлөх вэ гэдэг асуудлаараа бол ямар нэг арга зүйн үүднээс

МОНГОЛ НЭР ТӨМБӨНЬХОО ХУВЬД АГУУЛГАА ХЭРХЭН ТУСГАЖ БАЙГАА ВЭ ГЭДЭГ ДЭЭР НЬ БҮГДЭЭРЭЭ ЯРИЛЦЬЯ. ТЭРНЭЭС БИШ ХЭН ГАРГАСНААР НЬ ЗӨВ ГЭЖ ҮЗЭХ, ХЭН ГАРГАСНААР НЬ БУРУУ ГЭЖ ҮЗЭХ ТАЛААР НЬ, ЕРӨӨСӨӨ ИЙМ ХАЖУУГИЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙГ АЛЬ БОЛОХООР ОРУУЛАХГҮЙ БАЙХЫГ ХИЧЭЭЦГЭЭ. АЛЬ БОЛОХООР ОРУУЛАХГҮЙ БОДОЦГООХЫГ БОДЪЁ.

Хоёр их хөрштэй хилийн маргаан бий юу? Байгаа бол яаж шийдэх вэ? Энэ бол ярих асуудал биш. Ер нь манай хэвлэл мэдээллийн төлөөлөгчид ингээд ярихад зарим асуудлууд бид Их Хурлынхаа депутатуудын энэ бүрэн бүрэлдэхүүн дотор ярьж байна. Тухайлбал, бид нар өчигдөр та бүхэндээ тэр мөнгө төгрөг гарах, тэр сүлд, тэмдэг, далбаа солигдсоноор гарах тухай асуудал дээр манай Бага Хурлын гишүүн Товуусүрэн тодорхой мэдээллүүд хийсэн. Энэ мэдээллүүдийн заримыг нь заавал одоо олон нийгэд сонгох чиг хандлагатай тийм мэдээллүүд биш шүү дээ. Тийм учраас зарим үед энэ талаар бид ард түмнээс хаагдмал байх утгаараа биш, улс орныхоо үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, гадаад бодлогын чиг хандлага, энэнтэйгээ үндэслээд хийх дүгнэлтүүдийн талаар бас бодох зүйлүүд бий шүү.

Хөдөө аж ахуйд хоршооллын өмч байхыг хуульчлан батлахаас Улсын Бага Хурал татгалзаад байдгийн учир юу вэ? Энэ асуулыг би үнэндээ ойлгохгүй байна. Хоршооллын өмч байхыг гэж. Одоо аж ахуйн нэгжийн хуулиар бол аж ахуйн нэгжүүдийг бид ямар ямар байх вэ гэдгийг нь тодорхойлсон. Өмчийнхөө хэлбэрээр бол хувийн өмч, нийтийн өмч, холимог өмчгээд тодорхойлчихсон. Энэнээс огт гадагшаа гарахгүй шүү дээ. Харин аж ахуйн нэгжийн хуулийг гаргаад хоршооллын өмчийг хүчингүй болгосон, хоршооллын хуулийг хүчингүй болгосон, энэ хуулийг яагаад хүчингүй болгочихов, энэ чинь аж ахуйн нэгжээр зохицуулагдахгүй хууль байх ёстой гэдэг юм уу, эсвэл аж ахуйн нэгж дотор гээд тусгай статустай хоршоолол гэж нэг аж ахуйн нэгж байх ёстой гэдэг асуудал тавьж байгаа бол өөр хэрэг. Тэр утгаараа тэр дотроо бид нар энэ хоршоог бол ойлгож, дотор нь багтааж ойлгож байгаа. Энд бол татгалзсан зүйл байхгүй. Өмчийн хэлбэрийн нь хувьд ч гэсэн дундын өмчийн хоёр хэлбэрийн тухай Иргэний хууль дээр

3.

дүгнэлт хийх ёстой. Энэ үүднээсээ бол зарим шүүмжлэлийг хүлээж авах ёстой. Зарим шүүмжлэл дээр тайлбараа хэлэх учиртай. Энийг бид хоёр янзын аргачлалаар авч үзэх ёстой шүү. Дээр нь социологийн судалгаа гэж байдаг. Социологийн судалгааг бид авч үзэхдээ, өөрөө социологийн судалгаа^{нь} зөв аргачлалаар явагдаж уу, үгүй юу гэдэг талынх нь асуудлаас түүний боловсруулалт нь зөв боловсруулалтаар явагдаж уу, буруу боловсруулалтаар явагдаж уу гэдэг ийм ч утгаар нь авч үзэх ёстой бөгөөд, тэгээд төрийн байгууллага, еерийнхөө албан ёсоор итгэмжлэгдэн явуулсан социологийн судалгааны асуудал гэж бас дотор нь хоёр хуваах ёстой. Ийм хэдэн зүйлээр бид энд хоорондоо бие биенийхээ дуулгавартай, дуулгаваргүйн тухай асуудлыг авч үзэх ёстой, шүүмжлэх ёстой.

Манай улсаас хэдэн хүн цагаачилж гараад байна вэ, цаашид энэ хандлага ямар төлөвтэй байна вэ гэдэг ийм асуудал байна. Манай улсаас гадаадад амьдарч байгаа улсуудад цагаачлалын статус өгсөн улсууд нэг их олон биш байх. Би энийг мэдэхгүй байна. Одоо цагаачлалын статус өглөө гээд ингээд гаргаж байгаа. Энэ асуудлуудыг шаардлагатай гэвэл, эсвэл Ерөнхийлөгчийн Тамгын газрын зөвлөхүүдээр, эсвэл Гадаад харилцааны яамны улсуудаар чухам тэр асуудлуудыг хэлэлцэж байх үед зайлшгүй мэдээлэл хэрэгтэй бол урьдчилан энэ асуудлуудыг зохион байгуулж болно. Гэхдээ тухайлбал, та бүхэн үзсэн. АНУ цагаачдыг ямар шинж чанаруудаар, ямар бодлогоор авах вэ гэдэг талаар баримталж байгаа бодлогыг нь аваад үз л дээ. Ямар тивээс авах вэ хамгийн олныг, ямар мэргэжлийн чиглэлээс авах вэ гэдгийг тов тодорхой хэлсэн байгаа шүү дээ. Тэр үүднээс аваад үзэх юм бол одоо манайхаас очсон улсуудыг хэр зэрэг олныг цагаачлалын статусаар авах нь вэ дээ гэдэг нь бараг л нүдэнд тусах гээд л байгаа юм.

Цааз, цэц, засаг дарга гэх мэтийн нэр томъёог, үгийг ямар мэргэжлийн хүмүүс гаргав, танд эдгээр уг хэр зэрэг сонсогдож байна вэ? Энэ хэн гаргаж ирсэн нь огт ач холбогдолгүй бөгөөд харин зүгээр энэ маань хэр зэрэг тохирч байна вэ, агуулгаа уг нь илэрхийлж байгаа байдал, үгийнхээ түүхэн уламжлал юм уу

оруулчихсан. Хамтран өмчлөх дундын өмч, хэсгээр өмчлөх дундын өмч гээд. Ерөөсөө энд үүсч байгаа бүх харьцаануудын зохицуулалт бол зохицуулагдах, зохицуулагдах ёсоороо хэвээрээ үлдсэн байж л байгаа.

315 дугаар тойргийн депутат Бат-Эрдэнэ гуай асуусан байна. Их цаазын 17 дугаар зүйлийн долоод заасан 10 жилийн боловсрол олж авсны дараа их, дээд сургуулийг үнэ төлбөртэй суралцах нь ээ. Аав ээж нь хөрөнгө, мөнгөгүй бол, хүүхэд нь хичнээн ухаантай, авьяастай байсан ч их, дээд сургуульд орж чадахгүй юм байна. Энэ тухай тодорхой хариулт өгнө үү гэж. Их, дээд сургууль зөвхөн үнэ төлбөртэй суралцуулна гэсэн заалт л байхгүй байгааг анзаараарай. Нэг юм чинь олон хувилбартай шүү дээ. Энийг огт болохгүй, "А"-г огт болохгүй гэж болно тиймээ, "А"-гийн тухай огт дуугараагүй байж болно, тиймээ. Огт болохгүй гэж үзэхгүй гэж болно. Юманд олон хувилбараар хэлдэг, энд бол төлбөртэй сургалтыг л албан ёсоор зөвшөөрсөн тухай байгаа шүү дээ. Сургалтыг төлбөртэй болоод төлбөргүй явуулж болно гэж. Тэгэхээр зэрэг энэ чинь заавал төлбөртэй гэсэн үг биш. Төлбөргүй, төрөөс дээд боловсролыг төлбөргүй олгох ийм хувилбарууд байсаар байх болно.

Ерөнхий боловсролын хувьд ч гэсэн... за больё. Энэн дээр арай хэтэрхий дэлгэрүүлэх гэж байна. Энд бол ганцхан би эрхэм депутатуудад сүүлд нь хэлнэ. Энэ Их цааз дээр редакцийн хувьд зарим нэг засвар орох зүйл байгааг, тэрийг бас энэнийг гарахдаа алдсан зүйл бий. Тэрийг би та бүхэндээ хэлнэ.

Саяхан болсон нуглаанд оролцогчид бурхны шашныг төрийн албан ёсны шашин болгох, Их цаазад оруулж өгнө үү гэж хүссэн байсан. Энэ талаар ямар бодолтой байна вэ гэж. Эхлээд төрийн албан ёсны шашин гэж юуг ойлгож байгаа юм бэ гэдгийг ойлголцсоны дараачаар хэлэх хэрэгтэй. Төрөөс өнөөдөр аль ч шашныг бол энд хориглоогүй байгаа. Аль нэг шашныг онцгойлсон төрийн хамгаалалтад авах тухай асуудал биш. Ерөөсөө төр, шашны бай-

гууллага болох сүм хийдийг тусгаар байх тухай асуудлыг ярьсан байж байгаа. Тэгээд эрхэм депутатууд манай монголын нутаг дэвсгэр дээр хориглох шашин байх уу үгүй юу. Төрөөс онцгойлон авч үзэх ийм шашин байх уу үгүй юу гэдэг асуудал. Онцгойлон үзэх байдал нь юугаар илрэх вэ гэдэг энэ асуудлаа бол ярих л хэрэгтэй байх. Тэрнээс яг одоо төрийн албан ёсны гэдэг бол ойлгогдохгүй байна. Ямар статус өгөхөөр ийм болох вэ гэдэг асуудал.

Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг ямар аргаар хийх вэ? За энэ гарсан асуудал байна.

Сонгуулийн зарчмын асуудал яагаад тусгагдаагүй юм бэ гэж. Сонгуулийн Үндсэн хуульд байх хэм хэмжээний утгаар бол энд туссан гэж бодож байгаа. Сонгуулийн зарчим бол. Энээнээсээ үндэслээд, үүнтэйгээ нийцүүлээд сонгуулийн хуулиар бол бүх асуудлуудыг нарийвчлан тогтоох ёстой. Энэ хууль, шилжилтийн хууль хоёрт үндсэн зарчмууд нь тусчихсан байгаа. За энэ депутат Буяндэлгэр гуай асуусан, 188 дугаар тойргийн депутат.

За засаг захиргаа, нутгийн зохион байгуулалтыг өөрчлөх, Их цаазын төсөлд тусгахад одоогийн сумын хурал, захиргаанд ажиллаж байгаа хүмүүсийн саналыг судалж үзсэн үү? Та өөрөө хэлэхдээ эрдэм шинжилгээний ажилд байгааг дурдав гэж. Энэ эрдэм шинжилгээний байгууллага дурдав гэдэг маань эрдэм шинжилгээний байгууллагуудаас одоо юу гэдэг юм, энэ саналыг авсан мэтээр ойлгож болохгүй л дээ. Би юуг ярьсан бэ гэхээр өнөөдөр засаг захиргааны зохион байгуулалт, газар зохион байгуулалт, нутаг бүсийн зохион байгуулалт, цаашид монголын нутаг дэвсгэр дээр аж ахуй, үйлдвэрлэл, энэ л бүх асуудлуудыг монголын нутаг дэвсгэрийн хэмжээн дээр зохион байгуулж байх асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийж байгаа газруудын тухай ярьсан. Энэ судалгаанаас гарч байгаа эхний үр дүнгүүдийн талаар ярьсан. Зүгээр ингэж оруулах уу үгүй юу гэдэг асуудлаараа бол ер нь сумын хурал, захиргаа, одоо энд алба

7.

хааж байгаа улсуудын санал бодол бол байнга л сонсогдож байгаа шүү дээ. Орон нутагт Их Хурлын гишүүд, эрхэм депутатууд, Бага Хурлын гишүүд ч энд ярьж байгаа.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Д. Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.14
Кассет № 26
10.45-11.00

Ардын Их Хурлын 56 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдорж:

...олонхи ямар хандлагатай байна вэ гэдэг асуудлын талаар олонхи бол үүнийг хүлээж авч чадахгүй байгаа хандлага харагдаж л байна. Гэхдээ үүнийг бүрэн учир шалтгааных нь үүднээс бүрэн авч ойлгоод, өнөөдрийн шинэчлэлийн агуулга, удирдлага зохион байгуулалтын хоёлох ёсыг, өөрөө удирдах болон төрийн захиргааны хослох ёс, түүний хэрэгжих байдлыг аваад үзэхэд магадгүй эрхэм хүмүүсүүдийн бодол санаа үнэхээр бодитойгоор тусгагдаж гарч ирэх байх гэсэн ийм л найдлага байна. Эрхэм депутатуудын хувьд тавьж байгаа найдлагын хувьд ч тэр ялгаа байхгүй.

Үндсэн хуулийн талаар ард түмнээс авсан санал дээр хамгийн гол гэж хэлэхэд ямар ямар асуудал байсан бэ тэдгээрийг нэрээр хэлж, авч үзэж тусгана уу гээд энэ түрүүн илтгэл дээр маш тодорхой гарлаа. Илтгэл чухамхүү тэр талаар онцлон ярьсан. Энэ Осор гуайн хариултанд ийм байна. /125 дугаар тойргийн депутат Осор/

Хүний эрх, эрх чөлөө гэдэг II бүлэгт, хүний эрхийн түгээмэл тунхаг нь манай улс нэгдэн орсон бусад баримт бичигтэй зөрчилдсөн олон зүйл байна. Үүнийг Их цаазын 10 дугаар зүйлийн 4-т зааснаар дагаж мөрдөхгүй гэж ойлгох уу? эсвэл хавсралт хуулийн 7 дугаар зүйлийн 1-ээс 3-аар шийдвэрлэх үү? үүний ялгааг хэлж өгнө үү гэж.

Их цаазын төсөлд хүний эрхийн түгээмэл тунхаглал, манай улс нэгдэн орсон энэ үндсэн зүйлүүд бол тусгагдсан гэж үзэж байгаа бөгөөд /бүрэн нийцэж тусгагдсан гэж үзэж байгаа бөгөөд/ энэ талаараа бол мөн зохих байгууллагуудын экспертүүд тийм үнэлгээг өгсөн. Түүнд нь бид найдаж байгаа. Хэрэв эрхэм депутат яг тэр хууль чинь зөрчжээ гээд хэлбэл, түүнийг хариулахад бэлэн байна.

Тухайлбал, чөлөөт хэвлэл мэдээлэл дээр, тухайлбал Бодлын солбилцол дээр эрхэм эрдэмтэн болох гэж байгаа хуульч Орхоны "иргэн бүр тийм тийм зүйлийг харгалзахгүй, эрх тэгш" гэсэн заалт нь 30 нас хүрч байж, Их Хурлын гишүүнд сонгогдоно гэсэнтэй бол эрс зөрчилдөж байна гэж байгаа шиг ойлгож байгаа бол, энэ бол байж болохгүй зүйл. Энэ бол огт зөрчилдөж байгаа зүйл биш. Энэ бол хүний субъектив эрх, түүн дээр холбогдсоод үүсч байгаа бусад эрх хэмжээний зохицуулалтын асуудал, үүнийг бид ялгах ёстой, хууль тогтоохынхоо хувьд. Бид энэ болгоныг ялгаж чухамхүү авч үзэх ёстой. Тэгэхгүй гэж үзэх юм бол нэг настай хүн иргэн адилхан. Тэгвэл нэг настай хүнийг Их Хурлын депутат, гишүүнээр сонгох тухай асуудал тавих ёстой болж таарч байна уу гэдэг асуулт гарч ирнэ шүү дээ, эцсийн эцэст.

Дараагаар нь Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, шүүгч зэрэг олон сонгуультай насны хязгаар, хүний эрхийн хязгаарласан эрх гэж үзэх үү? Яг энэ дээр гарч байна. Энэ бол тэрүүнд огт зөрчилдөж байгаа зүйл биш.

Ардын Их Хурлын 146 дугаар тойргийн депутат Мөнхбат гуай асуусан байна. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлсний дүнд хуулийн нэр, улсын нэр, сүлд, тамгыг хэвээр байлгах ... энэ давхардаж байна.

Ерөнхийлөгчөөс Засгийн газрын Ерөнхий сайдыг томилох, Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах асуудал хуулийн төсөлд оржээ. Толилуулахаас өөр үүрэггүй Ерөнхийлөгч байж болохгүй санагдаад байгаа юм. Төрийн тэргүүн улсын Ерөнхийлөгчөө Засгийн газарт яаж нөлөөлөх, чиглүүлэх, зохицуулах талаар хуульд яагаад тусгаагүй юм бэ? Тодруулж өгнө үү гэсэн байна.

Хуульд энэ бүх эрх хэмжээнүүд бол тусгагдсан байгаа. Гэхдээ энэ Ерөнхийлөгчийн онцгойлсон эрх мэдэлд байгаа зүйлүүдийг багаджээ, ихэджээ гэдэг дээр санал байгаа бол тэр тухайгаа ярина. Энэ хуулинд одоо энэ эрх хэмжээнүүд, Ерөнхийлөгч маань

харьцангуй гүйцэтгэх эрх мэдэлд оролцох оролцолгооныхоо шинж чанараар бол тэнд олгогдсон Ерөнхийлөгчид олгогдсон, онцгойлон олгогдсон эрх хэмжээ нь тодорхойлогдож байгаа шүүдээ. Нэг хэсэг нь бол төрийн тэргүүн, эв нэгдлийн баталгаа, бэлгэ тэмдэг болохынхоо хувьд оногдож байгаа ийм онцгойлсон эрх мэдлүүд байж байгаа. Энэ хэмжээнээсээ бол авагдана. Тэгээд хэрэв Ерөнхийлөгч маань Засгийн газраа бүрэлдүүлээд эхлэх юм бол энэ маань өөрөө, өөр төрийн удирдлагын хэлбэр болоод явчихна шүү дээ. Тийм учраас парламентынхаа удирдлагын хэлбэрийг бид нар төрийн удирдлагын парламентын хэлбэрийг аваад үзвэл, энд ийм л хэмжээнд авч үзсэн юм.

Засгийн газартай харьцах харилцааны тухай энд асуудлууд нэлээн байгаа. Шүүхийн үндсэн тогтолцоонд цэргийн шүүх байх асуудал, төслийг хэлэлцэх явцад яригдсан уу гэж. Үндсэн хуулийн хэмжээнд байх ёстойгоороо орсон шүү дээ. Шүүхийг ямар зарчмаар байгуулах вэ? Шүүхийг ямар зөвшөөрлөөр байгуулах вэ? Энд орчихсон байгаа. Яг цэргийн шүүх гэсэн шүүх байгуулах тухай асуудал гээд ярих юм бол дараагийн шүүхийн байгууламжийн тухай хуулийнхаа хүрээнд үүнийг нарийвчлан зохицуулах асуудал шүү дээ. Шүүхийн байгууламжийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг явуулах явцад бол цэргийн шүүхийн коллеги байх тухай асуудал дээр яригдсан зүйл бий. Анхны хэмжээнд олонхийн байдлаар шаардлагагүй юм уу гэсэн ийм байдалтайгаар гарсныг яг ийм шийдвэр гарсан шиг авч үзээд өнөөдөр манай цэргийн шүүх, прокурорын байгууллага, албан тушаалтнуудаас эмзэглэж байгаа, үүнийг бид харилцан ойлголцох ёстой, эцсийн шийдвэр гараагүй, асуудлуудыг бид судалж үзэж, цаанид авч үзэж байгаа асуудал.

Одоогийн ядуурсан эдийн засагт, сүлд, соёмбо, улсын нэр зэргийг өөрчилсөн ий ач холбогдлыг... энэ түрүүн ярьчихсан. Одоо шийдвэрлэгдээгүй эрдэм шинжилгээний хэмжээнд байгаа асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд, Үндсэн хуулиндаа урьдчилан оруулаад байгаа нь ямар учиртай юм бэ гэж байна.

Ингээд нэг тайлбар, нэг буруу ойлголтууд өгөөд байдаг болохоор үнэхээр тайлбарыг маш хязгаарлагдмал байх нь зүйтэй юм байна л даа.

Үндсэн хууль гэдэг маань манай дээд хууль. Энэ дээд хууль маань гүйцэтгэх үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийн тулд, энэ хуулиа хэрэгжүүлэхийн тулд, энэ хуулийг бусад хуулиар дамжуулаад хэрэгжүүлэхийн тулд энд гүйцэтгэх үйл ажиллагаа явуулахын тулд энд бэлтгэсэн байдлууд ямар байна вэ? гэдэг асуудлынхаа хүрээнд л үүнийг ойлгож, учир зүйгээ ойлговол зүйтэй мэт санагдаж байгаа юм. Энэ дээд хууль маань нэг талаас хуулийн баримт бичиг, нөгөө талаас бол улс төрийн дээд баримт бичиг шүү дээ.

Их цаазын төслийг ямар учраас 9 жилээр томилох болсон юм бэ? шалтгааныг хэлнэ үү, ер нь Их цаазын төсөл байх нь зүйтэй юу гэжээ.

Энэ асуудал дээр зүйтэй, үгүйгийн талын асуудлыг бид бол ярилцах өөрсдөө 9 жилийн асуудлын хувьд ч энэ бол ярих зүйл. Энэ бол харьцангуй удаан хугацаанд, энд нэг зүй тогтол байгаа шүү дээ. 3 жил тутамд дарга нь солигдоод явна, энд бас хаягдсан зүйл байгаа. Энэ дээр энэ 3 хүнийг Их Хурлаар томилно, 3-ыг Ерөнхийлөгчөөс, 3-ыг нь Их Хурлаас, 3-ыг нь Дээд шүүхээс Их Хуралд санал болгож оруулж ирэх учиртай. Тэр санал болгосон субъектыг энд орхигдуулаад бичсэн тал байгаа. Түүнийг эрхэм депутатуудын оюунд толилуулья.

Тэгээд энд хугацааны талаар та бүхэн саналаа илэрхийлэх зүйл. Энэ Дхагвасүрэн гуайн асуулт байгаа юм.

Орон нутгийн өөрөө удирдах нэгжийг зохион байгуулалтанд шилжихэд манай улсад хэдэн аймаг, хошуутай байх вэ? Үүнийг ярихгүй гэсэн.

Энэ хуулин дотроо олон янзаар нэрлээд байна, үүнийг хэлээч гэсэн байна. Монгол улс гэж нэр ярих юм, Бүрэн эрхт тусгаар тогтносон бүгд найрамдах улс гэж нэг хэлэх юм, Парламентын бүгд найрамдах улс гэж нэрлэх юм гэж. Энэ маань бид бол Монгол улс гэж нэрлээд эндээ төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Бүгд найрамдах улс, мөн төрийн удирдлагын нарийвчилсан хэлбэрийн хувьд Парламентын улс гэдгээр газар, газар тодотгох, тодотгох газарт нь оруулаад явж байгаа шүү дээ. Энэ болгоныгоо заавал яг нэрлэх нэрэн дотроо бүгд найрамдах гэдгийг тусгах албагүй байдгийг дэлхийн бусад улсуудын практик харуулж байна. Бүгд Бүгд найрамдах улсууд, улсынх нь нэр нь бол заавал Бүгд найрамдах гэдгээ өөртөө оруулдаггүй байх жишээтэй, ийм л байх юм. Тийм учраас энэ ийм олон янзаар нэрлэж байгаа юм биш.

Ерөнхийлөгчөөс асуусан байна. Таны тавьсан илтгэлийг комиссын илтгэл санал гэх үү, эсвэл төрийн тэргүүн, Ерөнхийлөгчийн илтгэл гэж ойлгох уу? гэж. Бид нар Бага Хурлын тогтоол дээр тодорхой байгаа шүү дээ. Ингээд Бага Хурлаас, Үндсэн хуулийн комиссоос боловсруулж... Бага Хурлаас байгуулагдсан Үндсэн хуулийг боловсруулах ажлыг зохион байгуулах комисс, Бага Хурлаас олгосон эрхийн дагуу ард нийтээр хэлэлцүүлээд зохих засварыг оруулаад Бага Хурлаараа хэлэлцүүлээд, Бага Хурлаас өргөн барих төсөл болж хувираад энэ төслийнхөө тухай илтгэлийг Бага Хурлаас Ерөнхийлөгчөөрөө илтгэх нь зүйтэй гэж үзээд, Ерөнхийлөгчөө илтгэгчээр нь томоон томилсон байгаа шүү дээ. Үүнийхээ хувьд манай Ерөнхийлөгч илтгэл тавьсан.

Энэ улсын нэр, хуулийн нэр, төрийн сүлд, засаглалын хэлбэрээр, нийт ард түмний санал авах, ард түмний асуулга гэх гэсэн байх л даа. Санал асуулга авах ава бололцоо байсангүй юу гэж байна. Санал асуулга гэдэг маань том хэмжээний сонгууль шүү дээ. Маш том хэмжээний сонгууль. Ийм учраас үнэндээ манай өнөөдрийн явцад ингэж том хэмжээний сонгууль явуулах ийм боломж, энэ цаг хугацаанд үнэндээ байсангүй. Тэгээд ч бас хууль тогтоох практикийнхаа явцаар бид Их Хурлаараа тогтоочиход энэ бол чадвартай болов уу гэсэн ийм бодолтой байсан юм.

89 дүгээр тойргийн депутат Цүрэвгял гуайн тавьсан асуулт давхардаж байна.

1995 оны дотор багтаан аймаг, хошуудын газар зохион байгуулалтын асуудал хийгдэх юм шиг байна гэж байна.Энэ хийгдэх хүч, хөрөнгө, бололцоо байна уу? гэсэн байна.Энэ бол үнэхээр санаа зовоож байгаа асуудлуудын нэг мөн л дөө.Энэ зохион байгуулалтыг хийх, 1995-97 онд хэрэгжүүлэх асуудлууд дээр. Тэгэхдээ бас ирээдүй, алс руугаа харж, харьцангуй итгэлтэйгээр Үндсэн хуулиараа зорилт болгож тавиад, үүнийхээ хүрээнд бол төрийн дээд удирдлага, гүйцэтгэх байгууллагууд үүнийг зохион байгуулах ажилдаа орох шаардлагатай байна гэж бодож байгаа юм.

Илтгэлд, улсын яам, төрийн бусад албан газрыг хууль гаргаж байгуулах юм шиг байна.Үүнийг юу гэж ойлгох вэ гэсэн байна. Ерөөсөө улсын яамыг бол хууль гаргаж байгаа шүү дээ.Өнгөрсөн жил Улсын Бага Хурал, Засгийн газрын бүтцийн тухай хууль гаргасан.Тэр хуулийнхаа дагуу яамуудыг Засгийн газрын бүтцийг тодорхойлсон.Дараагаар нь бүтцийнхээ дагуу бүрэлдэхүүнийг нь Улсын Бага Хурлаас томилсон байгаа.Энд төрийн бусад албан газар гэж байгаа.Энд бол төрийн төв байгууллагууд, яам, төрийн төв байгууллагуудыг бол хуулиар, энд ийм асуудал гарсан юм л даа.Ер нь аливаа байгууллага, эхлээд дүрэм нь байж байж, дүрмийнхээ дагуу байгуулагдах ёстой.Энэ үзэл баримтлалыг бид хэрэгжүүлэх ёстой юм.Тэгэхгүй ямар нэг байгууллага дүрэмгүй байгуулагдчихаад, өөрөө дүрмээ хийгээд, түүнийхээ дагуу өөртөө олон янзын эрх мэдлүүдийг аваад, ингээд явуулдаг харьцангуй завхруулах шинжтэй ийм байдлыг өнөөдөр бид цэгцлэх ёстой.

Аливаа төрийн байгууллага, энэ бол бид яам, яамтай зэрэгцсэн төрийн төв байгууллагуудаа ярьж байгаа юм.

Бусад нь бол дүрмийн дагуу байгуулагдах ёстой.Урьдчилаад дүрэм нь байх ёстой.Ийм л үзэл баримтлалыг энд ярьж байгаа юм шүү.Хэрэв нэмж тусгана гэх юм бол бусад байгууллага нь дүрмийн дагуу байгуулагдах ёстой гэж нэмж оруулах юм бол болохгүй гэх газаргүй юм.

7.

Энд хоёрхон асуудал байна дуусгачихъя. Энд түрүүн гарчихсан байна. Хошуу байгуулахыг нутаг дэвсгэрийн үйлдвэрлэл эдийн засгийн цогцолбор программтай холбожээ. Урьдчилсан төсөл байна уу? үгүй юу гэж. За баярлалаа.

Ж.Уртнасан: Дэгийн дагуу завсарлага 20 минут.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Д.ЧУЛУУНШЭЦЭГ

1991.XI.I4.
Кассет №(14)-27
II.20-II.35.

Ж.Уртнасан -Цаг 5 минутаар хэтэрч байна. Орж ирээд суудлаа эзлэхсэн хормоо барьж байгаа депутатуудад хэлэх үг биш, хожигдож байдаг хүмүүст хэлмээр байгаа юм.Бид бие, биенээ хүндэтгэж, дэгээ хүндэтгэж, цагаа сайн барьж баймаар байна. Депутатуудын зарим нь орж ирээгүй байгаа учраас хүсэлтийн чанартай асуулт ирсэн юм,үүнийг хариулчихъя.

Хөдөөгийн депутатуудад зориулж Ардын эрх сонинг өдөр дутам буудалд худалдаж байх арга хэмжээ авна уу гэсэн байна. Үүнийг Ардын эрхийн редакцияд хэлсэн. Буудлуудад 12-ноос эхлээд Ардын эрх сонин худалдаж байгаа. Бусад нам,эвсэглүүдийн хэвлэлүүдийг тарааж байя гэсэн бид үүнийг хориогүй. Олон нийтийн хэвлэл,сонингууд та бүгдийн буудалд чөлөөтэй худалдах болсныг дамжуулъя.

Хуралдаанаа үргэлжлүүлье. Эрхэм Дэд ерөнхийлөгч та асуултанд хариулна уу.

Р.Гончигдорж -Эрхэм депутатууд аа! асуултанд ирсэн хариултаа үргэлжлүүлье.Аливаа нэг тийшээ хазайх хазайлт гарвал хэлээрэй. Тэхдээ тэгэхгүй байхыг хичээе. 166-р тойргийн депутат Дамцагдорж гуайн асуулт давхардаж байна. Нөгөө асуудал нь тусгаар тогтнол,ажуулгүй байдлыг хамгаалах нь төрийн болон иргэний үүрэг байх уу гэж байна. Иргэний үүрэг дотор нэг талаас Их цааз,бусад хуулийг дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх үүрэгтэй, хуулийн дагуу цэргийн алба хаах үүрэгтэй, мөн эх орон,байгаль орчныг хамгаалах журамт үүрэгтэй учраас энэ утгаараа энд иргэний хүлээх үүргүүд, хууль тогтоомжоороо болон Их цаазад заасан үүргийн дагуу байгаа юм.Гэхдээ тусгаар тогтнол,ажуулгүй байдлыг хамгаалах нь төрийн үндсэн үүрэг юм.

269-р тойргийн депутат Д.Сайнхүү гуай Улсын Их Хурлын гишүүдийг шинэчлэн,сэлбэж хийхдээ ямар шалгуураар өөрчилж

байхаар оруулсан вэ гэж байна. Үүнийг сонгуулийн зохион байгуулалтаар оруулсан. Хэрэв нэг мандаттай тойргууд байна гэвэл тойргуудаа хоёр хэсэг хуваана гэсэн үг. Олон мандаттай тойрог байна гэвэл тэр тойрог дээрх мандатын тоог хоёрд хуваагаад явуулаад байна гэсэн утгаар ойлгогдоно гэсэн үг юм.

Ерөнхийлөгч бүх шатны гишүүнийг ингэж сонгох нь ямар хдэстэй вэ? Түргүнд хэлсэн. Парламентын БНМАУ гэж байхаар хуульд оруулахдаа ийм заалтыг аль нэг тодорхой орны турш лага авч байна уу, эсвэл хэд, хэдэн орны үйл ажиллагаа судлаад, манай улс орны онцлогоор ийм болох гэж байна уу?

Манай Үндсэн хуулийг хараад БН Улс гэж, Төрийн удирдлагын парламентын хэлбэр нь юу байх вэ гэдгийг харахлаар л энэ Үндсэн хууль нь ингэж нэрлэх нэрийг бидэнд тулгаж байгаа юм. Ингэж нэрлэе гэж авч үзээд, үүндээ эргүүлээд зохицуулаад мөн Үндсэн хууль дахь төрийн удирдлагынхаа механизм, эрх хуваарилалтуудаа ингэж хийж байгаа юм.

Их цаазын цэц өөрөө энэ хуулиа зөрчсөн үйл ажиллагаа гарвал асуудлыг хаана шийдвэрлэх вэ?

Их цаазын цэцийг бид Их Хурлаар томилож, батлаж байгаа. Энэ утгаараа энд нэг талаас Их цаазын цэц нь зөвхөн Үндсэн хуульд захирагдаж үйл ажиллагаагаа явуулна гэсэн энэ хоёр зүйл нь тэдгээрийг Үндсэн хууль зөрчих үйл ажиллагааг боогдуулах шалтгаан болж чадна. Дээр нь Дээд шүүх мөн өөрөө Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн гомдлыг маргааны шинжээр авч шийдвэрлэх эрх мөн тэнд хадгалагдаж байгаа юм. Энэ бүхэн нь Их цаазын цэцийг өөрөө зөрчөөд яваад байхад нүдэн балай, чихэн дүлий байхгүй юм байна гэдгийн харьцангуй тийм зохицуулалтын юм байгаа гэж ойлгоно. Тэр сүлжээг эрхэм гишүүд дараагаар нь харахад аргачлалын хувьд ч гэсэн нарийвчилсан сүлжээг та бүхний танин мэдэхийн үүднээс харах нь шаардлагатай гэвэл тэр балансыг нь харицан хуваарилалт, шүтэлцээг нь зурж ч үзүүлж болно.

Засаг захиргааны зохион байгуулалт нь захиргааны нэгжийг заавал хошуу, баг гэж нэрлэхийн учир нь ямар үндэстэйг хариуллаа.

-Засгийн газрыг төрийн гүйцэтгэгч дээд байгууллага гэж Их цаазын төсөлд орж байна. Захирамжлах гэдэг томъёоллыг нь оруулах нь онол арга зүйн үндэслэл нь юу вэ? Энэ томъёоллыг нь хассанаар Засгийн газрыг зөвхөн гүйцэтгэгч үүрэгтэй болгоно гэж ойлговол буруу юу?

Гүйцэтгэн захирамжлах гэж ярьж байсан. Ярих ч төдийгүй, захирамжлах шинж чанар нь гүйцэтгэхээсээ саналгид захирамжлах шинж чанар байсан. Үндсэн хуулийн нэмэлтийн тухай ойлгохдоо бол гүйцэтгэн захирамжлах гэж, гүйцэтгэх хүрээн дотор хуулийн дагуу захирамжлах эрх зүйн үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа юм гэсэн ойлголтоор нэмэлтийн хуулиа ойлгож ирсэн. Одоо бид эрх мэдлийг хуваах энэ онолынхоо үүднээс гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Тэгээд Засгийн газар нь хуульд нийцүүлж, хуулийн дагуу гүйцэтгэх эрх мэдлээ хэрэгжүүлэх өөрийн тогтоол, шийдвэрүүдээ гаргана гэсэн байдлаар байгаа юм. Тийм учраас өмнөх үеийн утгаар захирамжлах гэдэг нь байхгүй, гүйцэтгэх хүрээндэх захирамжлах гэдэг утга нь өөрт нь байгаа юм.

-Хошуу, тамгын газар хар гарт хорьж, ёсөн эрүү тулгах зэрэг үйл ажиллагаа явуулах уу?

Энэ нь үгүй юм, төрийн хувьд нэгдмэл улс байна гэдэг нь энэ шүү дээ. Тийм учраас төрийн эрх мэдлийг өргөжүүлэх нурван өндөрлөг, зөвхөн тэр эрх мэдлийг тэнд хэрэгжүүлнэ, шүүхээс өөр шүүн таслах ажиллагааг хавна ч, хэн ч хэрэгжүүлэхгүй. Хүний эрхийн дотор гол, гол зүйлүүд орчихсон байгаа шүү дээ.

-/Хошуу, ноён/ нутаг газрын асуудлыг бие даан шийдвэрлэж байх болов уу?

Засаг дарга асуудлыг бие дааж шийдвэрлэхгүй, гүйцэтгэх эрх хэмжээндээ шийдвэрлэнэ. Энэ нь нэг талаас түүний үйл ажиллагааг дээд байгууллага, төрийн байгууллагын шийдвэрийг орон нутаг зохион байгуулж хэрэгжүүлэх, нөгөө талаар өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх хурлын шийдвэртэй хурал нь тэр орон нутагт хуулиар олгогдсон эрхийн хүрээн дэх шийдвэрлэх асуудлын шийдлийг тэр гаргана. Тэр шийдвэрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг энэ засаг дарга зохион байгуулна. Энэ утгаараа тэр нь ганцаар нээрхөх бүрэн утгаар засаглалыг хэрэгжүүлж байгаа юм биш ээ. Гүйцэтгэх эрхи мэдлийн хүрээнд ганцаар байгаа бөгөөд, мэдээж өөртөө тамгын газартай байна. Мөн өөрөө удирдах ёсны өөрийн хяналтын зөвлөлүүд байна. Эдгээрийн хоорондын гүйцэтгэх үйл ажиллагааны уялдаанууд нарийвчлагдан орон нутгийн өөрөө удирдах ёсны орон нутгийн засаг, захиргааны хуулиудаар нарийвчлан зохицуулагдах зүйл юм. Үүнийг ялгах тухай асуудал дээр 289.

-Цагаачлал тодорхой хуультай байдаг учраас Их цаазын төсөлд цагаачлах эрх яагаад ороогүй вэ? Цагаачлал нь улс орноо хөгжүүлэхэд ач холбогдол өгдөг гэж би ойлгосон гэж байна.

Манай иргэд оршин суух газараа өөрсдөө чөлөөтэй сонгох асуудлыг гадаад, дотоодын аль ч хүрээнд иргэний эрхийх нь хувьд зөвшөөрч байдаг учраар нь иргэнд цагаачлах зорилгоор гадаадад гарах тухай асуудал дээр нь тусгээмэл утгаар Их цаазанд хориг тавиагүй. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэсэн асуудал нь цаашид хуулиудаар хэрэгжинэ. Яг цагаачлагч болж чадах уу, үгүй юу гэдэг асуудал нь тэр хүний шинж чанар, цаад хүлээж авч байгаа улс тэр статуст олгох уу, үгүй юу гэдэг харьцаан дээр үүсдэг гэдгийг дахин хэлбэ. Үүнийг 252-р тойргийн депутат Цэрэннадмид гуай асуусан байна.

-Нийслэл хотын онцлогийг олон талаас харгалзан нийслэл, хотын тухай хууль гаргах уу? 156-р тойргийн депутат.

Хууль гаргах боломжтой гэж үздэг.

Засаг, захиргааны нэгжийн хувьд статусынхаа хувьд нийслэл, аймаг хоёр нь адил хэмжээтэй байгаа шүү дээ. Тэнд харин өөр онцгойлсон байдлыг хуулиар тодорхойлсон зүйлүүд, хуулийн хүрээнд заавал тодорхойлогдох ёстой учир шалтгаанууд үүсэж болно. Тийм шалтгаанууд ч амьдрал, практик дээр байдаг.

-Гадаадын иргэдэд газрыг өмчлүүлэх асуудлыг Үндсэн хуулиар хаадгийн учир юу бэ? Гадаадын иргэдэд газраа өмчлүүлээд, тусгаар тогтнолоо алдсан улс хэд, хэд байна вэ? Зах, зээл хөгжсөн улс, орнуудад манай улсын иргэн газар өмчлөх эрхтэй байхад манайд тэдгээр улсын иргэд газар өмчлөх эрхгүй үлдэж байгаа нь шударга ёс мөн үү? Үнэхээр тусгаар тогтнолд харшлах холбогдлууд салбар хууль, тодорхойлол газрын хуулиар зохицуулж болохгүй юу? гэж 428-р тойргийн депутат Ганболд гуай асуусан байна.

Үүнийг бодох асуудал юм. Ялангуяа манайд байгаа гадаадын иргэдийн эрх хэмжээг тэр улстай нь адил тэгш байх. Тэр улсад манай иргэдийн эрх, эрх чөлөө, үүргийн хэмжээ ямар байхтай харьцангуй адил байх зарчмыг баримтлана гэдэг үүднээс авч үзэхэд энд ингэж хэлэх үндэслэлүүд гарч ирж байгаа юм. Гэхдээ өнөөдөр манай улс, орны онцлог байдал, манай иргэдийн санаа зовж байгаа учир шалтгаан, энэ байдлаас олонхийн саналаар Улсын Бага Хуралд өргөн барьсан төсөлдөө газар өмч байх асуудлыг зөвхөн өөрсдийн иргэд, төрийнхээ онцгой эрх мэдэлд үлдээж байна гэж үзэж байгаа юм. Бусад орнуудын хувьд гэвэл чөлөөтэй байдаг. Мөн манайхаас бүр ч хатуу байдаг. Тэрбайтугай өөрсдийнхээ иргэдэд ч өмчлүүлдэггүй байдаг юм. Тиймээс үүнийг олон талаас нь бодох. Үнэхээр депутатын хэлж байгаа хүчин зүйлүүдийг хэн ч, яаж ч үгүйсгэж чадахгүй шалтгаанууд байна. Гэхдээ улс төрийн шийдэлийг бид гаргахдаа алийг нь харгалзаж үзэх үү гэдгээ бодоцгооё.

-222-р тойргийн депутат Банзрагч гуай: Бага Хурал дээр цаазаар авах ялын талаар маш их маргасан. Ийм ял байх шаардла-

04

гагүй гэсэн үндэслэлээ тайлбарлана уу? гэж байна.

Байх шаардлагагүй гэж Улсын Бага Хурал үзээгүй. Байх шаардлагатай гэж үзээд хүн амьдрах эрхтэй, зөвхөн хүнд гэмт, хэрэг ял оноосон тохиолдолд зөвхөн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр амь насыг нь хороож болох юм гэсэн утгаар Их цаазанд орсон байгаа шүү дээ. Эмнести Интернешнл болон хүний эрхийн байгууллагуудаас цаазаар авах ялаа халчихвал ясан юм бэ гэсэн зөвлөмжүүдийг, хүсэлтийг тавьсан. Гэхдээ үүнийг өнөөдөр хүлээж авах боломжгүй байна гэдэг тал дээрээ Улсын Бага Хурал олонхийн саналаар байгаа юм.

-95-р тойргийн депутат Төмөрбаатар гуай асуусан байна. Үндсэн хуулийн Их цаазын гол зарчим нь шударга, ёс тэгш байдал гэжээ. Хувийн өмч хөгжсөн, баян, хоосны ялгаа их болох тусам энэ зарчим хэрэгжиж байна?

Би мөн дахин хэлмээр байна. Хүний субъектив эрхийнхээ хувьд хүн бүр тэгш байна гэсэн томъёоллоо бид тунхаглаж байгаа шүү дээ. Түүнээс эрхээ хэрэгжүүлэх чадамжийн хувьд ялгаатай байхыг хэн ч, хэзээ ч яаж ч үгүйсгэж чадахгүй бөгөөд энд харьцангуй шударга ёсных нь үүднээс хуулиар зайлшгүй зохицуулах ёстой ийм шаардлага үүссэн тохиолдолд тэр ерөнхий субъектив эрхийг харьцангуй объектив эрхтэй нь холбож өгөх талаасаа хууль, тогтоомжоор авч үзэх шаардлага үүснэ. Энэ утгаараа иргэдийг нийгмээс янз бүрээр харж үзэх тухай асуудлууд энд тусгагдсан байгаа юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

У.Баярмаа

Ц.БАЯРМАА

Бичээч

С.Туул

Р.Гончигдорж:- Эрх чадамжийн хувьд бид үнэхээр хязгаарлалт тавьж болохгүй бөгөөд эргээд энэ маань тэр субъектуудийнхээ хувьд түгээмэл эрхийн нь хязгаарласан асуудал болоод хувирчих нь шүү дээ. Нүүдлийн мал аж ахуйн эдийн засагт зонхилох үүрэгтэй ямар орон газрыг хувьд өмчлүүлж байна вэ?, өмчлүүлж байж хөгжсөн юм бэ? манай оронд энэ талаар хийсэн судалгаа бий юу гэж, ер нь газрыг хувьд өмчлүүлж байж... юу гэнэ ээ нүүдлийн мал аж ахуй эдийн засагт нь зонхилох үүрэгтэй ямар орон газрыг хувьд өмчлүүлж байж хөгжсөн вэ? манай оронд энэ талаар хийсэн судалгаа байна уу гэж. Манай нүүдлийн мал аж ахуй, ер нь энэ зүгээр судалж танилцдаг улсууд олон байдаг байж. Бидний нэг гол онцлог газар өмчлүүлэх, газар бол хувийн өмчинд байж болох юм гэж авч үзээд гэхдээ газар зохион байгуулалтынхаа хүрээнд, газар ангиллынхаа хүрээнд ямар газар хувийн өмчлөлд байж болохгүй, ямар газар дээр энэ хувийн өмчлөлийг үүсгэх вэ гэдэг асуудлынхаа үүднээс авч үзэхэд бэлчээрийн мал аж ахуйтай байдаг гэдэг онцлогоо харгалзаж үзээд бэлчээрийг хувьд өмчлүүлэх тухай асуудлыг бол энд авч үзэхгүй байхаар ингэж онцгой тусгаж авч үзээд байгаа шүү дээ.

Гэхдээ өвөлжөө, бууцны харьцангуй суурьшилыг үүсгэсэн, дэргэдээ, тийм өвөлжөө, бууцны бууцны орчим газар гэдэг бол бас манай малчид ч гэсэн түүнийгээ бэлчээр гэдгийнхээ хүрээнд авч үздэг үү үгүй юу гэдгээ бодох л зүйл л дээ. Тэгэхлээр бэлчээр гэдэг агуулгынхаа хувьд. Тийм учраас магадгүй тэнд өвөлжөө бууцны ойролцоо газрууд, тэнд тодорхой хөрөнгө оруулсан, тодорхой барилга байгууламж байгуулсан хүмүүсүүдийн хувьд тэр хэсэгхэн газрыг өмчлүүлэх тухай асуудлыг бэлчээр гэдэг ангиллаас ялгаж авч үзэх нь зүйтэй байх л гэж ингэж бодогдож байна.

Хошуу, сум хоёрыг аль нь давуу болохыг нотолсон ямар баталгаа байна вэ, одоо бол нэрийн хувьд ярьж байна, хошуу гэдэг үг, сум гэдэг үг гэдэг утгаар нь ярьж байна гэж ойлгож байна. Цаашдаа жинхэнэ зохион байгуулалтын өөрчлөлт оруулахад

2.

аль нь илүү сайн вэ гэдэг нь амьдралаар харах, урьдчилж харах байдал дээрээ энэ тэмцэлдэх зүйл болов уу гэж бодлоо.

Дараа нь Их Хурлын депутат Чулуунбаатар гуай, Нэргүй гуай хоёроос асуусан байна. 420, 421-р тойргийн депутатууд Их цаазын төсөлд энэ нэрийн тухай асуудал байна. Депутат Зардыхан дарга депутатын үгүүдийг үл хүндэтгэж тодорхой хариулсангүй, Монгол улс гэж нэрлэх болсны учрыг тайлбарлаж өгнө үү гэж дахин дахин хүсч байна. Энэ маань яагаад бүгд найрамдах гэдэг тодотголыг нь хасав, яагаад ард гэдэг тодотголыг нь хасав гэдэг энэ л учир шалтгаан дээр бид нар ярилцах ёстой үг байна. Ард гэдгийг юу гэж ойлгож байна вэ, ингэж тодотгол оруулахын учир шалтгаан, нийгэм улс төр, иргэний байдал, нийгмийн өнөөдөр ойлгож байгаа хөгжлийн чиг хандлага энэ үүргээрээ байх уу үгүй юу, бүгд найрамдах гэдэг тодорхойлолтыг бүгд найрамдах, төрийн удирдлагын бүгд найрамдах хэлбэртэй ийм улсаа гэдгийг Үндсэн хуулиндаа тунхаглаад өгчихсөн байж байгаа, энэнийгээ нэрэндээ ч биш тодотголоо зүүх үү үгүй юу гэдэг асуудал, энэ дээр л үзэл бодлоороо ярьж л хуралдаж л ойлголцох л асуудал. Тэгээд ард гэдэг үгийг өнөөдөр юу гэж ойлгох уу, энэ ойлголт яаж ойлгогдоод заавал энд байх ёстой байна вэ, байхгүй байна уу гэдэг асуудал дээрээ л үнэхээр энэ бол философи, нийгэм судлал, төр судлал энэ бүх талаасаа авч үзэх л ийм асуудал байх. Энэ үүднээсээ эрхэм гишүүн, эрхэм депутат Зардыхан бол төр асуудал дээрээ харилцан ярилцаж санал солилцож байх үедээ ярьж гэсэн ийм байдлаар, энэ маань та бүхний эмзэглээд байгаа нөлөөлөхгүй байдал гэдгийгээ эрхэмлэх үүднээс ингэж түр хариултаа татгалзаад байгаа юм.

230 дугаар тойргийн депутат Очирбат гуай асуусан байна. Төрийн өмчийн газар ямар газар вэ гэсэн. Хувийн өмчлөлд өгөөгүй байгаа бүх газар л төрийн өмчийн газар. Багийг ямар хэмжээтэй байх вэ? одоогийн сумаас том уу бага уу, энэ ярих асуудал. Зүгээр баримжаалж байгаагаар бол одоогийн сумаасаа бага бөгөөд тэнцүү гэсэн утгаар л ойлгож байгаа шүү дээ. Бид иргэддээ ойртох анхан шатныхыг нь бид болгох тухай л ярьж

3.

байна. Бага Хурал яагаад төрийн тогтолцоонд ганц танхимтай парламентыг сонгосон юм бэ гээд би түрүүн учир явдлаа ярилаа. Төрийн жинхэнэ албан хаагч гэж хэн бэ гэж. Төрийн жинхэнэ албан хаагч гэдэг маань одоо бидний төрийн байгууллага сонгуульт болон томилогооны байгууллагууд дээр ажиллаж байгаа энэ албан хаагчдаа бид төрийн жинхэнэ албан хаагчид гэж байна. Төрийн захиргааны байгууллагын, шүүх, прокурорын, цэрэг, зөвсөгт хүчний бие бүрэлдэхүүн гэх мэтчилэн ингээд энэ олон тушаалуудаа бид нар төрийн жинхэнэ албан хаагч гэж байна. Харин дотроо тэнд байгаа байгаа юу гэдэг юм бичээч цэвэрлэгч гэдэг юм уу энэ улсуудыг бид нар төрийн жинхэнэ албан хаагч гэж ойлгохгүй шүү дээ. Байгууллагаар нь биш, байгууллага дотор нь чиг үүрэг, функцээр нь төрийн жинхэнэ албан хаагч гэдгээ ойлгож ингэж тусгаж ойлгож байна.

Ингэж гаргаж ирээд дараачаар нь эдгээрийн үйл ажиллагаагаа явуулах, нийгмийн баталгааг бий болгох тухай асуудлыг цаашид хуулиар зохицуулах асуудлыг хөндөн тавихын тулд Үндсэн хуулиндаа энэ субъектыг онцгойлон нэрлэж оруулж ирж байгаа хэрэг гэж ойлговол зүйтэй байх. Улсын нэр, сүлд, туг, Үндсэн хуулийг нутгийн засаг захиргааны шинэ бүтцийн талаар шинээр гарсан саналыг хүндэтгэн үзэхгүй байгаагийн учир юу вэ гэсэн ийм асуудал байна. Түрүүн ярьсан.

406 дугаар тойргийн депутат Тэрбиш гуай 3 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн хоёрт Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэг гурван жилээр шинэчлэн сонгож сэлбэнэ гэсэн. Энэнийг ярьсан. 3 дугаар бүлгийн 31 дүгээр зүйлийн нэг, тавдугаар заалтын талаар нэмэлт тайлбар авахыг хүсч байна гэж. 31 дүгээр зүйлийн нэг, тав, Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна гэсэн. Энэ өргөн утгаараа хоёр шаттай байгаа юм. Нэг шат нь нийт сонгогчдын дунд сонгуулийг явуулаад ингээд тэндээс эхний шат дуусна. Хэрэв эндээс сонгогчдын олонхийн саналыг авсан нэр дэвшигч байвал түүнийг Улсын Их Хурал дээр ёсчлон батална гэж. Хуульчлан батална. Ингээд хоёр дахь шат нь бол зөвхөн хуульчлан

батлах ийм байдлаар л дуусч байгаа юм. Хэрэв энд аль ч нэр дэвшигч олонхийн санал авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хувьд хоёр дахь шатны сонгууль нь Улсын Их Хурал дээр болж байгаа юм. Энэ утгаараа энэ бол хоёр шаттай сонгууль юм.

Өршөөл үзүүлэх шийдвэр гаргах, уучлал үзүүлэх гэсэн хоёр санааны зарчмын ялгаатай ямар байдлаар бодож хуульд оруулсан, энэ чинь хуулийнхаа ойлголтын хувьд нэг нь өршөөл үзүүлэх, нэг нь уучлал үзүүлэх гэж, уучлалыг Ерөнхийлөгчийн онцгой эрх мэдэлд байгаа, өршөөл бол хууль тогтоох байгууллагад байдаг хууль гаргаж байж, өршөөлийн тухай хууль гаргадаг ийм хоёр асуудал. Хуулийнхаа утга учир, агуулгынхаа хувьд нарийн ойлголтууд. Энэнийг хэрэв шаардлагатай бол манай хуулийн улсуудаас нарийвчилж хэлж болно. Энэ практикт Ерөнхийлөгчөөс ч уучлалууд нэлээн хийгдлээ, Бага Хурлын хувьд сая 70 жилийн ойгоор өршөөлийн тухай хууль гаргаж, Бага Хурал түүнийг бүр зохион байгууллаа. Энэ тухай манай тайланд орно. Тэр үед ч тодруулж асууж болно.

3 дугаар бүлгийн 36 дугаар зүйлийн нэгд Ерөнхийлөгчийн түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга эдэлнэ гэсэн. 3 дугаарт Улсын Их Хурлын бүрэн эрхээсээ түүдгэлзэнэ гэжээ. Үүнийг эрх мэдлийг дээдэлж байна гэж үзэх үү, эсвэл эрх мэдлээ алдаж байна гэж үзэх үү гэж, эрх мэдэл шилжиж байна гэдэг утгаар л ойлгоё. Тэрнээс дээд, доодын тухай асуудал ярих юм биш л дээ. Зүгээр Ерөнхийлөгч маань төрийн тэргүүн, Монгол улсаа төлөөлж би гэж хэлэх ганц хүнийхээ хувьд бол төрийн тэргүүн ганц хүн, энэ бол нэг хүнээр илэрхийлэгдсэн чадамжийнхаа хувьд манай монголын маань нэгдүгээр хүн шүү дээ. Энэ утгаараа яривал мэдээж хэрэг Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг өөртөө хүлээж авснаар бол тэр утгаараа бол дээшилж байна гэж ойлгож болно. Зүгээр эрх мэдэл, эрхэ хэмжээгээ хэрэгжүүлэх бол өөр өөрийн эрх мэдлийн хүрээтэй, тэрнийг дээр, доор гэж байлгахгүй, баланстай байлгахын тулд энэ Үндсэн хуулийн бүх л зохицуулалт үйлчилж байгаа. Жишээлбэл хоёр хүчин зүйл байгаа

5.

шүү дээ. Зүгээр түр эзгүйд бол үүргийг нь гүйцэтгэдэг, хэрэв хоёр дахь шалтгаанаар болбол Ерөнхийлөгчийнхөө бүрэн эрхийг шилжүүлж аваад энэ маань байнгын шинжтэй болох учраас өөрийнхөө Их Хурлынхаа даргын бүрэн эрхийг бол шилжүүлдэг. Ийм учир шалтгаантай юм.

411 дүгээр тойргийн депутат Даваажид гуай асуусан байна. Их цаазын төслийн 4-ийн хоёрт монгол улсын хилийг хуулиар бататгана гэсэн өгүүлбэрийн харилцан хөрш улсуудтай зөвшилцсөний үндсэн дээр гэж ороогүйгээс болж тэдний талаас ямар нэг дутуу дулимаг ойлголт төрөхгүй биз ээ гэж. Төрөхгүй бөгөөд төрөх ёсгүй гэж ойлгогдож байна. Шаардлагатай үед Монгол улсынхаа хилийг мөн олон улсын эрх зүйнх нь хүрээнд ч хуульчлан батлуулах ийм шаардлага үүсдэг ийм шинжийн практик ч бий. Зөвхөн хоёр оронтой зөвших асуудал төдийгүй.

369 дүгээр тойргийн депутат Пүрэвдорж гуай асуусан байна. Улсын Их Хурлын гишүүн 25, Ерөнхийлөгч 50 насны асуудлаар таны хувийн бодлыг сонсмоор байна. Улсын Их Хурлын гишүүний нас залуудаж, Ерөнхийлөгчийнх хожимдсон юм биш үү гэсэн ийм санал байна. Би энд хувийнхаа бодлыг хэлэхээс татгалзаж яваад байгаа шүү дээ. Зүгээр учир шалтгааныхаа хувьд олон талаас нь бодож байгаа юм. Энэ чадамжийг хуулинд тусгах уу, сонгосон сонгогчид өөрөө сонгох шинжүүд дотроо бодох уу гэдэг ийм л хоёр хүчин зүйлээс л шалтгаалж байгаа юм. Ерөнхийлөгчийн эрх мэдэл багадаа гэж танд бодогддог уу? Ялангуяа Засгийн газартай харьцах харьцааны хувьд гэж, үгүй энэ чинь одоо надаас асуугаад надтай уулзалт хийж байгаа юм шиг болоод байна аа. Бага Хурлаас бол Ерөнхийлөгчийн онц эрх мэдэлд байгаа энэ зүйлүүдийг парламентын хэлбэрийг бид сонгож авсан энэ тохиолдолд боломжтой эрх хэмжээнүүд гэж үзэж байгаа ийм юм. Гүйцэтгэх засаглал, эрх мэдлийнхээ хуваалцах хэмжээнд бол энэнээс гүн орох тохиолдол ер нь бол зарим талаар бэрхшээлтэй байдлуудыг үүсгэж болно гэж ингэж бас Улсын Бага Хурал дээр бодож санаж хэрэгжиж байгаа зүйлүүд бий. Энэ бол нэлээн одоо, ялангуяа

Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайлангуудыг ярилцахад та бүхний хэлж байгаагаар үнэхээр өмнө нь, Үндсэн хуулийн Нэмэлтийн хуулиар ажилласан энэ хугацаанд ямар зүйл дээр, ямар бэрхшээл учрав? Чадахгүй хувьд гарав уу, хуулийн эрх хэмжээ, хуваарилалтын хувьд гарав уу гэдэг асуудал дээр ярихад бол гарах байх гэж ярьсан. Тэхдээ энэ маань бол биднийг хэлэлцэж байхад аяндаа гарчихна гэж ойлгогдож байна. Биднийг хэлэлцэж байхад аяндаа санал бодлоор дамжаад гараад ирнэ.

Хошууны төлөөлөгчдийн хуралд орон тооны ажилтан байх уу гэж байна. Энэ бол тэр хошууны өөрийн эдийн засаг, хөрөнгө, боломжийн чадамжаар тодорхойлогдоно гэж үзэж байгаа. Тэд үнэхээр өөрснөө байнгын ажиллагаатай, орон тоотой ийм зүйлүүдийг авч үзэж чадах эдийн засгийн хүчин чадал байх юм бол энд ямар нэг байдлаар төрөөс хуулиар хязгаарлалт гаргаж өгөхгүй. Өөрөө өөрөө удирдах ёсоо, удирдах энэ эрх хэмжээгээ хэрхэн яаж хэрэгжүүлэх нь тэдгээрийн өөрийн асуудал байна.

Их цаазын Цэцийн гишүүн хуучин Улс төрийн Товчооны 9 гишүүн шиг болчих юм биш биз ээ гэж, ийм болохгүй гэх баталгаа байна уу гэж. Үндсэн хуульд тэр баталгаа нь байна гэж үзэж байна. Эрхэлж хэлэлцдэг асуудал нь ч шал өөр.

191 дүгээр тойргийн депутат Хамбаатар гуай асуусан. байна. Төсөлд багийн тухай ойлголт, газар нутаг, хүн амын тооноос гадна шинээр бий болж байгаа аж ахуйн олон нэгжүүдийн тухай харгалзаж үзсэн үү гэж, чухамхүү өнөөдөр хоёр хүчин зүйл хэллээ шүү дээ. Нэгдүгээрт бол орон нутгийн удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах гэж удирдлагынхаа зүйлийн, нөгөө нэг асуудал нь өнөөдөр манайд аж ахуйг, өмчийн харилцаа, аж ахуй эрхлэх харилцаа энэ дээр урьдаасаа шал өөр нөхцөл байдал бий болж байна. Эндээсээ эхлээд орон нутгийн эдийн засаг, нийгмийн чадамжийн байдал дээр шал өөр байдал үүснэ.

Энэ бүгдийг харгалзаж үзсэн байдал бол үнэхээр энэ засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтанд гарах өөрчлөлтийн

7.

Үндсэн сигналиуд мөн байх аа гэж. Тэгэхээр цаашид улс орноо хөгжүүлэх бидний яриад байгаа бодлогын хүрээ, хэмжээ хоёр бол энэнийг хэлээд байна гэсэн үүднээс энэнийгээ ярьж байгаа юм.

Тэгээд түүнээс гадна аж ахуйн удирдлага, энэ өөрөө удирдах, төрийн захиргааны удирдлага гэдэг хоёр бол хоёр шал өөр юм. Энэнийг бид нар ямар нэгэн байдлаар нэг субъектээр нийлүүлэх юм уу, харилцан бие биентэйгээ яг паралель байж байдаг зүйлүүд гэж л ойлгох юм бол бид буруудаад явчихаж болно шүү гэж. Өмнөх зүйлийнхээ нэлээд дутагдалтай талуудыг эндээс олж харж болох байх гэж.

Төсөлд улсын эдийн засаг, санхүүгийн талаар тусгай бүлэг орж болохгүй байсан юм уу, тухайлбал Улсын банкны ажиллагааг хэн зохицуулах вэ гэж энэ асуудал орсон байна. Тэгэхлээр зэрэг Улсын Их Хурлын онцгойлсон эрх мэдлийн дотор байгаа энэ үүднээс шалтгаалаад Монгол банк буюу төрийн эмиссийн бодлогыг явуулах тэр банк Улсын Их Хурлынхаа мэдэлд байх нь зүйтэй гэж ингээд Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийн агуулгаасаа гаргаад Банкны хуулиа гаргаад оруулаад ирсэн л дээ. Тэгэхээр зэрэг заавал энэнийг Үндсэн хуульд, одоо тэр Банкны хуулиар өнөөдөр зохицуулагдаж байгаа асуудлыг тусгах зайлшгүй шаардлага байхгүй юм болов уу л гэсэн ийм юм ярьж байгаа.

Энэ улсын эдийн засаг, санхүүгийн талаар тусгайлан бүлэг орж болохгүй юу гэдэг дээр түрүүн манай Ерөнхийлөгчийн тавьсан илтгэлүүдэд энэ тодорхой орсон. Ямар нэг хэмжээгээр шинэ агуулгатай тусгалууд бий. Олон хэвшилт эдийн засагтай ийм байх юм гэдэг утгаар.

Засаг даргыг дээрээс томилно гэдэг нь ард түмэн төрийн үйл хэрэгтээ шууд оролцох эрхэнд харшлахгүй юу. Чухамжүү харшлахгүй хоёр хүчин зүйлүүдээ л түрүүн ярьчихлаа шүү дээ.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л. Хорлоо

Р.Гончигдорж: -Төрийн хэрэгт шууд оролцох байдал, яаж үүсэх вэ гэж хэд хэдэн хүчин зүйлүүд байх байх. За нэг талын асуулт Засгийн бүх эрх мэдэл Засгийн эрхийн бүх эрхийг ард түмэн мэднэ гэдгийг шууд болоод төлөөлсөн байгууллагаараа дамжиж оролцох ингээд , шууд оролцох хэлбэр нь бол тухайлбал ард нийтийн санал асуулга, сонгуульд оролцох замаар бол энэ тэгээд шууд оролцох энэ агуулгаараа хэрэгжүүлж чадаж байна. Тэгээд та бүхнээр дамжуулж энэ төрийн эрх барих дээд байгууллагад оролцож байгаа утгаараа бол төлөөлөх байдлаар оролцож байгаа юм. Тэрнээс энийг бол шууд нэг иргэн төрийн шийдвэр гаргаад байх гэдэг утгаар бол ядууруулж ойлгож болохгүй л дээ. Зүгээр төрдөө өөрийнхөө санал бодлыг илэрхийлэх, санал бодлоо хэлэх энэ бүх эрхээр бол бүрэн хангагдаж байгаа үндсэн хууль дотроо бол энэ эрх нь байж байгаа. Энд бол засаг дарга өөр агуулгатай, өөр зүйл.

47 дугаар тойргийн депутат Лхагвасүрэн гуай асуусан. Манай улс хөрш оронтой улсынхаа хилийн шугамаа баталгаатай тогтоосон гэж үзэж байгаа юу. Би хэлсэн шүү, ийм асуудал дээр би хариулахгүй. бөгөөд би депутатынхаа хувьд бодол санаа юм, иргэнийхээ хувьд бол бодол санаагаа хэлж болно. Ямар нэг байдлаар тиймгүй гэдэг хариулт бол энэ маань өөрөө нэг канстац. Ийм учраас энэ бол цаашид аливаа зүйлд тодорхой хэлэгдэх боломжгүй зүйлүүд юм. Хэрэв баталгаатай байсан бол шинэ үндсэн хуулийн төсөлд улсын хил тогтооно гэж оруулсныг учир юу гэж байна вэ гэж, энэ асуудлуудыг хариулахгүйгээр орхье. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэж оржээ. Манай улсад ийм нэртэй алба байгаагүй ба гэнэт гарч ирээд шууд их цаазад ордгийн учрыг хэлж өгнө үү. Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулинд бол батлан хамгаалах зөвлөл гэж байгаа, батлан хамгаалах зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлж байгаа, өнөөдөр батлан хамгаалах зөвлөл гэдэг утгаар нь байх нь хэтэрхий явцуу байна. Ерөнхийлөгчийг толгойлуулсан батлан хамгаалах зөвлөл байгаа, энэ өөрөө зөвхөн батлан хамгаалах асуудал дээр биш ерөөсөө үндэстний аюулгүй байдлын асуудал дээр ийм зөвлөл байх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ бол улс орны нийт түгээмэл практиктч гэсэн байж байгаа ийм зүйл. Төрийн дээд удирдлагууд оролцсон ийм зөвлөл ажиллаж энэ төрийн нарийн ширийн бод-

логууд дээр зөвшсөн хэлэлцэж байх тэгээд энэ үүднээс нь эрх бүхий байгууллагууд шаардлагатай асуудлыг авч хэлэлцэж зохих ёсны шийдвэрүүдийг гаргаж байдаг байгаа. Тэрнээс энэ зөвлөл маань өөрөө бол шууд шийдвэр гаргадаг ийм байгууллага, субъектын утгаар энд ойлгогдохгүй байгаа шүү. Энэ маань үндсэн хуульдаа тусгагдахаас өөр аргагүй бөгөөд энийг Ерөнхийлөгч төрийн тэргүүнийхээ хувьд тэргүүлэн толгойлохоор энд тусгагдаж байгаа. Ийм зүйл. 64-р зүйлийн 3-т заахдаа Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн засаг дарга тухайн нэгжийн засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2-т заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилго, өмнөх засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална. Ийм байдлаар тухайн хурлаас нэр дэвшигчийг дээд ёсны засаг дарга нь томилохоос татгалзах тохиолдолд хоёр гурван удаа түүнээс олон тухайн нэг аймаг, сумд гарвал хэрхэх вэ, үүнийг бага хурал дээр юу гэж хэлэлцсэн бэ гэж, за энэ бол сонирхолтой бөгөөд үнэхээр харьцангуй цоорхой байгаа заалт гэж хэлж болно. Зүгээр засаг дарга хурлын шийдвэр дээр хориг тавих хориг тавиад хоригий нь хүлээж авахгүй бол өөрөө огцрохоо мэдэгдэх тухай асуудлууд гээд энэ хувьд зохицуулагдчихаад ингээд байгаа юм, зарим тохиолдол бол нэг удаагийн гэж байгаа. Нэг удаагийн ч гэсэн зүйлүүд байсан. Энэ хуулийг хэлэлцэж байхад, нөгөө талаас бол заримдаа дээрээс төлөөний хүнийг томилчихоод сонгуулийг тэр дороос шалгаж гарч иртэл нь тэгээд байлгаж байна гэсэн ийм зохицуулалт байж байгаа. Энэ дээр зайлшгүй энд зохицуулагдах харьцаа шаардлага үүснэ гэвэл эсвэл үндсэн хуульдаа хэлж өгөх, эсвэл орон нутгийн хуулиндаа оруулж өгөх ийм л зүйл байгаа юм. Тийм учраас бол Ерөнхий энд байгаа зүйлийг үндсэн хуулийн энэ агуулгаар нь тэд хуулинд салбар хуулинд оруулчихад бол үндсэн хууль зөрчсөн гэж хэлэгдэхгүйгээр байгаагийнх нь хувьд түр харьцангуй ойлголцлын онгорхойтойгоор ингэж томъёолоод байж байгаа юм. Их хурлын депутатууд маань энд ийм онгорхой байж болохгүй, нэг л удаа хойшлуулах байж болно, дараа нь тэрний нь шууд хүлээж авах ёстой гэсэн байдлаар ингэж гарч болно. Энэ харьцаа бол одоо яг амьдрал дээр гарч ирчихээд байгаа зөрчлүүд байгаа шүү дээ. Зөрчил байгаа.

352-р тойрог Жийдээ гуай асуусан байна. -За төслийн 33-р зүйлийн II-д Ерөнхийлөгч монгол улсын зэвсэгт хүчний ерөнхий жанжин байна гэж заажээ. Энэ зөв байх. Гэхдээ Ерөнхийлөгчөөр цэргийн хүн ихэвчлэн сонгогдохгүй байх, одоогийн ерөнхийлөгчөөр жишээ авсан ч гэсэн, тэгэхээр шинээр сонгогдсон Ерөнхийлөгч хэдийд нь цэргийн боловсрол мэргэжил эзэмших вэ энэ талаар төсөл боловсруулж ярилцсан уу, хуучин туршлага татгалзахгүй байгаа Цэдэнбалын маршал, Дэжидийн генерал болгосон км шиг л км уу даа гэж байна. Энэ ойлголтоо бид өр нь давтаж байгаагүй гэж болох байхаа гэж ойлгож байгаа. Нэлээд оронд тэгэх нь байтугай батлан хамгаалахынх нь сайд энгийн хүн байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Тэр нь ч зүйтэй гэж үздэг. Тэгэх дээр зэрэг тэр тусмаа одоо зэвсэгт хүчний ерөнхий жанжин байх гэдэг утгаар бол Ерөнхийлөгч заавал цэргийн хүн байх гэдэг энэ шаардлага үүсэхгүй бөгөөд гэхдээ яг энэ зэвсэгт хүчний онцгойлсон тохиолдолд гарах үүрэг, харилцааны үед бол энэ хүн маань өөрөө олон түшиг тулгууруудтай шүү дээ. I-р бүлэг 6 дугаар зүйлийн 2-т төрийн өмчинд байх зүйлд ус, ой, амьтан байгалийн бусад баялагийг хамааруулаад харин газар, түүний хэвлийд ургамлын үндэс байна гэдгийг зайлсхийсэн байна. Учир тайлбар өгөөч гэж, энэ маш их чухал зүйлийг хэлсэн бөгөөд энэ бол ямар нэг утгаар одоо бас бага хурлын төсөл дотор жаахан найруулгын байдлаасаа ч км уу жаахан өөрчлөлт орсон гэж хэлж болно, үнэхээр энд бол ой, ус, газар, түүний хэвлийн баялаг гэсэн утгаар бол тусч байж нэлээн тодорхой байдалд хүрэх байх. Энэ дээр ярилцахад нэлээн ярилцагдах ёстой асуудал гэж хэлээд орхье. Байгалийн бусад баялаг гэдэг бол их бэрхшээл учруулна. Түгээмэл тархалттай баялаг, газрын хэвлийдэх баялаг, Тэрнийг хэрхэн ялгах, ингээд энэ утгаар орвол дараа нь хуулийн зохицуулалт яаж гарах вэ гэх бэрхшээлтэй зүйлүүд гарна. Энэ дээр харин асуудал тавьсан явдал нь дараа хэлэлцүүлэгт их чухал зүйл байхаа.

I60-р тойргийн депутат Содном гуай асуусан байна. -Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлэхэд гарсан санал байдал түүнийг нэгтгээд улсын бага хурал хэлэлцээд гарсан төсөл одоо бидний гар дээр байгаа 2, тэнгэр газар хоёр шиг л зөрүү-

тэй боллоо. Өөрөөр хэлбэл улсын бага хурал 2 удаагийн хурлаараа ард түмнийхээ жинхэнэ сэтгэл үйл бодлыг резиндэж чаджээ. Нэгэнт ийм байсан юм бол ард нийтээр хэлэлцүүлэх шаардлага гарсан юмуу гэж, энэ 2 төсөл тэнгэр газар шиг байгаа явдал нь ард нийтээр хэлэлцүүлсний үр дүн мөн гэж үзэж байгаа. Их цаазад хүний эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусад хүний эрх чөлөөг хохироож болохгүй талаар тодорхой заасан гэсэн гэтэл бусдын эрх чөлөөг хохироож байгаа олон тохиолдолд хохирогч хохироод л өнгөрч байгааг анхаарч үзэж хохирогчийн эрх ашгийг хамгаалах талаар их цаазад тодорхой заалт ороогүй байгааг юу гэж үзэх вэ гэж, хохирогчийн эрх ашгийг хамгаалах тухай асуудал дээр депутат 409-р тойрог, Цэрэн гуайн энэ ярьж байгаа зүйлийг цаана нь бодож байгаа олон зүйлүүдийн хувьд бол өнөөдөр олон хуулиуд дээр байгаа зүйлүүдийг шинэчлэх агуулга шаардлагатай байна гэдэг тэр агуулгаар ойлгож байна, энэ ч үүднээс бол цаашид одоо хуулийн бодлого, хууль тогтоох бодлого бол явагдах ёстой байх, нэг талаас хохирогч, хохироулагч, хохирогчийн өмнө ялангуяа нөхөн төлбөрийн утгаар нэлээн өндөр үүрэг хариуцлага хүлээх ёстой гэсэн ийм үзэл баримтлал нэлээн явагдаж, яригдаж байгаа, энэ үүднээсээ бол цаашидын бусад хуулиудад тусгагдаж байгаа. Үндсэн хуулинд бол энэ зүйл үндсэн хуулийн хэм хэмжээнд тогтоогдох энэ байдал нь бол орчихсон болов уу гэж ингэж бодогдож байгаа юм. Бусад хуулиудын эрүүгийн иргэний бусад шүүхийн байгууламж, эдгээрийн тухай хуулиуд энэ бүх хуулиуд дээр бол төрөөс иргэний эрхийг баталгаатай болгох талцаа хуулиар дамжуулах бодлогод бодож авч үзэх асуудлууд байгаа байх гэж бодож байна. Хүн бүр эрх зүйн субъект байх хэрэгтэй гэдгийг субъектыг монголчилж болохгүй юм, малчид, өвгөд, ахмадууд ойлгохгүй байгаа шүү гэж байна. Их л бодоод байгаа, тэгээд уг олоогүй л байгаа байх. Эрх зүйн субъект болгох гэдэг утгаар нь үндсэн хуульдаа тодруулж орж байгаа нь бол түрүүний үндсэн хууль дээр ингэж тодорхой бүр агуулгаар тусгаагүй байсан. Энд тусгагдаж ингэж гарч ирж байгаа юм. Гол нь субъект байх эрхтэй гээд энэ нь юугаар илэрч байна вэ гэдэг тэр агуулгаараа бол хэнд ч ойлгомжтой болоод үүнийхээ үднээс бидний иргэд маань өөрийнхөө эрх, хэм хэмжээ эрхийгээ мэдээд эрхээ хамгаалуулахдаа өөрөө субъект гарахд өөрөө өөрийгөө хамгаалах чадвар нь ч дээшлэх учиртай байх. Тэр нэрний хувьд бол та бүхэн бодогдоо л доо.

Иргэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол журмыг хуулиар тогт ооно гэдгийг тодорхой тайлбарлана уу гэж. Энэ 2 л зүйл байгаа юм л даа, мэдээж хэрэг одоо бидний олсон томоохон ололт бол ингээд ярих дээрээ бид эмнэлгийн, эмнэлэг үйлчилгээний тогтолцоог бий болгож чадсан явдал бөгөөд иргэд үнэ төлбөргүй эмчилгээгээр үйлчлүүлж байгаа энэ зүйлүүд, цаашид бид нар нэг талаас иргэний эрүүл мэндийнхээ төлөө өөрөө хүлээх хариуцлагыг нэг талаас өндөржүүлэх тухай асуудал, нөгөө талаас нь болбол эмнэлгийн чадваржуулах тухай асуудлыг нөгөө 3 дахь ч талаас бид нар зах зээлийн эдийн засагт шилжих энэ хэдэн түгээмэл хандлага руу орж байх энэ үүднээсээ болбол мөн энэ асуудлыг эхнээс нь түгээмэл байдал оруулж байгаа юм. Ингэхэд 2 зүйл, иргэдэд төлбөргүй тусламж үзүүлэх болзол журмыг хуулиар тогтоох уу, төлбөртэй үзүүлэх болзол журмыг нь тогтоох уу гэдэг ийм 2 байдал дээр асуудал гарч ирж байсан л даа. Тэгэхдээ хамгийн зохимжтой хэлбэр нь бол иргэдийн эмнэлгийг эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол журмыг л хуулиар тогтоож болох юм гэсэн ийм байдлаар оруулсан юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш. Бурмаа

Ш. БУРМАА

1991.XI.14
Кассет № 30
12.05-12.20.

Р.Гончигдорж: ...телбөргүй тусламжийг цаашид өргөжүүлэх, хэрэгжих боломж байна уу гэж.Хувийн даатгалын эмнэлэг үйлчилгээ хэр зэрэг өргөжих вэ?

Энэ асуултаараа бол таны дотор бодож байгаа энэ олон зүйлүүд цаашаагаа өргөжиж хөгжиж байгаа байх аа.Энд 98 дугаар тойргийн депутат Марав гуай ярьж байна.Өнөөдөр манай хүний эрүүл мэндийн бодлогын асуудлаар яригдаж байгаа зүйлүүд энд олон байгаа шүү дээ.

104 дүгээр тойргийн депутат Д.Шагварал гуай илтгэлтэй холбогдуулж ийм асуудал тавьсан байна.Хошуу болгохын ач холбогдлыг ... Энэ ярьсан байна.Уршигтай талыг ярьж өгнө үү гэсэн байна.Сумын хор уршигтай талуудыг илтгэлээс бага сага ойлголоо.Гэвч дараах асуултыг баримтаар хариулж өгнө үү гээд нэлээн баримтаар сонирхсон асуудлууд байна.Манай улсад сум байгаагаас болж хичнээн иргэн өөрийн сумын иргэнтэй ханилж сууж чадахгүй хэлмэгдсэн юм бэ гэж байна.Үүнээс болж аргагүйн эрхээр гэрлэсэн өрх хэд байгаа юм бэ?

Үүний харгайгаар ухаан солио, бусад эрхтэн дутуу, гажиг хүүхэд хичнээн төрж, одоо хэд амьдарч байна вэ? Сумууд байгаагаас болж бие биенийхээ нутагт орж болохгүй түгжигдсэний гайгаар хэд хэдэн оноос хичнээн мянган нутаг бэлчээр таслаад гаргасан бэ гэжээ.

Уучлаарай, энэ хүчин зүйлүүдийг үндсэн хүчин зүйл гэж огт үзэхгүй байгаа.Энээс болж, үндсэн хүчин зүйлийг бид нар би түрүүн тэр агуулга хэлбэр байдлаар нь хэллээ шүү дээ. Энэ бол үндсэн хүчин зүйл.Магадгүй энийн Үндсэн учир шалтгаан бол монголын иргэд нутаг дэвсгэр дээрээ чөлөөтэй амьдрах газраа сонгох эрхийн хэрэгжилт муу байсантай холбоотой асуудлууд нь ихэнх болохоос биш, тэр л үндсэн шалтгаан болж байсан уу гэхээс биш энэ бол сум байсны үндсэн шалтгаан гэж үзээд сумыг өөрчлөх тухай асуудлыг тавьж байгаа гэж ойлгож огт болохгүй байх.Энэ дээр шаардлагатай хүн ам

зүйн бодлогын судалгаа, энэ зүйлийг гаргая гэх юм бол энэ шалтгаанаас гэж хэлэхгүйгээр өнөөдөр энэ ямар хэмжээнд байгаа юм бэ гэдгийг сонирхвол депутатуудын асуулга тавигдвал энийг зохих байгууллагуудаар гаргуулж энийг та бүхэнд мэдээлэл хийлгэж болно. Эдгээр асуудлыг эрдэм шинжилгээний ямар байгууллага, хэн гэдэг эрдэмтэн судлан тогтоосон юм бэ гэж байна.

Хүн ам зүйн бодлогыг эрхэлдэг зохих байгууллагууд энэ талаар судалгаа хийдэг байгууллагууд бол сум байснаас болсоно шалтгаан гэж тодорхойлоогүй байх. Зүгээр бодит амьдрал дээр хичнээн хэмжээний ийм согогтой, эмгэгтэй хүмүүсүүд байна вэ? Энэ дээр судалгаагаа хийгээд тоогоо гаргачихсан байгаа.

Одоогийн түвшнээс хэт уналгүй урагш ахихад сум саад болж хошуу тус болно гэдэгт та хэр зэрэг итгэлтэй байна вэ? Таны хэлсэн үгнээс үзэхэд хошуу болгох санал, эрдэмтдийн санал юмуу гэсэн санаа төрж байна. Энэ саналыг эрдэмтэд зонхилон тавьж байгаа юмуу гэсэн байна. Илтгэлтэй холбогдуулаад Ерөнхийлөгч асуугаад Ерөнхийлөгч энэ талаар тодруулна гэвэл сүүлд хариулах хариултандаа орох байх аа. Яг энэ утгаараа надаас, миний хувьд түрүүн хэлсэн.

Санал хэрэгсэхгүй юм бол яах гэж зардал гаргаж хэлэлцүүлсэн юм бэ гэж байна. 141 дүгээр тойргийн депутат Ж. Авхиа гуай тэгэж асуусан байна.

Тэгэхээр зэрэг энэ хоёр төслийн гол гол ялгаанууд байж байгаа. Энэ ялгаанууд хэрхэн тусгасан тухай компьютер дээр гаргасан. Компьютер дээр сангийн нэлээн шинэчилсэн зохион байгуулалт гаргуулаад сонирхох юм бол бас л энэ дээр өмнөх ард нийтээр хэлэлцүүлсэн төсөл, манай саяны өргөн барьсан төсөл, дараачаар нь энд юу юуг ялгааг гаргасан, юу юуны үндсэн дээр гэдэг гуравдагч мөр баганатайгаар энэ дээр мэдээллийн сангийн зохион байгуулалтыг хийж өгсөн байж байгаа. Энэ дээрээ тулгуурлаад дараачаар нь Их цаазыг, Үндсэн хуулиа та бүхний баталсан хэлбэрээр энэ сантайгаа нийлүүлээд энэ

3.

бол манай Үндсэн хуулийг хэлэлцэж явж тогтоосон тухай бидний түүхэнд ^{үлдэх} баримт болох байх аа гэж бодож байна.

Манай Үндсэн хуулийг хэрэгжүүлж буй хугацаанд гадаадын ямар орноос хуулийн төсөл ирсэн бэ гэж байна. Энд 92 дугаар тойргийн депутат Бүдий гуай асуусан байна.

Энэ Үндсэн хуулийн төслийн хугацаанд бол манай Бага Хуралд, Бага Хурлын Тамгын газар, ажлын хэсэг, комиссын хэсгүүд бол дэлхийн олон нийтийн Үндсэн хуулийн практикийг судлах талаар чадлынхаа хэрээр л ажилласан. Энд олон олон улсын Үндсэн хуулиудыг өөрсдөө олж авсан. Түүнээс гадна элчин сайдуудаас хүсэлт тавьж олон улсуудын Үндсэн хуулиудыг авчруулж үзэж, судалсан. Түүнээс гадна мөн олон улсын байгууллагуудын шугамаар манайд экспертүүд ирж эдгээртэй нэлээд хугацаагаар бол ажлын хэсэг, комисс, Бага Хурлын гишүүд, Байнгын хороод бол хамтарч ажилласан. Энүүгээр бол эрдэмтдийн өгсөн маш олон хуудастай, маш олон санал дүгнэлтүүд бий. Мөн тодорхой, олон улсын төрөлжсөн байгууллагуудаас мөн ийм зүйлээр бид нарт хүсэлтийг тавьсан, тавиагүй аль ч тохиолдолд гаргасан зүйлүүд бий, мөн түүнчлэн олон улсын хурлыг зохион байгууллаа. Энэ болгоны үндсэн дээр бол олон улсын Үндсэн хуулийн практикийг нэлээн судалж анзаарч үзсэн гэдэг ийм хариултыг өгмөөр байна. Тоог хэрвээ шаардвал өнөөдөр бидний гар дээр хичнээн орны Үндсэн хуулийн төсөл байгааг бол хэлж болох байх.

Манай Үндсэн хуулийг хэлэлцүүлж буй хугацаанд гадаадын ямар орноос хуулийн ... уучлаарай би буруу ойлгосон байна, хуулийн төсөл ирсэн бэ гэсэн байна.

Ямар ч улсаас ирээгүй, энэ бол баталгаатай хэлж болно. Монгол улс өнөөдөр өөрөө өөрийгөө мэдэх эрх зүйн хувьд ч, мэдлэг окуны чадамжийн хувьд ч гэсэн энэ хэмжээний юмыг үгүйлэхээргүй болсон байна гэдгээрээ бахархах болов уу гэж бодож байна.

Ер нь өнөөдөр бол нэг улс хуулиа хэлэлцэж байхад хуулийнхаа төслийг өгдөг ийм эрх зүйн доройтсон соёлтой улс

орон өнөөдөр харин дэлхий нийтэд алга болсон шиг байна. Энэ бол дэлхий нийтийн өнөөгийн хандлага. Тэгэх нь байтугай гадаадын эрдэмтэд бидэнтэй маш болгоомжтой харьцаж байсныг эрхэм депутатуудад хэлмээр байна. Энэ бол зүгээр хуулийн практик, шинжлэх ухаанд ингэж байдаг юм шүү гэснээс биш би та нарт энэ саналыг хэлж байгаа юм огт биш шүү гэдэг үгийг байнга байнга давтаж хэлж байгаа юм. Тэр хурал дээр хэлсэн хүн бол өмнөө дандаа ийм удиртгалтайгаар хэлдэг. Энэ маань гайхамшигт соёл, гайхамшигтай болгоомжлол. Та нар л тогтооно шүү, өөрсдөө гэж.

"Цааз" гэдэг үгийг тайлбарлуулах санал байна гэж байна. Энэний талаар бид нар түрүүн ярихдаа төрийн сүлдээ заавал өөрчлөх шаардлагатай байна уу гэдгийг энэ болгоныг ярьсан. Би бас буруу уншаад ойлгосон байна шүү. Би арай тийм асуудал байхгүй юм байна гэж ойлгосон байна. Уучлаарай.

351 дүгээр тойргийн депутат Б.Мөнгөн, орон нутгийн засаг захиргааны нэгжийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж байгаа улс орон дэлхийд хэд байна вэ?

Энэ манайд огт байгаагүй хэлбэр.

Энэ манайд огт байгаагүй гэвэл худлаа. Энэ бол манайд байж байсан зүйл. Энэ талаар хэрэв шаардлагатай гээд түүхийн лавламж, судалгаа шаардая гэвэл, хэрэв та нарыг зөвшөөрвөл хүн оноогоод ч яриулж болно. Энэ бол манай 20, 30 оны үед байж байсан зүйл. Өнөөдөр дэлхийн ардчилал хөгжсөн боловсон орнууд, Цэвээн гуайн хэлснээр нэг үгээр илэрхийлбэл, энд бол орон нутгийн засаг захиргааны өөрөө удирдах ёс гэдэг бол өндөр хэмжээнд очиж байна.

Миний ойлголтоор Югослав улс ийм удирдлагатай байсан. Одоо тэнд бүх юм байж байна. Энэ бол уучлаарай, худлаа байж магадгүй гэж би болгоомжилж байна. Югослав улс бол холбооны улс. Миний ойлголтоор бол Югослав улс ийм удирдлагатай байсан, одоо тэнд бүх юм дампуурч байгаа биш үү гэж байна. Өөрөө удирдах ёсны тухай асуудлаар. Бид хэлээд байгаа шүү дээ. Төрийн хувьд нэгдмэл. Энэ Югослав улс чинь холбооны улс.

Бид өөрөө удирдах ёс гэдэг маань бид орон нутгийн засаг захиргааны нэгжийнхээ хувьд ярьж байна шүү дээ.

Тийм ч учраас энд ямар нэг хууль тогтоох эрх мэдэл, шүүн таслах эрх мэдэл, энийг хэрэгжүүлэх парламентын юм бол тэр орон нутгийн юманд юу ч байхгүй байгаа. Энийг бид маш их ухаалаг ялгаж ойлгохгүй бол Үндсэн хуулиа хэлэлцэхэд санал өгөхөд их бэрхшээлтэй болно.

182 дугаар тойргийн депутат Г.Батболд асуусан байна. Одоогийн сүлдийг боловсронгуй болгох, сүлдний тухай асуулт байна. Асуулт нь өөр юмаа. Одоогийн сүлдийг боловсронгуй болгох буюу өөрчлөх, өөрөөр хэлбэл, манай эдийн засгийн гол салбар мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр гэдгийг нэгтгэн харуулсан нэг ч загвар Улсын Бага Хуралд ирээгүй юмуу, үзэсгэлэнд тавигдсан сүлдний загвар бол ялангуяа шувуу, шонхор, эзэнгүй морь зэрэг нь сэтгэлд буухгүй байна гэж байна.

Ийм загварууд ч байгаа л даа. Тухайлбал, энэ сүлднээс маань өмнө байсан сүлдийг ч гэсэн санал болгосон юм байгаа. Сүүлд ирсэн зурагнууд дотор ийм байсан. Бидний гол бодох юм бол ер нь бид төрийнхөө сүлдээр илэрхийлэгдэх бэлгэдлийг ямар агуулгын бэлгэдлээр бид илэрхийлэх вэ гэдэг дээрээ бодоцгоод тэрэнд нь юу тохирох вэ гэдэг дээрээ бодвол яасан юм бэ гэсэн зүйл байна. Ийм учраас энд зарчмын агуулгын хувьд бид энд үнэхээр мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн орон гэдгийгээ илэрхийлэх бэлгэдлийн агуулгын сүлд байх юмуу, эсвэл өөр шинж чанарын агуулгатай бэлгэдлийг сүлд илэрхийлэх ёстой юмуу гэдэг. Ер нь сүлд гэдэг чинь юу юм бэ? Ямар бэлгэдлийг илэрхийлэх ёстой юм. Тэр илэрхийлэгдэх бэлгэдлийн субъектууд юу юунаас бүрдмээр байна вэ гэдэг энэ тал дээрээ бодох зүйл их бий байх аа. Энэ маань манай түүхэн уламжлалын хувьд ямар ямар бэлгэдлийн агуулгаар орж ирж байж вэ? Хэдий үед аж ахуйжсан, эдийн засгийн хэвшлээ тусгасан бэлгэдлийн шинж нь давамгайлж вэ, дэлхий нийтийн хувьд, тухайлбал, улс орон сүлдтэй байдаг гээд, сүлд гэдгээрээ бэлгэдлээ илэрхийлэхдээ

юугаа бодож бэлгэдлээ илэрхийлдэг юм бэ гэсэн ийм арга зүйн талаас нь бүгдээрээ бодоод тэгээд олон хүний санаа бодлоо нийлүүлбэл, одоо бидний юунаас боломжтой сайхан ийм бэлгэдэл тэмдэг маань гарах болов уу гэж бодох юм даа.

Цагаан лянхуа цэцэг дээр суурилуулсан соёмбо ямар утга илэрхийлж байгаа ойлгохгүй байна гэж байна. Соёмбогийнгоо бид нар ямар утгыг илэрхийлж байна вэ гээд өдий хүртэл туган дээрээ тавиад явж байсан. Одоо юу гэж ойлгох ёстой юм бэ? Цагаан лянхуаг дор нь суурилуулснаар ямар утга илэрхийлж байгаа юм бэ бид сүүлд тайлбараараа ярьж л даа. Одоо би энийг дэлгэрэнгүй яриад байх юм байхгүй байна. Та нарт хангалттай дэлгэрэнгүй тайлбар ярианууд би байгаа гэж бодож байна.

Асуулт. 2 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 13-т халдашгүй чөлөөтэй байх эрхтэй гэж заажээ. Хүн ёсоо алдсан, монгол уламжлалаа бузарласан, онц догшин аюултай этгээдийг тодорхой хугацааны дараа баривчлах эрх автал ард иргэд түүнд хориг тавих ёсгүй боллоо гэж эмзэглэж байна гэж байна.

Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур зоргоороо хэнийг ч нэгжиж, баривчилж, хорих, мөшгих, эрх чөлөөг хязгаарлахыг хориглоно. Энийг ингэж ойлгосон болов уу даа. Урьд талынхын хараарай. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур.

Хуульд заасан үндэслэл журам маань таны яриад байгаа, эмзэглэж байгаа энэ зүйлийг хаачихсан байгаа шүү дээ. Тийм учраас хууль заасан үндэслэл журам энээс гадуур, энээс гадуур дур зориг байж болохгүй. Бид хуулиа эрхэмлэх, хуулиа дээдлэх эрх зүйт төрийг хэвшүүлэх гэдэг агуулгаараа бид энийг ойлгож болох зүйл.

Мөн бүлгийн 14-т өөрийн болон гэрийн бүлийнхээ гишүүд, төрөл садныхаа эсрэг мэдүүлэг өгөхгүй байх гэжээ. Энэ одоо зарим газар гараад байгаа ноцтой гэмт хэрэг үйлдэл, хохирог-

чийн хохь, амь амьдралаа хамгаалах эрхтэй гэдэгтэй зөрчилдөж байгаа юмуу? Би хуулийн анхан шатны мэдлэггүй хүн. Хууль тогтоогч, түүнийг сахиулагч нар юу гэж үзэж байгаа бол доо гэж байна.

Энэ бол хүний эрхийг хамгаалах тал л даа байгаа зүйл. Тэрнээс биш хүний эрхийг хохироох талдаа байгаа зүйл биш ээ гээд хэлчихье. Яагаад тэгэж байгаа юм гэдэг нарийн тайлбарыг энд өгч болно. Нэг эрхийг хамгаалж, нэг эрхийг нээж, нөгөөдүүлийг хааж байгаа ийм хэдэн зохицуулалт байдаг шүү дээ. Хэрэв хуучин өөрийнх нь гэр бүлийн эсрэг мэдүүлэг өгөхийг хуулиар шаарддаг, албаддаг байсан бол одоо энэ албадлагаас тэр хүнийг чөлөөлж, тэр хүн мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хамгаалж өгч байгаа юм. Хэрэв шаардлагатай гэж үзээд өөрөө өгөх тухай асуудлыг тавих юм бол энэ хүний эрх хаагдаагүй байгаа. Тэгэхээр ингээд бодохоор хүний аргагүй байх эрхийг энэ хамгаалж байна гэдэг нь ойлгомжтой болж байгаа юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:

Handwritten signature

Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

1991.11.14

Кассет № 31

12.20-12.37

Улсын Бага Хурлын дарга, 56 дугаар тойргийн депутат Р.Гончигдорж:

Улсын нэр, Үндсэн хуулийн нэр, сүлд, тэмдэг, далбааг еөрчлөхгүй бол их 7 болон манайд өнөөдөр өгөөмөр зан гаргаж, тусламж өгч байгаа улс орнуудтай тогтоосон харьцаанд нөлөөлө гэсэн бодол, таамаглал, санаа болон таны тодруулж байгаа байна уу гэж.

Ийм зүйл байж ч болохгүй. Энэ бол улс орны бүрэн до- тоод хэрэг бөгөөд, өөрийнх нь эрх мэдэл, ард түмнийх нь эрх мэдэл, түүгээр уламжилсан дээд байгууллагынх нь тогтоох эрх мэдлийн хэмжээ. Бусад харьцааны зохицуулалт, энэ асуудлууд дээр Үндсэн хуулинд зарим өөрчлөлтүүд гарах юм бол тэр маань гадаад харилцааны нөхцөл байдал дээр хуулийнхаа дагуу янз янзын өөрчлөлт гарч ирж болно. Тэгэх юм бол харин өөр хэрэг. Тэгэх юм бол угаасаа энэ байдал хэрэгжих Үндсэн хуулийн боломж- гүй болчих асуудал. Энэ бэлгэ тэмдгийн хувьд ийм асуудал байж болохгүй.

Монгол улсад сүм, хийд төрөөс тусгаар байна гэдгийн учрыг тайлбарлана уу гэж байна.

Сүм хийд маань өөрийнхөө юмыг өөрөө хийнэ. Төр маань өөрийнхөө юмыг хийнэ. Төрийн хэрэг сүм хийдийн болох байгуул- лагаас хутгалдахгүй , төрөөс сүм хийд болох ^{байгууллагын} үйл хэрэгт нь дотор нь орж хутгалдахгүй гэсэн ийм л түгээмэл агуулга:

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал гэдэг юу юм бэ?, түүнийг тайлбарлана уу гэж байна. Энэ дээр тайлбарлах зүйл алга. Энэ Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд сонгогдож гарч ирсэн төрийн дээд удирдлагын гишүүнийхээ хувьд бол энэ хүний хувьд тодорхой онцгойлсон эрх, эрхийн байдал үүсч байгаа юм.

Энэ байдлынхаа үүднээс халдашгүй дархан байх, үүнийг нь хуулиар зохицуулагдах ийм харьцаанууд үүсч байна. Тийм ч учраас хэрэв ийм хүмүүсүүдийн хувьд эрх зүйн зөрчлийн харьцаа үүсэхэд нэн тэргүүнд энэ онцгой эрх байдлынх нь үүднээс авч үзэх Их цаазын цэцийн төвшинд тэр байгууллага Их Хурлынх нь хувьд авч үзэх асуудал. Сонгогчдынх нь хувьд авч үзэх асуудал. Тэгсний дараагаар иргэнтэй нэгэн адил болсных нь дараа бүх иргэд, хуулийн өмнө, шүүхийн өмнө адил иргэдэг утгаар нь нөгөө асуудал нь хэрэгжээд явчих ийм л зүйл байгаа юм.

Тийм учраас энэ хүнд гарч ирж байгаа онцгой бүрхэвч байна. Тэр бүрхэвчин дээр үүсэх харьцааны хувьд бол гарцаагүй төрийн байгууллагын, дээд байгууллагынхаа хувьд холбогдолтойгоор энд онцгой байдал үүсч байгаа юм. Энэ бол хангамж биш. Хангамж гэдэг аж ахуйн утгаар хангамжийн тухай асуудал энд яригдахгүй байгаа юм. Эрх зүйн хангамжийн асуудал, эрх зүйн баталгааны асуудал.

Мизимхан /74 дүгээр тойргийн депутат/ гуай асуусан байна. Баян-Өлгий аймгийг татан буулгах асуудал Их цаазын төсөлд ороогүй гэж та хариуллаа. Гэтэл 1995 оноос нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, Баян-Өлгий аймаг, тэртэй, тэргүй бусад аймагт нийлнэ биз дээ.

-Мэдэхгүй, та яагаад тэгж үзэж байгаа юм бэ? Ойлгохгүй байна. Би даасан аймаг болж үлдэнэ гэсэн ямар баталгаа байна вэ? Саналаа хэлж байх шиг байна.

78 дугаар тойргийн депутат С.Исхан гуай асууж байна. Ямар ч тохиолдолд үл халдах иргэдийн халдашгүй иргэнд юу юу байдаг вэ? Үүнийг Их цаазад тунхаг лах аргагүй юу?

-Их цаазад төрөлжүүлэн тусгах хэлбэрээрээ бол бүгдийг нь тусгаад хэлчихлээ шүү дээ.

Үндсэн хуулийн цэц энгийн иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авдаггүй, зөвхөн дээгүүр зиндааны ханатай ажиллахаар дархлагдсан нь ямар учиртай юм бэ?

Энд Үндсэн хуулийн цэц иргэдээс өргөдөл гомдол авч болохгүй гэсэн юм байхгүй байна шүү дээ. Энэ Үндсэн хуулийн цэцийн авч үзэж, шийдвэрлэх, шийдвэрлэхээр уламжлах ийм зүйлүүд юу вэ гэдгийнхээ хувьд ярьж байгаа. Энэ бол үндсэн хууль зөрчлөлттэй холбогдсон тухай асуудал. Иргэдээс Үндсэн хууль зөрчлөлттэй холбогдсон тухай асуудлыг Үндсэн хуулийн цэцэд тавихад, тэр өргөдлийг авч үзэж, судалж, энд үнэхээр Үндсэн хууль зөрчсөн байна уу? үгүй юу гэдэг асуудлыг авч үзэж л таараа. Тэгэхдээ ингэж авч үзэх хэр хэмжээнд Дээд шүүхэд байгаа тэр эрх хэмжээний дагуу авч үзэгдэх асуудал байна уу? Их цаазын цэцийн хэмжээнд авч үзэж, шийдвэрлэх хэмжээний асуудлууд байна уу гэдэг агуулгаараа энэ бол тодорхойлогдоно.

Түүнээс гадна Их цааз тодорхой хэсэг асуудлынхаа хүрээнд Их цаазынхаа цэцийн асуудлыг авч үзээд тэгснийхээ үндсэн дээр Үндсэн хууль зөрчигдсөн тал нь Дээд шүүхийн чиг үүргийн дагуу шийдвэрлэгдэхээр болсон үенээс нь эхлээд түүндээ шилжүүлж, шийдвэрлэх ийм асуудлууд байгаа шүү дээ.

Ийм юмнууд нь эндээс Бага Хурлын байнгын хороон дарга хэлж байна. 17-ийн 2-т тийм эрхүүд нь томъёологдож, хийгдсэн байгаа гэж. Тийм учраас өргөдөл гомдлоор энэ асуудал яригдана. Яригдахаас өөр арга байхгүй.

Аймаг, хөшүүдийг аажмаар 1995-97 оноос эхэлнэ гэж тайлбарласан, тэр үед одоогийн сум, баг болох юм байна. Тэр хүртэл хугацаанд одоогийн сумд дороо баг гэж байх уу? Тэр үед сум, баг болно ч гэсэн юм огт байхгүй, тэр хугацаанд одоогийн суман дотроо баг ч гэж байх уу гэж байна. Баг байгуулах тухай асуудлыг шууд Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос эхлээд хэрэгжүүлэх тухай саналыг Хавсралт хуулин дотор оруулсан байж байгаа, 1992 оны I дүгээр сарын I-нээс эхлүүлээд. Түүнээс гадна одоогийн хувьд энд байгаа төрийн захиргааны нэгж болохынхоо хувьд биш гэхэд сумынхаа эрх хэмжээг шилжүүлэх утгаараа авч үзэх утгаараа багийг зохион байгуулах энэ

эрхийг бол Бага Хурлаас тогтоолын хэмжээнд өгчихсөн.Зарим газар ийм шинжтэй зохион байгуулалт хийгдээд явж байгаа шүү дээ. Сумын эрх хэмжээг өөр дээрээ шилжүүлэн хэрэглэх утгаараа. Энэ бол биеэ даасан засаг захиргааны нэгжийн утгаар байгаа.

38 дугаар тойргийн депутат Чойжамц гуай асуусан байна. Олон зуун жилийн уламжлал, ариун ёс түүх, соёл зан заншлаа хадгалан үлдээх, хөгжүүлэх талаар заалт бий юу?

-Ерөөсөө манай Үндсэн хуулийн нэг гол агуулга, тулгуур чулуун нь бол бид олон зуун жилийн уламжлал, ариун ёс түүх соёл, зан заншлаа хадгалан үлдээх энэ агуулгыг бид оршил хэсэг болгоод, цаашдын бүх хэсэгтээ үүнийгээ авч яваа гэж ойлгогдож байгаа.Үгээр биш үйлээр илэрхийлэх байдлаар Үндсэн хуулийн Их цааз гэсэн төсөл тусчээ гэж ойлговол зүйтэй болов уу.Нэмж юу тусгамаар байна уу? түүнийгээ та бүхэн хэлээрэй.

Их цаазад төрийн эрх уламжлагдах зарчмыг хэрхэн хэрэгжүүлэхээр заасныг тайлбарлана уу гэсэн байна.

Чухамхүү энэ үүднээсээ одоо төрийн хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх, төрийн эрх дээд байгууллага, Улсын Их Хурлыг 3 жил тутамд шинэчлэх байдлаар оруулж байгаа энэ маань төрийн эрх уламжлагдах зарчмыг баримтлах гэсэн гол үндсэн шалтгааны үүднээс үүнийг ийм болгоод байгаа юм.Ийм арга механизм байдаг юм байна.Үүнийг бид авч хэрэгжүүлбэ гэсэн ийм байдалтай байгаа юм.Түүнээс гадна зарим зүйлүүд байдаг шиг байна, тэр талаар ярилцаад, энэ талаар Бага Хурлаас энэ төсөлдөө оруулсан. Тухайлбал, Ерөнхийлөгч байсан хүний цаашдын асуудлууд , энэ Дээд шүүхийн гишүүд гэх мэтчилэн олон зүйлүүд дээр уламжлалт онцлогийг харгалзсан юмнуудыг хэрхэн тусгах вэ гэдэг асуудлууд байсан.

Төрийн засгийн тогтолцоонд улс төрийн намууд үүрэгтэй байх, тэдгээрийн үйл ажиллагааны хүрээг Их цаазад товч томъёолж болохгүй юу гээд би үүнд хариулт хэлчихсэн.

Намуудын үүрэг роль, эрх хэмжээний талаар. Энэ бол аргагүй улс төрийн тогтолцоонд оролцох оролцлогоог намуудын хувьд тов тодорхой болгож үзсэн гэж энэ Үндсэн хуулиар ойлгож байгаа. Их цаазын төслийн 29 дүгээр зүйлийн 3 дугаар заалт нь 47 дугаар зүйлийн 2 дугаар заалттай зөрчилдөх үү? Үүнийг тайлбарлана уу гэсэн байна.

29-ийн 3 дугаар зүйл Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг зөрчилд холбогдсон тухайд гагцхүү Улсын Их Хурлын чуулганаар хянан хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн санаалаар шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоогдвол эгүүлэн татаж шүүхэд шилжүүлнэ гэж байгаа заалт нь, 47-гийн 2, хуулиас гадуур шүүх байгуулах хийгээд шүүх эрхи мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. Энэ огт зөрчилдсэн юм байхгүй. Түрүүн хэлсэн, энэ Их Хурлын гишүүдийн халдашгүй байдлын хууль гэж. Тэгэхээр Их Хурлын гишүүн гэдэг дотроо иргэн иргэний гадна талд Их Хурлын гишүүнийхээ аль нэг онцгой, эмнэлгийн хэлээр хэлбэл имунитеттэй байгаа юм. Тэр имунитетийг эхэлж халдаад, тэр хальсыг нь хуулж авсны дараагаар иргэн болоод, иргэн болоод жинхэнэ шүүн таслах үйл ажиллагаа бол зөвхөн түүнийг хэрэгжүүлдэг шүүхээрээ л хэрэгжүүлнэ.

Энэ Их Хурал дээр хэлэлцэж байгаа асуудал маань бол энэ хүнийг Их Хурлынх нь гишүүнээр байлгах уу, үгүй юу гэдэг асуудалтай холбогдсон утгаар нь энэ асуудлаа авч үзэж байгаа юм. Тэгээд үнэхээр энд үүсч байгаа асуудал маань энэ хүнийг Их Хурлын гишүүн байлгах ийм хэмжээнд биш байна гэж үзэх үүднээс шийдвэрлэх юм бол шийдвэрлэчихээд, иргэн болохынх нь хувьд, шүүхдээ шилжүүлнэ гэсэн үг. Тэгээд шүүн таслах үйл ажиллагаагаа хэрэглэдэг тэр 47-гийн хоёроор тэр нь зөвхөн хэрэгжинэ. Ийм л юм байгаа юм. Энэ маань зарим газрын тухайлбал АНУ-ын сенатад байдаг шиг тэр шүүх биш. Энд жинхэнэ утгаараа тэр дотроо шүүх байдаг. Энэ бол тэр утгаар байгаа биш. Ингэж ойлговол зүйтэй болов уу?

37 дугаар тойргийн Бямбаа гуай асуусан байна. Газрыг заавал хувьд өмчлүүлэх гээд байгаагийн зорилго, ач холбогдол юу вэ гээд, түрүүн ярилаа. Зөвхөн удаан хугацаагаар гэрээ түрээсээр эзэдмшүүлж болохгүй юу? Хэрвээ газрыг хувьд өгвөл

үр тарианы талбайг өгөх үү гэж байна. Хувьд өгөх асуудал хувьд газар тариалан эрхлэхээр газар өмчлүүлэхийг хориглоно гэсэн заалт байхгүй байгаа. Бүх газар тариаланг хувьд өгнө гэсэн заалт байхгүй байгаа. Тийм учраас энэ бүх хэм хэмжээ бол өөрийнхөө хэм хэмжээгээр зохицуулагдана гэж ойлгогдож байна.

Төрийн албан хэргийг ямар бичгээр хөтлөхийг Үндсэн хуульд... энэ түрүүн ярьсан. Шашны сургуулийг төрөөс санхүүжүүлэх үү? гэж байна. Төрөөс санхүүжүүлэхгүй. Сүм хийдийг улсын хөрөнгө оруулалтаар байгуулах уу гэж байна. Сүм хийдийг улсын хөрөнгө оруулалтаар бас санхүүжүүлэхгүй. Энэ чинь сүм хийд төрөөс тусгаар байна гэдэг. Ганцхан энд нэг зүйл бий. Шашны сургуульд иргэний боловсролыг олгох ёстой үүргийг хүлээх учиртайгаар байгуулагдах тухай асуудал бий. Үндсэн хуулийн төсөлд, эрхэм депутатуудаас уучлал гуйя, тэр ерөнхий боловсролыг, үнэ төлбөргүй олгоно гэдгийн өмнө төрийн сургуулиар гэсэн тодотголыг энд хасалгүйгээр оруулсан байна билээ. Би тэнд редакцийн засварыг эрхэм депутатуудаас хүвнэ. Энэ зүтгээр ерөнхий боловсролыг тэнд олгож байгаагийнх нь хувьд эсвэл тэндэх ерөнхий боловсролыг нь зохион байгуулахынх нь хувьд оролцох оролцолгооны талаар бол хууль зүйн тайлбарын үүднээс хандах, зөвхөн тэнд л нэг зүйл бий. Түүнээс шашных нь сургалтынхаа цэвэр эрхэлж байгаа утгаар тэнд санхүүжилт байж болохгүй. Өөрөөр хэлбэл энэ Үндсэн хууль хүчин төгөлдөр болбол гэсэн үг шүү дээ, энэ заалтаараа.

I7 дугаар зүйлийн 5-д төрөөс эдийн засгийн тусламж авах эрхтэй гэдэгт юу хамаарах вэ? тэтгэвэр, тэтгэлэг байх уу? төрийн шагнал, одон медаль байх цол цаашид байх уу? гэж. Энэ бол төрөөс эдийн тусламж авах эрх гэдгийн дор бол тухайлбал одоо тэтгэвэр, тэтгэмж авах хөдөлмөрийн чадвараа түр алцахад төрөөс авах энэ болгон чинь орчихож байгаа шүү дээ. Төрийн байгууллагаас нэг удаагийн тусламж болгож олгодог гэх мэтчилэн янз янзын зүйлүүд байгаа. Энэ болгоныг. Түрүүн ард нийтээр хэлэлцүүлсэн дээр арай дэлгэрэнгүй оруулсан байгаа. Ерөөсөө тэгээд үүнийг төрөөс эдийн тусламж олгуулах энэ бүх хэлбэрийг өнөөдөр тоочиж баршгүй.

Энэ маань улам цаашаа өргөтгөх чиглэлдээ байж магадгүй юм. гээд ерөөсөө ийм товч хэлбэрээр оруулчихсан байж байгаа. Энэ төрийн шагнал, одон медаль олгох уу? үгүй юу гэж байна. Байна гэж бодсон учраас Ерөнхийлөгчийнхөө онцгой эрх мэдэлд олгох тухай түүнийг бий болгох тухай, энэ Их Хурлынхаа онцолсон эрх мэдэлд оруулаад явж байгаа шүү дээ, Их цаазын төсөл дотор.

Төслийн 46 дугаар зүйл Улсын яам байх, тэр нь тусгай хуулиар байгуулагдана гэж ойлголоо. Энд орон нутгийн өөрөө удирдах байгууллага, яамны хооронд ямар уялдаа байх вэ гэж байна. Энд хариулт өгөөд байх шаардлага байх уу даа. Энэ бол түрүүн би тайлбарласан, хуулийн үндсэн дээр байгуулагдах тухай асуудал ярьж байгаа шүү дээ. Хуулийн үндсэн дээр, тэгээд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаагийнхаа хувьд засаг дарга, Засгийн газартайгаа, дээд байгууллагатайгаа яаж харьцах вэ? тэр утгаараа одоо яам, Засгийн газар Ерөнхий сайд, засаг даргын харьцаа энэ болгон бол өөрсдийн үйл ажиллагаанд зохицуулахаар байж байх харьцаанууд байх.

264 дүгээр тойргийн депутат Цэнджаргал гуай асуусан байна. Улсын Их Хурлын гишүүний гэмт хэрэг, зөрчилд холбогдсонх тухайд Их Хурлын гишүүний саналаар үйлдсэн .../энэ түрүүн яригдсан юм байна./ гэх үндэслэлгүй гээд л шийтгэвэл ял завших боломж гарахгүй гэх баталгаа байхгүй юм шиг санагдана. Үүнийг юу гэж үзэх вэ гэж? Энд ял завшиж тухай асуудал үүсч яригдахгүй байхаа гэж бодож байна. Энд өөр янз янзын хяналтын механизмууд дотроо байгаа шүү.

Монгол улсын Их цаазын төсөл хэлэлцэх явцад Монгол улсын Ерөнхийлөгч сонгуулийн хугацаа дууссаны дараа Улсын халамжинд тодорхой хугацаагаар байх тухай яригдаж байсан уу? 50 нас гэж тогтоосны би зарим талаараа үүнтэй холбоотой юм болөв уу гэж бодож байна. Их цаазын хоёрдугаар бүлэгт энэ асуудлыг тусгайлан оруулах уу? эсвэл Ерөнхийлөгчийн тухай хуулиндаа... Ерөнхийлөгчийн тухай хууль гэж тусдаа гарна.

Одоо бид нар дараагаар нь энд байгаа шүү дээ. Энэ Хавсралт хуулийн дотор та бүхэн танилцаж амжсан байх гэж бодож байна. Энэ хууль тогтоох үйл ажиллагаа, цаашид шинэчлэх үндсэн хууль-даа нийцүүлж, ^{үйл ажиллагааг} + зохион байгуулах хэд хэдэн үе шаттай байгаа. Нэг нь бол одоо 1992 оны 3 дугаар сарын I-нээр, дараа нь 1992 оны 7 дугаар сарын I-нээр, дараагаар 1993 оны 7 дугаар сарын I-н байна уу?, тэгээд 1997 оны 7 дугаар сарын I. Ийм үе шаттайгаар байгаа. Үүний эхний 1992 оны 7 дугаар сарын I дотор багтаах асуудлууд дотор саяны асуудлууд байж байгаа. Тэгээд түрүүн Бага Хурлаас гаргасан Ерөнхийлөгчийн хуулийг энэ хуульд нийцүүлэх талаар тусгах тухайр асуудал байх уу? эсвэл шинэ үндсэн хуулиар нийцүүлээд шинээр тийм хууль гаргаж, өмнөх хуулиа хүчингүй болгох уу гэдэг асуудал бол хуулийн технологийн асуудал байх. Тэр бол яригдах зүйл. Тэгээд тэр бусад асуудал энд л тусна.

50 нас гэдгийг үүнтэй холбогдсон гэдэг учир шалтгаан бол байхгүй. Бага Хурал дээр ямар ч байсан энэ учир шалтгааны холбоо гэж авч үзэж, санал тусгагдаагүй юм.

Уугуул иргэн гэдгийг тайлбарлаж өгнө үү гэсэн байна. Уугуул иргэн гэдэг маань манай иргэний харьяаллын хуулийн дагуу шууд төрөхдөө тэр хуулийн дагуу л монголын иргэн гэж бүртгэгдсэн, ийм утгаар нь үүнийгээ бид уугуул иргэн гэдэг ийм утгаар нь ойлгож байгаа.

II бүлгийн 16 дугаар зүйлийн 2-т томъёолсноор цагаачлалын тухай ярьж байна гэж ойлгож болох уу гэж байна. 16-ын 2. бол ингэж байгаа юм. Монгол улс олон улсын гэрээгээ гадаадын иргэдийн иргэний эрх үүргийг тодорхойлохдоо уул иргэний харьяалсан улстай энэ талаар харилцсан, адил байх зарчим баримтална гэж байгаа юм. Энэ бол цагаачлах тухай ярьж байгаа юм. байна гэх юм бол энэ бол тэгсэн үг биш. Нөгөө л бид нар хуулиндаа хэлж байгаа шүү дээ. Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгаа гадаадын иргэний эрх үүргийг Монгол улсын хууль, уул иргэний харьяалах улстай байгуулсан гэрээгээр тогтооно. Ингэхдээ бол ийм зарчмыг баримтална гэж хэлж байгаа шүү дээ. Харьяалалгүй улсуудын хувьд бас өөрөөр зохицуулагдана.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Д. БАЯНДУҮРЭН

Р.Гончигдорж /56 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын дарга/ -За дараачаар нь Сейтмурат гуай асуусан байна, 77 дугаар тойрог, сүлдэнд орохоор цагаан шонхор шувуу монголын ард түмний түүх, үндэсний уламжлалд ямар гавьяа учир холбогдолтой юм бэ? гэсэн байна. Тайлбарлахад гарах байх. Үе үеийн гялбаанууд маш олон байдаг юм байна билээ. Анхны туг гэж гарч байхад тэрэн дээр байсан байх жишээтэй байна гээд сүүлд ярина биз дээ.

За 112 дугаар тойргийн депутат Могойтар гуай асуусан байна. Уучлаарай нэр буруу уншиж байвал та бүхэн залруулаарай. Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэх гэсэн ямар учиртай юм бэ? гэсэн байна. Энийг ярьчихсан. 50 хувь нь үүргээ биелүүлж чадахгүй хүнийг ард түмэн сонгох болж байна уу? гэж, тийм гэсэн утга энд огт байхгүй шүү.

Улсын болон хуулийн нэр, төрийн сүлд далбаа... энийг ярьсан. Хошуу байгуулах, энэ асуудлыг ярьсан. Үндсэн хуулийн төсөл боловсруулах явцад комиссын дотор ямар асуудлаар санал зөрж авч ярьж байсан бэ гэнэ. Энэ тухай асуудлыг бид одоо энд яриад байх хэрэггүй байх даа, ач холбогдолгүй юм л даа гол нь. Зүгээр ямар ямар зарчмын асуудлууд үзэгдэж байв гэдэг асуудал яривал, илтгэлд орчихсон байж байна.

Ардын Их Хурлын гишүүдийг 76 гишүүнээр тогтоосон үндэслэлээ тодруулна уу гэж байна. Энэ үндэслэлийн талаар түрүүн ярьсан.

Ард нийтээр хэлэлцүүлсэн төслийг харгалзан танай комиссоос Бага Хуралд оруулсан Их цаазын төслөөс заавал байх зүйлүүдээс Бага Хурлаар хэлэлцэх явцад хасагдсан уу? Тийм зүйлүүд байвал товч тайлбарлана уу? Өөрөөр хэлбэл Их цаазын төсөл боловсруулсан комиссоос Бага Хурлын хооронд зөрөөтэй

ямар онцгой саналууд байна вэ? Байвал ямар зүйл байна вэ гэсэн асуудлууд байна. Энэ талаар ярих шаардлагагүй зүйл шиг байна.

Энэ Цэрэннадмид гуайн асуудал давхардаж, түрүүн Цэрэн гуайн асуудал ийм байдалтай байна. 220 дугаар тойргийн депутат Цогтбаяр гуай, хүний эрхийн заалтад хуульд заасны дагуу төрөөс эдийн тусламж авах эрхтэй гэж байна. Үүнийг тайлбарлана уу гэсэн байна. Яг түрүүн ярьчихлаа.

За энд Нямдаваа гуайн асуудал давхардаж байна. Одоогийн сум цаашдаа хошууны зохион байгуулалтад шилжих, хошууны бүтэц, зохион байгуулалтын талаар тайлбарлана уу гэсэн байна.

Манай орны нийгмийн амьдралд олон нийтийн байгууллагууд ямар үүрэг гүйцэтгэнэ гэж та үздэг вэ? Тэдний хөрөнгө, сан хөмрөг хэр зэрэг батлгаатай байх бол гэж Гүррагчаа гуай асуусан байна. Энэ талаар хариулах шаардлага байна уу даа. Би энэ Үндсэн хуулийнхаа хүрээнд ярьж байгаа зүйлүүд дээрээ л яривал. Зүгээр аж ахуйн нэгжийн хуулийн дагуу асуудлыг зохицуулах асуудал дээр бол бэрхшээлтэй асуудлууд байгаа. Тэр асуудлын хүрээнд ярьж байгаа, шүүх дээр ч ярьж байгаа. Олон нийтийн байгууллагаас аж ахуй эрхлэхгүй гэдэг утгын хүрээнд байгаа хөрөнгөтэй улсууд хөрөнгөө хэрхэн эзэмшин, захиран зарцуулах гэдэг асуудал дээр гарч байгаа маргаанууд бий байх. Тэр бол бусад хуулиудынхаа бусад асуудлаар зохицуулагдах асуудлууд.

За энэ 78 дугаар тойргийн депутат Исхан гуайн асуудал бас давхардаж байна. Тариалангийн талбай, хошуу, сум болгох. Тариалангийн талбайг иргэдийн хувийн өмчид өгөхөөр төрхжээ гэж байгаа юм л даа. Өгөхөөр тусаагүй шүү дээ. Тиймээ. Хориггүй гэж байгаа юм. Тариалангийн талбайг иргэдийн хувийн өмчид өгөхийг хориглоогүй байгаа юм. Тэгээд хэдэн хувь нь байх юм, ямар үнэлгээ тооцоо байна вэ гэж чухамхүү энийг Газрын тухай хуулийг ярихдаа энд маш бодож ярих тухай асуудлууд

бий.

За 34 дүгээр зүйлд анхан шатны сонгуульд олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно, эсвэл олонхийн санал аваагүй хамгийн олон санал авсан хоёр хүний нэгийг Улсын Их Хуралд оруулан сонгоно гэж байна. Энд зөрчил байгаа юм биш үү. Эхний тохиолдолд Ерөнхийлөгч бүх ард түмнээс сонгогдсон учир парламент, түүний эрхийг хөндөх эрхгүй буюу, Ерөнхийлөгчийн засаглал тогтоох бус уу гэсэн байна. Түрүүн энэ хоёр шаттай гээд, учир шалтгааныг ярьсан. Түүнээс гадна яагаад заавал Их Хурал дээр хуульчлан баталж байгаагийн учир холбогдол, түүнээс үүсээд Их Хурал Ерөнхийлөгчийг сонгох, огцруулах тухай эрхийг эдэлж байгаа энэ эрх зүйн харилцаа, саян хуульчлан баталж байгаагаас үүсэх энэ балансууд байж байгаа юм, эрхэм депутатууд аа. Харин ард түмнээс шууд сонгогдсон гэдгээрээ Ерөнхийлөгчийн засаглал тогтдог юмаа гэдэг ойлголт байгаа бол энэ бол буруу ойлголт. Жишээ ярьж болно, шаардлагагүй болов уу гэж бодож байна. Олон олон улсуудад парламентын, төрийн удирдлагын парламентын хэлбэртэй олон улсуудад Ерөнхийлөгч нь шууд сонгогдоод, тэгэхдээ тэр бол Ерөнхийлөгчийн засаглалгүй байж байдаг.

Түүнээс гадна энэ бол Ерөнхийлөгч шууд ард түмнээсээ сонгогдоно гэж нэвэр хэлснээс бас арай жаахан өөр учир байгаагийн нь би түрүүн хэллээ шүү. Тэгээд нарийвчлах гэвэл сүүлд бид ярилцахдаа ярих зүйл. Энэ 7 дугаар тойргийн депутат Балдорж гуай асуусан байна.

128 дугаар тойргийн депутат Пүрэвдорж гуай, Их цаазын төсөл боловсруулах комиссын төсөл Бага Хурлаас баталж Их Хуралд орсон хоёрын хоорондох зөрөө. За энэ тухай түрүүн ярилаа.

Шилжилтийн үед, зах зээлд бүрэн шилжих үед, ер нь монгол улсад засаглалын ямар хэлбэр байх нь зүйтэй гэж үздэг вэ гэсэн ийм асуудал байна. Ингээд Бага Хурал бол Ерөнхийлөгчийн

удирдлагын, төрийн удирдлагын Ерөнхийлөгчийн хэлбэр байх нь л зүйтэй гэж, уучлаарай Парламентын хэлбэр байх нь зүйтэй гэж бүх л хэлэлцэх түвшиндээ тийм байр суурин дээрээ байлаа. Та бүхэндээ ингээд энэ хэлбэрээр өргөн барьж байна.

Дараагийн Үндсэн хууль хэдийд яах вэ, тэгээд тэнд ямар байх вэ гэдэг асуудлаар бид өнөөдөр таамаглаж ярихгүй. Жишээлбэл өнөөдөр Миттерам ирэх жил сонгууль явуулах бодолтой байна, тэрүүгээрээ Ерөнхийлөгчийн нэлээд эрх мэдлийг программд нилжүүлэх зайлшгүй шаардлагатай байна гэж байгаа шиг хэлэх ийм зүйл өнөөдөр бидэнд хараахан алга байна.

Улсын Их Хурал хэдий хугацаанд, хаана тайлагнах вэ гэж байна. Би түрүүн тэр тайлагнах тухай асуудал дээр ярьчихсан. Турван жил тутам монгол хүн амын хагас нь сонгуульд хамрагдах нь ээ гэж ойлгох уу гэж байна. Тэр бол түрүүн хэлсэн. Нэг мандаттай тойрог байх уу? Эсвэл олон мандаттай тойрог байх уу гэдгээс хамаараад, нэг мандаттай байвал таны хэлсэнээр ойлгож болно, олон мандаттай тойрог байвал сонгогч болгон сонгууль болгон дээрээ оролцоно. Харин мандатынх нь тал хувь дээр сонгууль явагдана гэсэн үг.

Ерөнхийлөгчийн хуулинд намаас татгалзах заалтгүй байхад намаас татгалзсан шалтгаан юу байна вэ? Намаас татгалзах биш, намынхаа гишүүнийг түдгэлзүүлэх, энэ хоёр бол маш чухал зарчмын ялгаатай, монгол үгнийхээ хувьд ч, эрх зүйн хэм хэмжээнийхээ хувьд ч гэсэн, гишүүний харьяаллын харьцааныхаа хувьд ч гэсэн хоёр өөр ойлголт шүү, эрхэм депутатууд аа. Энд бол зөвхөн намын гишүүнээсээ, би намаасаа гарсан уу? гараагүй, намынхаа гишүүнээс түдгэлзүүлсэн учраас, түдгэлзүүлсэн, түдгэлзүүлсэн байдлаа зогсоолоо гэдэг ийм л харьцаагаар энэ асуудал нь ярьж байх, ийм зүйл шүү. Тэрнээс биш намаасаа татгалзана гэвэл бүр их сонин агуулга илэрхийлэгдэнэ шүү дээ. Намаасаа гарна гэдгээс ч бүр өөр агуулгатай. Зүгээр энд иргэний эрхийн сонголт байгаа шүү дээ. Энэ хүн иргэний хувьд хоёр сонголт байгаа. Эсвэл намаасаа түдгэлзвэнэ, намын гишүүнээсээ түдгэлзвэнэ, эсвэл тэр хүн

намын гишүүнээсээ түдгэлзэхгүйгээр, тэр томилогдсон албан тушаалаа өөрчилнө, ийм эрх зүйн хувьд тэр хүн хоёр сонголтын өмнө байж байгаа учраас иргэний эрхийнх нь өөрийнх нь юу бол зөрчигдөж байгаа юм байхгүй байгаа юм, энд.

За энд бас Моголцог гуай нөгөө сүлдний талаар тайлбар өгөөч гэсэн байна, 154 дүгээр тойргийн депутат. За нэрийн тухай байна. Улсын нийслэл Улаанбаатар хот мөн гэж яагаад тогтоохгүй байгаа юм бэ гэж байна. Түрүүн ярьчихсан. Төрийн сүлдний талаар, ... За засаг захиргааны нэгжийг жижиглэснээр хөрөнгө үрэн таран болж, бэлчээрийн даац буурсан байгааг илтгэлд тэмдэглэжээ. Энэ лавтай баталгаа болж чадаж байгаа юм гэж үзэх үү гэсэн байна. Энэ 204 дүгээр тойргийн депутат Энх-Амгалан асуусан байна. За энэ л үндсэн шалтгаан ч гэж хэлээгүй, энэ бол зарим нэг үр дагавруудын хэмжээнд яригдсан ийм л ойлголт.

Нэг танхимтай парламент нь манай орны уудам нутаг дэвсгэрийн хувьд хэр зохимжтой вэ гэж байна. Уудам нутаг дэвсгэр гэдэгтэй холбогдуулж ярьж байгаа утгаараа бол нутаг дэвсгэрийн төлөөллийн асуудлаа юм уу, эсвэл иргэн түүнд хүрэх боломжийнхоо тухай л хэлсэн шиг байна л даа. Тэгэхээр зэрэг энэ нь бол хоёр танхимтай ч байсан, нэг танхимтай ч байсан адилхан тавигдах асуудал.

Ардын Их Хурлын 222 дугаар тойргийн депутат Адъяа гуайн асуулт байна. Зургадугаар зүйлийн тавд заасан газрыг гадаадын иргэн, харьяалалгүй хүнд түрээсээр олгох тухай зааж. Түрээсийг ямар хугацаатай хийх вэ? Хуульд заасан бусад болзол, хэлбэрээр гэдгээр зохицуулах юм уу, ер нь ямар хуульд заасан бусад байх юм бэ гэж. Түрүүн ярьчихлаа шүү дээ энэ бол. Өөрөө цааш нь Газрын тухай хуулиар нарийвчлан зохицуулагдах ийм зүйлүүд.

Иргэний эрх үүргийн харилцааг яагаад хол зөрөөтэй боловсруулагдсан юм бэ? Үүрэг нь Их цааз, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх гэж орсон атал хуулиар тогтоогд-

сон эрхүүдийг нэг бүрчлэн оруулсныг тайлбарлана уу гэсэн. Иргэний эрх, үүргийн харьцаа яагаад хол зөрүүтэй боловсруулагдсан бэ гэж. Хол зөрүүтэй гэдгийг би сайн ойлгохгүй байна. Зүгээр тооны зөрүүний хувьд нэг нь арван хэд, нэг нь дөрөвхөн байна вэ гэдэг асуудлын талаар ярьж байгаа бол, энэ ч бас нэг тоогоор хэмжигдэх зүйл биш юм шиг байна л даа. Тэгээд Үндсэн хуулийн ард нийтээр хэлэлцүүлсэн төслөөс энд яагаад заримыг нь хасаад оруулсан юм бэ гэдэг дээр тодорхой тайлбарууд байгаа. Тэр тодорхой тайлбаруудаа бол түрүүн заримыг нь ч гэсэн одоо цухас дурдаж хэллээ. Энэ тоогоор бол их эрхтэй, бага үүрэгтэй гэдгийг хэлж болохгүй шүү. Энэ бол тоогоор хэмжигдэх зүйл биш. Баталгаа, чадамжаар үндэслэгдэх зүйл.

Их цаазын цэц маань Их Хурлаас томилогдоно гэж хуулийн төсөлд орлоо. Их цаазын цэц нь энэ утгаараа Их Хуралд ажлаа тайлагнах мэт юм шиг санагдана. Үүнийг хуулийн үүднээс тайлбарлаж өгнө үү гэж тиймээ. Энэ тухай асуудлуудыг бол Бага Хурал дээр мөн энэ төслөө ярихдаа ярьсан. Нөгөө л гурван эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа төрийн дээд байгууллагуудын харилцан бие биенээсээ хамааралгүй бие даасан байх. Харилцан бие биендээ хяналттай байх. Харилцан гүйцээлттэй байх энэ үүднээсээ авч үзэж байгаа юм.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

В. Цуяа

ЭНХТУЯА

Бичээч Уранчимэг

Р.Гончигдорж /56 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын дарга/ -Энэ үүднээс нь авч үзээд Их цаазыг зөвхөн энд бол Их Хурал томилох, баталж томилох энэ л зөвхөн үүргийг нь авч байгаа юм.Тэрнээс энд бол тайлагнах ийм асуудлыг энд багтааж авахгүй байгаа юм.За түүнээс гадна энд санал болох субъектыг гурав байгаа гэдгийг бүр энд онцлоод нэмээд хэлээд байя.Энийг бас л одоо энэ хуулиндаа оруулахыг редакци хассан байна.Ерөнхийлөгчөөс гурав нь, Их Хурлаас гурав нь, Дээд шүүхээс гурав нь.Санал гаргах субъектүүд нь энэ гурав гурав гурваар нь гаргана.Батлах нь Их Хурал юм гэсэн ийм л байдлаар ойлгоорой.

За дараачаар нь 415 дугаар тойргийн депутат Ганбямба гуай, шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад үндэсний удирдлагын загвар ямар байхаар томъёолж, хэрхэн харгалзаж үзсэн бэ гэж байна.За үндэсний удирдлагын загвар гэдгийг юу гэж ойлгож байна вэ гэдгийг сайн ойлгож байж хариулахгүй бол болохгүй юм шиг байна.Зүгээр энэ хуулиндаа бол манай төрийн удирдлагын хэлбэрийг, тэгээд төрийн эрх мэдлийг чиглэл, чиглэлээрээ хэрэгжүүлэх, энэ бүх зүйлийгээ Үндсэн хуулиндаа тусгасныг нэг утгаараа бол төрийн удирдлагын Үндсэн хуулийн загварыг гаргажээ гэж ойлгох байх.Зүгээр энийгээ төрийн албан хаагчдын хэм хэмжээ, ранга, албан тушаалын энэ ялгааг гаргах тухай асуудлаар гэж зарим Үндсэн хуулийн, зарим газруудын Үндсэн хуулийн төсөлд байгаа шиг утгаар ярих юм бол тэрийг энд яриагүй, төрийн албан хаагч, жинхэнэ албан хаагч гэсэн ганцхан л тийм нэр томъёо энд орсон байж байгаа юм.

Зүгээр энд юу гэдэг юм, төвлөн удирдах ардчилсан зарчим энэ тэр гэсэн шиг тийм зарчимд тунхагласан агуулгаар Үндсэн хуулинд заадаг байсныхаа тухай асуудал яривал тийм зүйлээр тунхагласан юмыг энд байхгүй бөгөөд, өнөөдөр орон нутгийн засаг захиргааны хувьд өөрөө удирдах ёс, төрийн удирдлагыг хослох энэ зарчмыг баримтална гэсэн утгаар энд бол, энэ нэг хэсэг дээрээ орж байгаа зүйл.Нөгөө нэг зарчим нь засгийн эрх

мэдлийг хуваарилах онол дээр тулгуурлаж шүүх, хууль тогтоох, гүйцэтгэх гэсэн ийм гурван эрх мэдлийн хуваарилалтын зарчим дээр тулгуурлана гэсэн ийм загварууд, зарчмыг бид энэ хуулиндаа барьсан. За орон нутгийн засаг захиргааны нэгжийн талаар тодорхой биш байна. Аймаг, хот, хошуу, баг хэд байх юм бэ? 95 зохион байгуулалт, Үндсэн хуулийн заалт яах вэ гэсэн ийм зүйлүүд байна. За энэ асуудал давхардаж байна. Гомборагчаа гуайн /54 дүгээр тойргийн депутат/ асуулт байна.

Энэн дээр бид нар хавсралт хуулиа нэлээн харж үзээд, энд эрхэм депутатуудаас уучлалт гуйгаад хэлэхэд Монгол улсын Их цааз, Монгол улсын Их цаазын хавсралт хууль гэдэг маань бид нэгэн хуулийн мэт авч үзэж асуудлаа бол Их Хуралдаа өргөн барьсан. Тийм учраас энэ бол хоёулаа Үндсэн хуулийн хэм хэмжээтэй ийм утгаараа бол Үндсэн хуулийн хэм хэмжээнд батлагддаг тэр саналынхаа хэм хэмжээнд байна. Энэ хуулийнхаа илтгэлийг та бүхэнд тавьж танилцуулна. Ингээд Үндсэн хуулиа батлагдангуут бид энэ хуулиа үргэлжлүүлэн гүйцээж хэлэлцээд ингээд энэ хоёр хууль бид нар багцаараа батлаад гарах ийм болох юм гэж ингэж ойлгож, та бүхэндээ өргөн барьсан.

За ардчилсан эрх үүргийн нэгдлээр амьсгалж байж амьдрах чадвараа олно. Их цаазын төсөлд Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүхийн бүрэн эрхийг зарлан тунхаглахыг голчилжээ. Энэ эрхээрээ туйлшрахад хүрэхгүй юу. Бүрэн эрхийн хамт эх орон, ард түмний өмнө хүлээсэн онцгой үүргийг хуульд тусгах боломжгүй юу гэж 21 дүгээр тойргийн депутат Мөнхдорж гуай асуусан байна. Төр, иргэн гэсэн хоёр субъектын харьцаагаар бид энийг, нэгдүгээрт, иргэн нь төрийнхөө өмнө, дараа нь төр нь иргэнийхээ өмнө үүрэг хүлээнэ гэж. Энэ утгаараа төр, иргэний өмнө хүлээх үүргээ энэ төрийн эрхийг хэрэгжүүлэх энэ парламентынхаа хэлбэрээр төрийн эрх мэдлийг, гурав хуваасан эрх мэдлийг хэрэгжүүлэх гурван ангиллын төрийн эрх барих дээд байгууллагуудаараа дамжуулж, энүүнийг хэрэгжүүлж байгаа юм. Энэ маань хязгааргүй биш, өөрөө нэг талаас Үндсэн хуулийг,

3.

зөвхөн Үндсэн хуулийг, Үндсэн хуульд зөвхөн нийцүүлж үйл ажиллагаагаа явуулна. Энүүнийг өнөөдөр бид баталж байгаагаараа ард түмний хамгийн дээд хяналт тавьж чаддаг, дээд хуулийг энэ гаргаж өгч ингэж нэг хрэг хэрэгжүүлж байгаа юм. Цаашдаа бол бүсэд механизмуудаар эдгээр хэрэгжинэ. Түүнээс гадна энэ гурван өндөрлөг, тэдгээрийн төрийн байгууллагууд хоорондоо харилцан тэмцэл, харилцан хяналт, харилцан шүтэлцээтэй байгааг та бүхэн бүгдээс нь олж харж болно. Одоо яг утас сүлжсэн юм шиг хоорондоо, эрх хэмжээний хувьд. Энэ болгон энэ баланс бол энэ болгоомжлолыг үгүйсгэж чадах хэмжээг аль болохоор тусгасан гэж ингэж үзэж байгаа. Тэгээд болохгүй зүйлүүд өнгөрхой цоорхой байвал та бүхэн маань энэн дээрээ санал бодлоо хэлнэ биз дээ.

Улсын тусгаар тогтнол, ард түмний язгуур эрх ашгийн үүднээс төр, засгийн уламжлагдан хадгалагдах бодлого нэгдүгээр бүлэгт бүрэн багтсан уу? гэж. Уламжлагдах чанарыг багтаах арга механизмаа юугаар олсон бэ гэдгийгээ бид түрүүн хэллээ. Тухайлбал, үндэсний аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашиг, нүүдлийн өвөрмөц эзэмшлийн эрх мэдлийн асуудлыг харгалзах талаар дахин тайлбарлана уу гэж байна. Энэн дээр онцгойлоод хэлчихэд түрүүн депутат асуусан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэж Үндсэн хуулинд заавал яагаад гаргаж ирж байгаа юм. Урьд нь байгаагүй, энэ чинь юу гэсэн үг вэ гэж. Энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагаагаар төрийн уламжлагдах шинж чанар бол нэлээд явах боломжтой бөгөөд, үүн дотор манай төрийн нарийн ширийн, нандин уламжлагдах юмнууд энд хадгалагдаж явах учиртай болов уу гэж бодож байгаа. Энэ ч утгаар төрийг бас энд уламжлагдах шинж чанартай холбож авч үзэж болох зүйл юм байгаа юм.

За монгол бичгийн талаар байна. Шашны үйл ажиллагаа, үндэсний хэлээр явуулдаг болох бодлогыг хуульчилж болохгүй юу гэсэн ийм сонин асуудал байгаа юм. Энэ бол өөрөө сүм хийдийн дотоодын асуудал болно. Шашныг заавал монгол хэл дээр явуулах

тухай асуудал гэдэг бол, энийг төрийн зүгээс хуульчлах тухай асуудал гарна л гэвэл энэ маань эргээд нөгөө төр маань сүм хийдийн үйл ажиллагаанд орж байгаа асуудал болно.

21 дүгээр тойрог Мөнхдорж гуай асуусан байна.

36 дугаар тойргийн депутат Мөнхөө гуай асуусан байна. Дэлхийн аж ахуйн системд нэгдэн ороход, нээлттэй бодлого явуулахад Үндсэн хуулиндаа зайлшгүй тусгаж, тэдгээр орнуудад харьцах нөхцөлийг бүрдүүлэх. Газар өмчлөх, цагаачлал, нийгмийн салбар, зарах хөрөнгийн хэмжээг хязгаарлах гэх мэт байдаг уу? Ийм шаардлага байдаг бол Их цааз боловсруулахад оруулж тусгасан тал байна уу гэж. Үнэхээр Их цааздаа бид өнөөдрийнхөө, энэ л улс орныхоо чиг хандлага, энэ болгоныг бодоод Мөнхөө депутатын хэлснээр ийм учир шалтгаанууд бүгд байх юм. Энэ бүгд байх зүйлээ бид тунхаглалаа. Манай Үндсэн хуулийг гадаадын улс орнууд авч үзээд монгол улс ардчиллын чиг шугаман дээр, дэлхийн олон нийтийн энэ нэгдэлд нэгдэн орж байгаа байдал. Олон улстай харилцах, эдийн засаг, зах зээл, эрх зүйн харилцааныхаа байдалд хэрхэн нэгдэн нийлж байна вэ гэдэг энэн дээр үнэлэлт, дүгнэлттэй бөгөөд, цаана нь бидний харьцах харьцаа Үндсэн хуулийнх нь хэмжээнд хэрхэн баталгаажсан байна вэ гэдэг энэ бүх тал дээр бол дүгнэлтээ хийнэ. Тэгээд бидэнд цаашид нөгөө л энэ одоо тунхаглаж байгаа бодлогоо хэрэгжүүлэхэд энэ Үндсэн хууль маань маш том хэмжээний бидний эрх зүйн баталгаа, цаашид нь тавих боломжийг бүрдүүлж өгч байгаа ийм зүйл.

Газар өмчлөхөд хотын хүн, суурин газрынх давуу эдлэх гээд байгаа юм биш үү гэж байна. Тэгэхээр зэрэг хувьд өмчлүүлэх газрыг бид ямар шинж чанараар нь тодорхойлох вэ гэдэг асуудлаас л энэ хамаарч гарч ирнэ л дээ. Тэр тодорхойлж байгаа шинж чанар нь хотод илүү байна уу, хөдөөд илүү байна уу гэдгээрээ Мөнхөө гуайн асуусан, одоогийн улсуудын дунд яригдаж байгаа байдлаараа аваад үзэх юм бол, одоо суурьшсан амьдрал, өөрийн газар дээрээ оруулсан хөрөнгө оруулалт, суурьшилт төвлөрөөд,

энэ хэмжээгээр бол суурьшсан газруудад харьцангуй их хэмжээгээр, анхны утгаар өмчлүүлэх газрын хэлбэр нь тохироод байх шиг байна гэдэг асуудал ярьсан. Хэрэв одоо ер нь өвөлжөө бууц, тэр орчны газар гэдэг утгаар болоод, бусад хүчин зүйлүүдийг аваад цаашид бид нар одоо аж ахуйн нэгжүүд цаашид бий болж үүсэж, аж ахуйг эрхлэх боломж, хувиараа болоод хамтаараа эзэмших энэ байдлууд үүсээд, тэдгээр аж ахуйгаа эрхлэхтэй холбогдсон жижиг төвлөрөл, суурил, аж ахуйн барилга байгууламж үүсээд үл хөдлөх хөрөнгийн хичнээн хэмжээгээр л цаашид баяжиж өргөжиж явах вэ? Үүнийг дагаад энэ асуудал цаашаагаа байх байх гэж бодож байна.

Амьд явах эрхтэй гэсэн заалт, энд одоо маш нарийн нэг асуудал байна. Амьд явах эрхтэй гэсэн заалт, үр хөндөлтийг цаашид чөлөөтэй байлгахад нөлөөлөх үү гэсэн ийм асуудал байна. Гэхдээ амьд явах эрх гэдгийг нь бид иргэнийхээ эрх дотор иргэн хүн амьд явах эрхтэй гэдэг тухай ярьж байгаа юм. Иргэн хүн амьд явах эрхтэй гэдэг асуудал. Үр хөндөх тухай асуудал бол эх, эмэгтэй хүн иргэн болохынхоо хувьд эдлэх эрхийнх нь тухай асуудал ярихаас, тэнд иргэн болоогүй байтугай, ер нь биологийнхон олон янзаар тайлбарладаг юм байна билээ, тэр нэг энд яриад байгаа юу гэж хэлэх юм, субъект тийм үү, тогтсон үр хөврөл, тэрүүний эрх хэмжээний тухай асуудал л Үндсэн хуулиндаа байхгүй байгаа шүү дээ. Тийм учраас энэ бол үүнтэй эрх зүйнхээ хэр хэмжээнд зохицуулсан энэ асуудал дээр энэ бол холбоогүй зүйл юм.

Харин иргэний эрхийнхээ хувьд эмэгтэй хүн үр хөндүүлэх эрхтэй байна гэдэг асуудал нь бол иргэний эрхийн зохицуулалтын хэм хэмжээндээ гарах асуудал. Энд эрхийн хувьд ярьж байгаа юм. Хүний эрхийн хувьд асуудал ярих тухай асуудал болоод тэрийг нь биологи, энэ зүйлтэйгээ холбогдуулаад ярих юм бол энэ асуудал нь дараа нь гарч ирэх асуудал. За баярлалаа. Одоо цөөхөн асуудал байна. Завсарлаад дараа нь ярихад.

Ж. Уртнасан – Дэд ерөнхийлөгч өө баярлалаа. Депутатуудаа

хоромхон төдий сууна уу.Өнөөдөр бид өвчтэй, чөлөөтэй байгаа 10-аад хүн байгаа юм.Гэтэл энд суудал онгорхой байгаа тоог харахад даруй 40 гаруй суудал онгорхой байна.Ийм учраас бид бас нэг дэгтэй, журамтай байхыг бодож байна.Хариуцлага тооцох хэрэгтэй гэж бодож байна.Та бүгдийг ирцээ бүртгүүлэхийг хүсч байна.Энд бид нэрээр авна.Хэн маань байгаа юм, хэн маань өвчтэй юм, энийгээ бид чинь бас нэг тооцож байя.

Р.Гончигдорж /56 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын дарга/ -Уучлаарай даргаа, даргаас, депутатуудаас ганцхан асуулт байна.Түрүүн бичгээр ирэх саналаа тасалсан гэж ойлгосон уу үгүй юу.Тасалснаас хойш энд ирснийг би даргад өгчихөж болох уу? Хариулахгүйгээр.Надад өрсөн асуудал энд байна.

Ж.Уртнасан -Дэд ерөнхийлөгч энийг юу яана биз.Бид тасалснаас хойнхийг нь авлаа.

/танхимаас/

-Хурлын дарга

гаа бичгээр ирсэн асуудлыг таслаагүй шүү дээ.

Ж.Уртнасан -Уучлаарай депутатууд аа, бид юу ч гэсэн ирцээ нэг бүртгээд авъя.Энэ зарчмын ач холбогдолтой байна.Ирц шалгая, бэлтгэнэ үү.Хуралдаандаа суух асуудал депутатын үүрэг гэж би ойлгож байгаа.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Д.Алтанцэнэг

Д.АЛТАНЦЭНЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.14
Кассет № 34
15.05-15.20

Ж.Уртнасан: Депутатуудын өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанаа үргэлжлүүлье.Одоо дэд Ерөнхийлөгчийг урьж байна.Асуулт, хариулт үргэлжлэн явагдана.

Р.Гончигдорж: Эрхэм депутатуудын өдрийн амгаланг айлтгая. Улсын нэрийг яагаад хөдөлмөрчдийн олонхийн эсрэг Улсын Бага Хурал зүтгүүлсээр байгаад төсөлд хэвээр үлдээв ээ.Амьд явах ажлаа сонгож авах, эмнэлгийн тусламж үзэх эрхийн баталгааг илүү тодорхой хэлнэ үү.Урьдах хариулт тодорхой бус байна.

Бага, хошуунд хуваагдахад ямар нэг сөрөг үр дагавар гарах уу гэж 61 дүгээр тойргийн депутат Дамбийжанцан гуай асуусан байна.Энэ хуульд нэг талаас иргэндээ эрхийг тунхаглаад, энэ эрхийг баталгаажуулахыг асуудал нь бол төрөөс иргэний өмнө хүлээх үүрэг мөн гэж түүгээрээ хэрэгжүүлж байгаа юм. Тухайлбал амьд явах, ажлаа сонгож авах, эмнэлгийн туслалцаа үзэх энэ эрхийг энэ Үндсэн хуулинд байгаа түгээмэл баталгаажуулалт, энэ хуулинд нийцүүлэн гаргах, бусад хуулиудаар эдгээр зүйлүүд баталгаажих ийм зүйлүүд ээ.Амьд явах эрхийг нь 100 хувь баталгаажуулсан орон гэж өнөөдөр байхгүй гээд хэлэхэд болох байх.Энэ баталгаажуулалтыг өөрийн улс орны хөгжил, бусад олон зүйлээс шалтгаалах чадавхийн хэм хэмжээнд үүнийг хүний хамгийн эрхэм дээд эрх болохынх нь хувьд хүндэтгэж, түүнийг сахин биелүүлэх үүргийг төр, аливаа бүх аргаараа арга хэрэгслээрээ дамжуулж авах ийм үүрэгтэй.Энэ талаар доголдож байгаа хууль эрхийн актууд, зохион байгуулалт, арга хэмжээнүүдийг сайжруулах, боловсронгуй болгох энэ хүчин зүйл дээр анхаарах асуудал байхаа.

Баг, хошуунд хуваахад ямар сөрөг үр дагавар гарах вэ гэж байна.Энд хүн хүн янз янзын сөрөг үр дагавар хэлнэ, хүн хүн янз янзын эерэг үр дагавар хэлнэ.Гарах сөрөг дагаврыг аль болох багасгах, түүнийг эерэг давуу талыг нь улам илүүтэйгээр ашиглахаар үйл ажиллагааг зохион байгуулахаас их зүйлүүд хамаарах бизээ.

Хуулийн төслийн 51 дүгээр зүйлийн 5-д зааснаар бол Их цаазын цэцийн 9 гишүүн орон тооны бус байх юм гэж ойлгож болох уу? гэж 115 дугаар тойргийн депутат Даваасүрэн гуай асуусан байна.

Есүүлээ орон тооны байх тухай асуудлыг ерөөсөө авч үзэхгүй байгаа. Тусгайлан энэ Их цаазын цэцийн тухай хууль гарна. Үүгээр эдгээрийн цөөн хэдэн хүн орон тооны тухай байх асуудал гарч тусгагдах байх гэж бодож байна. Есүүлээ биш гэж.

185 дугаар тойргийн депутат Намсрай гуай асуусан байна. Ард нийтээр хэлэлцүүлсэн төсөлд байсан хүнлэг гэдэг үгийг яагаад хассан юм бэ? гэж. Тэгэхээр бид нар иргэний ардчилсан гэсэн үгэнд энэ бүрэн бүтнээрээ багтаж агуулагдаж байгаа утгаар үүнийг давтаж хэлсэнгүй.

Дарлал мөлжлөггүй, хүнлэг ардчилсан иргэний нийгэм гэж болохгүй юу гэж байна. Тухайлбал дарлал мөлжлөгийн асуудал гэдэг маань өөрөө ардчилсан энэ агуулгадаа бүрэн багтаад явчих учраас бас үүнийг овойлгож, товойлгож тодруулсангүй.

Төрийн эрхийг хууль бусаар хэрэгжүүлэхгүй байх баталгаа энэ төсөлд яаж туссан бэ? гэж байна.

Энэ баталгаа нь бусад хууль, тухайлбал Эрүүгийн хуулиндаа орж, энэ баталгаажиж, хэрэгжиж явах учиртай тал бий байх. Манай улсын эдийн засгийн хувьд гадаадын хараат болж хувиргахгүй байх баталгааг төсөлд яаж тусгасан бэ гэж байна.

Чухамхүү Үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдлынхаа үүднээс, төсөлд энэ зохицуулалтуудыг тусгаж энэ утгаар нь авч үзэж байгаа юм.

4 дүгээр бүлэг. Нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулна гэдэг нь аймаг, хошуунд тэргүүлэгчдийн дарга, засаг дарга нэг хүн байх уу? эсвэл хоёр хүн байх уу гэж 206 дугаар тойргийн депутат Хүүхэнбаатар гуай асуусан байна.

Тэгэхээр зэрэг энэ хоёр бол хоёр өөр ойлголт юм гэдгийг түрүүн тайлбарласан. Энд Засаг дарга гэж нэг хүн байна. Тэргүүлэгчид, Хурал, хуралдааныхаа хоорондох хугацаанд өөрийнхөө эрх үүргийг харьцангуй шилжүүлсэн тийм тэргүүлэгчидтэй, тэр нь байгууллага болохынхоо хувьд даргатай байх тухай асуудлыг энд тусгаж байгаа юм.

Үүнийг нэг хүн гүйцэтгэх, хоёр хүн гүйцэтгэх асуудлыг тухай бүрд нь, эрх зүйн зөрчил үл үүсэх тохиолдолд бодож тодорхойлж, орон нутаг өөрөө шийцэж болох үндэслэл бий гэж ойлгож байна. Гэхдээ нэг утгаар асуудлаа шийдвэрлэж, түүнийг гүйцэтгэх үйл ажиллагааг нь зохион байгуулж байгаа байдал, нэг хүн дээр төвлөрөх асуудлыг хэрхэн зохицуулах вэ гэдэг асуудал бий байх. Өнөөдөр гарч байгаа зарим нэг сөрөг үр дагавар, бэрхшээлтэй тал, бидний амьдралд ажиглагдаж байгаа зүйл.

Нийт ард түмнээр хэлэлцүүлсэн үед ард түмний дийлэнх олонхийн саналд гарсан улсын нэр, удирдлага яагаад энэ төсөлд туссангүй вэ? Түрүүн ярилаа. Тусгагдахгүй байх зайлшгүй шаардлагын үндэслэл байгаа бол гэж байна. Энэ талаар бид сүүлд санал бодлоо солилцох, хэлэлцэх төвшиндөө л үүнийг дэлгэрэнгүй ярилцана гэж ойлголцсон.

Илтгэлд төрийн сүлд, далбааг өөрчлөх... энд одоогоор хэдийгэтөлөвлөж байна вэ? яах вэ? ийх вэ гэсэн ийм асуудлууд байна. ЗИ дүгээр тойргийн депутат Амарбаянгийн асуулт давхцаж байна гэж хэлмээр байна.

Мөн бэлгэдлийг сольсонтой холбогдох хөрөнгө мөнгөний зардалын талаар санал, асуудал давхардаж байна. Чимид-хишиг гуай /29 дугаар тойргийн депутат/ Монгол улсын нэрийг албан ёсоор товчлон бичиж болох уу?

Хэрэв товчлон бичвэл юу гэж бичих вэ гэсэн ийм сонирхолтой асуулт байна. МУ гээд бичих нь эвгүй талаасаа бодоод ч гэсэн хэлэх гэсэн юм болов уу даа.

Тэгэхдээ гадаад хэлээрээ ганцхан л уг шүү дээ. Монголиа гэсэн уг тийм ээ? Энэ бол өөрөө товч богинохон болсон утгаараа энд товчлох тэр хүндрэлийн шалтгаан энд арилчихсан байх болов уу гэж бодож байх юм. Монгол улс.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодруулан хэлж өгнө үү? Улсын Бага Хурлаас юугаараа ялгагдах вэ гэж байна.

Энд Үндсэн хуулиндаа хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх улсын их хурлын үндсэн эрх хэмжээ, бүх зүйлүүдийг энэ Үндсэн хуулиндаа зааж өгсөн байгаа. Зарим тодорхой эрх хэмжээг бусад хуулиудаар зааж өгнө. Хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн зарчим бол өнөөдрийн Улсын Бага Хурлын хууль тогтоож явж байгаа энэ үйл ажиллагаатай төсөөтэй байх болно. Өөрөө данцаа хууль тогтоох үйл ажиллагаа гэдэг нэг л зүйл учраас ийм юм. Бүтэц, зохион байгуулалт цаашид боловсронгуй болох энэ асуудлууд байлгүй яах вэ?

Мөн түүнчлэн Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд Ерөнхийлөгчийн зүгээс хориг тавих хэмжээгээр оролцож байгаа. Ерөнхийлөгчийн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох оролцолгооны байдал нь түүгээр илэрч байна. Энэ маань мөн одоо байгаагаар төсөөтэй юм. Гэхдээ батламжлах гэдэг утгаар тэнд орохгүй байгаа шүү дээ. Тэгээд үндсэн зарчмын хувьд хуулиа дээдлэх, үндсэн хуульд бүрэн нийцсэн эсэх, ард түмнийхээ эрх ашгийг дээдлэх гэх мэтчилэн олон зарчмуудыг энд тодорхойлж хэлж болно.

283 дугаар тойргийн депутат Төмөрбаатар гуайн асуудал нь давхардаж байна.

227 дугаар тойргийн депутат Баасанхүү гуай ингэж асууж байна. Ерөнхийлөгчийн засаглалтай байхад олон улсын хэмжээнд болон манай улсын цаашид нийгмийн бүтцэд ямар нөлөөлөл байна вэ гэсэн ийм юм байна.

Энд онцгойлон зөвхөн ийм боллоо гэдгээсээ болоод манай нийгмийн бүтцэд нөлөөлөх нөлөөлөл гэдэг асуудал, нийгмийн бүтэц гэдгийг юу гэж ойлгож байна вэ? Нийгмийн бүтэц гэдгийг харьцангуй сонгомол утгаар нь ойлгож бодвол энд нөлөөлөх байхгүй байхаа. Төрийн удирдлагынхаа хэлбэрийн хувьд эрс өөрчлөгдөж байгаа утгаараа төрийн удирдлагын хэм хэмжээнд мэдээж хэрэг томоохон өөрчлөлтийг орох шаардлагатай болно.

Сумыг хошуу болгосноор эдийн засгийн ямар ашиг гарах вэ? Энэ давхардаж байгаа асуудлууд байна. Газрыг гадаадын буку харьяалалгүй иргэдэд ямар ч хэлбэрээр өмчлүүлэхгүй гэвэл олон улсын хэмжээнд манай гадаад харьцаанд нөлөөлөх зүйл бий юу гэж? Үндсэн хуулийн төсөлд бол ямар ч хэлбэрээр өмчлүүлэхгүй гэж орсон шүү дээ. Эзэмшүүлэх, ашиглуулах хэлбэрүүдийг тодорхой хэлбэрүүдээр, хуульд заасан хэлбэрүүдээр байж болно гэж хэлж байгаа.

372 дугаар тойргийн депутат Н.Хавал гуай асуусан байна. Монгол улсын иргэний үүрэг анхны төсөлд II байсан, сүүлийн төсөлд 4 болгон ихэнхийг нь хассан байна. Иргэдийн үндсэн үүргийг яагаад ингэж цөөрүүлэх болсон юм бэ? Анхны төсөлд онцын шаардлагагүй зүйл орсон гэж үзсэн юм уу?

Тиймээ үүнийг цөөрүүлэх учир шалтгааны талаар түрүүн ярилаа. Ерөнхийдөө асуудал давхардаж байх шиг байна. Эрхэм депутат сүүлд хэлэлцүүлгийн үед тодорхой зүйлүүдээр өөрийн санаа хэлээд яривал тэнд тодруулж, харилцан тайлбарлалцах зүйлүүд байна.

Улсын нэр, хуулийн нэр төрийг зайлшгүй өөрт нь заах... энэ мөн давхардаж байна.

346 дугаар тойргийн депутат Дэмбэрэлням гуай асууж байна. Их цаазыг боловсруулсан хэлэлцүүлсэн дунгийн тухай илтгэлдээ Ардын Их Хурлын байнгын комиссын, шинжлэх ухааны академийн төр, эрхийн хүрээлэн МУИС-ийн эрх зүйн тэнхим зэрэг санал дүгнэлтийг энэ хуралдаанд оруулах уу? эсвэл депутатуудад тарааж өгөх юм уу? гэсэн ийм асуулт байна.

Үүнийг депутатуудад тарааж өгөх эдгээр хүмүүсийг хуралдаанд оруулах зайлшгүй шаардлага харагдахгүй байна. Гэхдээ эрхэм депутатууд энэ Үндсэн хуулийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд байгаа гишүүдийнх нь хувьд бол энд оролцож, байлцаж байгаа, шинжлэх ухааны академиас ч байна, Их сургуулиас ч байна, бусад эрдэм шинжилгээний байгууллагаас байна.

Ардын Их Хурлын байнгын комиссын хувьд эрхэм депутатууд бүгдээрээ энд сууцгааж байгаа билээ. Тийм учраас тэд нараас сүүлд асуулт, хариулт, тайлбар сонсъя гэвэл энэ комиссын гишүүд энэ хуралдаанд оролцож байгаа юм. Ажиглагчаар болон шаардлагатай үед зөвлөх эрхтэйгээр оролцож байна.

36 дугаар тойргийн депутат Найдан гуай асуусан байна. МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫН ТӨСЛИЙН 12-ЫН 3-Т БИЧСЭН СҮЛДИЙН ТАЙЛБАР, СЭТГЭЛГЭЭНИЙХЭЭ БҮТЭЭЛИЙГ ТАЙЛБАРЛАНА УУ ГЭЖ БАЙНА.

Энэ талаар эрхэм гишүүдээс Хурлын дарга хүсч санал асуух байх. Энэ ажлын хэсэг болон энэ төслийг оруулж байгаа уран бүтээлч, энэ асуудлыг боловсруулах төвшинд илэрсэн, гаргасан материалууд болон бүх зүйлүүдээ багтаагаад 10-20 минутын видео кино аль хэдийнээ бэлэн болгосон байна. Үүнийг Их Хурлын депутатуудыг хэрэв зөвшөөрөл маргааш 3 цагаас үзүүлэхэд бэлэн байна гэж, дэлгэцтэй дүрс бичлэгийн аппаратаар дамжуулаад үзүүлэхэд бэлэн байна.

Мөн хэрэв радио, телевиз зөвшөөрчихвөл, үүнийг телевизээр үүнийгээ нэвтрүүлэхэд бэлэн байна гэсэн хүсэлт дамжуулсан, Их Хурлын даргын сонорт байгаа байхаа.

Засаг захиргааны талаар 374 дүгээр тойргийн депутат Санжаа гуай асуудал давхардсан байна. Газрыг гадаадын иргэд харьяалалгүй иргэдэд түрээсээр эзэмшүүлэхийн ач холбогдол гэж юу байна вэ дээ гэсэн байна.

Манай өнөөдрийн явуулж байгаа гадаад эдийн засгийн нөөлттэй бодлого, үүний хүрээгээр тайлбарлагдах болов уудаа.

268 дугаар тойргийн депутат Цэрэнжаргал гуай асуусан байна. Энэ асуудал давхардаж байна.

358 дугаар тойргийн депутат Жанцансамбуу гуайн асуудал мөн давхардаж байна.

310 дугаар тойргийн депутат Хад гуайн асуулт, энд зардлын тооцоонуудын талаар хэлсэн байна. Ерөнхийдөө бол асуудал давхардаж байна. Орон нутгийн засаг захиргааны нэгжийг төсөлд зааснаар тооцоход хэмнэгдэх зардлын тооцоог хэлж өгнө үү гэж байна.

Тэгэхээр өөрөө удирдах ёсны орон нутгийн өөрөө удирдах энэ эрх мэдлээ хэрэгжүүлэх, хуулид заасан тодорхой хүрэн дотор. Энэ хэрэгжүүлэх үйл ажиллагаа бол ерөөсөө бүхэлдээ өөрөө орон нутгийнхаа өөрийнхөө төсөв дээр сууж байх бөгөөд энэ бол улсын төсвөөс энд орж ирэх тухай асуудал байхгүй байгаа юм. Тэгээд тэр өөрийнхөө эдийн засгийн чадавхи, энэ байдал дээрээ, энэ аппаратаа хэр зэрэг том байлгах, орон тоогоо хичнээн байлгах, энэ асуудлууд бол тэндээ шийдэгдэх ийм асуудал юм.

Засаг дарга, түүний аппарат, энэ бол мэдээж хэрэг төрөөс санхүүжүүлж байх, энэ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх хүн байгууллага болж орон нутагт төлөөлж байгаа юм.

75 дугаар тойргийн депутат Хүрлээ гуайн асуулт байна. Асуудал давхардаж байна.


311 дүгээр тойргийн депутат Баяр гуайн асуулт байна. Парламентын бүтцийн талаар өөр саналуудыг бага зэрэг тодруулахгүй юу? гэсэн байна.

рүүд, тэдгээрийн газрын түрээслэлтүүдийг өнөөдөр зохицуулж, байна. Урьд нь эндээс алдаж, онож байсан зүйлүүд дэрээ нэлээд дүгнэлт хийж байх шиг байна. Ялангуяа газар түрээсийн төлбөрийн тухай асуудал, байгаль орчныг хамгаалах энэ үүднээсээ гарч ирэх төлбөрийн асуудлууд гэх мэтчилэн олон олон зүйлийг тусгах ёстой гэдгийг энд ойлгож байгаа.

Тариалангийн талбайн хувьд түрүүн ярилаа. Хүний эрхийн асуудлаар олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн гол санааг хэлж болох уу гэж байна.

Энд та бүхэнд түрүүн танилцууллаа. Энд Хүний эрхийн талаар олон улсын олон байгууллагууд, парламентууд, төрөлжсөн байгууллагуудаас санал, зөвлөмжүүд олон гаргасан. Манайх нэгдэн орсон олон улсын гэрээ, олон улсын тунхаглалуудыг бид харгалзаж үзсэн. Түүнээс гадна, мөн энд байгаа хүний эрх, иргэний эрх, дотроо гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсүүдийн эрх үүргийн талаар энд нэлээн зүйлийг ялгавартайгаар тодорхойлсон ийм явдлууд бий. Гэхдээ гадаадын хүний эрхийн асуудлаарх зарим газруудаас ирсэн санал нь, ер нь иргэд, монголд байгаа хүний эрхийг ер нь бараг адилсгах хэмжээнд авч үзэх талаар хүсэлтүүд тавьдаг бөгөөд, гэхдээ энэ бол үндэсний аюулгүй байдал, монголын тусгаар тогтнол, өнөөгийн байдлынхаа үүднээс тэр болгон боломжгүй зүйл учраас, эдгээрийн эрх хэмжээг зайлшгүй ялгаатай авч үзэх, ийм шаардлага үүсдэг юм. Энэ бол бас манай улсын эдийн засгийн хүчин чадалтай ч бас холбоотой ийм асуудлууд юмаа.

Соронзон бичлэгтэй тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Энд хот, суурингийн тухай ярьж байгаа юм. Хот, сууринг бид засаг, захиргааны нэгжийн заавал төв байх юм уу, эсвэл өөрөө засаг, захиргааны биеэ даасан нэгж байх тухай асуудлын утгаар ойлгодог байсан. Тэр байдлаас салах ёстой гэсэн үзэл баримтлалаар энд оруулсан. Энэ нь хэд, хэдэн үндсэн шалтгаантай. Тухайн засаг, захиргааны нэгж дотор хэд, хэдэн том суурин ч байж болно. Нэг нь тэр засаг, захиргааны нэгжийн төв, нөгөө нь хүн ам, барилга байгууламж болон энэ талаар онцгойлон төвдөрсөн хот, суурингууд байж болох, хот суурин иргэнийхээ шугамаар өөрийн дэг, өөхион байгуулалтын статустай байж болно: Энэ нь засаг, захиргааны нэгжийнхээ хувьд аймаг, хошуу, баг, эсвэл хот, хороо хорин гэсэн энэ аж ахуйн нэгжүүдийнхээ байдлаар байх юм.

Нэг засаг, захиргааны нэгжийн нутаг дэвсгэр дотор өөр засаг, захиргааны нэгж бие даан оршин байдаг энэ зохисгүй байдал нь наад зах нь гэхэд энэ байдлаас болж арилах ёстой болно. Өөр дэлгэрүүлж тайлбарлах ёстой зүйлүүд бий.

Иргэний үүрэгт хөдөлмөрлөх гэсэн үг алга байна. Миний бодлоор гол үүрэг нь хөдөлмөрлөх баймаар юм гэсэн байна. Түрүүнд энэ тухай тайлбар ярьсан. Журамт үүргийн хэмжээнд авч үзэх асуудлыг Бага Хуралд дээр ярьсан. Хөдөлмөрлөхийг иргэний зайлшгүй үүрэг болгож хувиргавал нэгдүгээрт өөр учир шалтгааны албадан хөдөлмөрлөхтэй холбоотой асуудлын хавьцаа үүсэх үү, үгүй юу гэсэн асуудал, нөгөө талаас иргэн хөдөлмөрлөх үүргээ хэрэгжүүлэхийн тулд түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах үүднээс өнөөдөр ажлын байраар хангах төрөөс гарч ирэх үүргийг хэрхэн хангаж чадах вэ гэсэн асуудалтай ч холбоотой, олон зүйл, учир шалтгаантай холбоотой юм. Тийм учраас үүнийг Иргэний үүрэг дотор нь шууд утгаар нь оруулж томъёолсонгүй.


Засаг, захиргааны шинэ хуваарьт оруулах 3 орчим, түүнээс ч олон хувиар байгаа гэж дуулсан. Түүнийг Бага Хуралд авч үзсэн үү, бидэнд мэдэгдэж байна уу? Газар зохион байгуулалт

рүүд, тэдгээрийн газрын түрээслэлтүүдийг өнөөдөр зохицуулж, байна. Урьд нь эндээс алдаж, онож байсан зүйлүүд дэрээ нэлээд дүгнэлт хийж байх шиг байна. Ялангуяа газар түрээсийн төлбөрийн тухай асуудал, байгаль орчныг хамгаалах энэ үүднээсээ гарч ирэх төлбөрийн асуудлууд гэх мэтчилэн олон олон зүйлийг тусгах ёстой гэдгийг энд ойлгож байгаа.

Тариалангийн талбайн хувьд түрүүн ярилаа. Хүний эрхийн асуудлаар олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн гол санааг хэлж болох уу гэж байна.

Энд та бүхэнд түрүүн танилцууллаа. Энд Хүний эрхийн талаар олон улсын олон байгууллагууд, парламентууд, төрөлжсөн байгууллагуудаас санал, зөвлөмжүүд олон гаргасан. Манайх нэгдэн орсон олон улсын гэрээ, олон улсын тунхаглалуудыг бид харгалзаж үзсэн. Түүнээс гадна, мөн энд байгаа хүний эрх, иргэний эрх, дотроо гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсүүдийн эрх үүргийн талаар энд нэлээн зүйлийг ялгавартайгаар тодорхойлсон ийм явдлууд бий. Гэхдээ гадаадын хүний эрхийн асуудлаарх зарим газруудаас ирсэн санал нь, ер нь иргэд, монголд байгаа хүний эрхийг ер нь бараг адилсгах хэмжээнд авч үзэх талаар хүсэлтүүд тавьдаг бөгөөд, гэхдээ энэ бол үндэсний асуулгүй байдал, монголын тусгаар тогтнол, өнөөгийн байдлынхаа үүднээс тэр болгон боломжгүй зүйл учраас, эдгээрийн эрх хэмжээг зайлшгүй ялгаатай авч үзэх, ийм шаардлага үүсдэг юм. Энэ бол бас манай улсын эдийн засгийн хүчин чадалтай ч бас холбоотой ийм асуудлууд юмаа.

Соронзон бичлэгтэй тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.14.
Кассет № 35
15.20-15.37.

Р. Гончигдорж -Иргэний ардчилсан нийгэмд хүний амьд явах баталгааг нийгмийн зүгээс хандах боломж хангалттай байж чадах уу? гэж байна.

Үүнийг хангалттай хэмжээнд төр, иргэнийхээ өмнөх үүргийг хэрэгжүүлэх байдлаар шийдвэрлэх ёстой тухай түрүүнд ярилцлаа.

170-р тойргийн депутат Баяндалай: Одоогийн бага Хурал нь Их Хурлын чөлөөт цагт төрийн бүх эрхийг барьж, үндсэндээ ганц танхимтай Парламенттай төсөөтэй байдлаар, өөрөөр хэлбэл Их цаазын төсөл бий, Их Хуралтай адил байдлаар ажиллаж байна. Энэ байдлаас үзвэл ганц танхимтай Парламент манай нөхцөлд зохиотой гэж та үзэж байна уу? Туршлагаас үзвэл ямар байна вэ? гэж байна.

Бага Хурал хэрхэн үзэж байна уу гэдэг үүднээс хариулъя. Тэхээр өнөөдөр Улсын Бага Хурал хууль тогтоох эрхмөдлийг хэрэгжүүлэхдээ зөвхөн Үндсэн хуулийг батлах, өөрчлөх, нэмэлт оруулах энэ эрх нь Их Хуралд хадгалагдаж, бусад хууль тогтоох хүрээндээ нэгт танхимтай, байнгын ажиллагаатай Парламентын шинжийг бүрэн өөртөө агуулж ажиллаж байгаа юм. Үүнийхээ байдлаас үндэслээд энэ Үндсэн хуулийнхаа төслөөр байгуулагдах Их Хуралд Парламент ёсны тодорхой үндэс, суурь бага зэргийн туршлага, үүнийг бий болгохын төлөө гэсэн бодол санаа Бага Хурлын эрхэмлэж зорьж байгаа асуудлын нэг нь юм.

Их Хурлын гишүүний тал хувийг ямар аргаар сольж байх юм бэ гэж байна. Энэ тухай түрүүнд хэлсэн. Энэ нь сонгуулийн байдлаас хоёр янзын аргачлал байна гэж.

290-р тойргийн депутат Цэвээндорж гуай асууж байна. Төсөлд хот гэсэн нэр алга, Дархан, Эрдэнэт гэсэн хот байна. Энэ нь ямар зохион байгуулалтанд орох юм бэ?

хот байгуулалт, комисс тэдгээрээс боловсруулж байгаа хэд, хэдэн хувилбарууд, өмнө нь эдийн засгийн хүрээлэнгийн дотор байсан секторын эрдэм судалгааны ажлын үр дүнд гаргасан зүйлүүд, энэ болгоноос Улсын Бага Хурал газрын тухай хууль болон бусад хуулиудын төслүүд дээр ажиллаж байх үед Бага Хуралд танилцуулсан урьдчилсан хувилбарууд байгаа юм. Үүний талаар хэрэв депутатууд дэлгэрэнгүй танилцах шаардлагатай гэвэл тэр шаардлагын дагуу эдгээр улсуудтай уулзуулж ярилцуулж болох байх. Ямар нэгэн ажлын зохион байгуулалтын хэлбэрээр.

Хөдөлмөрчин олны түмний олонхийн саналыг авахгүйгээр төсөлд Бага Хурлын гишүүдийн саналыг тусган оруулдаг нь ямар учиртай юм бэ? Энэ шүүмжлэл давтагдаж байна.

108-р тойргийн депутат Б.Ширмэн гуайн асуудал мөн давхардаж байна.

Хуулийн төсөлд Парламентын нам Засгийн газраа бүрдүүлэх үү? Хуулинд тодорхой тусгаагүй байна. Энэ талаар тайлбарлана уу?

Энд тодорхой байдлаар туссан гэж үзэж байна. Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг эсвэл Парламентад, Их Хуралд олонхийн суудал авсан намтай зөвшилцож дэвшүүлнэ. Хэрэв тийм нам байхгүй бол Их Хуралд олонхийн суудал авсан нам байхгүй бол Их Хуралд суудал эзэлсэн намуудтай зөвлөлдөж Ерөнхий сайдын нэрийг дэвшүүлж, Их Хурлаар томилуулна гэж байгаа юм. Энэ эхлэлийн үүсэх шалтгааны үүднээс олонхийн суудал авсан нам Засгийн газраа эмхлэн байгуулах эрхийн үүсвэр бий болж байгаа юм. Олонхийн суудал аваагүй тохиолдолд харилцан зөвшилдөх нөхцөлийн үед ямар намууд хоорондоо зөвшилцөж, нэг нэр дэвшүүлсэн байна, тэр нь алсдаа Ерөнхий сайдаар дамжуулаад эвслийн Засгийн газраа байгуулах тухай хэлэлцэл тэндээс эх үүсвэр үүсч байна гэж үзэх үндэстэй. Ямар нам нь энэ хэлэлцэлд орсонгүй тэр нь Засгийн газарт ороогүй, оппозиц нам болох тухай асуудал юм. Энэ нь Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх

энэ үйл ажиллагааны намуудтай зөвшилцөх явцад энэ харилцаа үүсч эхлэж байгаа гэж үзэж байгаа юм. Энэ утгаар тодорхой туссан гэж хэлмээр байна.

223-р тойргийн депутат би гаргахгүй байна, уучлаарай. Зохиогчоор нь яриулъя гэж байна 55-р тойргийн депутат Адъяасүрэн.

200-р тойргийн депутат Халзанхүү : Манайх шиг орны тухайд Ерөнхийлөгчийн засаглалтай байж боломгүй онолын үндэслэлийг хэлж өгнө үү?

Үүнд байж болохгүй гэсэн онолын үндэслэл байж болохгүй л дээ. Тийм учраас онолын үндэслэл гэж хэлж болохгүй. Харин төрийн удирдлагын ямар хэлбэрийг сонгож авах уу гэдэг асуудал дээрээ ярилцахдаа аль нь зохимжтой байна вэ гэдэг дээрээ санал, бодлоо ярих нь зүйтэй. Улсын Бага Хурал зохимжтой хэлбэрийн талаар саналаа та бүхэнд өргөн барьж байгаа юм.

Улсаа үнэхээр сайн авч яваа Ерөнхийлөгч хэдэн ч удаа сонгогдож яагаад болдоггүй юм бэ? гэсэн байна.

Олон улсын практикт байдлыг авч үзэхэд Ерөнхийлөгч хоёр удаа сонгогддог журам нэлээд олонх байх юм. Нэгэн улсад Ерөнхийлөгч болж чадах хүмүүс зөвхөн ганцаар олон жил дагнаж хязгаарлагдахгүй байх л даа. Түүнээс гадна учир, холбогдлуудыг нь тайлбарлаж болох байх. Олон жилийн хугацаагаар нэг Ерөнхийлөгч давтагдан сонгогдохоос гарах сөрөг үр дагавар юу байж болох вэ гэсэн асуудлууд дээр.

Төрийн өмчийн газрыг Монгол улсын болон гадаадын иргэд харьяалалгүй хүнд түрээсээр, түүнчлэн хуульд заасан болон эзэмшүүлэнэ заалт юунаас үндэслэн гарав? Энд асуудал давхардаж байна. 378-р тойргийн депутат Шагдар гуай асуусан байна.

327-р тойргийн депутат Энхсайхан гуайн асуулт байна. Нэг асуудал нь давхардаж байна. Монгол улсын Парламент хоёр танхимтай байвал зохимжтой биш үү, өнгөрсөн жилийн нэг жилийн хурлын үйл ажиллагаанаас дүгнэлт хийж үзвэл ямар байна вэ гэсэн асуудал байна. Түрүүнд учир байдлаа тайлбарлаж хэлсэн, төсөлтэй холбогдуулж.

157-р тойргийн депутат Одончимэд гуай асуусан байна. Төрийн сүлд, далбаа, дуулал, Үндсэн хуулийн нэр Их цааз, Улсын нэрийг ингэж өөрчлөө гэсэн саналыг чухам хэн, хэн эхлэж хэлээд, түүнийгээ хамгаалсан юм бэ? Санаачилсан хүмүүсийн нэрийг хэлж өгнө үү. Тэр хүнээр нь учрыг нь тайлбардуулъя гэж байна.

Тэхээр хэн эхлэж хэлсэн гэдэг нь учир, шалтгааны гол зүйл биш байх. Харин үүнийг тайлбардуулъя гээд дэлгэрэнгүй тайлбарлуулах шаардлагатай болвол Бага Хурал эндээс төлөөлөн аль нэг гишүүнээрээ тайлбарлуулж болох байна.

370-р тойргийн депутат Цамба гуай: Их цаазын төсөлд хувийн өмчийг хууль бусаад хураахыг хориглосон заалт оржээ. Энэ нь үндсэндээ нийтийн эмчийг хууль бусаар хурааж болно гэж бичсэнтэй адил юм. Яагаад ингэж онцгойлох болсон юм бэ гэж байна.

Тэхээр Иргэний хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахдаа манайд хувийн, нийтийн гэсэн ийм өмчийн хэлбэр байна. Нийтийн өмч гэдэг нь үнэн хэрэгтээ өөрөө төрийн мэдэлтэй байгаа өмчийг ярьж байгаа шүү дээ. Тэхээр тэр, өөрөөсөө өөрийнхээ өмчийг хураах гэдэг ойлголт байхгүй гэсэн тайлбарыг хэлмээр байна. Өөрөө түүнд эзэмшүүлэх эрхийг олгочихоод, эзэмшүүлэх эрхийг нь хорих, боох тэр асуудлууд байдаг асуудлууд учраас тэр нь өөр зүйл шүү дээ. Өмчийн харьцааны хувьд энд ярьж байгаа юм.

Сумыг нэгтгэж хошуу болгоход аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, өөрөөр хэлбэл аль нэг сумын нутаг дэвсгэрт хуваагдахгүйгээр хошуу зохион байгуулагдах баталгаа бий юу гэж байна.

Ийм сонирхол байвал энэ сонирхол, зайлшгүй шаардлагын үүднээс тэгж зохион байгуулж болно шүү дээ. Энэ цаашдын зохион байгуулалтын асуудлууд юм.

Аж ахуйн нэгжээр дагуулаад, дахин зохион байгуулалт хийх гэж байна гэж ойлгож болохгүй шүү дээ. Хэрэв тэгж үзвэл өнөөдөр нэг сумын нутагт гурван аж ахуйн төмөөхон нэгжүүд байгуулагдаж байна. Тэхээр түүгээрээ сум болох гэж байна гэсэн болгоомжлол ярьж байх шиг байна л даа. Тийм байдал болохгүй. Энэ нь аж ахуйн нэгж, аж ахуйн зохион байгуулалтын асуудал бол өөр юм. Харин эдийн засгийн тодорхой биеэ дансан чадавхи бүхий нутаг дэвсгэрийн нэгжийг бий болгох үүднээсээ хандаж авч үзэж байгаа нэг хүчин зүйл энэ дотор нь бий шүү дээ.

Улсын Их Хурлын ээлжит сонгууль гэж байх уу? Гурван жил дутамд явагдаж байгаа шинэчлэн, сэлбэж байгаа сонгуулийг ээлжит сонгууль гэж ойлгож болох уу? гэж байна.

Болно, энэ чинь ээлжит сонгууль шүү дээ.

Бэлчээрийн талаар, ялангуяа өвөлжөө, хаваржааны хувьд өмчлүүлэхгүй байгаа шалтгаан нь юу бэ? Хэрэв бэлчээр, бууцыг өмчлүүлэхгүй бол өвөлжөө, хаваржаанд хувийн хөрөнгөөр хашаа, байшин барих, хөрөнгө оруулах хүн гарах болов уу? гэж байна.

Энэ утгаар таны саналтай нийлж байна. Энэ талаарч ^{өмчлүүлэх} Улсын Бага Хурал дээр үүнийг хэлэлцэж байхад боломжийн хувьд+ газрын тодорхой хэсгүүд энд үүсэж болохыг би үгүйсгээгүй юм аа.

96-р тойргийн депутат Сэндэнжав гуай: Их цаазын төслийг батлавал хэд орчим жилийн хугацаанд үйлчлэж болох хууль вэ ! гэж байна.

Жилийн талаар тодорхойлж хэлэхэд хэцүү. Үүнийг бодоход Их цаазыг харьцангуй хатуу хуваадаг хэлбэрийнх нь хувьд хатуу байх талаас нь өөрөөр хэлбэл харьцангуй удаан хугацаанд байх зайлшгүй шаардлагатай үед нэмэлтээр зохицуулагдаж байх байдлаар л авч үзэх оролдлого, бодлоготойгоор төслөө өргөн барьсан. Түрүүнд ч хугацааны талаар хувийн саналаа хэлж байсан.

Их цаазыг хэрэгжүүлэх баталгаа хэр хангагдаж байна уу? Өөрөөр хэлбэл төслийн хамт ямар гол баримт, бичиг, чиглэл боловсрогдсон бэ гэж асуусан байна.

Тэхээр энд Үндсэн хуулийн хавсралт хуулинд 7-р сарын I-ний дотор тогтоох ёстой хуулиудын талаар энд хилсэн байгаа юм. Мөн 3-р сарын доторх, эдгээрийн хувьд тодорхой хэмжээний төсөл боловсрогдсон, зарим нь Улсын Бага Хурлаар эхний хэлэлцүүлэгээ зарчмын асуудлаа хийчэхсэн байдалтай байгаа юм.

Төслийн хоёр бүлгийн I6-р зүйлийн 2-р хэсгийг тайлбарлана уу? гэж байна.

Энэ нь гадаадын иргэд... I6-ын 2-т Монгол улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх үүргийг тодорхойлохдоо уул иргэний харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчмыг баримтлана гэж байна.

Энэ нь I-р зүйлээсээ тодруулаад, харилцан адил байх зарчим гэж байна. Энэ нь тухайлбал энгийнээр тэр иргэн манайд байгаа тэр улсын иргэн манайд үнэ төлбөргүй эмчилгээ авах, хууль зүйн эрх хэмжээний хувьд тодорхой эрх хэмжээнүүд,

Мөн түүнчлэн эдийн тусламж авах эрхийн тухай асуудлууд гэдэг дээрээ манай иргэн тэнд мөн эдгээр эрхүүдээр хэрэг зэрэг тэнцүү хангагдаж байна уу гэсэн энэ утга агуулгынхаа үүднээс харилцан адил байх зарчим баримтлана гэсэн агуулгыг тусгаж ойлгож байгаа гэж бодож байгаа юм.

Соронзон хальстай
тулган нийлсэн

Ц.БАЯРМАА

Бичээч

С.ТУУЛ

Р.Гончигдорж: -Хэрэв дэлгэрэнгүй нарийвчилсан тайлбар шаардлагатай гэвэл энэнийг хэлэлцлийн явцад бид хоорондоо ярьж болох ёстой юм.

320 дугаар тойргийн депутат Хишигдалай гуайн асуудал Улсын Бага Хурлаас өргөн мэдүүлж байгаа энэ төслөөр Их цааз батлагдах юм бол хэдэн жилийн дараа нөхөөстэй хууль болохгүй гэх баталгаа хэр байна вэ? Энэ талаар түрүүнийхтэй холбогдуулаад бодлоо хэллээ. Манай Их цаазын төсөлд заагдсан төрийн байгуулал нь улс орны төр засаг төвшин, нэг хүний буюу нэг хэсгийн дарангуйллаас ангид байна гэсэн санаа илтгэлд тусгагдлаа. Үүнийг баталгааг нарийвчлан тайлбарлаж өгнө үү гэж. Энэ чинь бүхэл бүтэн Үндсэн хуулийнхаа заалт болгон дээр хэлэх тайлбар дотор энэ болгон өөр өөрөө тусгаад хэлэгдээд явах байх. Түрүүн ч зарим асуудлуудтай холбогдуулж энэ санаагаа хэлсэн.

Нэрийн тухай асуудал энд давхарцаж байна.

17 дугаар зүйлийн гуравт хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй гэж байна. Энд шударгаар гэдгийг юу гэж ойлгох вэ? Ямар бол шударга бус гэж үзэх вэ гэдэг ийм асуудал байна. Энд ийм л асуудал гардаг л даа. Шударгаар, шударгаар биш байна гээд. Тэгэхлээр чинь бол жишээлэх юм бол энэ дээр эрх зүйн харьцаа үүсээд энэ дээр ямар нэг маргаан үүсэхэд энэ шударга байж уу, шударга биш байж уу гэдгийг шударга гэдэг үгийг яаж хуулийн шинжүүр болгож байх юм бэ? Ийм учраас иймэрхүү үгийг авъя гэдэг ийм шүүмжлэл байдаг л даа. Гэтэл зайлшгүй шаардлагатай нөхцөл тохиолдолд хуулийн тайлбараас Үндсэн хуулийн тайлбар хийх хэмжээгээр, бусад хуулинд иймэрхүү үг байхад тэр хуулинд албан ёсны тайлбар өгдөг газруудын тайлбараар бол энэ асуудлуудыг тодорхой томъёолж болдог. Энэнийг бол хамгийн энгийн

утгаар нь бол хууль ёсоор хөдлөх, үл хөдлөх хөрөнгө олж авах, тэрнийгээ хууль ёсоор өвлөх, өв залгамжлах гэсэн ийм утгыг бол энд яах юм, зүгээр хөрөнгийг бүрдүүлэх хөдөлмөрийн хувьд шударга хөдөлмөрлөх ёстой гэсэн асуудлуудаас үүсээд шударга хөдөлмөрөөр энэ хөрөнгө бүрдэх ёстой гэсний цаана хөдөлмөрийг шударга гэж үнэлдэг асуудлууд бий шүү дээ. Тэрийгээ бодохлоор зэрэг нөгөө дам, элдвийн юмтай холбогдуулаад ингээд яваад өгдөг. Энэнээсээ илүү хуулийн дагуу гэдэг утга нь энд, тэр хөдөлмөрийн шударга гэдгээсээ энд байгаа шударга нь хуулийн дагуу гэдэг агуулгаараа илүү ноёлж байгаа гэж ойлгож болох байх аа гэж бодож байна. Мөн зүүлд тэр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчлан авахад үнэт эрх үүслээ гэж байна. Энд нийгмийн зайлшгүй хэрэгцээ гэж юуг ойлгох вэ гэж. Энд олон нийгмийн зайлшгүй шалтгаан үүсч болно. Хамгийн энгийн жишээ хэлэхэд жишээлбэл энд одоо нэг гэнэт гал түймэр гарлаа гэхэд энд нэг хувийн тэрэг зогсож байлаа гэхэд тэр хувийн тэргийг шууд дайчлан аваад энэ гал унтраах үйл ажиллагаанд оролцуулах ийм нөхцөл шалтгаан үүсч болно шүү дээ. Тэгэхэд тэрнийх нь үүсэх төлбөрийг бол шударгаар үнийг төлөх үүрэгтэй. Төлбөртэйгээр дайчилж авах. Энэнээс том масштабын, том хэр хэмжээний асуудлууд энд бол зайлшгүй үүсч болно.

Тэгэхдээ энэ асуудал зөвхөн Үндсэн хуулийн, зөвхөн энэ асуудлаар зохицуулагдах биш, Үндсэн хуулинд энэ эрхийн хэм хэмжээг нээж өгч байна. Энэний дагуу бусад хуулиудаар бол тэр төлбөрийн асуудлууд, ямар тохиолдлыг зайлшгүй гэх юм, энэ хууль тойрсон буюу хуулийг завхруулсан ийм хэм хэмжээнд орчихгүйгээр зохицуулагдах хуулийн нарийн зохицуулалт байж таарна шүү дээ. Тэрийг энд үгүйсгэхгүй. Энэ маань энэ түгээмэл хүний эрхтэй холбоотой асуудал шүү дээ. Хүний хөрөнгөнд халдах тухай асуудал. Хөрөнгийг өөрийнх нь дур зоргоор биш дайчлан авах асуудал. Энэ утгаараа зайлшгүй Үндсэн хуулинд эрхийн ийм нээлтийг тавьж өгөх хэрэгтэй болж байгаа юм. Нийтлэг үндэслэлээр. Тэгээд дараачаар нь нарийвчилсан хуу-

3.

лиар зохицуулахад Үндсэн хуулийг зөрчиж байна гэсэн маргаан үүсэх учиргүй болж өгч байгаа юм.

67 дугаар тойргийн депутат Дашдэндэв гуай асуусан байна. Амьд явах эрхтэй гэсэн байна. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэсэн байна. Үүний арын баталгаа бий юу. Байгаа бол тодруулна уу гэж. Энэ тухай түрүүн ярилцсан гэж тийм ээ.

Төсөлд яагаад, ямар учраас шашныг төрөөс, ерөнхий боловсролыг зориуд салгаж тусгаад байгаа юм бэ? гэж. Шашныг төрөөс тусгаарлах гэдэг тухай асуудал байхгүй байгаа шүү. Сум, хийдийг төрөөс гэж байгаа. Ерөнхий боловсролыг зориуд шашнаас тусгаарлаад байна уу гэж. Тэгэхлээр зэрэг иргэний боловсрол, шашны боловсрол гэсэн ийм хоёр агуулгаар энэ хоёрыг тус тусдаа гэдэг утгаар нь тусгаарлаж байна. Иргэний боловсрол. Тэгээд шашны боловсролыг хэрхэн олгох тухай асуудлыг тэнд тусгасан байгаа. Шашны сургалтаар. Энд ард түмний санал хэр зэрэг бодитой тусгагдсан бэ гэж. Тэгээд хэлсэн. Тэр шашны боловсрол гэж чухамхүү юу байх, түүнд юу хамааруулах, иргэний боловсрол, тэндээс түрүүн манай ёс заншил, түүх судар, хүний ариун шударга ёс, энэнийг ойлгох ойлголт, этика, эстетика энэ бүх талыг шашинд ойлгодог ойлголтуудынх нь хэмжээнд тэрнийг ерөнхий хүмүүжлийнх нь хувьд сургууль соёлын газруудад сурах, судлах асуудлыг энүүгээр хааж байгаа асуудал биш бөгөөд энэ чухамхүү сүсэглэн бишрэх, шашны зан үйлийн үйл ажиллагааны тэр ёс дэгээр нь сургалтаа холж тухай асуудлын хувьд ялгарал байгаа гэдэг утгаар ойлгогдохоос биш тэр бол тэндээс ямар нэг шашны түүх, философийн асуудлуудыг иргэний боловсролын сургууль судлахгүй гэсэн утгаар тийм эрс хуваарилалтын зааглалны тухай асуудлууд биш байгаа шүү дээ.

227 дугаар тойргийн депутат Баасанхүү гуайн асуулт байна. Цэргийн албан хаахыг хуулиар заажээ. Тэгвэл цэргийн албан хаахаас үзэл бодол, санаагаар татгалзах эрх байж болох уу? гэж. Энд чинь ингэж байгаа шүү дээ. Хуульд заасны дагуу цэргийн

4.

албан хаах үүрэгтэй гэж. Тэгэхлээр зэрэг яг энэ сэтгэлгээнээс авч үзвэл эмэгтэй хүнийг бас цэргийн алба хаах үүрэгтэй гэж хэлсэн юм шиг ойлгож болохгүй л дээ. Жишээлбэл. Хуульд заасан үүргийн дагуу. Яг эндээс үүсээд гарч байгаа юм. Магадгүй тэр хүний тодорхой сэтгэлийн дотоод байдал, сүсэг бишрэл, элдэв зүйлтэй холбогдуулаад бусадтай нэгэн адилаар цэргийн албыг хаах боломжгүй учир шалтгаан үүссэн тохиолдолд хуулийн дагуу цэргийн албыг хаана гэдэг нь заавал цэрэг болоод очоод алба хаах тухай асуудал биш гэж ойлгогдож байгаа юм. Цэргийн албыг ямар нэг өөр, хялбарчилсан юм уу, эсвэл төлбөрийн хэлбэрээр За юу гэдэг юм олон хувилбар байж болно. Энэнийг бол цэргийн үүргийн тухай хуулинд нарийвчилж орж ирэх учиртай бөгөөд зарим нэг эрх хэмжээнийхээ хувьд бол зарим хуулиуд дотор ингэж холилдон орж ^{тусгах} ийм зүйлүүд. Хуулийн дагуу гэдэг үгийг анхаараарай.

Улсынхаа Ерөнхийлөгчийг бүх ард түмэн сонгож болохгүй гэх ямар үндэслэл байна вэ? Энэ бол бид нар өөрсдөө л тэр үедээ л ярилцах, санаа болдоо солилцох асуудал юм.

54 дүгээр тойргийн депутат Гомборагчаа гуай асуусан байна. Биологийнх нь талаас, цагаан шонхор шувууны тухай.

32 дугаар тойргийн депутат Мандах гуай асуусан байна: Энэ нэг танхимыгаа тайлбарлахгүй юу гэсэн байна л даа. Тэгэхлээр зэрэг энэ дээр их олон дэлгэрэнгүй тайлбар, тэр тохирох уу тохирохгүй гэж, энэ нэг жилийнхээ туулсан замтай холбогдуулаад тайлбарлана уу гэж. Энэ бол үнэхээр ингээд тайлбарлаад сайн талыг нь гаргаад ирье гэвэл үнэхээр ухуулгын шинж уруугаа илүү давамгайлчих болов уу. Тийм учраас хэрэггүй байх. Ямар ч л байсан Бага Хурал ийм байхад болох юм байна гэсэн төслөө та бүхэндээ илтгэн толилуулаад байгаа юм.

Илтгэлд дэвшүүлсэн санаа тараасан төсөлтэй хэрхэн уялдаж, ам ажлын нэгдэл хангаж байгаа юм бол оо.

а/төрийн удирдлага нэгжид ойртож байна гэж ярих юм.


5.

Өөрсдөө шийд гээд л улам холдоод, эзгүйдүүлээд байгаа юм биш үү гэж. Энэ бол арга барилын асуудал байх. Түүнээс энэ бол тогтолцооны тухай асуудал нь биш байх гэж бодож байна.

Орон нутаг төрийн удирдлага 1989 оноос эхлэн бужигнаад шинэ төслөөр юу ч үгүй, хааш нь ч болгож болдоггүй, шийдэж ч болдоггүй, нэг л хэрүүлийн хурал гараад ирж байгаа юм биш байгаа даа гэж. Энэ бол чухамхүү энэ сөрөг байдлуудаас салж чадах ийм орон нутгийн засаг захиргааны нэгж, түүнийг хослон барих удирдлагын хэм хэмжээг нь энд тусгаж ярьж өгч байгаа юм. Чухамхүү болохгүй байсан тэр шинж, шалтгаануудыг энэ Үндсэн хуулийн Их цаазын Цэцэнд оруулсан энэ хэм хэмжээгээр зохицуулахад арилах хүчин зүйлүүд байна аа гэж үзэж байгаа юм. Шаардлагатай, яагаад гэх юм бол энэний талаар сүүлд яг энэ асуудлаа хэлэлцэх байх үедээ нарийвчилж бодол саналаа солилцож болох юм. Нийт депутатуудад хурлын явцад гарсан зарим асуудлуудтай холбож эв нэгдлийн бэлгэдэл мөн гэдгийг тайлбарлах нь зохимжтой болов уу гэсэн байна. Энэ дээр тайлбарлаад байх юу байх вэ.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

П. ТӨМӨРБААТАР



Бичээч Л.Хорлоо

Р.Гончигдорж: -Нэг талаас төлөөлөх эрх байдал, нөгөө талаас хүндэтгэх эрх байдал гээд олон зүйлүүд төрийн тэргүүнийхээ хувьд за энэ илэрхийлэл болгож энд гарч ирж байгаа эрх хэмжээ, онцгой эрх онцгойлон еэрт нь тусгагдсан эрх хэмжээ энэ болгонд гарч ирж байгаа. Аль аль нь яаж шингэм, юу гэж ойлгогдож байна гэдгийг нь тэр тухай бүрд нь ярина. 58-р тойрог, Рэнцэнбал гуай асуусан байна. Энэ бас асуудлууд давхцаад байна. 17-гийн 1-д амьд явах хэрэгтэй гэсэн гэтэл осол авариар танхайрагчдын гарт амь үрэгдэж явдал өссөөр байна, хууль батлагдаж энэ зөрчил багасна гэж бодож байна уу, үгүй юу, гэж, зөвхөн хууль ганцхан батлагдснаас ч одоо гэв гэнэтхэн цөөрөөд явчих тухай асуудал байхгүй л дээ, өнөөдрийн хуулийн хэр хэмжээ хуулинд бол энэ баталгааг тодорхой хэмжээгээр хангах ийм л хууль, арга хэмжээ, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанууд байгаа энэ дээр гарч байгаа ажлын доголдол олон хүчин зүйлүүдээс бол энийг 100 % баталгаатайгаар хангах асуудал бол доголдолтой байгаа юм. Энэ бол шууд Үндсэн хуульд батлагдах эсэхдээ үндсэн хуульд энийг оруулахгүйтэй холбоотой асуудал биш юм даа. Улсын дээд шүүх ерөнхий шүүгчийг нэг л сонговол насан туршид нь ажиллуулах уу гэж байна, энд бол үнэхээр тодорхой хугацаатайгаар томилохгүй байгаа. Хугацаагүйгээр томилж байгаа бөгөөд үйл ажиллагааны явцад зайлшгүй шаардлагын үүднээс зөвхөн түүнийг тохоон томилсон юм уу ерөнхийлөгчөөс эгүүлэн татах тухай асуудлууд аар л энэ тохиолдолд шүүгчийг ажлаас нь халах, мөн тэдгээрийн зөвшөөрөлтэйгээр шүүгчийн цалинг бууруулах гэх мэтчилэн шүүгчийн хараат бус байдлыг хангах үүднээс бол энд ийм байдлаар туссан байгаа юм. Үнэндээ бол тодорхой хугацаа байхгүй. Энэ утгаараа бол насан туршид нь гэж ойлгогдох талтай юм. 71-р тойрог, Лхамсүрэн гуай асуусан байна. Бас амьд явах эрх баталгаагүй байгаа тухай асуудал дээр шүүмжлэлтэй хандсан байна.

211-р тойрог Дагвадорж гуай байна, Их хурлын даргад хандсан зүйл байна, АИХ-ын дарга эрхээ эдэлж аль асуултад нь хэнээр хариулт өгөхийг шийдэж байна гэсэн байна.

Үндсэн комиссоос оруулсан саналыг бага хурал өөрчилсөн тул депутат Ёндонжамцын асуултанд Гончигдорж даргаас ^{харуу} авъя гэж байна. Ер нь тэр л байдлаараа яваад байх шиг байна.

Төсөл хэлэлцэх үед парламентын 2 танхимтай байх, хүчтэй Ерөнхийлөгчтэй байж тэр нь Засгийн газраа толгойлох санал гарсан үүнийг авч хэлэлцэх үү, хэлэлцсэн үү гэж байна. 2 танхимтай парламент, I танхимтай парламентаас юугаараа ямар ялгаатай вэ, энэ бүх асуудлыг улсын бага хурал дээр энэ төслүүдийг хэлэлцэх бүх үе шатанд бол эдгээр асуудлууд хэлэлцэгдсэн, тусгагдсан энэ дээр бол санал бодлоо нэлээд их хэмжээгээр улсын бага хурал дээр санал солигдсон, энэ зүйлүүдээр, давуу тал, дутагдалтай тал, энэ болгон болвол яригдсан. Манай онцлог төрийн уламжлал энэ хэлбэрийн хувьд ч гэсэн яригдаж сонсогдож байгаа зүйлүүд ээ. За IOI-р тойрог депутат Дорж-бат гуайн асуудал давхардаж байна.

Чимид даргаас гээд тусгайлан асуусан байна. Үндсэн хуулиа Их цааз гэж нэрлэвэл бусад тусгай хуулиудаа бас л цааз гэх үү гэж. Бид нарт энэ тухай асуудал зөндөө гарч ирж байсан. Энд бол Чимид гуай төдийгүй олон улсууд энийг цааз гэж нэрлэх шалтгаан эндээс үүсч бий болохгүй гэж, яагаад гэвэл бид эндээ оноосон нэр өгөх тухай асуудлаа л ярьж байгаа шүү дээ. Оноосон нэр, улсынхаа дээд гол хууль болсон улсынхаа үндсэн хууль болсон энэ хуулийг онцгойлон нэрлэж Их цааз гээ гэдэг тухай л санал явж байгаа. Тэгэхлээр зэрэг бусад хууль болгонд онцгойлсон нэр өгөхийн учир шалтгаан энийг дагаад үүсэхгүй байх л даа. Одоогийн оноосон нэр, одоогийн сумдын нийлүүлж хошуу ^{болгох} за асуулт давхардаж байна Жамбалдорж гуай II8-р тойрог, Хошууны төв болоогүй сумд ямар болж үлдэнэ гэж бодож байна вэ л гэж л байна л даа. Одоо нөгөө балгас болох уу гэж хуучин туршлагаар, тэрний талаар өмнөх хариултууд дээр гарсан. Бодож байгаа бодол шүү дээ. За улсын нэрийг энэ асуудал давхардаж байна. 39I-р тойргийн депутат Лхагва гуайн асуудал, сонгуулийн хугацаа нь бол янз бүр байдаг нь юум бэ, жишээ нь Ерөнхийлөгчийг 4 жил, УИХ-ыг 6 жил, гишүүнийг 3 жил, Засгийн газрыг 6 жил, цэцийг 9 жил гэх мэтчилэн, энэ улсын их хурлыг 6 жил гээгүй шүү ^{дээ} улсын их хурлын хувьд бол одоогоор улсын их хурлын хугацаа гэж байхгүй байгаа. Нэг гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байгаа, улсын их

хурлын гишүүдийн сонгууль бол 3 жилийн дотор тал хувийн суудал дээр сонгууль хийгдэж ингэж явахаар байгаа. Үүнтэй холбогдуулаад Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 6 бөгөөд 6-гий нь 3 + 3 байгаа гээд учир шалтгааныг нь Жүгдэр хариултад дээрээ тайлбарласан, цэцийн 9 жилийг бол 9 жил л гэж тогтоолоо. Эрхэм депутатууд энийг их, багын тухай бол өөрсдөө учир зүйгээрээ ярих учиртай байх. Ерөнхийлөгчийн 4 жилийг бол ерөнхийлөгчийнхийг бол харин заавал энэ сонгуулиудтай давхцуулаад байхын учир шалтгаан зайлшгүй үүсэхгүй юмаа гэдгээрээ эдгээртэйгээ хамаагүйгээр авч үзээд 4 жилийн гэсэн ийм л санал оруулж байгаа юм. Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын хоорондын засаглал хуваарилалтыг яагаад хязгаарлагдмал эрхтэй Ерөнхийлөгч байхаар тогтоосон юм бэ, Ерөнхийлөгчийн буюу Засгийн газар Ерөнхийлөгч нь толгойлох хэлбэр авч үзсэн үү гэж, энэ хэлэлцэгдэж л байгаа Ерөнхийлөгчийн төрийн удирдлагын ерөнхийлөгчийн хэлбэр байх уу, парламентын хэлбэр байх уу, энэ болгон маань энэ үндсэнээс энэ асуудлууд зөндөө яригдаж байгаа шүү дээ. Энэ бол Ерөнхийлөгч маань үндсэн агуулгаараа бол гүйцэтгэх эрх мэдлийнхээ тэр хэмжээнд л багтаж ингэж үзэгддэг эрх мэдлийг хуваарилах энэ онолынхоо үүднээс тийм л байгаа юм. Хууль тогтоохдоо бол хориг тавих эрхтэйгээр оролцдог, сонгуульд ялсан нам Засгийн газраа шууд толгойлон эмхлэн байгуулах талаар тодорхой тусгаж болох уу, энэ 2-ын аль нэгийг тодорхой сонгон туслах талаар авч үзсэн үү гэж түрүүн тайлбарлалаа, энэ бол үндсэндээ үндсэн хуульд тусчихаад байна гэж ойлгогдохоор. Энэ Батбаяр гуай асуусан 309 дүгээр тойрог. Чулуунбаатар гуай, 175-р тойрог, Энэ үндсэн хуулийн 2 дугаар хувилбарыг хэлэлцэх боловсруулах ажлыг жаахан хурдавчилаад арай ядахдаа 10-р сарын 15-нд ард түмний гар дээр тавьж болсонгүй юу, шалтгаан нь юу вэ гэж, бага хурал нэлээн хамгийн богино хугацаанд л үндсэн хуулийг боловсруулах ажлыг зохион байгуулах комисс маань аль болох богино хугацаанд дотор 9 сард ард нийтийнхээ хэлэлцүүлгийг дуусгаад дараачаар нь энийг оролцуулаад боловсруулах ажил дээрээ суулаа, шууд боловсруулж дуусангуут нь бага хурал авч үзлээ. Бага хурал маань 10 өдөр, өдөр болгон 10 цаг

хүртэл хуралдаж байгаад та бүхнийхээ 15 хоногийн өмнө өгөх энэ зайлшгүй үүргийнхээ дагуу ажиллаж байгаад ингээд л одоо та бүхнийхээ гар дээр өглөө, үнэндээ энэнээс хурдан энэнээс өмнө болох боломж бид нар л зохион байгуулж лав чадсангүй. Боломж байсан юмуу үгүй юм уу тэрний нь хэлж мэдэхгүй байна. Үндсэн хуулийн 2 хувилбарыг ард түмний саналаар маш өөрөөр боловсруулагдаж гарсан, ард түмний саналаас, одоо бол улсын бага хуралд ирсэн гадаадын эрдэмтдийн санал ихээхэн нөлөөлснөөс ийм болжээ гэж үзвэл болох уу гэж, тэгж үзэж болохгүй бөгөөд энэ хоёр хоорондоо маш өөр болсныг нь ард нийтээр хэлэлцүүлсний үр дүн тэр хооронд ард нийтийн хэлэлцүүлэх явцад гарсан саналууд болгон дээр шинжилгээ хийж, тэрний дагуу болон мөн зохих олон улсын байгууллагууд олон улсын эрдэмтдийн санал зөвлөмжийг сонсож, энэ болгоныхоо үндсэн дээр боловсруулаад ингээд энэ 2 төслийн одоо бүр маш өөр байгаагүй нь болбол үүний ач холбогдол гэж үзэж байна. 152-р тойрог Рашитхан гуайн энэ асуудал давхардаж байгаа юм. Улсын их хурлын гишүүн Ерөнхийлөгч болох хүмүүсийн насыг зааж өгч байгаа хүний ^{эрхийг} зөрчиж байгаа асуудал биш үү гэж, энэ бол зөрчиж байгаа асуудал биш, гэхдээ энэ насыг тогтоох уу үгүй юу гэдэг асуудал дээр бол бид ярих асуудлууд. Давхардсан байна.

За энэ Шагдар гуайн асуудал 398-р тойрог давхардаж байна. Эргүүлж үзээд Баярсайхан депутатын асуудал байна 395-р тойрог, одоогийн аймаг сумдын ардын их хурлын гүйцэтгэх захиргаад яаж өөрчлөгдөх вэ, хошуу багт ямар хэлбэртэй байх вэ гэж, тэгэхээр зэрэг энэ бол бүр өөрөөр авч үзэгдэж байна шүү дээ. Төрийн удирдлагыг засаг даргаараа, нөгөө удирдлага нь бол төлөөлөгчдийн болон бүх нийтийнхээ хурлаар дамжиж, энэ бол тун өөр болж байна. Сонгуульд парламентын олонхийн суудал авсан нам гэж ямар намыг хэлэх вэ гэж суудалд олонхийн суудал авсны нь л тэгж хэлнэ шүү дээ. Их хуралдаа одоогийн төслөөр бол их хурлын гишүүдийн дотор аль намаас нь нэр дэвшигдэж сонгуульд ялсан депутатууд хичнээн байна вэ, түүгээрээ энэ их хуралд тэр нам тэдэн суудал эзэлж байна гэж л тодорхойлогдож яригдах юм. Тэгээд түүгээрээ олонхи, цөөнх, гэдэг асуудал уламжлагдаж гарч ирнэ. За Гомбожав гуайн асуудал байна 420-р тойргийн депутат. Сонгуулийн

асуудлаар байна, Ерөнхийлөгчийн сонгууль 4 жил, их хурлынх 6 жилээр сонгож байх ялгаа нь юундаа байгаа юм. 6 жил адилхан байвал яасан юм бэ гэж, ийм санал байгаа юм. Улсын нэрээс Бүгд найрамдах гэдгийг нь хасч байгаа нь ямар учиртай юм бэ гэж, энэ учир шалтгааны тухай түрүүнд товч хэлбэрээр хэллээ. Төрийн удирдлагын хэлбэрээ бүгд найрамдах улс гэж сонгож авсан. Энийгээ заавал нэрэндээ оруулах уу үгүй юу гэдэг асуудлыг бид зайлшгүй шаардлагатай ~~жөөг~~^{эсэх}ээр нь авч үзнэ гэж ярилаа шүү дээ. За Пунцаг гуай, асуудал давхцаж байна, хөрөнгө мөнгө зохион байгуулалт сум хошуудын зохион байгуулалтын талаар. 392-р тойрог Сандуй гуайн асуулт байна. Ерөнхийлөгч илгээлт гаргана гэж хуулийн 33-р зүйлд заасан нь ямар утга агуулгатай бичиг гарна гэсэн үг вэ гэж, Ерөнхийлөгч маань ард түмэндээ төрийн тэргүүнийхээ хувьд эв нэгдлийнхээ баталгааны хувьд ард түмэндээ хэрхэн ямар байдлаар хандах вэ тэр л хандах бүх хэлбэрийг л ямар нэг ерөнхий утгаар нь бол илгээх гэсэн ийм байдлаар л ойлгож хэлж байна. Өнгөрсөн практикт бол Ерөнхийлөгчийн айлдвар гэж ч гаргасан байгаа, тэр нь тодорхой хэм хэмжээнд Ерөнхийлөгчийн зарлиг гэж гарсан байгаа. Энэ бол Ерөнхийлөгч ард түмэнтэй харьцах харьцааны тодорхой илэрхийлэл болсон ийм л илэрхийлэлтийг нь илгээлт гаргана гэдгээр томъёолж байна. За хуулийн 17-р зүйлийн 3-т төрийн төр, түүний эрх барих байгууллага нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн эд хөрөнгийг дайчилах дайчилгаа хийнэ гэж зайлшгүй хэрэгцээ гэдгийг тодруулж өгнө үү гэж, энэ бол хуулиар тодруулж зааглах зүйлүүд байгаа байх гэж бодож байна. 30-ын 2-т Ерөнхийлөгч 4 жилээр сонгогдохоор заасан гэтэл Засгийн газар, их хурал 6, за түрүүн асуудал давхардаж байна. Шүүхийг хугацаагүйгээр байхаар заасан байна. Эхний төсөлд 12 жил гэж байсан, энэ яагаад хугацаагүй байгаа юм гэж, за тэр шүүгчийн хараат бус байдал, үйл ажиллагаандаа итгэлтэй байх, үүнийхээ дагуу хэнээс ч хамааралгүй шахалт шахалтгүй байх хуульдаа зөвхөн хуульдаа захирагдах энийг баталгаа болгож байна л гэж бодож байна. За асуудал давхардаж байна. Тэтгэврийн хуулинд өөрчлөлт орох уу, хэвээрээ байх уу, 35-36 насны за энийг бид бага хурлынхаа тайлангаа хэлэлцэх хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох тухай асуудал дээр энийгээ ярилцна.

За Батмөнх гуай, 198-р тойргийн депутат. Нутгийн өөрөө удирдах ёсны тухай их цаазын 4-р бүлгийн зүйлүүд бол тухайлбал баг, хоринь иргэдийн нийтийн аймаг, нийслэл, хошуу хорооны иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 1950 оноос манайд төлөвшиж эхэлсэн. Сонгуулийн ардчиллын тэгш шууд байх зарчмуудаас ухарч байгаа хэрэг бус уу гэж, энэтэй огт холбоогүй юмаа гэж хэлчихвэл нэг их хол тусчихгүй байх гэж бодож байна л даа. Эсвэл улс орны онцлог, цаг үеийн байдалд нийцүүлэн сонгуулийн ардчиллыг монголын уламжлалыг сэргээж байгаа хэрэг үү, хэрэв тийм бол үнэнийг хэлнэ үү гэж, энэ бол сонгуультай ямар ч учир холбогдолгүй бөгөөд зүгээр орон нутаг, өөрийнхөө нутаг дэвсгэр дээр өөрийнхөө өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх тэр хурлаа сонгох, бүрэлдүүлэх энэ нь бол өөрийх нь сонгуулийнхаа юугаар хэлэлцүүлнэ шүү дээ. Тэр нь бол энэ нийтлэх тухайлбал их хурлын гишүүдийг сонгох сонгуультай бол бараг огт хамаагүй гэхэд болно. Зүгээр сонгуулийн тойргийн зохион байгуулалтыг яаж хийх вэ гэдэг асуудал тэрэнд захирагдах засаг захиргааны нэгжийг бүхлээр нь дотроо багтаах эсэх тухай асуудал сонгуулийн тойргийн зохион байгуулалтан дээр бол яригдана. Гэхдээ энэ нь бол манайх шууд ардчилсан нууц байх гэдэг энэ сонгуулийнхаа зарчмаас огт ухарч буцсан зүйл байхгүй байгаа шүү дээ. Сум болгон дээр нэг тойрог гаргаад тэгээд явдагтай адилхан тийм агуулга бол яригдах гэж байгаа юм биш. За Тангад гуай асуусан байна, 297-р тойрог, өнгөрсөн жил гаруйн үйл ажиллагаанаас үзэхэд хууль тогтоох дээд байгууллага, бага хурал, их хурлын хамгийн гол зөрчил доголдолтой талын энэ талаар таны дүгнэлт юу байна вэ гэж, за энэ дүгнэлтийг ч одоо больё доо. Сүүлд шаардлагатай бол бага хурлын тайлангийнхаа хувьд ярь. Одоогийн хуулиар бага хурал хууль тогтоох хянан шалгах, уучлаарай депутат хүний асуусан асуулганд үл ойшоож хариулж байна гэж битгий ойлгоорой. Би хүндэтгэж байна, энэ асуудалд сүүлд ярихад яг одоо хэлэлцэж байгаа асуудалтайгаа энэ шууд холбоо бүхий асуудлаар ярьж гэж байна. Үүнийг хэлж байгаа асуудалтай шууд холбоотой гээд төрийн удирдлагын ямар хэлбэрийг сонгох вэ, 2 парламенттай байх уу, үгүй юу гэдэг дээр ярьж гэвэл тэрнийгээ сүүлд дэлгэрэнгүй хэлбэрээр ярилцах боломжтой. Одоогийн хуулиар бага хурал, хууль

тогтоох, хянан шалгах, зохион байгуулах 3 гол үүрэгтэй, ийм ч функцтэй, шинэ төсөлд их хурал хууль тогтоох эрх мэдэлтэй, иймд хянан шалгах, зохион байгуулах үүргүүд нь төрийн гүйцэтгэх дээд байгууллагад шилжинэ гэж ойлгох уу гэж, ингэж ойлгохгүй, энд бол зүгээр бид нар хэлж байна шүү дээ, эрх мэдлийг хуваах зарчим гэдэг энэ зарчим дээр тулгуурлаж гүйцэтгэх хууль тогтоох, шүүн таслах гэдэг 3 эрх мэдлээрээ 3 бүлэг хуваарилаад хууль тогтоох эрх мэдлийг зөвхөн их хурлаар хэрэгжүүлнэ гээд ингээд явж байгаа бөгөөд эрх мэдлийн онцгойлсон бүрэн эрхийн дотор бол түүнийг хянан шалгах гэж үндсэн хуулийн нэмэлтийн хуульд байгаа тэр үүрэг ч байгаа зохион байгуулах ч үүрэг байгаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш. Бурмаа

Ш. БУРМАА

1991.XI.14.

Кассет № 38

16.05-16.20.

Р.Гончигдорж: ... энийг гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлнэ гэж ойлгохгүй, гүйцэтгэх байгууллага өөрөө гүйцэтгэх үйл ажиллагааныхаа хүрээнд байх өөрийн хянах чиг үүргүүд бол тодорхой хэлбэртэй байна шүү дээ. Энэ бол Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийн тэр хэмжээнд байгаа гэж үзнэ.

Шинэ төслөөр байх байнгын ажиллагаатай нэг танхимын Их Хурлын зардал одоогийн хоёр танхимтай Ардын Их Хуралтай харьцуулахад нэмэгдэх үү, эсвэл хорогдох уу гэж байна.

Зардлын талаар бидэнд ярьсан юм их бий. Энийг сүүлд ярина. Бид тодорхой санал ч оруулна гэж бодож байна. Бага Хурлынхаа тайлангийн үед.

170 дугаар тойргийн депутат Д.Лхагвасүрэн, бидний Үндсэн хуулинд зарлан тунхаглах гээд байгаа иргэний ардчилсан нийгмийг юу гэж ойлгож байна вэ гэсэн байна.

Энэний талаар сүүлд харилцан ярилцая гэсэн байх, яг асуудлаа хэлэлцэх үедээ.

Л.Баатарсүрэн, 410 дугаар тойрог. Төсөлд Монгол улсын иргэний үндсэн эрхийг хангалттай тусгасан байна. Харин иргэн хүний талаар цөөн заалт орсон байна уу даа. Өөрөөр хэлбэл, хэтэрхий ерөнхий байна. Иргэн бүр хөдөлмөрлөх үүрэгтэй ... асуулт давхардаж байна.

Б.Буянменх, 177 дугаар тойрог. Засгийн газрын гишүүд орсон байдаг хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын төсөл тус тусдаа байгаа. Зарим оронд парламентад Засгийн газрын гишүүд орсон байдаг. Хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага төсөлд тус тусдаа байгаа. Үүнийг ямар давуу талыг үндэслэж сонгов? Ер нь дээрх хоёр зарчмын ялгаа, сул тал, давуу талыг хэлнэ үү?

Энэ дээр Улсын Бага Хурлын, ялангуяа сүүлийн чуулганы

хуралдаан дээр энийг хэлэлцэж байхад маш их хэмжээгээр ярьсан, олон талаасаа ярьсан.

Засгийн газрын гишүүн хууль тогтоох байгууллагынхаа гишүүн байх боломжийн тухай асуудал, түүнээс гарах эерэг, сөрөг, сайнтай муутай талуудын талаар маш тодорхой ярьсан. Энэ асуудлаар тодорхой асуудал гарч ирээд бид нар энийгээ хэлэлцэх үедээ, энэ асуудлаа хэлэлцэх үед энэ дээр ярих олон зүйлүүд, маш олон зүйлүүд бий. Олон улсын практикт аль аль хувилбар нь байгаа юм.

Д.Дамдин 275 дугаар тойрог. Монгол улсын Их цаазын хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь заалтанд 1992 онд багтаан зарим аймгийн нутаг дэвсгэрт байгаа улсын харьяатай хот, өөр сумын нутаг дэвсгэрт байгаа хороо, районыг зохих аймаг, хошуунд нэгтгэхээр заасан байна. Ийм хороо, район хэд байгаа юм бэ? Ингэж нэгтгэсний дараа хошуудыг зохион байгуулах үед дахин өөрчлөгдөх явдал гарах уу, үгүй юу? Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчилсэн хуваарийг нэг л тодорхой хугацаанд хийж болохгүй юу?

Бид нар Их цаазынхаа хавсралт хуулийг хэлэлцүүлэхэд нэлээн нарийвчилж ярилцах зүйл бөгөөд ер нь энэ Үндсэн хуулийгаа хэрэгжүүлэх үед хамгийн тэргүүн ээлжинд хамгийн хялбар байдлаар засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтад орох ийм боломжийн хэсгүүд бол эндээс эхэлж байгаа юм. Энд хот суурин гэж томъёолоод түүнийгээ түрүүн тайлбарласан. Захиргааны биеэ даасан нэгж заавал байх гэдэг утгаас нь энийг авч гаргасан. Үүнтэй холбогдуулж энэ зохион байгуулалт бол ялангуяа өнөөгийнхөө эрх ашигт илүү тохиромжтой болох байх аа гэдэг хандлагыг, хандлагатай байгаа юм.

Тэнд бол манай бүх л хотууд байна шүү дээ. Өөр засаг захиргааны нэгжийн нутаг дээр байрлаж байгаа, өөрөө биеэ даасан засаг захиргааны нэгж болж байгаа хотуудыг гэх юм бол бүгдээрээ тийм байгаа шүү дээ. Тэгээд тэрнийгээ засаг захиргааны нутаг дэвсгэрийн гэдэг зарчмаа баримтлаад засаг захиргааны нэгжээ байгуулахдаа нутаг дэвсгэр

дээр нэг засаг захиргааны нэгжид байгаа бол тэрнийг дэд хэсэг юмуу, эсвэл түүний төв байх утгаар тэгээд засаг захиргааныхаа хувьд, эсвэл хошуу гэдэг статус авах уу, эсвэл хороо гэдэг статус авах уу, эсвэл баг гэдэг байдлаар байх уу гэдгийгээ бол шийдвэрлэх. Эсвэл зүгээр суурин байх юмуу, хүн ам оршин суусан. Тийм учраас энэ эхний алхмын зүйл. Сүүлд хошууг юу гэж өөрчиллөө гэхэд энээс үүдээд бэрхшээл үүсэх зайлшгүй шалтгаан бодогдохгүй байгаа юм.

Саяхан аймгийн дарга нартай уулзахад "хошуу", "сум" гэсэн нэрийг солих төдий асуудал гэж ярьсан. Одоо болохоор сумдыг нийлүүлж хошуу болохоор яригдаж байна. Ингэж үзсэн нь аймгийн дарга нартай уулзсаны дараа шийдсэн асуудал уу? К.Мизамхан 74 дүгээр тойрог.

Үгүй ээ. Аймгийн дарга нартайгаа уулзалтаа эхлэлгүй мөн дуусгалгүй тарсан уулзалтан дээрээ бол бид нар тэгэж ярьсан. Яг шууд Үндсэн хууль хүчин төгөлдөр болоод энэ хавсралт хуулийнхаа дагуу авч үзэж байгаа энэ төсөл боловсрогдож, бүр өмнөөсөө ярьж байгаа юм. Энэ бол эхний түвшинд сум гэдэг нэрийг шууд "хошуу" гэдэг нэрээр шууд солигдоно, эхлээд. Дараачаар нь засаг захиргааны зохион байгуулалтын энэ явцад дараачаар нь энэ хошуунууд хоорондоо нийлэх юмуу, салах юмуу, ямар томрох энэ асуудлууд нь тэр зохион байгуулалтынхаа хувьд яригдах зүйл. Тийм учраас эхний шат нь шууд нэрээ авах шат, тэгээд дараачаар засаг захиргааны нэгжийн цаашдын зохион байгуулалтаар энэ асуудал шийдэгдэнэ. Тийм учраас энэ бол дарга нартай уулзахад ч, уулзахаас ч өмнө ийм л баримтлалтайгаар, тийм ч учраас энэ шилжилтийн хуулин дээр тийм байдлаар туссан байгаа юм.

Ж.Лхагважав. 171 дүгээр тойрог. Ерөнхийлөгчийг нийт ард түмний олонхийн саналаар сонгосон атлаа Улсын Их Хурал 76-хан гишүүнтэй олонхийн саналаар огцруулдаг нь ямар учиртай вэ гэсэн байна.

Энэ огцруулна гэдэг бол маш өндөр учир шалтгаантай тэр тохиолдолд, тэгээд энэ огцруулах учир шалтгаан байна уу

үгүй юу гэдэг талаар Үндсэн хуулийн цэц асуудлыг оруулж ирсэн олон зүйлээр нөхцөлдсөн ийм нөхцөл байдал үүссэн онцгой тохиолдолд энэ харилцаа үүсэх учиртай юм. Тэрнээс тэр дур зоргийн асуудал огт биш. Олон давхар хадаастай, бэжлээтэй, харилцан хяналттай ийм асуудал.

Их цаазын цэцийг 9 жилийн хугацаагаар сонгож, 9 хүнийг томилно гэснийг тайлбарлана уу гэсэн байна.

Их цаазын цэцийн талаар Үндсэн хуулиндаа нэлээн тодорхой хэлбэртэй, эрх үүрэг хэмжээг нь тодорхойлсон байгаа. Түүнээс гадна Их цаазын цэцийн тухай тусгайлсан хууль тодруулж гарч ирнэ. Зүгээр тооны талаар та бүхэн өөрсдөө бодох асуудал. 9 гэдэг тоо нь гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Их Хурал, гурвыг дээд шүүхээс оруулах гэдэг утгаараа ийм 3-т хуваагдах шинжтэй гэдгийг гаргаж байгаа юм. Тооных нь хувьд бэлгэдлийн шинж чанар ч байж болохыг үгүйсгэхгүй юм.

Энд насны талаар асуултууд байна. Заавал нас, ажилласан жилүүдийг заагаад байхын шаардлага байгаа нь юу юм бэ гэж байна. Энэ бол тэр хүнд л тавьж байгаа ажил мэргэжил, чадвар дадлага, практик, энэ ажил, эрхээ явуулах энэнд нь зарим нэг талаар тавих шалгуур шаардлагууд гэж бодож оруулаад байгаа юм. Тэгээд эрхэм депатуудыг энийг цөөрүүлэх, хасахыгаа ярилцаж, хэлэлцээд энэ дээрээ харилцан тайлбараа өгөөд шийднэ биз дээ.

Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг Ерөнхийлөгч, бусад чуулганыг Их Хурлын дарга товлон зарлана гэжээ. Үүний учир юу юм бэ? Хурлын хугацаа эрхээ дуусгавар болтол хэрэгжүүлэх ёстой биш бил үү?

Тэгэхээр энэ хоёр өөр зүйл юм даа. Улсын Их Хурлын сонгууль явагдаад Улсын Их Хурал бүрэлдэн бий болчихлоо гэхэд энэ Их Хурлын анхны чуулганыг зарлах нь одоогийн Ерөнхийлөгчийн эрхэд байгаа. Одоогийн Ерөнхийлөгч тэр хурлыг зарлана. Тэр хурал зарлаад энэ Үндсэн хуулийн төслөөр бол 30 хоногийн дотор анхан шатны сонгууль явагдсанаар

нэр дэвшигдсэн Ерөнхийлөгчөөс Ерөнхийлөгчөө сонгоод Ерөнхийлөгчийг сонгонуут энэ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусаад Ерөнхийлөгчийн эрх мэдэл тэр Ерөнхийлөгчид шилжээд ингээд явах тухай асуудал байгаа шүү дээ.

Тэрнээс хойш Их Хурлын чуулганыг зарлах асуудал нь тасралтгүй үргэлжлэх ийм утга учиртай, ийм л зохицуулалтын асуудал.

415 дугаар тойрог Н.Ганбямба гуай асуужээ. Төсөлд Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатанд Улсын Их Хурал бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх, *Бас Улсын* дүгнэлтийг үндэслэн огцруулж болох заалт бий. Гэтэл эхний шатны сонгуулиас 50-иас дээш хувийн санал авсан Ерөнхийлөгчийн Их Хурал огцруулж болох уу, үгүй юу гэдэг асуудал гарч ирнэ. Энэ талаар тайлбар өгөхийг хүсье.

Чухамхүү эхний шатаар олонхийн саналыг авсан тийм Ерөнхийлөгчийгөө хуульчлан батлах эрхийг Их Хуралд байлгаж байгаагийн энэ шинж чанар нь энэ л байдлаас эх үүсвэр гаргаж, учир шалтгаанаар нөхцөлдсөн юм гэдгийг тайлбарлан хэлсэн, түрүүн.

Зарим асуулт давхардаж байна.

Энэ асуудал давхардаж байна. 173 дугаар тойргийн депутат Д.Лхамсүрэн гуай асуусан байна. Төр, шашныг тусгаарлах асуудал, иргэний боловсрол шашнаас тусгаар байх тухай асуудал.

Тухайлах юм бол, иргэний боловсрол тодорхой үзэл суртал байгаа нөхцөлд заавал шашнаас тусгаар байна гэж заасны учир юу бэ?

Ер нь иргэний боловсролыг ч гэсэн үзэл суртлаас ангид байлгах тухай асуудал гэдэг маань өнөөдрийн боловсролын байгууллага дахь нэг өөрчлөлт шинэчлэлтийн үндсэн агуулга болгож тавигдаж байгаа шүү дээ.

Энд жаахан статистик тоонууд асуусан байна.Энэ компьютерт байгаа тоонууд.

Р.Чойжинням гуай асуусан байна, 186 дугаар тойргийн депутат.Их цаазын төслийг бүх ард нийтээр хэлэлцүүлэхэд шинээр боловсруулсан хуулийг Их цааз юмуу Үндсэн хууль гэж нэрлэх талаар аль нь олонхийн санал авсан бэ?

Санал авсан бэ гэдэг байдлаар томъёолж болохгүй гэдгийг би түрүүн хэлсэн.Иргэдээс ирсэн санал дотор аль нь хэдэн хувь байна вэ гэдэг тэр тоо бол энэ компьютерт байж байгаа.Тэр тоог тэндээс гаргаад хэлбэ.

Төрийн сүлдийг хуучнаар нь хэрэглэх, шинээр зохиох талаар мөн ирүүлсэн саналын дотор эзлэх хувиуд ямар байна вэ? Монгол улсын засаг захиргааны нэгжийн тухайд аймаг-сум-баг, аймаг-хошуу-баг гэдэг зохион байгуулалтын талаар хөдөлмөрчдийн гаргасан санал, ирүүлсэн санал ямар хувь хэмжээтэй байна вэ гэсэн асуулт байна.

Энэ бол компьютерт диаграммаар байж байгаа.Тэрнийг надад бичээд өгчих байх.

Төслийн талаар төслийн нэр 562 санал ирсэн байна. Их цааз гэж 12,1 хувь нь, Үндсэн хууль гэж 52,3 хувь, Их засаг гэж 13,0 хувь, Их хууль гэж 4,1, бусад 18,5 хувьтай байгаа юм байна.Нийт 562 хоёр санал иржээ.

Улсын нэрийн талаар 494 санал ирсэн байна.БНМАУ гэж хуучнаар нь байлгая гэж 63,8 хувь, Монгол улс 25,3 хувь, Бүгд Найрамдах Монгол Улс гэж 6,1, бусад нь 4,8 хувь байна.

Төрийн удирдлагын хэлбэрийн хувьд Ерөнхийлөгчийнх гэж 31,6, Парламентын 63,2 хувь, бусад хэлбэрийг 5,2 хувь.

Нутаг дэвсгэрийн хуваарилалтын талаар 289 санал ирсний зөвшөөрсөн нь, төсөлд байсныг зөвшөөрснийг 31,5, зөвшөөрөхгүй байгаа нь 47,1, бусад 21,4 хувь байна.

159 дүгээр тойрог, Б.Эрхэмбаяр гуайн асуулт давхцаж байна.

Улсын хэмжээгээр удирдлагын нийт зардал хэдэн сая төгрөг байна вэ гэсэн нэг асуулт байна.Энийг мэдэж байгаа улсууд хариулна уу, удирдлагын зардал.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулийн төслийг бидэнд танилцуулах уу гэж байна.

Би өчигдөр болгож санал болгож хэлсэн, та бүхэнд.

Улсын нийслэл Улаанбаатар гэж байсныг өөрчилсөн гэж байна.

Энийг өөрчлөөгүй.Улсын нийслэлийн тодорхойлолтыг тэнд өгсөн байгаа.Нэмэлт хуулиндаа бол Улаанбаатар гэдэг маань улсын нийслэлээрээ байгаа.Энэ хавсралт хуулиндаа.

Удирдлагын зардлыг санаж байна уу, Энхсайхан аа. Улсын төсвийн 8 хувь.

Нарийвчилж тодруулаад Энхсайхан аа, үзэж байгаад хэд хэдэн хувилбараар нь гаргаад депутатад өөрт нь хариу өгье, Б.Эрхэмбаяр гуайд.

384 дүгээр тойргийн депутат М.Санжаа гуайн асуулт байна.Улсын нэрийн талаар байна.Ардчилсан улс гэж байсан, Бүгд Найрамдах Улс гэж байна.Энэ маань хоорондоо холбоогүй зүйл гэдгийг түрүүн тайлбарлалаа.

Төрийн эрх ард түмний мэдэлд байна гэж байсан.Одоогоо засгийн бүх эрх ард түмний мэдэлд гэжээ.Ялгааг нь хэлнэ үү гэжээ.

Энд зарчмын ^{ялгаа} алга аа. Зайлшгүй энд нарийвчлан тайлбар-
лах асуудал үүсвэл энэ дээр тайлбар тавьж болно.

Засгийн эрх, төрийн эрх гэсэн асуудлынхаа хувьд хэлбэр-
ийн ялгааг жаахан тодруулж болно. Засгийн эрх түүн дотор
багтаж байгаа төрийн эрх гэдэг утгаас цаана нь хальж байгаа
жаахан юм нь юу байдаг юм бэ гэдэг талаар нарийвчлан тайл-
бар өгч болно.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

241

Гончигдорж – Хүнлэг ардчилсан нийгэм, иргэний ардчилсан нийгмийн зарчмын ялгаа юу вэ гээд үүнийг дараа ярьж гэж тогтоолоо. Хууль цаазат ардчилсан ёс, БНМАУ-ын ялгааг тодотгон тайлбарлаж өгнө үү гэлээ. Энэ дээр бас цаашаагаа хоорондоо ярилцаж тэр үед хэлэлцэж байх үедээ албан ярилцаж гэж. Төрийн эрх, засгийн эрх гэдэг ялгаа байна уу гэж. Түрүүн хэллээ. Тэр хоёрын хоорондын жишиг ялгааг. Ялгаатай бол I дүгээр бүлгийн 3-р зүйлийн нэгд зөвхөн засгийн эрхийг ард түмэн мэднэ гэснийг учрыг хэлнэ үү. Үнэхээр Засгийн эрх утгаараа бол тэр бол ард түмний мэдэлд байна. Тэр тусмаа түүн дотор багтаж байгаа төрийн эрх бол ард түмний мэдэлд байх асуудлаар. Зайлшгүй тайлбарлаж гэвэл үүнийг тухайлбал Чимид гуай, Зардыхан гуай хоёрт өгөөд саяын ярьсан хэсгүүдийг тайлбарлаж болж байна. Мөн прокурорын гадаадын болон харьяалалгүй иргэдэд газрыг түрээсээр өгөхийг сая энэ асуудал нь давхцсан, Дамдинсүрэн гуайн асуудал байна. 400 дугаар тойрог. Прокурорын үүрэг өөрчлөгдлөө, улсын хэмжээгээр ерөнхий хяналтыг хэн тавих юм бэ гэсэн асуудал байгаа юм. Би энэ асуудлыг Цог гишүүнээр хариулуулмаар байна. Энд бол хуучин Үндсэн хуулинд байгаа прокурор, шинэ үндсэн хуулинд байгаа прокурорын болбол нилээн өөрөөр томъёологдон хэрэглэгдэж байгаа. Прокурорын хуучин тавьж байсан одоо ерөнхий хяналтын гэдэг тэр ойлголт. Тэр хэрхэн өөрчлөгдөж, хэнд энэ зүйл шилжих юм бэ гэдэг асуудлын талаар. Энэ асуудал хоёр байна.

– Оршин суух эрхээ өөрөө сонгоно гэсэн байна. Сум, хошуунд очих эмч, багш нар олдох болов уу гэж санаа зовсон байна. За эдгээр очиж ажиллах нийгэм, эдийн засаг, мэргэжил, ажлын ашиг сонирхлоо үгүйсгэх энэ үүднээсээ тайлбарлагдах байх даа. Тэрнээс биш тэрүүнээс болоод Үндсэн хуулинд чөлөөтэй газраа сонгох асуудлыг хязгаарлаж болохгүй байх. Цог, Чимид, Зардыхан гуай хариулах уу. Гуравхан энэ зүйл дээр нэг нэг тодруулаад хэлмээр байна.

Гончигдорж -За ингээд 3 гишүүнийхээ тайлбарыг сонсчихье. Та бүхний тавьсан санал таслах хүртэл бичгээр тавьсан асуудлууд дууслаа. Ингээд та бүхнийг олон асуудлууд тавьж хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархаж байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Чимид -Тэнэтхэн аваад тулгамдах бололтой байна. Засгийн эрх гэдэг нь бол Засгийн бүх эрх гэж төрөөс мэддэг зүйл. Орон нутаг өөрөө мэддэг зүйл хоёрыг багтаасан ойлголт юм. Бас олон нийт өөрөө мэддэг зүйл. Ер нь төрийн засаг буюу төрийн эрх олон нийтийн засаг, төв засаг, орон нутгийн засаг захиргаа гээд энэ юмнуудыг бүгдийг нь багтаахын хувьд засгийн бүх эрх гэж өргөтгөж хийсэн юм. Товчдоо ийм. Төрийнх гэдэг нь мэдээжээр төрөөс шийддэг, засагладаг, захирдаг тэр асуудал нь байгаа. Тийм учраас Үндсэн хуулийнхаа багтаамжийг өргөтгөхийн тулд орон нутгийн өөрөө удирдах ёс, төрийн төвлөрсөн төв засаг энэ бүгдийг нийлүүлээд хэлсэн байгаа. Мэднэ гэдгийг бол мэдэлд байна гэдэг үгтэй байсан. Тэгэхдээ мэднэ гэж хэлнэ манай хэл Үндсэн хуулийн хэл найруулгын ажлын хэсэг тэгэж өөрчилсөн байна лээ. Тэрэн дээр ярих асуудал бий байх аа.

-Үүнийг маргааш 3 цагаас бүр тодорхой ярьж гэж дарга хэлсэн шүү дээ.

Уртнасан -Депутат Цог.

Цог -Прокурорын ерөнхий хяналтын тухай асуудал олон дахин гарах шиг боллоо. Үнэндээ түрүүчийн Үндсэн хуулиас өөр төсөөлөгдсөн томъёологдсон байгаа. Энд би хоёр зүйлийг ярьж гэж бодож байна. Нэгдүгээрт, прокурорын ерөнхий хяналт гэж ямар юм байсан юм бэ гэсэн асуудал байгаа юм. Мөн чанараараа юу байсан юм бэ, одоо өөр болох юм бол функцийг нь хэн гүйцэтгэх юм бэ гэсэн ийм асуудал байгаа юм л даа. Тэгэхлээр бид нар олон жил түрүүчийн үндсэн хуульд томъёолсон ёсоор прокурорын ерөнхий хяналт бол прокурорын байгууллага өөрөө төрийн нэрийн өмнөөс хуулийн биелэлтэд дээд хяналт тавина гэж томъёолж ирсэн. Үнэн хэрэг дээрээ дээд байж чадаагүй хяналт нь. Яагаад гэвэл дээд хяналт бол үндсэн хуулиасаа эхлэх ёстой. Бусад хууль нь

үндсэн хуультай нийцэж байна уу, үгүй байна уу нэгдүгээрт. Хоёрдугаарт, төрийн дээд байгууллагууд Ардын Их Хурал, Засгийн газар, одоо бол ерөнхийлөгч энэ бүхэн Үндсэн хууль, бусад хуулийг зөрчиж байна уу гэдгийг хянаж байх ёстой. Гэтэл түрүүчийн үндсэн хуульд заасан ёсоор прокурорын байгууллага засгийн газраас доош түвшингийн эрхийн актыг хянадаг байсан. Энэ утгаараа дээд байж огт чадаагүй. Хоёрдугаарт, 1922 онд Лениний томъёолсон томъёоллын дагуу Монголд прокурорын байгууллага бий болсон гэж ярьдаг. Ингэж ойлгож ирсэн. Гэтэл Ленин томъёолохдоо аливаа хуулийг бүх орон даяар Казаны гэдэг юмуу Калугийн гэдэг юмуу өөр өөр ойлгохгүй, нэг мөр ойлгоход хяналт тавих тийм механизм хэрэгтэй гэж томъёолсон байгаа. Тэрнийгээ орон нутагт харьяалагддаггүй, зөвхөн төвд харьяатай, прокурорын байгууллага гэж томъёолсон юм. Гэтэл манай прокурорын байгууллагын ерөнхий хяналтын үйл ажиллагаа манай түрүүчийн тогтолцооны бодлогоос шалтгаалж үнэн хэрэг дээрээ ёстой ерөнхий нэрэндээ тохирсон ойлгомжгүй болж хувирсан байгаа юм.

Прокурорын байгууллага хуулийн биелэлтийг шалгах биш аливаа нэгэн яамдын сайдын заавар, үйлдвэрийн газрын технологийн сахилга, төлөвлөгөөний тасалдал, малын хорогдлын шалтгаан, хадлан тариа аваагүй шалтгаан ингээд аж ахуйн ажил руу ороод явчихсан байгаа. Энэ бол ухаан нь прокурорын байгууллагын өөрийн нь буруу биш байх. Тухайн тогтолцооны, хатуухан хэлэх юм бол эдийн засгийн амьдралыг захиргааны аргаар удирддаг байсан тэр тогтолцооны механизм болохын хувьд ийм аж ахуйн төрөлтэй ажилд хутгалдаж явсан. Ингээд яг өнөөдрийн байдлаар төрийн хуулийн биелэлтэнд дээд хяналт тавих тэр функц нь тодорхой бус ийм болсон байгаа. Ер нь цаашдаа ингээд үзэх юм бол энэ чиг үүргийг өөр байгууллагад хэрэгжүүлэх ийм тогтолцоо байдаг байна. Тэгэхээр нийтдээ, нэгдүгээрт эрхийн актыг хянана, хоёрдугаарт, хяналт шалгалтыг хийе гэсэн хоёр том төрлөөр л прокурорын ерөнхий хяналтын ажил явагдаж байгаа. Эрхийн актыг хянах ажил өнөөдөр шинэ үндсэн хуульд томъёолсноор Үндсэн хуулийн цэцээс эхлэх ёстой. Цэц өөрөө үндсэн хуулийг хянах үүрэгтэй болно. Үүнээс дээд хяналт нь эхлэх ёстой гэж

ойлгож байгаа. Хоёрдугаарт, парламент, Улсын их хурал өөрөө хууль хянах ёстой. Гуравдугаарт, иргэдийн эрхтэй холбогдсон, ер нь хууль зөрчсөн олон маргааныг шүүх шийдэх ёстой болж байгаа. Энэ утгаараа шүүхийн засаглалын шүүхийн эрх мэдлийн хүрээ өргөжинө. Гуравдугаарт, Засгийн газар ч гэсэн өөрөө хуулийн биелэлтийг шалгах, хуулийн биелэлтийг зохион байгуулах энэ үүргээс ангид байх ёсгүй гэж ойлгож байгаа.

Нэгэнт одоо ерөнхий хяналтын үйл ажиллагаанд өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, сахилгын биелэлт гэсэн том зүйл орж явсан учраас үүнийг товчхон ч болов ярих ёстой гэж бодож байна. Тэгэхлээр бид нар ноднин ардын хяналтын байгууллагыг эндээс нэгэн дуугаар устгасан. Энэ бол үнэн хэрэг дээрээ эзэнгүй **байсан** өмчийг хамгаалдаг, ямар нэгэн хэмжээний механизм байсан. Яг өнөөдрийн байдлаар эзэнгүй **байсан** өмч бүр эзэнгүй болж үрэн таран болж байгаа нь үнэн юм. Ийм учраас харин прокурорын байгууллагын ерөнхий хяналтын алба түр хугацаанд, энэ шилжилтийн үед ардын хяналтын байгууллага байж өмч хөрөнгө хамгаалах энэ чиглэлийн дагуу нилээн их эонхилох үүрэгтэй байх байсан болов уу гэж бодож байгаа юм. Ингээд үнэн хэрэг дээрээ прокурорын байгууллагын тэр эрхийн акт хянах үүргийг нь түрүүчийн томъёолсноор ухаан нь Их цаазын цэц, парламент өөрөө Засгийн газар, шүүх хэрэгжүүлээд өмч хамгаалах тэр функцийг нь одоо өөр байгууллага тухайлбал сэргийлэхийн өмчийн албыг томсгох замаар магадгүй одоо улсын хяналтын алба гэж байгаа үүнийг бэхжүүлэх замаар хэрэгжүүлж болох юмаа гэж. Ингээд бид **хуулийн** төслийг хийхдээ зах зээлийн орны хуулийн байгууллагын тогтолцоо, тэр дундаа прокурорын байгууллагын чиг үүргийг сайн харсан. Тэгэхлээр тэр тогтолцоог үзэх юм бол прокурорын байгууллага хэрэг бүртгэх мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд хяналт тавьдаг, хорих ял эдлэх байгууллагад хяналт тавьдаг ийм чиг үүрэгтэй байдаг юм байна. Нэгэнт бид Үндсэн хуулиа хийж байгаа, өөрөөр хэлбэл 20, 30 жилийн багцааны үйлчилгээтэй хууль хийж байгаа учраас өнөө маргаашийн зовлонг бодолгүй зүй тогтлын дагуу сонгодог утгаар нь прокурорын чиг үүргийг тогтоосон маань энэ байгаа юмаа.

Ингэж л ойлгох нь зүйтэй болов уу гэж бодож байна. Ер нь би зүгээр гадарлаж байна. Прокурорын байгууллагын орон нутгийн нилээд олон нөхдүүд өөрийнх нь депутатад хүссэн хүсэлт байгаа болов уу гэж бодож байна. Ямар ч байсан прокурорын байгууллагын ерөнхий хяналтыг түрүүчийн үндсэн хуульд заасан ёсоор нь хэвээр нь үлдээх талаар санал онолоо гаргаач ээ гэсэн гэдгээ бидэнд ч гэсэн, нуулгүй хэлж байгаа. Чин үнэнийг хэлэх юм бол прокурорын байгууллагын одоогийн удирдлага бидний шинэ томъёолсон энэ зүйлийг бүрнээ дэмжиж байгаа, санал нэгтэй байгаа.

Эдийн засаг нь өөрөө бие даагаад явчих тийм зах зээлийн тогтолцооны үед эдийн засгийг захиргааны аргаар хамших тийм чиг үүрэг үнэн хэрэг дээрээ хэрэггүй гэдэг нь ойлгомжтой байгаа юм. Ийм л зүйлийг товчхондоо хариулах байна.

Ж. Уртнасан - За баярлалаа. Депутат нехед өө. Манай хуралдаан дэгийн 12 дугаар зүйлийн 3 дугаар заалт буюу анхны хэлэлцүүлэг "в" хэсэг буюу асуулт хариулт явж байгаа юм. Асуулт хариулт маань манай дэгийн II-ийн "в" хэсэгт заасан амаар, бичгээр гэсэн хоёр хэлбэртэй юм. Бичгээр өнөө өглөөнөөс хойш, өчигдрөөс эхлээд манай дэд ерөнхийлөгч хариуллаа. Та бидний олонхийн саналаар асуулт бичгээр авахыг больё гэдгээс хойш 23 депутатын 43 асуулт над ирээд байна. Хоёрдугаарт, ерөнхийлөгчийн нэр зааж ирүүлсэн хэдэн асуулт байгаа. Юуны өмнө ерөнхийлөгчийн нэр зааж ирүүлсэн асуултад ерөнхийлөгчийг хариулт өгөөч гэж хүсч байна. Ер нь энд асуусан асуултуудыг хараад байхад нилээд хэсэг нь давхар хариулагдчих шиг боллоо. Хэрэв үлдсэн болбол бидэнд нэг хувилбар нээлттэй үлдэж байгаа. Амаар асуух энэ хувилбар. Тэгэхлээр одоо бичгээр ирсэн асуудлууд дотроос ерөнхийлөгчийн нэр зааж ирсэн депутатуудын асуултанд хариулт өгөхийг ерөнхийлөгчид хандаж хүсч байна.

П. Очирбат - 153 дугаар тойргийн депутат Чойжамц, 244 дүгээр тойргийн депутат Доржхорлоо хоёрын асуудал ижил утгатай байна.

Энэ дээр таныг шинэ үндсэн хуулийг төсөл боловсруулах комиссын даргаар Бага хурлаас томилсон юм байна. Энэ байдал хууль зүйд хэрхэн нийцэж байгаа юм бэ гэж ийм утгатай асуудал.

-Энэнд хууль зөрчсөн юм байхгүй. Ер нь төрийн тэргүүний хувьд үндсэн хууль боловсруулах ажилд зайлшгүй оролцох үүрэгтэй. Тийм болохоор Бага хурлаас шийд гаргаад энэ ажлыг зохион байгуул гэсэн үүрэг бол хуулийг зөрчсөн юм байхгүй гэж хэлэх байна.

СӨРӨНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Баянцүрэн

/Д.БАЯНЦҮҮРЭН/

Бичээч Д.Энэбиш

Ц.Очирбат -64 дүгээр тойргийн, уучлаарай энд бас нэг ийм асуудал байсан юмаа. Энэ төрийн бэлгэ тэмдгийн өөрчлөлт, танай комиссын санал уу? Бага Хурлын санал уу гэж. Тэгэхээр төрийн бэлгэ, тэмдгийг өөрчлөх шаардлага байгаа. Тийм учраас энийг яаж өөрчлөх вэ гэдэг талаар санал боловсруулах тусад нь групп гаргаад, тэгээд энэ групп мэргэжлийн хүмүүсийг ажиллуулаад, саналыг нь аваад, тэгээд сонгож Их Хуралд оруулах энэ ажлыг Бага Хуралд ^{хийсэн} Өчигдөр Маам товчхон танилцуулсан. Маргааш гурван цагт дэлгэрэнгүй танилцуулъя гэж.

За 64 дүгээр тойргийн депутат Молон, 280 дугаар тойргийн депутат Цэндбаяр, 89 дүгээр тойргийн депутат Пүрэвгял нарын асуудал байна. Энэн дээр Монгол улс парламентын бүгд найрамдах улс байх нь ээ, төслөөр. Энэ нөхцөлд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нэг хүн байвал яасан юм бэ? гэсэн ийм утгатай асуудал байна.

Тэгэхлээр бид энэ бол албан тушаал хавсрах тухай асуудал бишээ. Энэ төрийн тогтолцооны зарчмын асуудал. Ийм учраас нэгэнт бид парламентын төрийн удирдлагынхаа хэлбэрийг сонгож авч байгаа бол энэн дээр Ерөнхийлөгч, гүйцэтгэх засаглалыг толгойлох нь нийцэхгүй байгаа юм. Тийм учраас тус тусдаа байх ийм тогтолцоог Үндсэн хуулийн төслөөр авч ярьж байгаа.

Энэ удаад Үндсэн хууль, 59 дүгээр тойргийн депутат Пүрэвдорж ингэж асууж байна. Энэ удаад Үндсэн хууль боловсруулахад гадаад, дотоодын бас ч багагүй хурал зөвлөлгөөн хийх мэтээр их ажил хийгдлээ. Үндсэн хуулийг боловсруулахад ямархуу хэмжээний зардал гарсныг хэлж өгнө үү гэж.

Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажилд бид 40 мянган төгрөг зарна гэж төлөвлөж байсан. 161 мянган төгрөг зарсан. Энэн дээр зүгээр нөхдүүдийн, санхүүгийнхний гаргаж өгснөөр мэргэжлийн хүмүүсийг ажлаас нь чөлөөлж ажиллуулсан хөлсөнд

7000 төгрөг өгсөн байна. Төслийг хэвлэх, олшруулах, энэ бага хурал хийх энэ зардлуудад, тэр бичиг техникийн, унааны, үйлчилгээний гэх мэтийн зардлуудад 140 мянган төгрөг зарсан байна. Шуудан холбооны зардалд 14 мянган төгрөг зарсан байна. Гадаадаас энэ хуралд оролцохоор ирсэн хүмүүс өөрсдийнхөө зардлаар ирсэн. Энэ хүмүүсээс олж авсан валют гэвэл 344 мянга 800 төгрөгтэй тэнцэх чөлөөт валют олж авсан байна.

За 245 дугаар тойргийн депутат Чинбат асууж байна. Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүнг сонсож мэдлээ. Их цаазын төслийн талаар ард түмний санал бодол тодорхой байгаа. Гэтэл энэхүү санал бодлыг танай ажлын комисс Улсын Бага Хуралд оруулахдаа хамгаалж чадсангүй. Энэ нь одоо Их цаазын төслийг зүйл, бүлэг бүрээр хэлэлцэх үед тодорхой болно гэж үзэж байна. Иймд танай комиссыг Улсын Бага Хурлын танхимын уур амьсгалд автагдаж, үүргээ хангалтгүй биелүүллээ, ард түмнийхээ өмнө хариуцлага алдсан байна гэж үзэж болох уу гэж байна.

Энэ яаж батлагдах, та бүхэн яаж дүгнэхээс шалтгаалах байх. Урьдчилж хэлж чадашгүй.

368 дугаар тойргийн депутат Баасанжав асууж байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд парламент, Засгийн газар хоёр хоорондоо хэр зэрэг уялдаатай ажиллагаагаа явуулсан гэж дүгнэж байна вэ гэж.

Ер нь парламент Улсын Бага Хурал, Засгийн газар хоёр ажлаа ер нь нэлээн нягт уялдаатай явуулж ирсэн. Зарим үед уялдаа нь хэтрэх шахаад байсан. Тийм учраас Бага Хурал, Засгийн газарт зарим үед онцгой эрхүүдийг олгох шийдвэр хүртэл гаргаж байсан шүү дээ.

Хоёрдугаарт, Бага Хурлын өнөөгийн байгаа гишүүдийн тоог та бүрэн зөвшөөрдөг үү? Ер нь цөөдөх тал руугаа л байсан даа. Их богино хугацаанд маш их ажил хийх шаардлагатай байсан.

энийгээ улам үр дүнтэй цагаа зарцуулах үүднээс нэг санал тавья гэж бодож байна.

Дэгийг хэлэлцэж байхад олон депутатууд хэлж байсан. Ерөнхий санал явуулж, ойлголтоо гүнзгийрүүлье гэж. Энд бол асуулт гол нь ойлголтоо гүнзгийрүүлье гэсэн ийм санаа байна. Тэгэхээр ерөнхий саналын үед бол тэр ойлголт илүү их гүнзгийрнэ гэж бодож байна. Тэрүүнээс гадна харамсалтай нь бид дэгэндээ тусгаж чадаагүй, хуралдааны үйл ажиллагааг заавал танхимын биш, өөр маягаар, ойлголцох маягаар хороодууд хуралдах маягаар юм уу, депутатууд хоорондоо ярих маягаар бас заримдаа явуулж болох юм гэсэн санал дэгд оруулъя гэж зарим хүн ярьж байсныг би санаж байна. Харамсалтай нь бид тэгж чадаагүй. Тийм асуудал бид нар нэгэнт цаг авах эрх байгаа учраас бас болно гэж бодож байна.

Түүнээс гадна асуудал бүрээр, зүйл бүрээр бид нар одоо энэ Үндсэн хуулиа ярихдаа ингэж ерөнхий ярьснаас илүү, бие биенээсээ асууж лавлах, ойлголцох, тэгээд нэг шийдэнд хүрэх явдал бол бид нар урьдчилан ингэж их цаг барж ярихаас илүү үр дүнд хүрэх байх гэж бодож байх юм. Тэгэхээр би тийм маягаар энэ ач холбогдлыг би их өндөрт үзэж байна. Тийм маягаар ойлголцоо цааш нь үргэлжлүүлбэл яасан юм бэ гэсэн ийм санал тавиад, санал асуултаа таслаад ерөнхий хэлэлцүүлэгтээ орвол яасан юм бэ гэсэн санал тавьж байна.

Д.Маам /Улсын Бага Хурлын гишүүн/ -Сая энэ Ерөнхийлөгч болон манай Бага Хурлын даргын тавигдсан асуултуудад хариулсан хариултын халуун мөрөөр нэг зүйлийн тодотгол хийе гэж би босож ирж байгаа юм. Юу вэ гэвэл Үндсэн хуульд монгол бичгийн асуудлыг хуульчлан тусгаж батламжилж болохгүй байсан уу гэсэн асуултад манай Бага Хурлын дарга дараахь хариултыг өгсөн. Юу вэ гэвэл энэ асуудал тогтоолоор, Бага Хурлаар хэлэлцэгдэж тогтоолоор шийдвэрлэгдсэн. БНМАУ-д төрийн хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай тийм тогтоол гарсан. Тэгэхлээр энэ бэлтгэл 1994 онд

хангагдсан байвал бид нар монгол бичигтээ орох, эс тийм бол бас тэрэн дээр наашаа цаашаа юм байж болох мэтээр би ингэж ойлгосон. Хэрэв ташаа ойлгосон бол эрхэм Бага Хурлын даргаас уучлалт хүсье.

Тэгэхээр энэн дээр би ийм биш гэдгийг хэлмээр байгаа юм. Юу вэ гэвэл манай тогтоол бол ийм гарчигтай шүү дээ. БНМАУ-д төрийн хэргийг, төрийн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэлийг хангах тухай. Энийг л хэлэх гэсэн юм.

Т. Ядамсүрэн /71 дүгээр тойргийн депутат/ - Улсын Дэд ерөнхийлөгчөөс нэлээн олон асуудал хүч зарж тодорхой харигу өглөө. Гэвч зарим нэг зүйлийг тодруулъя гэж бодож байна.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын 76 гишүүний хоёрны нэгийг шинэчилнэ гэдэг асуудалд тодорхой ойлголт авч чадсангүй. Дээрээс нь одоогийн саяын ярьж байгаагаар бол ер нь хоёрны нэгийг шинэчилж өөрчилнэ гэж байна. Гэтэл хуулиндаа бол сонгохыг нь хөдөлмөрчид нь мэднэ, сонгогчид нь. Сонгогчид маань депутатаа огцруулахгүй гээд байвал тэр чинь шинэчлэлт болох уу. Энийг одоо явал шинэчиллээ гэж үзэх юм бэ? Эсвэл наадах чинь, танайх энэ Их Хурлынхаа гишүүнийг хас гээд тулгалт өгөх гээд байна уу? Яах гээд байна вэ? Энийг бид үнэхээр ойлгохгүй байгаа, нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал, Ардын Их Хуралд тайлан тавих уу? Тавьдаг бол хэдийд, хаана тавих ёстой юм бэ? Хэрэв тайлан тавьдаггүй юм бол ямар ч хяналтгүй болчихсон юм байна гэж ойлгож болох уу? Ийм ойлголт, сэтгэгдэл төрөөд байна.

Цааш нь 15-ын гуравт харьяатаас хасахыг хориглоно гэж байгаа. Гэтэл 33-ын 8-д Ерөнхийлөгчид харьяатаас гарахыг шийдвэрлэнэ гэж байгаа. Хэрэв харьяатаас хасахыг хориглосон юм бол Ерөнхийлөгч шийдвэрлэх ямар учир байна вэ?

Хуулинд ийм хоёр салаа утгаар оржээ.

За цааш нь, 48-ын нэгд, шүүх эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах төрлөөр дагнан байгуулагдана гэж заасан. Захиргааны шүүх гэж ямар шүүх юм бэ? Ямар хэргийг шийдвэрлэх вэ? Хуучин арбитрын хэргийг буцаагаад сэргээгээд байгаа юм уу гэдэг ойлголт байна. Энэн дээр нарийн ойлголт авч чадахгүй байна.

Цааш нь, 54-ийн хоёрт, Дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг өөрөө хүчингүй болгоно гэж заасан. Шүүхийн шийдвэр нь хууль зөрчсөнийг хэн сөхөж тавьж илрүүлэх юм бэ? Хуучин байсан шиг, саяын энэ Дугархорлоогийн хүн амины хэрэг шиг ийм юм болбол яах юм бэ? Дээд шүүхийг алдахгүй гэсэн баталгаа хэн гаргаж чадаж байгаа юм бэ? Энэнд тодорхой хариулт шаардаж байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Муга

ЭНХТҮЯА

Бичээч Уранчимэг

Т.Ядамсүрэн /71 дүгээр тойргийн депутат/ -За цааш нь 6-гийн хоёр, газрыг гадаадын иргэн, харьяалалгүй хүнд түрээсээр ашиглуулж болно гэсэн.Энэн дээр нэлээн ярьж байна. Тэгвэл одоогийн бидний ноднингийн нэмэлт оруулсан Иргэний хуульд өмчлөгч биш, түрээслэгчийн эрхийн тухай асуудлыг заасан.Тэр хуулинд чинь түрээслэгч байна, өмчөө эзэмшинэ, захирна, зарцуулна гэж заасан байгаа.Энэ хуулийн чинь заалтыг аваад гадны хүн, нэг хэсэг хүн хүрч ирээд газраа хоорондоо захирч зарцуулж байгаа нь энэ гээд зараад байвал яах юм бэ? Энэ мэтийн асуудал дээр тодорхой хариулт өгнө үү.

Р.Гончигдорж /Улсын Бага Хурлын дарга, 56 дугаар тойргийн депутат/ -Улсын Их Хурлын 76 гишүүний хоёрны нэгийг шинэчилнэ гэдэг бол заавал шинэчилнэ гэдэг утга тэнд байхгүй байгаа.Тийм ч учраас хэлсэн шүү дээ.Гурван жил болоод дараачаар нь сонгууль явуулахад /хэрэв эхний хувилбараар/ ганц мандаттай,тойргийн зохион байгуулалтаар сонгууль явагдаад ерөөсөө Их Хурлын бүх гишүүд шинээр сонгогдоод эхлэхэд эхний гурван жилд явуулах сонгуульд бол тэр тойргуудын хоёрны нэгийн талыг ямар нэг аргаар сонгож, тэр тойргууд дээр сонгууль явуулж, тэгээд шинэчлэгдсэн тал хувийн шинэчлэл үүснэ гэж. Энэ шинэчлэлт гэдэг маань сонгууль нь шинээр явагдаж байгаа болохоос биш, заавал нэг Их Хурлын гишүүн хоёр дахь удаагаа сонгогдож болохгүй тухай энд огт байхгүй.Тэгэх нь байтугай нэг хүн одоо хэдэн ч удаа, тав, зургаан удаа нэг тойрог дээрээс дандаа сонгогдоод байж болно.Энийг үгүйсгэсэн, хориглосон заалт ерөөсөө байхгүй бөгөөд зөвхөн сонгох эрх тэр сонгуулийн тойргийн иргэдэд бүрэн утгаараа хадгалагдаж байгаа ийм л юм.Тийм учраас энэ шинэчилнэ гэдэг бол энэ утгаараа.Сонгуулийг явуулах утгаараа юм.

Ардын Их Хурал хууль тогтоох байгууллага, төрийн дээд байгууллага, өөрөө байгууллага болохынхоо хувьд нэг субъект болохынхоо хувьд тайлан тавих тухай асуудал бол байхгүй байгаа.

7000 төгрөг өгсөн байна. Төслийг хэвлэх, олшруулах, энэ бага хурал хийх энэ зардлуудад, тэр бичиг техникийн, унааны, үйлчилгээний гэх мэтийн зардлуудад 140 мянган төгрөг зарсан байна. Шуудан холбооны зардалд 14 мянган төгрөг зарсан байна. Гадаадаас энэ хуралд оролцохоор ирсэн хүмүүс өөрсдийнхөө зардлаар ирсэн. Энэ хүмүүсээс олж авсан валют гэвэл 344 мянга 800 төгрөгтэй тэнцэх чөлөөт валют олж авсан байна.

За 245 дугаар тойргийн депутат Чинбат асууж байна. Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүнг сонсож мэдлээ. Их цаазын төслийн талаар ард түмний санал бодол тодорхой байгаа. Гэтэл энэхүү санал бодлыг танай ажлын комисс Улсын Бага Хуралд оруулахдаа хамгаалж чадсангүй. Энэ нь одоо Их цаазын төслийг зүйл, бүлэг бүрээр хэлэлцэх үед тодорхой болно гэж үзэж байна. Иймд танай комиссыг Улсын Бага Хурлын танхимын уур амьсгалд автагдаж, үүргээ хангалтгүй биелүүллээ, ард түмнийхээ өмнө хариуцлага алдсан байна гэж үзэж болох уу гэж байна.

Энэ яаж батлагдах, та бүхэн яаж дүгнэхээс шалтгаалах байх. Урьдчилж хэлж чадашгүй.

368 дугаар тойргийн депутат Баасанжав асууж байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд парламент, Засгийн газар хоёр хоорондоо хэр зэрэг уялдаатай ажиллагаагаа явуулсан гэж дүгнэж байна вэ гэж.

Ер нь парламент Улсын Бага Хурал, Засгийн газар хоёр ажлаа ер нь нэлээн нягт уялдаатай явуулж ирсэн. Зарим үед уялдаа нь хэтрэх шахаад байсан. Тийм учраас Бага Хурал, Засгийн газарт зарим үед онцгой эрхүүдийг олгох шийдвэр хүртэл гаргаж байсан шүү дээ.

Хоёрдугаарт, Бага Хурлын өнөөгийн байгаа гишүүдийн тоог та бүрэн зөвшөөрдөг үү? Ер нь цөөдөх тал руугаа л байсан даа. Их богино хугацаанд маш их ажил хийх шаардлагатай байсан.

Цаашдаа энэ төсөлд санал болгож байгаа тэр хэмжээнд, тоонд хүрэхэд болох юм болов уу гэсэн ойлголт өнгөрсөн хугацааны үйл ажиллагаанаас анзаарагдаж байгаа.

Хүний эрх чөлөө гэсэн хоёрдугаар бүлгийн 17 дугаар зүйлд иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзлоос гадна эрүүл мэндийн даатгалыг хуулинд тусгаж болохгүй юу?

Даатгалын тухай асуудал яригдаж байгаа. Энийг Эрүүл мэндийн яам боловсруулаад энэ асуудал тусдаа орж ирж шийдэгдэнэ.

74 дүгээр тойргийн депутат Мизимханы асуудлыг Улсын Бага Хурлын даргын хариултанд орчихсон. Зүгээр энд ганцхан юм хэлэхэд Засгийн газрын сонгууль гэж байхгүй л дээ. Тэр томилолтоор явагдаг учраас, энэ сонгуулийн тоонд тэрийг оруулаад яриад хэрэггүй юм шиг байна. За түрүүчийн нийтлэг асуудал энэ Ерөнхийлөгчийн Тамгын газар ямар орон тоотой, ямар зардалтай байдаг юм бэ гэсэн байна. Түрүүн сонинд бичсэн, зүгээр нийтдээ 34 хүнтэй байна. Сая 287 мянган төгрөгийн төсөвтэй байна. Энийгээ хэтрүүлээгүй байгаа гэсэн. За ингээд өөр асуудал байхгүй. Баярлалаа.

Ж. Уртнасан - За бичгээр ирсэн асуултууд үндсэндээ хариулагдлаа гэж бодож байна. Бичгээр ирснийг тасалсны дараа сая хэллээ, 23 хүний 43 асуулт байгаа. Зарим нь давтагдаж байгаа юм билээ. Одоо Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгчөөс асуух асуулт байвал микрофоны ард гараад амаар асууя. Дараалал маань микрофонхоо дарааллаар явна гэдгийг депутатуудад урьдчилан сонордуулъя.

Уучлаарай энд нэг санал байна сонсьё. Депутат Дашням.

Л. Дашням /22 дугаар тойргийн депутат/ - Манай хуралдаан яг дэгийнхээ дагуу налгар сайхан явагдаж байна. Энд бол дэгийн ёсоор бид нар илтгэлийг таван цаг гаруй асууж хариулт авлаа. Тэгэхдээ би энэ асуулт хариулт дэгээ жаахан цааш нь явуулаад,

Тэнд сонгогдсон гишүүн хүн өөрийнхөө сонгуулийн тойрог дээр, өөрийнхөө үйл ажиллагааны талаар хэзээ ч дандаа тайлагнасан, тэд нартайгаа холбогдсон ийм байх учир холбогдолтой. Энэний хээ үүднээс дараа тэрэн дээр дахин сонгогдож чадах уу үгүй юу гэдэг асуудал тэр хувь заяагаараа шийдвэрлэгддэг ийм шинж чанартай байна. За энэ байдлынхаа үүднээс бол нэг субъект болохынхоо хувьд Ардын Их Хурал нь тайлангаа аливаа нэгэн газар тавихгүй, гишүүн нь тайлангаа сонгуулийн тойрогтоо болоод шаардлагатай нөхцөл байдалд бол бусад газруудад тавих шаардлагын хэрэгцээ үүсч болно гэж энүүгээр л ойлгох нь зүйтэй. Энийг хэрэв ямар нэгэн төлөөллийн байгууллагад тайлан тавина гэвэл тэр тайлангий нь авдаг төлөөллийн байгууллагад өөрөө бас хаана тайлан тавих вэ гээд ингээд явах юм бол энэ нь дээшээгээ дуусашгүй ийм цамхаг босч гарч ирнэ. Тэгэхээр зэрэг л одоо сонгогчдоороо бүрэн эрхээ авч, хамтраад нэг субъект болж байгаа энэ бол одоо манайд аль нэгэн юманд тайлагнадаггүй байж чадах ийм л байгууллага юмаа гэдэг эрх нь тэр сонгогчдоо төлөөлөн гарч ирж байгаа агуулгаараа илэрхийлэгдэж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Харьяатаас хасах, харьяатаас гарах гэдэг бол хоёр өөр асуудал. Тэр хяналт гэдэг маань би та бүхэнд хэлсэн шүү дээ. Хамгийн том хяналт бол энэний бүх үйл ажиллагаа, Их цаазын хүрээнд байх ёстой. Их цаазыг хэрхэвч зөрчиж болохгүй бөгөөд, зөрчих тухай асуудал үүссэн байхад Их цаазын цэц бол түүн дээр хяналт тавьж байна. Түүнээс гадна хууль бус үйл ажиллагаа иргэний харьцаанд, бусад харьцаанд хууль зөрчсөн асуудал үүсэхэд Дээд шүүх дээр асуудал нь иргэний шугамаараа байна. Мөн прокурорын хяналтын тодорхой хэм хэмжээ хүрээ бол бас энд хамаарагдаж байгаа. Гэх мэтчилэн, мөн Ерөнхийлөгчөөс бас тавих хяналтын механизм, зарим нэг үг сүлжээ, сүлбээ бас тэнд бий. Тийм учраас энэ бол харилцан ийм уялдаа сүлжээндээ байгаа ийм юм. Нөгөө дэм дэмэндээ дээс эрчиндээ гэдэг шиг энд бол бие биеийгээ багласан их сонин сүлжээ байгаа л гэж хэлэх гээд байгаа юм.

Харьяатаас гарах, харьяатаас хасах гэдэг бол хоёр өөр ойлголт. Харьяатаас хасна гэдэг бол хүчээр, түүний дур зоригийг үл анзааран шууд түүний харьяат байх эрхийг нь цуцлаж байгаа асуудал. Хасах. Харьяатаас гарна гэдэг бол тэр хүн би харьяатаасаа гаръя гэдэг тэр хүнээс өөрөөс нь үүссэн санаачилгын үүднээс асуудал шийдвэрлэх тухай асуудал. Энэ утгаараа бол энэ хоёр өөр зүйл. Тэгээд харьяатаас гарах тухай асуудлыг Ерөнхийлөгчийн онцгойлсон эрх мэдэлд шийдвэрлэгдэж байх ийм асуудал.

Тэр гадаадын хүнд түрээслүүлэн эргүүлэх, тэр Иргэний хуулин дээр орсон түрээс дээр бол түрээслэгчийн эрх, үүрэг, түрээслүүлэгчийн эрх, үүрэг гээд тэнд маш олон зохицуулалтууд байгаа. Түүнээс гадна түрээслэлтийг энд байгуулахад, түрээслэгч нь бол нэг тал, түрээслүүлэгч нь тухайлбал тэр байх нь байна шүү дээ. Тэр хоёрын хооронд гэрээ байгуулагдаж байж түрээсийн харьцаа үүсэх ёстой бөгөөд, тэр гэрээнд энэ түрээслүүлэгч ямар ямар үүргийг байх ёстой, газрын үржил шимийн талаар, байгаль, орчны хяналтын талаар, бусдад шилжүүлэх эрх, эрхгүйн талаар. Түрээслэлтийг өвлөх, өвлөхгүйн талын асуудал. Энэ болгон дээр тэр болгонд тодорхой туссан байх ёстой бөгөөд, магадгүй цаашид нарийвчлан гаргах тухай асуудлууд дээрээ онцгойлон энд бас хуулийн дагуу зарим хяналт, хязгаарлалтын шинжтэй зүйлүүдийг оруулахыг үгүйсгэхгүй, ийм л юм байгаа юм. Тэрнээс туйлын утгаараа энд эзэмших, ашиглах, захиран зарцуулахын хэлбэрүүд янз янзын байдлаар энэ гэрээнүүдэд тусч болно.

Шүүхийг тэр төрлөөр нь дагнуулах, захиргааны шүүх гэж юу юм бэ? Захиргааны шүүх ямар хэргийг авч шийдвэрлэх ийм шүүхийн төрөл юм бэ гэдэг асуудал дээр захиргааны эрх зүйн зөрчлийн асуудал дээр, захиргааны тухай хуулийг одоо Улсын Бага Хуралд нэмэлт, өөрчлөлтөө яг оруулах гэж байна. Энэ хуулийн эрх зүйн үндсэн дээр үүсч байгаа зөрчлийг, үүссэн маргааныг шийдвэрлэх шүүхийн үйл ажиллагааны тэр төрлөөр юмаа гэж ингэж л ойлгох юм. Хэрэв далгэруулбал манай хуульчдаас

тодруулна.

Дээд шүүхийн шийдвэр хууль зөрчих юм бол өөрөө хүчингүй болгоно гэж байгаа. Түүнээс гадна Дээд шүүх хүчин төгөлдөр биш хуулиар шүүх ажиллагааг явуулж болохгүй гэж байгаа юм. Энэ хоёр зүйл бол Дээд шүүхийн үйл ажиллагаа, Дээд шүүх зөвхөн хуульд захирагдах гэдэг энэ эх үүсвэрээсээ үүсч гарч байгаа ийм үндсэн шаардлагууд. Тэгэхээр зэрэг зүгээр энэ Дээд шүүх гэдэг маань өөрөө хэргийг анхан шатны болон хяналтын гэсэн хоёр шаттай байж байгаа шүү дээ. Энэ шат нь өөрөө хоорондоо уялдаад ирэхээрээ зэрэг бас бие биендээ тавих хяналтын, нөгөө талаас иргэний гомдлын шинжээр болон иргэний гомдол, хажуугийн гомдол энэ болгоны бүх байдлаар бол энэ шалтгаан дандаа үүсч бий болж байна. Болж чадаж байна гэсэн ийм л баталгаа байгаа юм.

Дээд шүүхийн шийдвэр хууль зөрчсөн тухай асуудлыг цуцлахыг дээр нь ямар нэгэн юм гаргаж тавиагүй асуудал нь бол төрийн эрх мэдлийг хуваарилах, тэр нь харьцангуй бие даасан байх, шүүх үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөлөлгүй, гаднаас нөлөөлөлгүй байх ийм л байдлын үүднээсээ энд харьцангуй өөрөө өөрийгөө залруулах эрх хэмжээнд л оруулж гаргасан зүйл. Ноцтой зүйл, байдал, шалтгаан үүсэхэд энд бас үүсэх өөр давхар механизмууд үүсэхэд Шүүхийн байгууламжийн хууль энэнд бол, энэ өөрөө өөрийнхөө шийдвэрийг хүчингүй болгоно гэдгийг Үндсэн хуулийн энэ агуулгын хүрээнд яаж энэн дээр өөр давхар юунуудыг гаргах вэ гэдгийг Шүүхийн байгууламжийн хууль болон бусад хуулиудад оруулж болох үндэслэлүүд байх байх гэдгийг үгүйсгэхгүй байна. Товч ийм байна. Дэлгэрүүлбэ гэвэл мэргэжлийн хүмүүсийн туслалцааг би гуйна.

Ж. Уртнасан - За баярлалаа. Дэгийн дагуу завсарлага 20 минут.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Д. Алтанцэцэг

Д. АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.14
Кассет № 42
17.21-17.35

Ж.Уртнасан: хуралдаанаа үргэлжлүүлбэ.Одоо асуулт хариулт явж байна.12 дугаар зүйлийн 3 дугаар заалтын хэлэлцүүлэг,"в" хэсэг.

89 дүгээр тойргийн депутат Л.Пүрэвгял:

Энэ Үндсэн хуулийн төслийн IV бүлэгтэй холбоотой, энд ойлголт гүнзгийрүүлэх шаардлага байна.Тэгэхээр ечигдрийн асуулт хариултаас засаг захиргааны хуулийн төсөл ямар нэгэн хэмжээгээр бэлэн болсон юм байна гэсэн ойлголт авсан, буруу ойлгоогүй бол.Хэрэв тийм байдаг бол төслөөр ч гэсэн депутатуудын гар дээр энэ талаар анхны төслийг ч байсан тарааж өгвөл их зөв байна.Тэгэхгүй бол тодорхой санал гарахад их хэцүү, ямар нэгэн ойлголт авч чадахгүй их бүрхэг байна.Ийм учраас, хэрэв тийм төсөл байдаг бол депутатуудын гар дээр өгөх бололцоо байвал өгөхгүй юу гэсэн ийм саналтай байна.

Депутат /нэр,тойргоо хэлээгүй/

Би нэг зүйлийг ойлгохгүй байна, тодруулмаар байна.Ардын Их Хурлын 76 гишүүнийг сонгох асуудал дээр яаж энэ сонгох хүнээ дороосоо, сонгуулийн тойргуудаас гаргаж ирэх бол , бодоход энэ урьд байсан томилолтын депутат шиг дээрээсээ хэдэн хүний нэр гаргаад ингээд хэлэлцүүлгээ юм болов уу, үүнийг би сайн ойлгохгүй, учрыг мэдэхгүй байна.Үүнийг тайлбарлаж өгөөч ээ гэж хүсч байна.

Сонгуулийн хуулиар тодорхойлох байх л даа.Гэхдээ энэ ойлгомж муутай байна.Хоёрдугаарт, сая ерөнхийлөгчөөс нэг асуулт асуухад ингэж хариуллаа.Өнгөрсөн жил гаруйн хугацаанд Засгийн газар, Улсын Бага Хурал хоёр их ойр холбоотой ажиллаж, зарим талдаа холбоо нь бүр хэтэрч байсан тал ч байх шиг ийм хариулт авлаа.

Тэгэхээр энэ хэвлэл уншиж байхад сүүлийн үед валютын нөөц, Засгийн газрын зарим шийдвэрийн талаар хүмүүс их шүүмжлээд байх юм. Дараа бид Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланг хэлэлцэх үед яригдах байх л даа. Хэрэв Засгийн газарт ямар нэгэн буруу зүйл гаргасан шийдвэр, улсын валютын нөөц хомсодсон энэ асуудалтгарвал үүнийг бас Бага Хурал адилхан хүлээнэ гэж ойлгож болох зүйл үү? энэ ямар учиртай юм бэ? би энэ дээр эргэлзэж байна. Ийм хоёр асуулт байна.

Р.Гончигдорж: /Улсын Бага Хурлын дарга, 56 дугаар тойргийн депутат/

Түрүүний тэр орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулийн одоо боломжтой байгаа төслийг өгөх боломж байна уу? Гэсэн депутатын асуулт байна. Одоо бид шууд Бага Хурлын сүүлчийн чуулганы, намрын чуулганы эхний хуралдаанаар хэлэлцэж байгаад энэ дээр зарчмын асуудлууд дээрээ ярилцаад, энэ хуулийн анхны хэлэлцүүлгийн дарга гарсан төсөл нарийвчлагдан боловсрогдож дуусаагүй байна. Тийм учраас шууд та бүхний гар дээр хуулийн төслийн хэлбэрээр тавьчихад бэрхшээлтэй тал бий. Бага Хуралд Засгийн газраас өргөн барьсан төсөл бол байж байгаа. Түүний дагуу Бага Хурал дээрээс оруулж байгаа зарчмын өөрчлөлтүүдийг гаргаж, оруулаад, хоёрдахь хэлэлцүүлэгт оруулах тийм төсөл одоо хараахандаа боловсроогүй байна. Хэрэв шаардлагатай энэ дээр нэмэлтүүдийг хэлье гэвэл манай орон нутгийн асуудал эрхэлсэн дэд хорооны дарга Д.Жанцан байгаа. Жанцан энэ дээр тэр боломжийн асуудлууд, тэр ажлыг яаж зохион байгуулж болох вэ гэдэг дээр та бүхэн сүүлд нь санал солилцож болно.

76 гишүүнийг хаанаас яаж сонгох вэ гэж байна. Сонгуулийн хуулийг баталж гаргаж, тэр сонгуулийн хуулийн дагуу сонгуулийг явуулна. Сонгуулийн хуулийн талаар одоо хэд хэдэн хувилбарууд, үзэл баримтлалууд, сонгуулийн хуулийн тал дээр ажиллаж байгаа ажлын хэсэг байгаа.

Энд бидний гол нь энэ 76 хүнтэй их хурлыг сэлгээтэйгээр явуулахтай холбогдсон учир зүйгээр нэг, хоёр зүйлийг ярьж байгаа юм.

Нэг нь бол, нэг мандаттай тойрог, нөгөө нь бол олон мандаттай тойрог гэж яриад байгаагийн учрыг эхлээд хэлье. Тэгэхээр 76 гишүүнтэй байя гэж үзээд, 76 сонгуулийн тойрог гаргах учиртай, тэгээд сонгуулийн тойрог болгоноос, сонгуулийн эцэст нэг Их Хурлын гишүүн сонгогдоно. Олон мандаттай гэх юм бол олон мандаттай тойргуудад хуваагдаад нэг тойрог дээрээс, хоёр, гурван Их Хурлын гишүүн зэрэг сонгогдож гарч ирэх юм. Магадгүй 4-өөр зохион байгуулж бодож болно. Жишээ нь, 4 мандаттай нэг сонгуулийн тойрог гэвэл энэ дээрээс 4 их хурлын гишүүн сонгогдож гарч ирнэ гэсэн үг. Үүнтэй холбогдуулаад 4 хүнд нэр дэвшүүлнэ. Нэр дэвшүүлэх субъектын хувьд ямар байдалтайгаар авч үзэж байна вэ гэвэл нэр дэвшүүлэх субъектууд нь улс төрийн намууд байна. Ийм л баймтлалтай байгаа юм. Улс төрийн намуудаас нэр дэвшүүлж, нэг мандаттай ч бай, олон мандаттай ч бай, мандат болгон дээр улс төрийн намуудаас нэр дэвшүүлж, энд өрсөлдүүлэн сонгох ийм л зарчмын асуудал. Түүнээс дээрээс нэр өгөх тухай асуудал энд одоо нэгэнт түүхээ өнгөрөөжээ. Өнгөрсөн сонгууль ч гэсэн ийм байдалтай байгаагүй.

Өөр бас хувилбарууд байдаг. Тэр хувилбарууд нь бас нэлээн нарийн шинжтэй ийм хувилбарууд байгаа юм. Ерөнхий баримжаалж байгаа эхний хувилбарууд ийм л хувилбартай сонгуулийн тухай ярьж байгаа.

Сүүлийн асуудалтай холбогдуулж ярих юм бол энэ дээр та бүхэнд мэдээлэл байгаа. Бага Хурлын хуралдаанаар энэ асуудлыг Засгийн газрын мэдээ, танилцуулга, тэнд дээр ажилласан ажлын хэсгийн мэдээллийг сонсоод, Бага Хурлаас энэ асуудлуудыг нарийвчлан судалж, Бага Хурлын дүгнэлтийг төслийг боловсруулах асуудлыг хоёр байнгын хороондоо үүрэг болгочихоод байгаа.

Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо эдгээр нь дүгнэлтийн төслөө боловсруулаад Их Хурлын хуралдааны явц дунд бид энэ асуудал дээрээ хэлэлцээд, нарийвчлан шийдвэр гарч, энэ дүгнэлтээ Их Хурлын депутатуудад мэдээлэх нь зүйтэй гэж үзсэн шийдвэр ^{ОЙЛНИЙ} хувьд бий. Үүнийхээ дагуу ярина. Тэгэхээр учир зүйн энэ бүх шалтгааны үүднээс, энэ асуудлууд тодрох байх, тодорч таарна. Гэхдээ тэр хариуцлагын асуудал, гэм буруугийн тухай асуудлуудыг хэрхэн хуваалцах тухай асуудлууд дээр та бүхэн үүнийг ер нь Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайлангийн гадна талд өөрөө тусгайлсан байдлаар Их Хурлын депутатуудад өгөгдөх мэдээллээр орж ирэх юм байна гэсэн ийм ойлголттой байвал болох юм. Гэхдээ Ардын Их Хурлын депутатуудын өөрсдийн бүрэн эрх нь аливаа асуудлыг хэлэлцэх асуудал болгоод авч хэлэлцэх боломжтой шүү дээ. Үүнийг та бүхэн шийдэх асуудал. Бага Хурлаас албан ёсоор гаргасан мэдээндээ энэ Засгийн газрын танилцуулга, Бага Хурлын дүгнэлтийг Их Хурлын депутатуудад мэдээлэх нь зүйтэй гэж үзлээ гэсэн ийм шийдвэрийг гаргасан.

413 дугаар тойргийн депутат Н.Насан-Очир: Би Ерөнхийлөгчөөс хоёр, гурван асуулт асуусан, танд хүрсэнгүй юу? Их Хурлын даргад дамжигдсангүй юу гэдгийг асуушихмаар байна.

нутгийн

Гончигдорж даргаас асуухад, өөрөө удирдах ёс гэдгийг сайн ойлгохгүй байна. Одоогийнхоос их өөр болно гэж байна. Тэр ард түмнээ ер нь яаж захирах юм болж байна. Ойлгохгүй байна. Буруу ойлголт байж магадгүй. Өөрөө л цалин мөнгөшэй орон нутгийнхаа орлогоор амьдарч чадвал орон тооны бай, чадахгүй бол байхгүй бай гэсэн үг юм биш байгаа. Ер нь тойруухан бөгөөд шинэхэн үгээр хэлэхэд улсын төсвөөс санхүүжүүлэхгүй гэж байгаа юм биш бизээ. Нэгдүгээр асуудал энэ.

Хоёрдугаар асуулт нь, энэ сум хороодыг үндсэндээ, үг нь хэлэгдэхгүй болохоос биш, Үндсэн хуулиараа татан буулгах гэж байна шүү дээ, сум гэдэг үгийг. Нэг хэвлэлээс уншсан, сум гэдгийг хятад үг юм гэнэ билээ. Энэ үг хятад болоод өөрчлөгдөж байна уу? хошууг тэгвэл монгол үг гэсэн баталгаа байгаа юм уу?

үгүй юм уу? би бодохдоо хошуу нь нэлээн хятад руу төстэй юм биш байгаа гэж ойлгоод байна. Ингээд сумдыг бол балгас болгохгүй гэсэн баталгаа бол байхгүй ээ. Балгас болно, болох болохдоо бүр ч айхтар болох байх гэж бодож байна, баталгаатай болох байх. Яагаад вэ гэхээр 1995, 96 оноос эхлээд хошууны зохион байгуулалтанд орё гэж байна. Үүнийг чинь дуулсан бүх сумын удирдаж байгаа сайн муу ч гэсэн бүх дарга өөрийнхөө ажлыг хайгаад яваад өгнө. Тэр хөрөнгийг хайхардаг хүнгүй болно. Ингээд Монголын ард түмэн, засаг захиргааныхаа төвийг балгас болгосон том хариуцлага хүлээх ажил гарвал маний үеийн 430 депутат хүлээх үү? санал болгосон Бага Хурлын 53 гишүүн хүлээх үү гэдэг ажил дээр таны бодол ямар байдаг вэ?

Энэ хуулийн төсөл дээр улсын Их Хурлын 76 гишүүний цалин хангамжийг баталгаатай тогтооно гэсэн байна. Энэ хангамж гэдгийг чинь жил гаруйн өмнө шүүмжлээд байгаагүй биш биш үү? Одоо энэ чинь хангамж гэдгийг заавал энэ хуулиндаа оруулж, дахиад ард түмний дургүйцлийг хүргэж байх хэрэг байна уу? Хангамж байвал ямар хангамж байх юм бэ? Та нөхдийг чинь энэ хангамжийн талаар нэг байшинг тэр чигээр нь улсын Бага Хурлын гишүүд авлаа гэсэн яриа нийслэл хүрээнд чинь их байдаг юм байна шүү дээ. Үүнийг та нөхдүүд ойлгож байгаа байхаа.

Цалин хөлсний асуудлаар зөвхөн 55 дугаар зүйл дээр байна билээ. Шүүгчийн цалинг ер нь бууруулахыг хориглоно гэсэн байгаа юм. Бусад нь засаг төрийн ажилтнууд цалингаа бууруулж болдог, шүүгч бууруулж болдоггүйн учир юунд байна вэ?

Р. Гончигдорж: Өөрөө удирдах ёсыг хэрхэн ойлгож байгаа тухай асуудал дээр л ярьж байх шиг байна л даа. Энэ бол дураараа дургих тухай асуудал юм уу боломжоороо жиргэх тухай асуудлын тухай ярьж байгаа биш л дээ. Энд тодорхой хуулиар орон нутаг өөртөө мэдэж хэрэгжүүлэх эрх хэр хэмжээ ямар байх юм бэ? төрийн удирдлага, төрийн эрх

мэдлээр энэ орон нутагт дахь ямар эрх мэдлийг хэрэгжүүлэх юм бэ? гэдгийг тодорхой эрх хэмжээг хуваарилсан энэ хуулийн хуваарилал, хуулийн хэм хэмжээ байнаа гэж ойлгож байна. Энэ хуулийн хэм хэмжээний хүрэн дотор тэр нутаг дэвсгэр дээр засаг захиргааны нэгж дээр амьдарч байгаа иргэд, өөрийнхөө засаг захиргааны нэгж дээр гарч байгаа нийгэм, эдийн засаг, соёл, бүхий л асуудлуудаа тэр хуулинд олгогдсон эрхийн хэм хэмжээний дотор хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудлаар өөрсдөө мэдэх, энэ мэдэж байгаа эрх мэдлээ өөрсдийн төлөөллийн байгууллага Хурлаараа дамжуулж шийдвэрлэх, багт бол бүх гишүүдийнхээ хурлаар энэ асуудлаа шийдвэрлэж байх, энэ шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх үүргийг төрийн удирдлагыг тухайн орон нутаг дахь төрөөс явуулах, удирдлагыг хэрэгжүүлэхээр дороос гарч, дээрээс томилогдсон Засаг дарга хэрэгжүүлэх ийм л зүйл байгаа шүү дээ.


Засаг дарга гэдэг маань ганц хүн биш. Өөрөө бол тэнд өөрийн аппараттай, энэ аппараттаараа гүйцэтгэх үйл ажиллагаагаа явуулж чадах ийм чадвартай байх ёстой гэж.

Одоо бид нар чинь жишээ нь, орон нутгийн тодорхой хэсэгт өөртөө гадаадтай эдийн засгийн талаар бусад иргэний харьцаанаар яаж гадаадтай харьцах эрх мэдэл, орон нутагт ямар хэмжээгээр өгөх вэ? төрд байлгах эрх мэдэл ямар хэмжээтэй байх вэ? эдийн засгийн хүчин чадлын хувьд одоо жишээ нь өөрийн олсон, өөрийн нутаг дэвсгэр дээрээ бий болгосон материаллаг баялгийг хэрхэн хуваарилж, хэрхэн, хэднэ өөрийнх нь мэдэлд, хэд нь төрийн мэдэлд шилжих ёстой вэ? энэ бүх зүйлүүд чинь одоо татвар, шимтгэл бүх л хуваарилалт энэ зүйлээрээ гарчихна шүү дээ. Тэгээд өөртөө бүрэн мэдэж захиран зарцуулах энэ эд хөрөнгийн болон эрх мэдлийн хэм хэмжээн дотроо энэ асуудлаа өөрөө мэдэж зохион байгуулах ийм л удирдлагыг, дээд талын төрийн удирдлагатай хослуулах энэ л утгаар ярьж байгаа учраас тэр Хурал гэдэг бол үүнийгээ шийдвэрлэж байх, үүнийгээ хэлэлцэж байх, ийм зүйл. Түүнээс гадна үүнийгээ цаашлаад хэрэгжүүлэхдээ янз янзын орон нутгийн хурлын дэргэдэх

янз янзын зөвлөлийн хэлбэртэй үйл ажиллагаагаар орон нутгийн боловсролын асуудлаар, орон нутгийн нийгмийн асуудлаар, орон нутгийн холбоо, тээврийн асуудлаар ингээд. Энэ нь дээрээсээ төрийн удирдлагын, төрийн гүйцэтгэх засаг, гүйцэтгэх засгийн төрийн төв байгууллагууд, түүвээр холбогдож байгаа чиг шугамаараа төрийн удирдлагын чигээр орж ирэх ийм зүйлүүд. Ийм л нэгдлийн тухай асуудал ярьж байгаа юм.

Зардал, мөнгө, чадал хэм хэмжээнийхээ хувьд ярих юм бол мэдээж хэрэг засаг дарга, түүний аппаратын хувьд түрүүн хэллээ, тэр бол төрөөс санхүүжиж байх ийм юм. Мөн өөрийн удирдах удирдлагын аппаратын хувьд, түвшинд нь ч гэсэн одоо төрөөс дэмжлэг үзүүлэх хэм хэмжээнд байх тэр дэмжлэгийг бол үгүйсгэхгүй бөгөөд түүнээс гадна гол нь өөрсдөө хэрхэн орон нутаг дээр үүнийгээ шийдвэрлэж чадаж өөрөө өөрийнхөө энэ удирдлага зохион байгуулалтынхаа чадвараар өөрийгөө хэрхэн сэргээн байгуулагдаж чадаж байгаа байдлаасаа. Түүнээс гадна өөрийнхөө нутаг дэвсгэр дээрх татварын болон бусад санхүүгийн эх үүсвэрээс оруулж ирэх орлогоо бүрдүүлж чадаж байгаа байдлаасаа эдгээрийн нийгмийнхээ асуудлыг шийдвэрлэж чадах чадамж болон өөрийнхөө аппаратыг цалинжуулж байх чадамжийн хэмжээнүүд нь тэндээсээ эх үүсвэр урсгалтай байх ёстой гэсэн ийм л төсөөлөл байгаа шүү дээ.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.14.
Кассет № 43
17.35-17.50.

Р.Гончигдорж -Үндсэн хууль бий болонгуут сум, хороодыг татан буулгах ойлголт огт байхгүй гэдгийг хичнээн олон удаа ярих юм бэ. Хэрэв та бүхэн энэ нэр нь ингэж орно гээд хавсралтын хуулийг үндсэн зарчмаар нь тодорхой зүйл дээр зөвшөөрлөө гэхэд эхний ээлжинд зөвхөн нэр солих асуудал байгаа шүү дээ. 1992 оны I-р сарын I-нээс Үндсэн хууль нь шууд хүчин төгөлдөр болсон цагт л нэр солих асуудал юм. Түүнээс 1992 оны I-р сарын I-нээс татан буулгах асуудал огт байхгүй. Цаашдын зохион байгуулалт, хөгжлийн жам ёсоор явж ирэхдээ энэ нь ямар хэв хэмжээтэй болох вэ гэсэн асуудал яригдана. Үүн дээр тодорхой зүйлийг ухуулах, сэтгэл санааны хүчин зүйлийн хувьд цаашдын явцад гарах эерэг үр дагаварынх нь талаар огт яримааргүй байна шүү дээ. Түүнээс гол зорилго нь хэзээ орон нутгийн өөрөө удирдах ёсыг тэр нутаг дэвсгэрийн хүмүүс итгэлтэй хэрэгжүүлж чадна гэвэл нийгэм, эдийн засаг, газар нутаг, дэвсгэрийн цогцолбор, бүрэн бүтэн байдал, үүнийг чадамжтай болгож чадах зөв хуваарилалт, зохион байгуулалтанд зөв орсон байх ёстой.

Энэ нь өнөөдрийн нутаг дэвсгэрийн байгаа байдал, мөн үүн дээр байгаа бүх зүйл нөхцөлдүүлж бүрэлдүүлж чадаж байгаа бол арга алга, болж л байна. Гэтэл чадвар суухын тулд заримдаа юм нэгддэг, салдаг шүү дээ. Тэхээр орон нутгийн засаг, захиргааны Үндсэн хуульд байгаа шинэ механизм үнэхээр иргэдэд үр ашигтай үйлчлэж чадахын тулд засаг, захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтанд өөрчлөлт орох шаардлага байна уу, үгүй юу гэдэг л асуудал гол үндсэн шаардлага болно. Түүнээс өөрчлөхийн тулд өөрчлөж байгаа ч юм биш, шинэчлэж нийлүүлэхийн тулд ч нийлүүлж ч байгаа юм биш юм. Ийм л зүйл байгаа юм. Тэхээр энэ нь та бүхний ажил хэргээр цаашдаа үргэлжлэх л зүйл юм.

Улсын Бага Хурлын 76 гишүүний цалин, хангамжийн тухай асуудал. Хангамж гэдэг нь тэр хүний хувийн амьдралын хангамжийн асуудал огт биш юм. Цалин, харамж гэж хуучин байсан нэр томъёог

авъя гэсэн асуудал гарч ирсэн. Хангамж гэдэг нь хүн үйл ажиллагаагаа явуулахад зайлшгүй шаардагдах зардлын тухай асуудал юм. Бид магадгүй Их Хурлаа байгуулаад, бусад Парламентуудын үндсэн түгээмэл шинж чанарын үүднээс нэг Их Хурлын гишүүнд зарцуулагдах зардал гэдгийг бий болгож, тэр зардлын тодорхой тогтоогдсон хэв хэмжээгээр цалин нь, бусад зүйлүүд нь тэр хүн нь өөрийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах, нэг ёсоор аппаратаа бүрдүүлэх, өөрийн сонгуулийн тойрог дээр ажиллах зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг явуулах зардал гэсэн утгаар нь гарч ирэх хангамж байх учиртай юм. Түүний тулд хувь хүнд өөрт нь наалдах зүйлийг хатуу хязгаарлах бөгөөд цалин гэсэн утгаар үүнийг нь тусгайлан хэлж байгаа зүйл нь энэ юм.

Жишээ нь АНУ-ын нэг сенатор 6000-1,5 сая долларыг өгдөг. Түүгээр тэр хүн нь өөрийн сонгуулийн тойрог дээрх аппаратаа ч бий болгодог. Мөн өөрийн сенат дээр ажиллах Парламентаа ч бий болгодог. Түүнийхээ бүх зардалд саяны хэргийг зарцуулж байдаг бөгөөд, энэ зарцуулалт нь тодорхой хяналтанд, тэр хүний өөрийн хувийн карманд ороогүй гэсэн баталгаа үүсч ирнэ. Ийм байдлаар бидний хууль тогтоох байгууллага Парламентаа хүчтэй болгож, нэг талаас, сонгогчдын холбоог байнгын хэмжээг хадгалах, хууль тогтоох ажиллагааг мэргэжлийн төвшинд явуулж чадаж байх нөхцөл байдлыг үүсгэхийн тулд энэ нь зайлшгүй ийм хангамжийн асуудал юм. Энэ хангамжийг эрхэм депутатууд ингэж л ойлгоороой, түүнээс карман болон амьдрал, тэр лүү нь орох тийм хангамжийн тухай асуудлыг энд огт яриагүй байна. Ийм л асуудал байна.

Шүүхийн цалингуу бууруулж болохгүй гэдгийг шүүх үл хамаарах, шүүх зөвхөн хуульд захирагдаж хажуугийн ямар ч нөлөөнд автагдахгүй байх гэсэн хүчин зүйлийг өнөөдрийн бодит шалтгааны үүднээс нь цалин нь үүний бүрэлдэхүүн хэсэг мөн гэсэн үүднээс түүний цалингуу бууруулах асуудлыг энэ хуулиар хориглосон байгаа юм.

Цалин гэдэг нь энэ нэгэнт төрийн албан хаагч учраас улсын төсвөөс цалинжуулж, санхүүжүүлнэ. Энэ улсын төсвийг шүүхэд зарцуулах улсын төсвийг хорогдуулж болох уу гэдэг асуудал дээр Бага Хурал нэлээд маргасан. Мөн олон хувилбаруудыг ярьсан. Ярьж байгаад улсын төсвийн чадвар жил, жилд унаж, өсөж янз бүр байх юм. Үүнийг дагалдуулж унаж, өсөж байх асуудал нь их бэрхшээлтэй, цалин хадгалана гэдгээс илүү бусдад хардлага төрүүлэх асуудал байна гээд зөвхөн нэг асуудал дээр ядаж цалинг бууруулах асуудлыг дур, зоргоороо шийдвэрлэхгүй гэсэн, гуравдагч итгээдээс, үүнийг шийдвэрлэхгүй байх гэсэн асуудлаар хэлсэн, зөвхөн онцгойдсон тохиолдолд өөрийн ерөнхийлөгчид шүүхийн зөвлөлийн хүрээ хэмжээнд цалин мөнгөний асуудал, албан тушаалыг нь бууруулах нь зөвхөн ажлын хариуцлагатай холбогдсон шинж чанартай байхаас биш, хажуугийн шахалт, урамшууллын шинжтэй байх болохгүй. Ийм л агуулгаар нь шүүхийн хувьд оруулсан ийм л зүйл юм.

Би үүн дээр маргахыг хүсэхгүй байна. Сумд тарна, нийлнэ гэсэн агуулга, энэ нь сумын төв. Өнөөдөр бид аж ахуйн нэгжийн өмч сайн хөгжиж, өнөөдөр үйлдвэрлэлийн зөвхөн монопол үйлдвэрлэл жижгэрч, жижиг үйлдвэрүүд болох төдийгүй, үйлдвэрлэлтийн орон нутгийн тархан байршилтын асуудал дээр ч гэсэн ийм жигдрэлт бий болно гэдэгт итгэлтэй л байдаг.

Өнөөдөр мал аж ахуй эрхлэж байгаа хүмүүс зөвхөн малаа хариулах төдийгүй түүнээс гарч байгаа бүтээгдэхүүн болон өөрсдийн цаг, заваа зарцуулж, түүнд өөрсдийн чөлөөт үйлдвэрлэлийг эрхлэх асуудал, түүнтэй холбогдсон үл хөдлөх хөрөнгийн байршил зохион байгуулалтууд бүрдэх, энэ бүх асуудлууд нь аяндаа жижиг хэмжээний суурин, төвлөрлүүдийг зайлшгүй бий болгоно. Ийм юмтай болох зайлшгүй өрмөлзэл үүсэх энэ үед яагаад өмнө нь бий болгосон одоо үеийн үл хөдлөх хөрөнгийн оруулалттай бий болгочихсон барилга, байгууламжийг нураах тухай асуудал үүсэж яригддаг юм бэ гэдгийг, Бага хурлын гишүүд амьдрал мэдэхгүйн хувьд ойлгохгүй байна уу, эсвэл үүн энэ үйл ажиллагаандаа чөлөө-

тэй идэвхтэй, үр бүтээлтэй болно гэдэгт нь найдамтаа ингэдэг юм уу, үүнийг балгас болгодог төвлөрсөн соронзон үйлчлэдэг үетэй адил биш, тараадаг, хүчин зүйл үйлчлэж байгаа гэсэн утгаар энэ нь бэлэн төвлөрсөн байгууламжууд байна гэж ойлгогдох хэмжээнд орох байх гэж ойлгож, бодох үүднээс хараахан шийм балгас болчихгүй болов уу л гэж бодож байна.

Нэрний хятад, Монгол гарал үүсэлийн хувьд та бүхний ярих зүйл бөгөөд гэхдээ хэрэв яг уг, үсгийнхээ гарал үүсэлийн хувьд ярьж эхлэнэ гэвэл нарийн мэргэжлийн хүмүүс, хэл судлаачид, хэл зүй судлаачид, үгийн гарал үүсэл судлаачдын асуудал байх, хэрэв түүхэн уламжлалынхаа хувьд нэр томъёо хэзээ гарч, бий болсон гэсэн асуудал нь түүхийн судлаачдын асуудал байх, энэ хүмүүсийн Бага Хуралд өгч байгаа мэдээллүүдийн үүднээс авч үзвэл ямар ч байсан хошуу гэдэг нь уламжлалынхаа хувьд сумаасаа хамаагүй өмнө байсан зүйл, сум гэдэг нь анх засаг захиргааны шинжтэй юм уу, эсвэл иргэдийн бүлэглэлийн шинжтэй нэгж болохынхоо хувьд анх байгуулагдсан нь манжийн үед сум гэдэг нэртэйгээр байгуулагдсан шинжтэй байгаа юм. Хошуу гэдэг нь монгол үе удмаараа анх өөрөө нэгж болохынхоо хувьд, иргэдийн бөөгнөрлийн нэгж болохын хувьд Монгол гэж өөрийгээ мэдэж байсан үедээ гарч ирсэн нэр томъёо юм байна. Үүнийг нарийвчлан хэлэх нь миний мэдлийн хэмжээнээс гарсан зүйл байх л даа.

215-р тойргийн депутат Ж. Чунагсүрэн -Өнөөдрийн хуралдааны асуулт, хариултыг таслаж, өргөн шүүмжлэлд орох саналтай байна. Хариулж байгаа хүн ч ядарч байгаа байх. Бүтэн өдөржингөө хөл дээрээ зогслоо.

Нөгөө талаар асууж байгаа асуулт ч давхардаж байна. Бидний зарж байгаа нэг минут 118 төгрөг урсаж байгаа гэдгийг Ерөнхийлөгч хэлсэн. Цагаа бид хэмнэмээр байна. Түрүүнд депутат Дашням өргөн шүүмжлэлдээ орё гэсэн санал гаргасан. Үүнийг хэлэлцүүлж өгөө чээ гэдгийг би хүсэж байна. Бид маргааш асуулт

тавьж болно. Бид дараа нь асуулт тавих олон илтгэлүүдийг хэлэлцэнэ. БагаХурлын илтгэл хэлэлцэнэ. Мөн Засгийн газрын илтгэлийг ч хэлэлцэнэ. Бас бусад асуудал гэсэн зүйл ч бий. Тийм учраас энэ нь зөвхөн асуулт, хариултын хуралдаан байж болохгүй. Бид өнөөдөр хэтэрхий семинарын байдалд орчихоод байна.

Хоёрдугаарт ечигдрийн хуралдаанаас хороо байгуулсан байх ёстой. Тэр хороо юу болсон сургийг нь сонсмоор байна. Манай дэгээр Ардын Их Хурлын хуралдааны хэвлэл, мэдээллийн бүлэг үүсэж байгуулах ёстой. Түүнийгээ мөн байгуулав уу, яав гэдгийг мэдвэл зүгээр байна. Миний саналыг хэлэлцүүлж өгөө чээ гэдгийг хурлын даргаас хүсэж байна.

Д.Тогооч/430-р тойргийн депутат/ -Тодруулах хоёр зүйл байна. Улсын Их Хурал төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн үү, биш үү гэсэн төрийн дээд тогтолцооны асуудал нэлээд яригдах ёстой зүйл болов уу гэж бодож байна. Хэрэв бидний сонгох Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний илч төлөөлөгч бол тэрүүгээр дамжиж байгуулагдсан Улсын Их Хурал нь төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага байгаа. Гэтэл Их Хурлын гишүүнийг зарим хүмүүс тайлбарлахдаа та нөхдийн сонгосон илч төлөөлөгч биш ээ, Их Хуралд суух байнгын эрх барих байгууллагын гишүүн гэсэн тодорхойлолт байна. Нөгөөтэйгүүр иргэдийн эрх дээр ярихлаар иргэд өөрсдөө шууд буюу төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар дамжин төрийн эрхийг барина гэж байна. Тэхээр төрийн эрх барих дээд шатанд Улсын Их Хурал дээр ард иргэд нь төлөөлөгчдийн байгуулаггүй болж зөвхөн орон нутагт төлөөлөгчдийн байгууллагын хэлбэрээр ажиллах юм гэсэн сэтгэгдэл төрж байна. Тийм учраас Улсын Их Хурал гэдэг нь дээд байгууллага уу, үгүй юу. Улсын Их Хурлын гишүүн гэдэг нь ард түмний төлөөлөгч мөн үү, үгүй юу гэдэг асуудлыг тодруулж өгнө үү.

Хоёрдугаар асуудал, засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь дээрээ баримталсан гол зарчмыг ойлгохдоо нутаг дэвс-

гэрийн зарчмыг баримтлажээ. Ийм үндсэн дээр Үндсэн хуулийн төсөлд нэгжүүд байх юм гэж ойлголоо. Гэтэл үүний хажуугаар засаг, захиргааны нэгж гэсэн зүйл баймаар санагдаж байна. Би юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл хотууд, одоогийн байгаа улсын харьяалалттай хотууд ч байна. Мөн аймгийн төвийн хотууд ч байна, бусад хотууд ч байна. Тэхээр энэ нь засаг, захиргааны нэг нэгж биш юм уу, үүнийг Үндсэн хуулийн төсөл юм уу, эсвэл Их цаазын төсөлдөө оруулж өгөхгүй юм уу гэсэн асуудал байна. Хэрэв ийм тодорхойлолтгүй бол манай улс нийслэл гэдгээс өөр хотгүй улс болох юм биш биз дээ. Бусдыг нь суурин, төв гэж нэрлэх нь хангалттай юм биш үү гэсэн ийм хоёр асуулт байна.

Р.Гончигдорж —Улсын Их Хурал нь төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн гэж ойлгөж байна. Улсын Их Хурлын гишүүн одоогийн депутат хоёрын хооронд ялгаа бий юу гэдэг утгаар нь ойлговол ялгаатай гэж үзэх ийм үзэл баримтлалаар асуудлаа ярьж байгаа юм. Энэ ялгаа нь төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллагад ард түмэн өөрийн эрх мэдэлд байдаг засгийн, тэр дотроо төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхийн тулд өөрсдөөсөө төлөөлөн суулгаж байгаа төрийн төлөөлөгчид, үүнийг энэ Их Хурал, төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрх мэдлийг зөвхөн гагцхүү түүнийг хэрэгжүүлэх энэ байгууллага гишүүн болгож илгээн явуулж байгаа тэр эрхийг нь, суурь эрхийг нь олгож өгч байгаа энэ утгаараа сонгогчид, тэр сонгогдсон тойргийн Их Хурлын гишүүн хоёрын эрх зүйн харьцаа үүснэ гэсэн ойлголтоор юм. Түүнээс депутатын захиа, даалгаврыг авч, түүнийг хэрхэн биелүүлж байгаагаа бидний өмнө тайлагнаж, тэр тайлагналаас үүсэж депутат үүргээ биелүүлж чадахгүй байна гэсэн эрх зүйн харьцаанд ордог. Захиа даалгавар нь зөвхөн улс төрийн захиа даалгаварууд одоогийн хувьд байдаггүй шүү дээ. Ийм байдлаар зарчмын шинэ байдал үүсэж, Их Хурлын гишүүд хэдийгээр нэг тойргийн сонгогчдоор Их Хурлын гишүүнийхээ эрхийг сонгож авсан бол үндсэн тэр хүн нь Монгол улсынхаа зөвхөн тэр эрх ашиг, нэрийн үүднээс хандах ёстой болдог.

Соронзон
Тулгаж нийлсэн *Ц.Баярмаа* Ц.БАЯРМАА
Бичээч С.ТУУЛ

Р.Гончигдорж:—Сонгогчдынхоо, зөвхөн сонгуулийнхаа тойргийн сонгогчдынхоо, зөвхөн тэдний өмнө шууд эрх хүлээх төдийгүй Монголын бүх иргэдийн өмнө хүлээх үүргээрээ адилхан тооцогдох ийм л агуулгаар гишүүдийг Их Хурлын гишүүдийг, одоогийн бидний Их Хурлын депутатын энэ хоёрын ялгааг ойлгож байгаа юм. Хэрэв энэ ойлгогдохгүй нарийн тайлбар шаардлагатай бол явц дундаа ярьж болох ийм зүйл юм.

Засаг захиргааны, төрийн эрх барих дээд байгууллага гэдгийг бүхий л, олон байдлаас нь бид нар таньж мэдэж болно шүү дээ. Төрийг энд нуршихын хэрэггүй байх гэж болож байна. Засаг захиргааны хуваарь гэж. Үнэхээр тэр засаг захиргааны хуваарийг бол нутаг дэвсгэрийн шинж бол анхдагч шинж болгож гаргаж ирж байгаа. Тэгэхлээр хот гэдэг маань өөрөө засаг захиргааны биеэ даасан нэгж байхыг үгүйсгэхгүй байгаа шүү дээ. Жишээлэх юм бол хошуу гэсэн засаг захиргааны нэгжийн биеэ даасан байдалтай хот байхыг үгүйсгэхгүй. Хороо гэсэн нэртэй тийм засаг захиргааны нэгж байхыг үгүйсгэхгүй, мөн баг гэсэн нэртэй засаг захиргааны нэгж байхыг үгүйсгэхгүй байгаа шүү дээ. Зүгээр нэг засаг, жишээлэх юм бол нэг хошуу гэсэн нутаг дэвсгэр, хошууны нутаг дэвсгэр дээр хоёр хот суурин байх гэж болъё. Нэг нь яах вэ төрний төв нь байг, төв нь байгаа утгаар хошуун доторхи төв, засаг захиргааны нэг нэгж болъё гэвэл тухайлбал баг болох нь. Төрний дэргэд өөр нэг хот байх юм бол энэ маань бас дахиад нэг хошуун доторхи засаг захиргааны нэг дэд хэсэг байхаар л байж болно, энэ маань өөрөө түрүүний багийн нутаг дэвсгэр дээр байж байгаа жижиг суурин байх юм бол энэ маань дахиад нэгдсэн засаг захиргааны нэгж байхгүй, зүгээр иргэний шугамаар иргэний олон нийтийн удирдлагын өөрийн статустай байхыг хэзээ ч үгүйсгэхгүй байгаа, энд бол мэдээж хэрэг тэнд тийм зохион байгуулалт бол байж л таараа шүү дээ. Нийгмийн асуудал, орон сууц, хангамж, халаалт, дулаалга энэ бүгц дээрээ иргэний нийгмийн асуудлын талаараа тэнд өөрийн статустай, өөрийн зохион байгуулалттай. Энэ маань яг тийм засаг захиргааны нэгж гэдэг энэ утгаараа

бол биш байж болно.

Ардын Их Хурлын 250 дугаар тойргийн депутат Т. Дамдин-дорж:— За би өөрийнхөө ойлгохгүй байгаа гурван зүйлийг асууя. Энэний урд тал дээр бас нэг ярьчихмаар юм байх юм. Тэгэхлээр зэрэг бид зарим нь асуултаа больё. Шууд ажилдаа орё гээд байна. Ингэхлээр зэрэг бид өнөөдөр асуудлаа жаахан явуулж бид жаахан зүгээ олж авмаар, манай дээдүүл ч бас маргааш юу гэж хариулах вэ гэдэг талаар бас жаахан юм бодож санахад ч буруугүй болов уу гэмээр юм амьдралаас харагдаад байх шиг байх юм. Тийм учраас энэ сонгуулийн талын асуудал маш олон дахиж яригдсан. Ер нь тодорхой сэтгэл ханасан хариулт авч чадахгүй байна. Одоо би энэнийг бас дахин асуухаар босч ирлээ. Тэгэхлээр бид тодорхой хүрээнд, жижигхэн объёмонд сонгууль явуулж байхдаа эндээс нэг нэр шуудангаар явуулаад тэнд очоод Их Хурлын депутат сонгогчид нэг үе байсан. Энэний дараа өөрчлөлтийн үе дээр ард түмнээр сонгуулах гэсэн. Өөрийнхөө харьяалал, сум, бригадаас сонгох гэж нэг хэсэг үзсэн. Ингээд энүүхэн жаахан объёмонд сонгох гэхлээр зэрэг бүтэн жил гаруйтай хугацаа болоход манай улсын хэмжээнд одоо сонгож чадаагүй сум байгаа. Энэн дээрээс бид бас сургаж авч бодуштай юм байх болов уу.

Ингээд одоо 76 Их Хурлын депутат улсын хэмжээгээр сонгоно гээд ард түмнээр сонгууль гэхэд авгайгаараа тавья депутат гэх хүн ч цөөхөн гарах байх, сум, орон нутгаасаа таньдаг хүнээрээ тавья гэнэ, аймгийн хэмжээнд гэж үзэх юм бол аймгийнхаа даргыг алдаг оног таньж байгаа шүү дээ хүмүүс чинь. Бие биенийгээ таньж, зан заншлыг нь мэдэж сонгох нь битгий хэл. Ингэхлээр зэрэг сонгууль маань нэг их унжирсан айхтар юм болох болов уу. Үүнийг бид хуулийг хэлэлцэж батлахаасаа өмнө энэнийг учрыг нь сайн олохгүй бол.

Хоёрдугаарт 3 жил болоод тал хувийг нь шинэчлэн сонгоно гэж байгаа. Шинэчлэн сонгох болохлоор чинь зэрэг яхнийх нь яах вэ ингээд түрүүн Бага Хурлын дарга хариулахдаа ямар нэгэн

Гуравдугаар асуулт, шүүхэд ер тэгээд миний бодлоор бол шүүх гэдэг маань тусгай нэг тийм дашилсан бух шиг газар гарч ирэх гэж байгаа юм болов уу гэж.

Хүн нэг харвал харна, харахгүй бол тэгээд хойтон жил ногоо идээд цадаад таргалсан цагтаа завод, тасгаар бууж ирдэг энэн шиг л байгуулах гэж байгаа юм болов уу. Ер нь хяналт шалгалтгүй. Бид энэнийг яг ажлаа, үүргээ гүйцэтгээд байдаг ариун цагаан ^{алт} шиг амьтан байна гэж ерөөсөө бодогдохгүй, манай алтны хэрэг хаанаасаа гарч байгаа вэ гэвэл толгойноосоо гарч байгаа, хонины хэрэг хаанаасаа гарч байгаа вэ гэвэл доороосоо гарч байгаа. Тэгвэл энэ шүүхийг бас тэгж ингэж их бүслүүргүй, хүрээлэлгүй тавьчихаж болж байна уу үгүй юу гэдэг талдаа, энэ асуудлууд дээрээ одоо хариулт авахыг хүсэхгүй, харин энэнийг бол бодож боловсруулж байгаад, яг хуулиа ярихлаар энэн дээр тодорхой шийдэж өгөх байх аа гэж бодож байна.

Р. Гончигдорж:—За санал нэг байна. Хуулиа ярилцаж, тухайн зүйлүүд дээрээ харилцан ойлголцох юм. Таны саналыг сонслоо.

Ардын Их Хурлын 47 дугаар тойргийн депутат С. Лхагвасүрэн:—Тэгэхээр энэ дээр би Дамдинжав гуайн саналтай нэг байна. Хурлын дарга аа. Яагаад гэхлээр зэрэг би бодож байгаа юм. Ноднин жилийн мандатаар, анхдугаар хуралдаанаар сонсоход бараг 60-70 хувь нь сум, нэгдлийн дарга, малчин, ажилчин, голжуу гүйцэтгэх ажилтагууд бид энэ депутатад сонгогдсон, тэгэхээр энэ хуулийг боловсруулахад хичнээн хүн хэдэн сар оролцов? Жил гаруй оролцов? Төчнөөн төгрөг гаргасан, энэнийг бид сая Ерөнхийлөгчөөс сонссон, энэ хуулийг бүхэлдээ биеэ даасан том шинжлэх ухаан гэж үзэж байгаа. Тэгж ч үздэг, тийм ч юм аа. Тэгэхлээр хоёр гуравхан цагийн хариултаар бид нар хангалттай боллоо гэж ингэж хэлэх эрх алга байна нэг талаас. Нөгөө талаас ойлгохгүй юм нэлээн байна. Зарим нь хуудсаар өгөөд бас хариултыг дутуу авсан. Миний хувьд бас дутуу авсан. Нөгөө талаас энэ асуулт явагдаж байгааг би хоёр утгаар ойлгож

бол биш байж болно.

Ардын Их Хурлын 250 дугаар тойргийн депутат Г. Дамдиндорж:— За би өөрийнхөө ойлгохгүй байгаа гурван зүйлийг асууя. Энэний урд тал дээр бас нэг ярьчихмаар юм байх юм. Тэгэхлээр зэрэг бид зарим нь асуултаа больё. Шууд ажилдаа орё гээд байна. Ингэхлээр зэрэг бид өнөөдөр асуудлаа жаахан явуулж бид жаахан зүгээ олж авмаар, манай дээдүүл ч бас маргааш юу гэж хариулах вэ гэдэг талаар бас жаахан юм бодож санахад ч буруугүй болов уу гэмээр юм амьдралаас харагдаад байх шиг байх юм. Тийм учраас энэ сонгуулийн талын асуудал маш олон дахиж яригдсан. Ер нь тодорхой сэтгэл ханасан хариулт авч чадахгүй байна. Одоо би энэнийг бас дахин асуухаар босч ирлээ. Тэгэхлээр бид тодорхой хүрээнд, жижигхэн обьёмонд сонгууль явуулж байхдаа эндээс нэг нэр шуудангаар явуулаад тэнд очоод Их Хурлын депутат сонгочихдог нэг үе байсан. Энэний дараа өөрчлөлтийн үе дээр ард түмнээр сонгуулах гэсэн. Өөрийнхөө харьяалал, сум, бригадаас сонгох гэж нэг хэсэг үзсэн. Ингээд энүүхэн жаахан обьёмонд сонгох гэхлээр зэрэг бүтэн жил гаруйтай хугацаа болоход манай улсын хэмжээнд одоо сонгож чадаагүй сум байгаа. Энэн дээрээс бид бас сургамж авч бодуштай юм байх болов уу.

Ингээд одоо 76 Их Хурлын депутат улсын хэмжээгээр сонгоно гээд ард түмнээр сонгууль гэхэд авгайгаараа тавья депутат гэх хүн ч цөөхөн гарах байх, сум, орон нутгаасаа таньдаг хүнээрээ тавья гэнэ, аймгийн хэмжээнд гэж үзэх юм бол аймгийнхаа даргыг алдаг оног таньж байгаа шүү дээ хүмүүс чинь. Бие биенийгээ таньж, зан заншлыг нь мэдэж сонгох нь битгий хэл. Ингэхлээр зэрэг сонгууль маань нэг их унжирсан айхтар юм болох болов уу. Үүнийг бид хуулийг хэлэлцэж батлахаасаа өмнө энэнийг учрыг нь сайн олохгүй бол.

Хоёрдугаарт 3 жил болоод тал хувийг нь шинэчлэн сонгоно гэж байгаа. Шинэчлэн сонгох болохлоор чинь зэрэг ихнийх нь яах вэ ингээд түрүүн Бага Хурлын дарга хариулахдаа ямар нэгэн

3.

аргаар болох байх аа гэсэн. Манайх ийм аргацаасан арга бас бодож ч байж мэднэ нэг юм. Хоёрдугаар арган дээр очоод 76 хүнийг чинь 76-ууланг нь огцруулчихвал яах вэ? Нэгдүгээрт бүрэлдэхүүн маань алга болно, эсвэл 76 хүнийг чинь 76 чигээр нь батлаад байвал манайх болох ёстой нэг арга бий гээд дахиад сонгууль явуулаад байх уу? Тийм учраас энэ сонгуулийн тухай асуудлыг ер нь тодорхой хариулт авч, тодорхой ойлгоцтой байж байж сонгуулийнхаа юман дээр тогтмоор, энэний хариултыг би одоо заавал авах гэж хүсэхгүй, өөрөөр хэлбэл маргааш энэ тухай, сонгуулийн тухай асуудал яригдана, энэ дээр тодорхой ойлгоц авч байгаад хариултыг нь өгөөсэй гэсэн бодол байна. Бид өглөөнөөс аваад Бага Хурлын даргыг энэ дээр хариулуулах гэж сойлоо. Тэгвэл бүтэн өдөр нэг хүн сойж байх арга алга. Тэгвэл бид чинь Бага Хурлын гишүүн 50 хүн сонгосон. Тэрний хэн нэг нь босоод хариулж болж байна энэ хариултанд. За сонгуулийн талаар ийм юм.

Нөгөө талаар нутаг дэвсгэрийн асуудал дээр, засаг захиргааны асуудал дээр нэлээн юм ярьж байна. Энэн дээр бага шиг тайлбар хэлээд ярьчихъя. Хүү нь цэрэгт яваад ирэхэд эх эцэг нь гэр барьж өгдөг. Тэр гэр орныг сэргээгээд хүү айл, амьдралаа зохиодог, бариад өрсөн гэрээ хаячихаад айлын хүргэн болоод суучихвал эх эцэгт нэг тусгай бодлого хэрэгтэй. Тэгвэл одооныхоо үйлчилгээний, ^{төв} бид сумын төв гэж яриад байгаа чинь одоо бол ард түмний үйлчилгээний төв байгаа, тэнд очиж луннаж юмаа тушааж, өгдөг юмаа өгч, авдаг юмаа авч, эмнэлэг доктороо дуудаж, үр хүүхдээ сургаж хүмүүжүүлж ингэж байгаа төв байгаа, тэгвэл ард түмэн маань нэгэнт байгуулчихаж байсан юмаа их баллалаа. Энэ нэг барьсан гэрээ бариастай нь хэдэн жил болохсон гэж хүсээд байгаа юм. Тэгвэл Засгийн газар, Бага Хурал дээрээ нэг ойлгоцтой, доороо нэг ойлгоцтой салангид байгаа юм биш байгаа. Энэ талаар анхны хэлэлцүүлгээр ер нь Бага Хурал энэ хууль боловеруулж байгаа хүмүүст ард түмний санал ирээгүй юу? Ирсэн бол бас ард түмний санал бодлыг жаахан харгалзаж үзвэл яасан юм бэ? гэсэн ийм асуулт байна.

байна. Нэг нь бол маргаашаас эхлээд бид нар хэлэх үгээ хэлнэ. Сонгогчдынхоо саналыг илэрхийлнэ. Нөгөө талаас тэрэндээ мэдлэг нэмэрлэж байна гэж бодож байна. Бид бас чадлаараа судалж үзэж сууж байна. Нөгөө талаас бид энэ хуулийг боловсруулалцаагүй, тийм боломж байдаггүй ажилтай улсууд, хүний, олон эрдэмтдийн боловсруулсан зүйлийг шууд үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар бидэнд алга байна. Тийм эрх ч байхгүй, тийм учраас энэ асуулт хариултаас бид энэ хуулиа баталчихаад эргээд очиход энэ хурлын дарга, бид нарыг удирдаж байгаа дарга нарын хэмжээнд, боловсруулсан хүмүүсийн хэмжээнд бид хариулж чаддаггүй юм гэхэд ямар ч гэсэн голыг нь олж хариуцлаг чадвартай очих хэрэгтэй байна. Түүнээс биш олныг дуурайж гар өргөчихөөд баталчихаад ирлээ гээд инээгээд гүйгээд очих бол бид нарын зорилго биш юм аа. Тийм учраас энэ хоёр замаар бид мэдлэг олж авах хэрэгтэй гэдэг үүднээс асууж байгаа юм аа. Нэгдүгээр асуудал ийм байна.

Түрүүн асуусан. Улсын хил тогтоох гэж 23 дугаар зүйлийн 8-д байж байгаа. Тэгэхлээр энэнийг ойлгохгүй байна. Манай улсын хил бол хоёр хөрштэй хоёулантай нь албан ёсоор хэлэлцээд гарын үсэг зурчихсан баримттай, хөдөлгөөнгүй байгаа, хилийн дээс, зураас бараг тэнд ургуулчихсан байгаа. Хөдөлгөөнгүй. Тэгэхлээр зэрэг дахиад хил тогтоох гэдэг асуудлыг нарийн ойлгохгүй байна. Хоёрдугаар асуудал 46 дугаар зүйлийн дөрөвт ингэж бичээстэй байгаа. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно гэж бичсэн байгаа. Гэтэл 65 дугаар зүйлийн гуравт очоод засаг даргын тавьсан хоригийг Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга огцрох саналаа дээд байгууллагадаа тавина гэсэн байгаа. Гэтэл гурван жилд нэг удаа Засаг даргыг томилно гэсэн байгаа. Тэгэхлээр энэ гурвын чинь уулзвар энэ хуулин дээр уулзалдаггүй байна. Өнөөдрийн системээр болох гээд байна шүү дээ. Ингээд л нэг боловсон хүчнийг, байдал ийм байгаа шүү дээ. Чи огцорчихвуу, би огцорчихоод ирлээ гэхэд, аа тийм үү, сонгогччихоод ирлээ гэвэл аа тийм үү гээд л байж байгаа шүү дээ. Ийм учраас энэ уулзвар мөн л хэвээрээ үргэлжлэх гэж байна.


Дараа нь Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тухайд гагцхүү Улсын Их Хурлын чуулганаар хянан хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн байна. Тэгэхлээр энэ дээр түрүүчийн Дамдинжав гуайн хэлдэг хоёр үг л цухалзаад **Большихлоо**. Шүүх, прокурорын ажиллагаа чинь энэ дээр чинь шал өөрөөр тусах байсан юм биш үү? Энэ чухам ямар утгаар ингэж тусгаж байгаа юм бол доо гэж асууж байгаа асуулт мөн болов уу гэж ингэж бодож байна.

Гурав дахь нь 36 дугаар зүйлийн гуравдугаарт Ерөнхийлөгчийн халдашгүй байдлыг хуулиар тогтооно гэж байгаа юм. Гэтэл энэний дээд талд нь Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна гээд хэлчихсэн. Дараа нь Ерөнхийлөгчийн нэр төрийг хуулиар хамгаална гээд биччихсэн байгаа. Гэтэл энэ дээр халдашгүй байдлыг хуулиар тогтооно гэдэг нь халдашгүй байдал гэдэг дотор энэнээс өөр юу байдаг юм бол доо гэж сонирхож байна.

Р. Гончигдорж: Зарим нь саналын шинжтэй байгаа учраас заримыг нь хариулах юмгүй байна. Заримыг нь хэрэв шаардлагатай гэвэл бусад гишүүдээрээ хариулуулъя. Тэгэхлээр зэрэг ер нь зүгээр бид нар нэг удаа та бүхэнтэй хуралдаан эхлэхийн өмнө уулздагийн гол зорилго бол магадгүй энэ дээр танин мэдэхүйн шинжтэйгээр харилцан ярилцах зүйлүүд байна уу гэсэн утгаар нэг уулзалт зохиосон юм. Тэр болоогүй юм. Ер нь хуралдааныг заавал чуулганыхаа хуралдаан хэлбэрээр төдийгүй шаардлагатай үед хуралдаанаа завсарлаад зарим зүйлүүдээр цэвэр танин мэдэхүйн болон онолын агуулгын ойлголтын хэмжээнд заавал нэг депутатаасаа нөгөө депутатууд нь авах төдийгүй энэ дээр бол бусад зүгээр эрдэмтэн мэргэдээс бол зохион байгуулж болдог. Бага Хуралд заримдаа энэ практикийг хэрэгжүүлж л байдаг юм. Ийм байдлаар бол танин мэдэхүйнхээ хувьд ярих зүйлүүд байх байх. Хуулиа баталсны дараачаар бол бидэнд шал өөр нөхцөл байдал үүснэ. Тэнд бол ёстой жинхэнэ утгаар хичээл заалцаж сонсон суралцах бол ямар ч шаардлагагүйгээр хэрэгжиж болох байх аа. Ингээд бол богинохон хугацаан дотор бид үүнийг бүтцийгээ ойлгомжтой болгочихож болох байх гэж бодож байх юм.

Хариултын шинжтэй байх, Засаг дарга огцрох, энэ бол ийм шүү дээ. Бид нар нэг л энэ эрх зүйн харилцаанд орж байгаа энэ нэг харилцан бие биендээ шүтэлцээтэй байх л энэ л байдлыг бодоод байгаа юм шүү дээ. Жишээлэх юм бол түрүүний үүргээс Засаг дарга тэр орон нутгийн удирдах ёсоо хэрэгжүүлэх хурлын шийдвэрийг хэрэгжүүлнэ гэж байгаа юм.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

Р.Гончигдорж: -Төгөхлээр зэрэг шийдвэрийг хурал гаргалаа. Засаг дарга хэрэгжүүлэх ёстой боллоо, засаг дарга эхлээд энэ шийдвэр чинь буруу болж байна уу, бүтэхээргүй шийдвэр байна гэдэг талаар эхлээд хориг тавина, хориг тавих дээр зэрэг тэр хурал эргээд авч үзээд тэр хоригийг нь тавьсны дагуу хүчин төгөлдөр биш болоод шийдвэрээ өөрчилж болно хэрэв хурал бид өөрчлөхгүй, ийм л шийдвэр гаргана, энэ шийдвэрийг зохион байгуулах гүйцэтгэх үүргийг та биелүүлэх ёстой болж байна гээд хэлээд ирэхдээр зэрэг тэр засаг дарга өөрийнхөө саналаар хэн ч тулгаагүй байхад өөрийнхөө саналаар би энэ гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж чадахгүй юм байна, энэ шалтгааны үүднээс би огцрох саналаа өөрөө тавьж байна гэж ингэж тавих тухай асуудал, энэ чинь харилцан шүтэлцээ байхгүй юу, нэг нь нэгэндээ тулгах биш, нэг нь нэгэндээ одоо соёлтой хэлбэрээр харилцан бие биенийхээ чадах чадамж эрх хэмжээ, энийхээ хүрээнд бие биендээ одоо гар сунгаж байгаа л гэсэн үг. Ийм л агуулга, тэрнээс биш одооных шиг одоо нэг хэдэн хүн бичиг цаас гаргаад огцрохгүй бол тэглээ, ингэлээ гэдэг энэ асуудал огтхон ч биш. Энэ бол шал өөр эрх зүйн үүднээс гарч ирж байгаа хүн сэтгэлийн харилцан байдал. Ийм л байдалтай байгаа юм, ялгаа нь бол, зүгээр их хурлын гишүүнийг эргүүлэн татуулах тухай асуудал дээр ярьсан зүйлийг би түрүүн ярьсан шүү дээ, эрхэм депутатууд аа, энэ бол их их хурлын гишүүн гэж тэгж сонгогдоод цаана нь бол түүнийг сонгосон сонгогчдын мандат нөгөө талаас төрийн дээд байгууллагад ажиллаж байгаа тэрний өндөр үүрэг хариуцлага, энэ болгон бол тодорхой үйл ажиллагаагаа явуулж чадах тийм чадамжийн хамгаалалттай байх ёстой. Энэ хамгаалалтыг янз янзын аргаар эвдэх оролдлого байхыг үгүйсгэхгүй. Ямар нэгэн байдлаар энэ хүнийг хэрэгт холбогдуулах гэж оролдоод хэрэгт холбогдсон тухай сэжиг л гарвал шууд татдаг байх юм бол тэр маань тэр хүнийг хэлмэгдүүлэх нэг том онгорхойг бий болгож өгнө. Нэг тэгүүлээд татсан бол дахин сонгууль шинээр явуулж байж л тэр хүн ахин сонгогдож магадгүй, эсвэл тэр хүн тэгээд дуусаа. Ар талд нь сонгогчид нэг талд нь төрийн дээд байгууллагын гишүүн хүн. Тийм учраас энэ мэтээсээ энэ одоо байдлы нь бид юу гэж байна вэ гэхээр зэрэг гишүүний халдашгүй эрх гэж нэрлээд байгаа хэсгийг хэлж байна шүү дээ.

Тэгээд дараа[чаар нь үнэхээр энүүнийг авч үзээд их хурал, их хурал зөвхөн өөрөө санаачилгаар биш, хажууд нь олон зүйл орж байгаа шүү дээ, их цаазын цэц байна, бусад санал, гомдол гаргаж байгаа газрууд байна. Шаардлагатай прокурорын хяналт байна. Эд нарын бүх шаардлагын үүднээс их хурал өөрөө энэ асуудлыг авч үзээд, үндэслэлтэй байгаа эсэх тухай асуудлыг авч үзээд, олонхийн саналаар энд үндэслэл байна гэж үзсэн тохиолдолд түүнийг гишгүүнээс эгүүлэн татаад тэгээд иргэнтэй адил болгоод иргэнтэй адил журмаар цаана нь бол одоо шүүхийн хууль хяналтын байгууллагад ердийн иргэнийх нь утгаар бол асуудал нь шийдвэрлэгдэх ийм л учир холбогдолтой юм шүү дээ. Тэрнээс биш энэ бол шүүн таслах үйл ажиллагаа огтхон биш. Шүүх эрх мэдлийг их хурал хэрэгжүүлж байгаа зүйл огт биш. Ийм л юм байгаа юм. Их цаазын төслийг ярих үед бол нэлээн дэлгэрэнгүй та бүхэнд ойлгогдох байх. Түүнээс гадна бол юу гэдгийн Ерөнхийлөгчийн одоо халдашгүй дархан байдал, нэр төрийг хуулиар хамгаална, гээд хуулинд юу гэж тусгагдав тэр ялгаа нь юу байна вэ гэдгийг чинь бид ерөнхийлөгчийн тухай хууль гээд улсын бага хурлаас гаргасан хуулин дотор түүнийг харьцангуй дэлгэрэнгүй тавьсан зүйлүүд байж байгаа, ийм л хэмжээнд л гэж. Сая бага хурлаар хэлэлцэж байхдаа аргачлалын хувьд ингээд л засгийн газрын гишүүд, түүний их хурлын гишүүд түүний, ерөнхийлөгч түүний гээд ингээд газар болгон дээр дэлгэрэнгүй юмыг нуршаад байхын хэрэг алга. Ерөөсөө энэ хуулиар зохицуулагдана гэдэг үүднээсээ хийчихнэ. Тэгээд тэрэнд нь тэртэй тэргүй одоо энэнээс дагаж мөрдөх гарах өөр дэд хууль байна, тэр хуулинд нь бол энийг жагсаагаад гаргаад тодорхойлоод өгнө. Энэ хэрхэн ямар хэмжээнд хамгаалагдаж байх ёстой юм, ямар ямар элементүүдээр нь хамгаалалт байх юм, энэ нь гараад л ингээд зохицуулагдах асуудал гэж арга зүйн хувьд бол дандаа ингээд хуулиар зохицуулагдана, хуулиар зохицуулалт нь ингээд хийгдсэн. Магадгүй үндсэн хуулийнхаа зөв болсон болов уу гэж, Үндсэн хууль тодорхой бөгөөд эрхийн нээлтийг бий болгох эрхийг нээж өгөхийнх нь үүднээс бол ингэж зохицуулаад явах нь зүйтэй юмуу гэсэн ийм л саналтай байсан юм.

-Хурлын даргад нэг асуулт, хүсэлт байна, бид нар 3, 4 хоногийн өмнө нэг иймэрхүү ярилцлага явуулж байя гээд депутатууд

яриад ерөнхийлөгч орж ирсэн, тэгсэн чинь та нараас семинар авахгүй гээд ингээд больчихсон, өнөөдөр бүр нэлээн гүнзгий семинар аваад маргааш видео хичээл заалгаад, ингээд бид нар чинь дараа нь үндсэн хуулиа яг бүлэг, зүйлээр нь хэлэлцээд явахдаа зэрэг чинь өнөөдрийн энэ асуудал чинь дахиад бүгдээрээ яригдаад эхэлнэ. Одоо бол өнөөдрийн энэ асуулт бол яаж байна вэ гэхээр үндсэндээ зүгээр миний буруу ойлголт байж магадгүй. Өнөөдрийн 6, 7, 8 цаг үндсэн бүтэн өдрийн ажил бол нэг л жаахан өгөөж муутай, үр дүн муутай болчих шиг боллоо. Энэ талаар депутат Дашням, Ядамсүрэн гуай нар санал гаргасан тэрнийг ер нь анхаарч үзсэнгүй. Би тэр саналыг дэмжиж байна. Яагаад вэ гэхлээр Г.Ончигдорж дарга арга буюу бага хурлаасаа оруулж байгаа үндсэн хуулийнхаа хүрээнд яг тэрнийхээ дагуу л хариулт өгөөд байна. Тэгэхээс өөр арга байхгүй. Санал шүүмжлэл явчих юм бол энэ чинь шал өөр болоод үр дүн өгөөж нь нэмэгдчихнэ. Ийм учраас ийм юмаа асууя. Дипломат асуулт, хариултыг болиод шууд шүүмжлэл саналдаа ормоор байна.

220 дугаар тойрог Д.Цогтбаяр:—Нэг асуулт байна. Энэ улсын их хурлын 76 гишүүний энэ ойлгоцыг гүнзгийрүүлмээр байна. Энэ чинь болбол одоогийн одоо 76 гишүүн чинь 5-6 сумын дунд тэр утгаараа бодохоор зэрэг одоогийн тэр төсөлд хийсэн тэр хошуу зохион байгуулалтад ойлгох гээд байна шүү дээ. Энийг гүнзгийрүүлж байж үүний уялдаа холбоог сайн ойлгохыг гүнзгийрүүлж өгөхгүй бол эндээс чинь одоо сонгогдох, сонгох, утгагүй тэр эрх чинь зөрчигдчих гээд байгаа юм биш биз дээ. Энэ улсууд чинь болбол хагас жилд 75 хоног чуулна гэж байгаа шүү дээ. Тэгэхээр юу гэж тэр хөдөө байж байх юм бэ, 75 хоног чуулчаад дахиад орон нутагтаа ажиллаж чадах уу, тэр хүн чинь, их хурлын гишүүд, энэ ойлгоцыг л жаахан уялдуулж гүнзгийрүүлж өгвөл миний хувьд бололцоотой байна. Өөр юм алга.

Р.Г.Ончигдорж:—Тэр сонгуулийн тойрог, заавал орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтын хилийн цэц дээс цэцтэй бол зохицож байх шаардлага шалтгаан байхгүй гэж. Ингэж үзэж байна. I-рт, тэрүүнтэй заавал уялдах ямар ч учир шалтгаан байхгүй байж болно. Сонгуулийн тойргийн цэц гэж гаргавал, сонгуулийн

тойргуудын цэ ийн хувьд бол , түүнээс гадна цаанаа одоо хошуу болгочихоод 76 хошуутай болгох гээд ингэчихсэн юм байна гэсэн их сонин ажиглалт байдал ийм байдлаар ойлговол бас тэгсэн үг биш. Нөгөө талаас олон мандаттай байх тохиолдол байж магадгүй. Сонгуулийн хуулинд тэгэх юм бол юуг гэдэг юм одоо тэгэх юм бол энэ маань бүр еер болж хувирна. Тэгээд энэ хүн сонгуулийнхаа тойрог дээр ажиллаж чадах уу үгүй гэдэг асуудал түрүүний тэр хангамж гэж хэлж байгаа асуудал энэ тэр чинь энэ парламентаа байгуулж өгчихөөд тэр парламентыг хичнээн чадвартай болгохыг нь хувьд түүнийг хэр зэрэг төсөлжилтөөр хангаж өгч чадах юм бэ гэдэгтэй холбоотой. Тэр нь байх юм бол энэ хуралдаан жилд 2 удаа хуралдаан хийдэг, хуралдаан нь бол тодорхой хугацаанд үргэлжилдэг, хуралдааны хооронд бол мөн янз янзын үйл ажиллагаа тухайн тохиолдолд өөрийнхөө тойрог дээр очиж ажиллах ийм боломжийг үгүйсгэхгүй бөгөөд ийм боломжийг бүрдүүлж өгөх асуудал өнөөдөр зөвхөн санхүү төсөв энэ л боломжтойгоо холбоотой байна шүү дээ. Тэрнээс бол энийг үгүйсгэж юм байхгүй. Би тийм учраас зарим нэг жишээ бол түрүүн татлаа. Энэ бол боломжтой. Тэр нь заавал нэг ганцхан засаг захиргааны нэгж байх албагүй л юм шиг л ийм л нөлөөлөл байгаа юм. Энэ бол сонгуулийн хуулийн хувилбарууд дээр ярьж болох юм байгаа юм.

54-р тойргийн депутат Б.Гомборагчаа: -Энэ ярилцлага бол бид нар гүнзгийрүүлж ойлгоод нэгдсэн ийм ойлгоцтой орох гэж ярилцлага, асуулт хариулт явж байгаа байх гэж ойлгож байгаа. Энэ дээр түрүүчийн хассан юмнаас би бас асуух гээд байгаа юм. 2 км би ерөөсөө ойлгохгүй байна, ойлгохгүй яагаад вэ гэхлээр зэрэг энэ орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт байна, ер нь яахав 91 оноос сумаа хошуу болгочихож. Нэрийг нь өөрчилчихож. Энүүгээр ерөөсөө аймаг, хошуу, баг байх юм гэж нэг ойлгож байна. Гэтэл төвлөрүүлж хийв гэж ингэж яриад байх юм. Тэгэхээр аймаг нь хэд байх юм, хошуу нь хэд байх юм, баг нь хэд байх юм гэж ойлгохгүй учраас ер нь хошуу болгоод хэд хэдэн хошуу болчихвол сум байхгүй болчихоод олон юм алга болчихно гэсэн ийм ойлголт яригдаад байх шиг байна. Тэгэхээр энэ хуучины төсөл явж байна. Бүр дээр үеийнхээр нь халх дорно, шавь тавар нь

авах юм уу, энэ хаврын яригдсанаар 7 аймаг болоод хэдхэн хошуу болчих юм уу, энэнээс нь хамаг учир нь ойлгогдохгүй байгаа юм. Тэгэхээр энэ тоог мэдэхгүй учираас бид ярьж чадахгүй байна. Нотолгоо байхгүй болчихоод байна. Хэрэв ерөөсөө л сум нь хошуу гээд нэр нь өөрчлөгдчихөөд явж байвал энд яриа нэлээн гарга-мааргүй юм шиг байгаа юм. Нэг дүгээр асуудал энэ, 2-р асуудалд би тэр тал хувь нь шинэчилнэ гэдгийг яаж шинэчлэхийг нь ойлгохгүй байгаа юм. Таны хариулж байгаа бол сонгогдохы нь яриад байх шиг байх юм. Би бол 76 хүн сонгогдчихжээ, Улсын их хурлын 76 хүн байна. 3 жил болчихож, 76-уулаа одоо ажил үүргээ гүйцэтгээд сууж байна. Тэгэхээр зэрэг тал жувий нь өөрчилнэ гэхлээр чинь одоо яаж өөрчлөх юм би учры нь олохгүй байна. Үндэслэлийн нь мэдэхгүй байгаа юм чинь. Эсвэл намууд нь хүнээ татаад буцаагаад авчих юм уу, эсвэл 76 хүний 50 % нь өөрчлөгдөх нь хэн хэн нь өөрчлөгдөх юм гэж хэлэх юм уу, ерөөсөө учры нь олохгүй байна. Ийм л 2 юм байгаа юм.

Р.Гончигдорж: -Бид нар зарим нэг тал дээрээ бол энэ үндсэн хуулийнхаа баталж гаргасныхаа дараачаар үндсэн хуулийгаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үед, зохион байгуулах асуудалтай холбогдсон тэр нэлээн томоохон асуудлууд байгаа байх, өнөөдөр шууд шийдчихсэн хэмжээгээр хариулт авах гээд байх юм. Тэрийг бол өнөөдөр ерөөсөө хариулт өгөх ямар ч боломж байхгүй нь бүр ойлгомжтой зүйл шүү дээ. Тэгэхээр зэрэг ер нь үлгэрлэх юм бол бид нар ямар ч байсан бидэнд энэ за яахав асуулт гарсан учраас заримтай нь ярья, би сайн ярьж чадахгүй байгаа бол зарим улсуудаа төлөөлүүлж ярина. Төлөөлүүлж ярьж болно. Ер нь зүгээр төрөөгүй хүүхдэд төмөр өлгий гэж ярьдаг шигээр ойлгож бодоод байх юм бол бас юм бүтэхгүй л байх л даа. Тэрийн хүн хүн монгол хүнийхээ ухаанаар хэллээ. Ер нь хүүгээ цэргээс ирэхлээр зэрэг гэр бүл болно гээд гэр барина гэдэг шиг. Манай улс орон цаашдаа хөгжих хөгжлийнх нь хандлагад их цааз гэсэн энэ том гэрийг бариад өгөх гэж байна. Энэ маань цаашаа гарч л аливаа зүйлд саад болохгүй байгаасай. Нэг талаас, нөгөө талаас тэр өөрөө хөгжихөд нь хууль зүйн дээд хуулийнхаа хувьд үндэс нь болж өгөөсэй гэсэн ийм л зүйлээр ярьж байгаа юм. Тэрнээр өнөөдөр 4 аймаг болгоод юу гэдэг юм 70 хэдэн хошуу болгоод ингэж зохион байгуулах гэж байгаа юмаа гээд шийд нь гарчихсан

бол шууд тэрнийгээ л энэ дотроо хийгээд өгчихөж болно шүү дээ. Тийм учраас энэ тухай асуудлуудыг огт яриагүй байна. Энэ бол цаашид яаж энэ орон нутгийн засаг захиргааны шинэчлэн зохион байгуулалтыг хэрхэн зохион байгуулж гүйцэтгэх вэ энэнийхээ дагуу яаж үндсэн хуулиа цаашид үндсэн хуулийнхаа дагуу энийг төгөлдөржүүлж, хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал ард талдаа маш их хэмжээний ажил байна. Өнөө үед ч гэсэн хэн ч хэдийд ч ямар саналаа хэлж зайлшгүй шаардлагатай үед энэ ард нийтийн дунд ямар байдлаар энэ санал асуудлуудаа хэлэлцүүлэх вэ энэ бол энэ үндсэн хуулиа хэлэлцүүлснээс илүү томоохон асуудлууд болж засаг захиргааны хуваарилалт, энэний зохион байгуулалтыг шинэчлэх асуудлууд яригдах байх, гэж л бодож байгаа. Үндсэн хуулийг хэлэлцэх зөвхөн энэ хүрээний хүрээн дотор бүх км танилцсан, км бүх кмыг хийчихсэн байх боломж бол байхгүй нь ойлгомжтой. Та бүхний эмзэглээд байгаагийн хувьд ч гэсэн энэ асуудал тийм том агуулгатай асуудал гэдэг нь ойлгомжтой байна шүү дээ. Тэргээд хийгээдхээ гэтэл үндсэн хууль нь тэрүүндээ тушаа болчихсон байгаад хийчих дээрээ үндсэн хуулиа өөрчлөх тухай асуудал руу орчихгүй байвал гэдэг нь ийм л санаа байна. Энэ л үүд байгаа тэрнээс тэн дээр бол бидэнд хэн нь ч одоо тэдэн хошуу тэдэн аймаг, 7 аймаг, 7 хошуу тэр тухай ярьж чадахгүй байх. За тэр 76 депутатын хувьд би ерөөсөө шуудхан тодорхой хэлье л дээ. 76 тойрогтой байлаа, 76 тойргоос 76 гишүүн сонгогдохлоо. Тэгвэл тойргоо 2 хэсэг хуваана. Тойргоо хоёр хэсэг хуваагаад юу гэдэг км хамгийн энгийн гэх км бол тойргуудаа дугаарлачихъя, дараачаар нь тэгш дугаартай тойргууд сондгой дугаартай тойргууд, тэгвэл 3 жилийн дараагаар тэгш тоогоор дугаарлагдсан тойргууд дээрээ дахин сонгуулиа явуулна гэсэн л үг. Тэгээд дахин сонгуулиа явуулаад тэндээс шинээр депутат сонгогдоход тэр сонгогдсон депутата сонгогдонгуут нөгөө тэнд байсан их хуралд байсан тэр тойргоо сонгогдсон гишүүний бүрэн эрх дуусгавар болоод дараагийн шинэ депутат нь энэ их хурал дээр суудлаа эзэлнэ гэсэн үг. Магадгүй тэгэхэд өмнө нь байсан депутат дахин сонгогдохыг үгүйсгэхгүй. Ийм л км. Зүгээр яагаад, ямар шинж чанараар тойргуудаа сонгох вэ гэдэг дээр бусад янз янзын газрууд янз янзын хувилбарууд байна гэж ярьдаг ишээдтэй

хөгтэй ч сонсогдож магадгүй, заримдаа бол нийт тойргийнхоо дугааруудыг оруулж хэлж байгаад тэндээ бид шодолт явуулаад шодолтоос эхний 3 жилд сонгууль явах тойргийнхоо дугааруудыг сонгодог ийм тал чиг л байна. Хэлэхэд инээдтэй юм шиг мөртлөөсөө хэрэв бид нар энэ парламентын уламжлалт байдлыг хадгалах мэргэжсэн шинж чанарыг хадгалах шинэ хуучны харьцангуй тогтолцоог хооронд нь уялдаатай явуулъя гэвэл ийм л байгаа юм. Эсвэл 6, 6 жилээрээ бүрэн эрх нь дуусаад цоо шинэ байдлаар нэг парламент үүсээд ингээд яваад байх юм бол угүйсгэхгүй. Энэ бол та бүхний шийдэх асуудал.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

Р. Гончигдорж: -Энд би хамгаалах талаас огт ярихгүй байгаа учраас миний хариултууд бол тун ерөнхий байгаа. Би ерөөсөө энэ асуудлуудыг хамгаалахын төлөө ярихгүй, энд юу гэж бодсон юм, юуг тусгасан юм бэ гэдгийг ярина. Хоёр талаас бүгдийг мэдэж байгаагийн хувьд ч би хариулахгүй. Тэгэхээр ярихаар юм бол би гишүүддээ, гишүүд энийг маш дэлгэрэнгүйгээр надаас нэлээн ухаалгаар тайлбарлаад ярьчих ийм улсууд байгаа юм.

171 дүгээр тойргийн депутат Ж. Лхагважав: -Хоёр асуулт байна. Тэгэхээр энэ Их цаазын төсөлд шүүх засаглалын тухай асуудал орсон байгаа. Энэ талаар бол ойлгомжтой нь үнэн. Дээд шатны шүүхэд 35 нас хүрсэн, 10-аас дээш жил ажилласан, хууль зүйн дээд боловсролтой хүн ажиллана, бусад шатны шүүгчээр 3-аас дээш жил ажилласан, 25 нас хүрсэн ийм хүмүүсүүдийг ажиллана гээд заачихжээ. Энэний тухайд болдог юм гэж үзэхэд шүүхийн засаглалыг юугаараа Их цааздаа оруулаад өгсөн байлаа гэхэд ард түмний жинхэнэ эрх ашгийг хамгаалах ёстой, байлгүй яах вэ, шүүх нь шийтгээд байдаг юм гэхэд хар ухаанаар ярья. Гэтэл юу гэхээр, шүүхийн хажуугаар иргэдийг чинь өмгөөлдөг өмгөөллийн байгууллага орж ирэх ёстой, байх ёстой. Тийм учраас өмгөөллийн байгууллага гэдэг Их цаазын төсөлд алинд ч орсонгүй. Тийм учраас өмгөөллийнхөө байгууллагыг шүүхийнхээ засаглалд багтаагаад оруулсан юмуу гэсэн нэг асуулт байна.

Хоёрдугаарт, Ерөнхийлөгчийг сонгох, огцруулах тухай асуудлаар би түрүүн бичгээр асуулт өгсөн. Тэр хариулсан, хангалттай болж чадсангүй гэж бодож байгаа. Жишээлбэл, ер нь сонгогчоос нь авч үзэх юм бол 14 мянган хүнээс нэг тойрог, хүн ам зүйгээс авч үзэх юм бол 25-27 мянган хүнээс нэг тойрог байгуулагдахаар ингэж бодож байгаа. Энийг юу гэхээр, Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгоно гэсэн асуудал бий. Энэ бол хуулинцаа заагаад орсон, төсөлд заагаад орсон байгаа.

Гэтэл огцруулах тухай асуудлыг Их Хурлын 76 хүний олонхийн санал буюу Их цаазын цэцийн дүгнэлтийг үндэслэн огцруулна гэж заасан байж байгаа. Би энийг эргүүлж харах ёстой асуудал болов уу гэж бодоод байгаа юм. Жишээлбэл, бидэнд өнгөрсөн жилийн туршлага байгаа. 3500 сонгогч сонгоод нэрийг дэвшүүлээд сонгогдсон 86 дугаар тойргийн депутат С.Харжаубайн асуудлыг ямар байдлаар яриад, ямар асуудал болсныг бид өөрсдөө мэдэж байгаа. Одоо 119 дүгээр тойрог дээр нэр дэвшигдээд тэнд сонгогдчихоод байгаа Цэен-Ойдовын асуудлыг өнөөдөр 15 депутатын бүрэлдэхүүнтэй Депутатын бүрэн эрхийн асуудал эрхэлсэн байнгын комисс өнөөг хүртэл тэр асуудлыг бүрэн шийдээгүй байж байгаа. Энийг ч гэсэн эргэцүүлээд бодъё. Тэгвэл юу гэхээр, 76 хүний олонхийн санал тэрэн дээр Их цаазын цэцийн 9 хүн 9-үүлээ очих юм гэхэд өнөөдөр сонгогч 14 мянган хүн байлаа гэхэд тэрнээс сонгогдсон тэр Ерөнхийлөгчийг огцруулах эрх 9 хүн, 76 хүний олонхийн саналаар шийдвэрлэж болох уу, үгүй юу? Энэ асуудлыг ялгааг нь салгаж, гаргаж тайлбарлаж өгөөч гэсэн хүсэлт байна.

Р.Гончигдорж: -Эрхэм депутат аа, би түрүүнийхээс илүү үндэслэлтэй тайлбарыг эндээ хэлж чадахгүй юм. Ер нь энэ бол нэлээн нарийн, учир зүйн зангилааных нь үүднээс энэ асуудал тавигдаад ингэж огцруулах субъект байх юм. Тэр нь бол Их Хурал байх юм гэж гарч ирж байгаа юм. Ингэх эрх хэмжээ гаргахын тулд хоёр шаттай сонгууль байгаад хоёр шаттай сонгууль хэдийгээр эхний шатандаа олонх болсон ч гэсэн Улсын Их Хурал дээр түүнийг хуульчлан батлаж байгаа энэ байдал нь эргээд түүнийг огцруулах энэ эрхийг эдлэх боломжийг бүрдүүлж байгаа, нөгөө талаас энэ зөвхөн өөрийн санаачилгаар биш тун онцгой нөхцөл байдал, тохиолдолд энэ хэрэгжих ийм хуулийн механизм нь энэ Үндсэн хууль, энэ Их цаазын төсөл дотроо байгаа юм л даа. Тэрнээс зүгээр нэг хэдэн хүн санал гаргаад, энийг огцруулъя гээд огцруулах, Ерөнхийлөгч үүргээ биелүүлж чадаж байна, чадаагүйн тухай асуудал дээр ч энийг дүн шинжилгээ хийгээд огцруулах тухай огт биш. Энэ бол Ерөнхийлөгч өөрийнхөө тангаргаас

няцсан, гэмт хэрэг үйлдсэн тэр онцгой тохиолдолд Их цаазын цэцийн үндэслэл гарсан ийм байдалд Их Хурал авч хэлэлцээд ингээд энэ Ерөнхийлөгчийг огцруулах тухай асуудал ярьж байгаа юм. Зарим тохиолдолд бусад газруудын хувьд, бусад дэлхий нийтийн улсын хувьд ч гэсэн ийм байдал болоод импичмент гэдэг тэр байдлаар Ерөнхийлөгчийн эрхийг зогсоодог, дуусгавар болгодог янз янзын механизмууд байна. Эрдэмтэн улсууд ч гэсэн энэ байдлуудыг санал болгож гаргаж л байна. Бага Хурлын гишүүдийн санаанаас гарсан зүйл! болов уу гэж хүндэтгэж авч үзвэл энд нэлээн учир зүйн сүлжээ байгаа юм шүү. Эрхэм депутатууд минь еерсдөө харж үзээрэй. Тэгэхгүй бол Ерөнхийлөгчийн ард түмнээр огцруулна гэвэл Ерөнхийлөгчийг огцруулах нэг сонгууль явуулж л таараа даа. Тэгвэл тэрнийг хэн явуулах, хэн зарлах ёстой болох вэ? Тэгвэл тэр зарлах эрх Их Хуралд орж ирнэ гэдэг бол бас л ялгаа байхгүй Их Хурал огцруулах санаачилгыг гартаа авч байгаа тухай асуудал шүү дээ. Түүнээс гадна тэгээд эцсийн эцэст шүүх эрх мэдлийг шүүхээр хэрэгжүүлэх, хууль тогтоох эрх мэдлийг Их Хурлаар хэрэгжүүлэх гэх мэтчилэн эрх зүйнхээ ийм л зүйлийг гаргаад ирсэн. Тэгээд иргэдийгээ энэ эрх мэдлийг төлөөллийн байгууллагаар оролцох ёстой гээд бид нар тунхаглаж байгаа Үндсэн хуульдаа баталж байгаа бол энэ учир зүй энд бүрнээ нийцэж байгаа юм байна гэсэн ойлголтоотой байгаа юм, Бага Хурал дээр.

186 дугаар тойргийн депутат Р.Чойжинням: —Би ганцхан хүсэлт тавих гэсэн юм. Тэгэхээр бид Үндсэн хуулийн төслийн талаар Ерөнхийлөгчөөс, дэд ерөнхийлөгчөөс нэлээн тодорхой асуулт, хариултын журмаар семинар авч байна. Тэгэхээр энэ дээр бидний ойлгоогүй зүйл дээр нэлээн ойлгож авч байна.

Нөгөө талаар ерөнхий шүүмжлэлийн дараагаар бид нар зохих хариулт авах болов уу гэж бодож байна. Ингээд юу өгөхийг хүсч байгаа юм бэ гэх юм бол, бид нар жинхэнэ депутатынхаа эрхийн дагуу, цаанаас сонгогдсон хөдөлмөрчдийг төлөөлж жинхэнэ саналаа бүлэг зүйл болгон дээр санал гаргана. Энэ үед л жинхэнэ тэр хариулт, урьдаас тайлбар битгий тавиасай гэдэг ийм хүсэлт тавих гэж байна. Энд бид санасан санаагаа, хөдөлмөрчдийнхөө хүсэлтийг тухайн үедээ тавина. Энэ дээр хариу

тайлбартай болчих юм бол өнөө дээрээс, өнөө санаагаа тулгасан ийм хэлбэрт орчих гээд байна. Чи энийг юунд ингэж яриад байна вэ гэхээр бүсийн зөвлөлгөөн дээр бид хөдөлмөрчдөөрөө, сонгогч нараараа хэлэлцүүлсэн асуудлаа авчирч өгсөн. Өөрсдөө тэр товчилсон санал бодлоо тавьсан. Гэтэл баахан тайлбар урьдаас сонсоод очсон хойно малчин, ажилчин, сэхээтэн улсууд надад "та энэ саналаа энэ Үндсэн хуулийн төсөлд тусна" гэж бодож байна уу гэж надаас асууж байна. Та бүх тайлбар авчихаад ирсэн тэр тусахгүй гэж ярьж байсан.

Бага Хурлаар ороод гарсан төсөлд хэд нь тусав гэж та бодож байна. Та тайлбараа аваад ирсэн одоо тулгалт чинь тэрэн дээрээ гараад ирсэн, одоо ингээд дуусна шүү дээ гэж.

Тэгвэл бид нар одоо өргөн хэмжээгээр явагдаж байгаа, хөдөлмөрчид сонсч байгаа энэ үед жинхэнэ биднээс санал гаргах тэр зүйл дээр тайлбар битгий хэлээч. Одоо жинхэнэ саналыг маань, депутатуудын хэмжээнд / олонхийн саналаар байдаг юмуу, нэрсийн жагсаалтаар авч тасалж байгаач ээ гэдэг хүсэлт тавих гэсэн юм.

Р.Гончигдорж: -Би ямар нэгэн семинар явуулж байгаа гэж ойлгохгүй байгаа шүү. Дэгийн дагуу энд асуултад хариулж байгаа. Семинар явуулж байгаа бол би өөрөөсөө хамаагүй илүү мэдлэгтэй, чадвартай улсуудаар хийлгүүлнэ. Ийм зориг байхгүй.

Улсын Бага Хурлыг нэг хүний нэрээр төлөөлөх ямар нэг төлөөллийн хэлбэр эрх мэдлийнхээ хувьд Улсын Бага Хурлын дарга гэдгийнхээ өмнө та нарын өмнө Бага Хурлаа төлөөлөөд зогсч байна. Тэр хэр хэмжээндээ та бүхэнд хариулж байгаа юм. Тэрнээс семинар өгөөд, тулгахгүй гэдэг тэр хязгаарын би өөрийгөө барьж, хариултаа хязгаарлаж байгаа гэж ойлгож байгаа. Та бүхэн ямар нэг тийм шинж гарвал битгий түүнд тулгагдаарай.

157 дугаар тойргийн депутат Л.Одончимэд: -Би семинар явж байна гэж бодохгүй байна. Өнөөдрийн энэ асуулт, хариулт бол их ач холбогдолтой зүйл болж байна гэж бодож байна.

Гэхдээ асуух юм их олон байсан, зогссоор байгаад заримыг мартаад одоо гурван юм асууя.

Сэтгэл зовоож байгаа, данцаа бодлоос гарахгүй юмнууд байна. Маргааш үзүүлэн таниулахдаа нэлээн сайн ойлголт өгөх юм шиг байна. Гэхдээ өнөөдөр, тэрнээс наана дахиж асуумаар санагдаад байх хоёр, гурван юм байна. Энэ улсын нэр, хуулийн нэр, төрийн сүлд, далбаа, сүлд дууллыг заавал өөрчлөхийг хэн шаардаад байгаа юм бэ? Энэ зах зээлд ороход дараа болоод байгаа юмуу, өмч хувьчлахад дараа болоод байгаа юмуу, гадагшаа алт гаргахад дараа болоод байгаа юмуу? Ерөөсөө энийг би ойлгохгүй юм. Хэрвээ энд сонгогдсон 427 депутатыг ард түмний төлөөлөгч гэж үзэж байгаа бол одоо энэ депутатууд энийг өөрчлөөд ирээрэй гэсэн даалгавар сонгогчдоос авсан хүн хэд байгаа юм бэ гэж би асуумаар байна.

Тэгэхээр Гончигдорж дарга, энийг шинэчлэхгүй бол үнэхээр болохгүй болсон юм гэдгийг нэг сайн ойлгуулж өгөхгүй бол би маргааш ерөнхий хэлэлцүүлэг болон тэр хичээлийг чинь үзээд ч ойлгохгүй шинжтэй байна. Энийг нэг хариулж өгнө үү, Гончигдорж дарга аа. Би өчигдөр бичгээр өгсөн. Тэгээд энэ тухай олон хүмүүс асуусан болохоор хүмүүс энийг үнэхээр сонирхож байгаа. Өчигдөр манай Маам багш тэр нарыг "коммунизмын улаан нар" гэсэн би ертөнцөд нэг нартай гэж бодож явдаг. Тэгэхээр хаана, юу гэж бичсэнээрээ бид ойлгодоггүй. Монгол хүн нарыг нэг л гэж ойлгодог. Яагаад гэвэл, нарыг дагаж амьдардаг монголчууд бол.

Хоёрдугаарт, хоёр танхимтай парламентын засаглал тогтоох тухай ярьж байгаа, олон хүмүүс ярьж байгаа. Энийг би Гончигдорж даргын ярианаас би сайн ойлгож чадсангүй. Энийг юу гэж үзэж байгаа вэ гэдэгт хариу авмаар байна.

Гуравдугаарт, түрүүн Гончигдорж дарга хариулахдаа ард түмэн гэж, ард түмэнг төлөөлж чадаж байна уу, үгүй юу гэдгийг хоёр аргументаар гэх юмуу, хоёр янзаар ойлгоно гэж нэлээн удаан тайлбарласан. Бид нар бол амлалтын депута-

тууд ч гэдэг, томилолтынх ч гэдэг, янз бүрээр нэртэй. Гэхдээ бидний ард хэдэн хүн байгаа. Энэ улсууд биднийг тэр ард түмнийг төлөөлсөн, монголын бүх ард түмэн тойргийн хэсэгт хуваагдаад депутат болж бид нарыг гарсан гэж бодож байгаа. Биднийг ард түмнээ төлөөлж үгээ хэлж чадаж байна. Ард түмний төлөөлөгч гэж үзэж байгаа юу, үгүй юу. Ийм гурван юмыг танаас асуух гэсэн юм.

Р. Гончигдорж: -Өнөөдөр улсын нэрийг, төрийн сүлдийг, төрийн дууллыг, далбааг монгол улсын өнөөдрийн байгаа удирдлагууд ямар нэг юмтай дэнчин тавьж худалдчихаагүй байгаа. Энэ утгаараа гаднаас тийм шахалт шаардлагад орсон юм байхгүй бөгөөд энэ шалтгаан нь энийг солих шалтгаан гэж үзэхгүй байна. Огт үзэхгүй байна.

Манайх 1924 онд Ардын хувьсгал ялж төрийн тусгаар тогтнолоо олох үед өмнө хэрэглэж байсан туг далбаагаа ямар үндэслэлээр сольж байсан юм, 1960 онд яагаад сүлдээ сольж байсан юм. Үүнтэй адилтгах хүчин зүйлийн шалтгаан өнөөдөр манай төрийн тогтолцоо, төрийн байгуулал дахь улс орны хөгжлийн шатанд үүсч үү, үгүй юу гэдэг энэ асуудлын үүднээс ярьж байна. Өөр ямар ч шалтгаан алга.

Хэрэв бид нар жишээлбэл, хуучин Үндсэн хуулийн зүйлээр БНМАУ-ын төрийн сүлд бол төрийн мөн чанар, улс түмний найрамдлын эрх ашиг, тус орны үндэсний болон эдийн засгийн онцлогийг үзүүлэн тусгах ёстой гэдэг энэ үзэл баримтлалаар бид өнөөдөр авч үзэх үү, эсвэл өөр үзэл баримтлалаар энд тусгаж, бэлгэдэл юуг илэрхийлэх ёстой вэ гэдгийг авч үзэх үү? Өнөөдөр бид нар, жишээлбэл, социалист реализмын аргаар энэ бэлгэдлийг дүрслэх ёстой гэж үзэх үү, эсвэл өөрийнхөө ёс заншил, түүх уламжлалаар бэлгэдлийгээ хэрхэн дүрслэх вэ гэдэг тэр арга зүйн үүднээс авч үздэг юмуу, энэ олон хувилбаруудыг та бүхний окуны өмнө дэлгэж байна. Тэр байдлаас нэг төслийг тодорхой санал болгоод тавьж байна. Тэгээд та бүхэн энэ дээр оюн бодол, арга зүйгээсээ авч үзэх ёстой. Тэрнээс тулгаж байгаа юм байхгүй. Энийг заавал солихгүй бол одоо ямар нэг цөмөрчих гээд байгаа, нөмөрчих гээд байгаа юм байхгүй. Байхгүй.

Тэгэхээр эцсийн эцэст бэлгэдэл гэдэг, туг гэдэг, дал-
баа гэдэг, сүлд гэдэг юм юуг илэрхийлдэг юм. Илэрхийлэх
шинж чанар өнөөдөр чанарын өөрчлөлтэнд орж уу, үгүй юу гэдэг
л асуудал байна. Энийгээ та бүхэн өөрсдөө бодоцгоо. Өөр хэлэх
юм алга.

Хоёр танхимтай байх тухай асуудлыг ярьж байгаа. Улсын
Бага Хурал дээр хоёр дахь хувилбар болгоод тавигдаад яриг-
даж байсан асуудлууд байна. Ганцхан хоёр танхим гэдгийг
өнөөдрийн Их Хурал, Бага Хурал байгаа шиг ингэж үүсгэн
байгуулагдсан шиг энэ утгаар бол энийг хоёр танхим гэж
ойлгож болохгүй шүү гэдгийг ганцхан хэлсэн. Тэрнээс хоёр
танхим зэрэгцэн оршоод харилцан үл хамааран хоёулаа бай-
гуулагдаад тэдгээр хууль тогтоох үйл ажиллагаандаа оролцох
оролцлогооны шүтэлцээнд ингэж байгуулагдаад төлөөллийн шинж
чанар нь аль аль нь ямар ямар байдлаар илэрхийлэгдэх вэ,
хугацаа нь ямар байх вэ энэ бүх зохицолгоо хийгээд ингээд
хоёр дахь хувилбар байхыг үгүйсгэхгүй. Энэ бол дэлхийн
практик өнөөдөр байж байгаа, хэрэгжээд явж чадаж байгаа
ийм л нэгэн зүйл. Нэг танхимтай нь бас л адилхан хэрэгжээд
явж байгаа, ингээд явж байгаа зүйл. Энэ бол улс төрийн
шийдлийг л бид нар энэ дээр хийх гэж байгаа юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Тэгээд дараачаар нь нэг танхимтай байхдаа уламжлал шинэчлэлийн асуудлыг авч үзэх үү, эсвэл хэсэг хэсгээрээ таслагдаад явдаг ийм парламентын шинж чанарыг хүлээж авах уу та бүхний л шийдэх асуудал, бас л улс төрийн л шийдэл. Цаана нь байдаг шинжлэх ухааных нь хувьд аль аль нь байж болдог гэдгийг аль ч эрдэмтэн аль ч эрдэмтнийхээ өмнө сөргүүлж тавиад үгүйсгэчихээгүй ийм л зүйлүүд байх юм. Ийм л юм байна.

-Ард түмнийг төлөөлөх тухай асуудал бол би түрүүн өөр зүйл дээр хэлсэн гэж бодож байна. Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг хийж байхад ард нийтийн санал асуулгын үед ард түмнээс иргэдээс ирсэн саналын **процентыг** ард нийтээр саналын асуулга авсан юм шиг шууд тусгал болгож авч үзэх үү үгүй юу гэдэг дээр би шинжлэх ухааны хариулт өгч чадахгүй гэдгээ л хэлсэн шүү дээ. Энэ бол ирсэн саналуудын дотор эзлэх хувь гэдэг ийм томъёоллоор нь хэлэх ёстой. Би тэр энгэр дээр байгаа нэг хонийг наад талаас нь хараад хар хонь байна гэж хэлж чадахгүй. Яагаад гэвэл цаад бөөр нь цагаан байвал яах юм бэ. Тийм учраас бидэнд ямар хэмжээнд ямар мэдээлэл ирэв тэрнийгээ хэлэхээс биш энэ бол ард түмэн тэгэж байна гэдэг үгээр хэлэх зүрх нэгдүгээрт байхгүй. Харин ард нийтийнхээ дунд санал асуулга явуулаад санал асуулгаа хууль журмын дагуу явуулаад дүн гараад ирсэн бол энэ дээрээ нийт ард түмний сонгогчдын маань тэдэн хувь нь тэгэж, тэдэн хувь нь ингэж гэдгийг хэлж болох л зүйл шүү дээ. Ийм л зүйл байна.

Эрхэм депутатууд бол мэдээж хэрэг өөрийнхөө сонгуулийн тойрог дээр өөрийнхөө сонгогчдоос төлөөлөөд өөрийн чинь сонгогчид та бүхнийхээ төрийнхөө төлөөлөгчдийн эрх барих дээд байгууллагадаа сонгоод явуулсан ийм төлөөлөгч шүү дээ. Үүнийг хэн ч тэр эрх тэр статус тэр эрхийн онцгой байдлыг түдгэлзүүлээгүй, татгалзуулаагүй, хориглоогүй, тийм учраас та бүхнийг сонгогчдынхоо бүрэн эрхт төлөөлөгч гээд хамтран хуралдаж байгаа

шүү дээ. Үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй.

-Тэгэхлээр санал асуулгаа явуулдагаа явуулаад, сонгуулиа явуулаад Их хурлын өмнө сонгогчидтойгоо уулзаад, тэгээд захиа даалгавраа аваад ирсэн байгаа шүү дээ. Ийм учраас биднийг зүгээр социологийн судалгаагаар авсан анкеттай битгий зүйрлээч ээ Гончигдорж даргаа. Бид нар чинь амьд улсуудтайгаа уулзаад ямар ч шинжлэх ухаан хэрэггүй, өдөр тутмынхаа амьдралаасаа амьдарч явж байна шүү дээ. Тийм учраас би үүнийг л хэлэх гэсэн юм.

Гончигдорж - Өөрөөр хэлбэл зарим депутатууд өөрийнхөө тойргийн бүх сонгогчдын дунд санал асуулга явуулсан юм байна л даа. Үүнийг би бол буруу зүйл ч гэхгүй, зөв ч гэхгүй, тэрнийхээ үндсэн дээр хэлж байгаа юм. Гэтэл зарим сонгогчид маань депутат маань өмнө нь ирэхдээ уулзсангүй ээ гэж хэлж байна. Тэгэхлээр нэг депутат юмуу хэсэг депутатын хийсэн санал асуулгыг бол бүгдийг санал асуулга хийчихжээ, тийм учраас үүнийг нэгтгээд Монгол улсын хэмжээнд санал асуулга болгоод тавьсан гэдэг тухай ярихгүй байгаа шүү дээ. Эрхэм депутатууд аа. Тийм учраас депутат болгон үнэхээр өөр өөрийнхөө сонгогчдын саналыг яаж авсан юм бэ, тэр яаж хэлж байгаа юм тэрнийгээ мэдээлээд өөрийнхөө саналыг илэрхийлье. Энэ бол миний хариулах зүйл ч биш, миний маргалдах зүйл ч огт биш.

Ж. Уртнасан - Уучлаарай депутатууд аа. Бидэнд та бүгдээс санал авмаар байна. Одоо 7, 1, 3, 4-р микрофоноор дөрвөн депутат байна. Бид нарт бас нээлттэй орхисон хоёр эгзэгтэй асуудал бий. Дээр нь өнөөдрийн дотор багтаж та бүгдийн сонорт хүргэхийг шаардсан хөдөлмөрчдөөс ирсэн зарим мэдээлэл, шаардлага, захидал, цахилгаан зэрэг олон зүйлүүд байна. Ийм учраас микрофоны ард байгаа хүмүүсийн нэрийг бичээд маргааш өглөө үргэлжлүүлэх нэг хувилбар байна. Эсвэл олонхийн санал гарлаа гэж бодоод асуулт хариултыг таслах санал байна.

Санал хураалт явуулъя. Томьёоллыг та бүхний сонорт хүргэе.

Ер нь сайн асууж, сайн танилцаж авах явдал бидний цаашдын хэрэгт их нааштай болох боловч ер нь гол нь бид асуух ёстой зүйлүүдийг асууж амжлаа гэж ойлговол санал хураалтанд бэлтгэж болж байна уу. За баярлалаа. Санал хураалт явуулъя. Одоо асуулт хариултыг таслая гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

-Өнөөдрийнхийг таслах гэж байна уу, бүр маргааш бүрмөсөн таслах гэж байна уу?

Ж.Уртнасан -Бүрмөсөн.

Ж.Уртнасан -Асуулт хариултыг таслая гэдэг саналыг санал өгсөн депутатуудын 88 хувь нь зөвшөөрч байна. 12-^{ХУВЬ} буюу 35 хүн татгалзлаа. 2 хувь буюу 6 хүн тэдгэлзэж байна. Ингээд цөөнхийг сонсож олонхийн саналаар шийдвэрлэдэг зарчмаар энэ асуулт хариултыг таслая.

хөдөлмөрчдийн захидал, цахилгаан мэдээллийг орлогч дарга Батбаяр уншиж сонсгоно.

Батбаяр – Эрхэм хүндэт депутатууд аа. Өнөөдрийн хуралдаанд уншиж танилцуулахыг хүссэн иргэд, байгууллага, хамт олноос ирсэн нэлээд олонхзүйл байна. Санаа давхардсангуудыг хасаад тоймлож уншъя. Тэгэхгүй бол нилээн олон минут унших юм шиг байна.

АИХ-ын II хуралдааны нэр дээр байгууллага, иргэдээс бичгээр 5, цахилгаанаар 3, утсаар 55, хүлээн авах байраар 13 хүн ирж санал хүсэлт тавьсныг тоймлон дурдвал:

– Говь-Алтай аймгийн Бугат сумын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга Алтангэрэл, Завхан аймгийн Шилүүстэй сумын тооцооны кассын эрхлэгч **Жамбалжамц**, Хэнтий аймгийн **Дадал** суман дахь Амралт сувиллын дарга Даржаа, Хөвсгөл аймгийн Ой, модны үйлдвэрийн дарга Сүрэнжав, Найрамдлын районы 16-р хорооны иргэн Дүгэржав, Сүхбаатарын районы 29 дүгээр хорооны иргэн Дамба нар хуралдааны **ажилд** амжилт хүссэн байна.

Мөн нилээн олон иргэд хуралдааны ажиллагааг радио, телевизээр явуулах хугацааг нэмэгдүүлэхийг хүссэн байна.

-Хэнтий аймгийн Дадал сумын Рашаан сувиллын дарга Даржаа хурлын ажиллагааны тоймыг сонсож байхад зохион байгуулалт, дэг журам муутай, ялихгүй зүйл дээр хэт маргалдаж, цаг их үрж байгаад сэтгэл дундуур байна. Хотын депутатуудын хувьд хөдөөгийн амьдрал мэдэхгүй байж хөдөөгийн депутатуудад бодол санаагаа шууд тулган хүлээлгэхээр дайрч давшилж байгаа хандлага байна. Хурал дээр Хэнтий аймгийн депутатуудын дуу хоолой сонсогдохгүй байна.

-Улаанбаатар хотын Барилга хөрөнгө оруулалтын газрын ажилтан Даваажав, Дорнод аймгийн Чойбалсан хотын 9 дүгээр хорооны өндөр настан Долгор -Депутатууд их маргалдаж байна. Хуулиа дээдэлж хүндлэх талаар анхаарах.

-Булган аймгийн **прокурор** Цоодол утсаар: -Эхний өдрийн хуралдаан дээр депутат Цэен-Ойдов прокурор биднийг гүтгэлээ. Тэр үед **сонгогчдын дунд** Цэен-Ойдовын нэр хүнд муу байсан, Цэен-Ойдов сонгогчдын захиа даалгаврыг яаж биелүүлж байгаа, итгэл найдварыг хир зэрэг хүлээж байгааг шалгах нь зүйтэй. АИХ-ын хуралдаанаас депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн ямар үндэс байгааг тодруулж өгөхийг хүссэн байна.

-Октябрийн районы 25 **дугаар** хорооны өндөр настны зөвлөлийн дарга Чойдог утсаар -Манай тойргийн депутат Ламжав сонгогчидтойгоо уулзахгүй байна. Хөөцөлдөж байж 5 дугаар сард нэг удаа уулзалт хийсэн. Түүнээс хойш депутат Ламжав бидэнд ямар ч хариу өгөөгүй, уулзаж санал бодлоо ярихаар 4,5 удаа урьсан боловч ирж уулзаагүй. Хуралдааны эхлэлийн байдлаас удааширч сунжрах төлөвтэй байна. Иймд депутатууд ард түмэн биднийхээ төлөө хэлэлцэж байгаа асуудалдаа буурь суурьтай хандаж, амьдралд нийцсэн, **хэрэгжих** шийдвэр гаргахыг хүсч байна.

-Эсгий, эсгий гутлын үйлдвэрийн токарьчин Буяннэмэх нарын 6 хүн: -Депутатууд бидэнтэй уулзаагүй боловч манай

сонгогчдын санал ийм байна гээд өөрийнхөө бодлыг ярьж байгааг анхаарах.

-Октябрийн районы 6 дугаар хорооны иргэн Гантөмөр - Депутатууд ямар ч бэлтгэлгүй иржээ. Ингэж ялихгүй зүйл дээр маргалдаж цаг үрээд байх юм бол 21 хоногт багтахгүй. Хэрэв энэ хугацаанд багтахгүй бол илүү гарсан хоногийн зардлыг депутатуудаар төлүүлэх хэрэгтэй.

-Хөвсгөл аймгийн Ой, модны үйлдвэрийн дарга Сүрэнжав: АИХ-ын депутатууд цагийг үр бүтээлтэй, зөв ашиглах, асуудалд хандахдаа ард түмний эрх ашгийг юун түрүүнд анхаарах. 80 гаруй сая долларын өрийг яаж шийдэхийг ард түмэн энэ хуралдаанаас хүлээж харж байна. Иймд энэ асуудлыг шийдээд ард түмэнд мэдээлэх.

-Сүхбаатарын районы 33-р хороо, Бэлхийн 18-ын 341 тоотод суудаг Тумбааш хүлээн авах байраар: -Төрийн ордонд хуралдаанаа хийж байгаа депутатууд маань монгол түмнийг төлөөлж байгаагийн хувьд хэлэлцэж буй асуудлууддаа ихээхэн нухацтай уужуу ухаанаар хандахыг хүсч байна.

-Их цаазтай холбоотой нилээд олон асуудлууд байна. Өндөрхаан хотын I-р хорооны өндөр настан Наваанбалдан, Сүхбаатарын районы 3-р хорооны иргэн Пагамдулам, Октябрийн районы 27-р хороо, 28-р байр, 4 тоотод суугч өндөр настан Сосорпүрэв, мөн районы 35-р хорооны өндөр настан Жигжиддулам, Хандмаа нарын 15 хүн утсаар -Олон улсын хэмжээнд монгол улсын нэр, далбаа тарсан учир БНМАУ-ын нэр, сүлд далбааг хэвээр байлгах, газрыг гадаадын хүмүүст түрээслүүлэхгүй байх.

-Сүхбаатарын районы 8-р хороо, 15-р байр, I-ийн 5-д суугч Ш.Баяраа утсаар: -Үндсэн хуулийг Их засаг гэж нэрлэх, улсын нэрийг Монгол улс гэж нэрлэх.

-Октябрийн районы 35-р хорооны иргэн Пунцагнамжил утсаар:

Газрыг улсын өмчид байлгах, ерөнхийлөгчийг бүх ард түмнээр сонгох.

-Сүхбаатарын районы 33-р хорооны дарга Хадбаатар утсаар: Засаг захиргааны зохион байгуулалтын хувьд районыг хороо, хороог хорин болгоно гэдгийг зөвшөөрөхгүй.

-Октябрийн районы 37-р хорооны иргэн өндөр настан Жигжиддулам, Хандмаа, Долгор нарын 15 хүн, мөн районы 26-р хорооны иргэн Баасанжав: -Цагаачлах асуудлыг Үндсэн хуульд оруулахгүй байх, ойрын 2-3 жилд ерөнхийлөгчийн засаглалтай байх.

-Сэлбэ амралтын ахлах тогооч Дүгрээ, гэр бүл Лхагваагийн хамт утсаар: -Төрийн сүлд, далбааг хэвээр байлгах, хэрэв өөрчилбөл моринд нь хоёр жигүүр хийх.

-Октябрийн районы 25-р хорооны иргэн ахмад зүтгэлтэн Зундуй утсаар: -Сүлдийг өөрчлөх гээд байгаа хүнд арга хэмжээ авах.

-АБЯ-ны Монгол бичиг сургалтын төвийн мэргэжилтэн Хүрэлсамбуу: -Үндсэн хуулинд монгол бичиг нь улсын бичиг мөн гэсэн санааг оруулах. Энэ бол зайлшгүй байх **ухагдахуун гэж** үзэж байна.

-Октябрийн районы 6-р хорооны иргэн Гантөмөр: -Үндсэн хуулийн нэрийг Их засаг гэж нэрлэх.

-Сүхбаатарын районы 6-р хорооны иргэн Цэдэнпил: -Улсын нэрийг Монгол улс, Үндсэн хуулийг Их цааз гэж нэрлэх.

-Завхан аймгийн Шилүүстэй сумын тооцооны кассын эрхлэгч Жамбалжамц: -Үндсэн хуулийн нэрийг Монгол улсын их цаазат хууль гэх. Төрийн сүлдэнд хүн, морь, нар, сар, гал энэ тавыг заавал оруулах.

-Сүхбаатарын районы 5-р хорооны өндөр настан Бадамдорж: Үндсэн хуулийн нэрийг хэвээр байлгах, хэрвээ заавал өөрчлөх шаардлагатай гэвэл Их засаг гэж нэрлэх. Улсын нэрийг БНМАУ гэх. Газрыг өмчлөхгүй байх, хүчтэй ерөнхийлөгчийн засаглалтай байх.

Засаг захиргааны зохион байгуулалтыг хэвээр байлгах. Шарын шашныг төрийн гол шашин байхаар заасан гол саналуудыг ирүүлжээ.

-Дорнод аймгийн Улсын хянан байцаагч Лхүндэв, Сүхбаатарын районы 29-р хорооны иргэн Цэвгээ, Дамба нар: -Төрийн сүлдэнд шувуу хэрэггүй ээ. Учир нь цагаан сүүгүй амьтан.

-Дорнод аймгийн улсын хянан байцаагч Лхүндэв: -Хуулийн нэрийн талаар ард түмний саналыг харгалзан шийдвэрлэх. Төрийн далбааг цогт хунтайжийн үед хэрэглэж байснаар байлгах.

-Найрамдлын районы II-р хороо, Булгачны 3-ын 50-д суудаг Лодойбалдан: -Үндсэн хуулийн нэрийг хэвээр байлгах, сүлд далбааг энэ удаа өөрчлөх шаардлагагүй. Засаг захиргааны нэгжийн хувьд сум, багийг даргатай байлгахаар тусгах. Аймаг, сум, районыг депутаттай, хуралтай байлгах. Иргэний үүргийг нэмж өгөх, тухайлбал заавал хөдөлмөр хийх үүрэгтэй гэж оруулах.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Хвгенов

/Д. БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

Н. Батбаяр: /Ардын Их Хурлын орлогч дарга/: -Газрыг гадаадын иргэнд түрээсээр эзэмшүүлэхэд 25 жилээс илүүгүй байхаар оруулж, иргэдийн хувийн хашаа, байшин барьсан газрыг үнэгүй эзэмшүүлэхээр тусгах. Сүхбаатарын районы 2 дугаар хороо, 24 дүгээр байр, 35 тоотод суудаг Ганбаатар. Үндсэн хуулинд төрийн гурван засаглалыг тэнцүү хуваарилах, тэнцүү байхад ихээхэн анхаарч шийдвэрлэх. Сүхбаатарын районы 10 жилийн 2 дугаар дунд сургуулийн багш Болд. Их цаазын төслийг хэлэлцэхдээ уг төслийг боловсруулсан комисс, Улсын Бага Хурлын саналыг эхэлж сонсох хэрэгтэй.

Октярийн районы 31 дүгээр хорооны иргэн Осор. Хэвлэлийн эрх чөлөө гэдэг нэрийг дор Ерөнхийлөгчийг шоглосон зураг гаргаж болохгүй гэсэн заалтыг Их цаазад шууд тусган Ерөнхийлөгчийнхөө нэр хүндийг хамгаалах асуудлыг хуульчилж өгөх. Ерөнхийлөгч нь 50-иас дээш насны монголын гурван үе дамжсан хүн байхаар Их цаазад оруулах.

Сүхбаатар дүүргийн 28 дугаар хорооны иргэн Найдан. Хуулийнхаа төслийн үг үсэг, өгүүлбэр бүрийн ил, далд утга санааг тунгаан тооцож, сэтгэл хөөрөлгүй тав тухтай хэлэлцэх. Төрийн сүлдийг таван хошуу малын дүртэй хуучин байдлаар нь хийх, Монгол улсын эдийн засгийн үндэс болсон таван хошуу малаа шүтнэ. Далбааны өнгийг цэнхрээр, соёмбо, тэмдгийг хэвээр үлдээх. Монгол улсын нэрийг БНМАУ, нийслэл Улаанбаатар хот, Үндсэн хууль гэсэн нэрийг хэвээр үлдээх.

Монголын улс төрийн хэлмэгдэгчдийн холбооноос дараахь уриалгын санааг ирүүлжээ.

Сүүлийн 70 жилд монгол үндэсний соёл, хүний эрх чөлөө, сүсэг бишрэл, нашин шүтлэг хамгийн ихээр хэлмэгдсэн гэж дурдаад Монгол бичгийг монгол улсын төрийн бичиг мөн гэж тогтоох, хүний эрхийг дээдлэн хүндэтгэж хэлбэрэлтгүй мөрдөхөд

Их цаазаараа баталгаажуулах, хэлмэгдэгчдийн алдагдсан эрхийг сэргээж, амссан хохирлыг бүрэн арилган, нийгмийн шударга ёсыг дээдлэхийн хамт алах ялыг халах боломжийг бүрдүүлэх гэсэн саналуудыг тавьжээ.

Мөн ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Танхимуудын дарга нар Алимжанов, Любимчика нар БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасанд илгээмж ирүүлсэнийг өнөөдөр тус улсад суугаа элчин сайд Ситников гардуулсныг уншиж сонсгоё.

БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан танаа. Хүндэт нөхөр Жамбалдоржийн Уртнасан, Таныг БНМАУ-ын Ардын Их Хурлын даргаар сонгогдсонд тань баяр хүргэе. Хоёр орны парламент хоорондын харилцаа цаашид улам хөгжинө гэдэгт итгэж байгаагаа илэрхийлж байна. Шинэ алба хашихдаа амжилт гаргахыг хүсэн ерөөе гэсэн ийм цахилгаан ирүүлжээ.

За энд бас нэг зүйл байна. Нэлээн уртхан юм байна. Бүгдийг унш гэж шаардлага тавьсан юм байна. БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, 281-ийн холбооны ерөнхийлөгч Ш.Гүрбазар танаа: Бидний энэ шаардлагыг хавсралт баримтыг чуулганд оролцогчид болон, депутатуудад уншиж сонсгохын хамт орон даяар радио, телевизээр нэвтрүүлж ард түмэнд сонсгож өгөхийг хүсэж шаардаж байна гээд ардаа бас нэлээн шаардлагатай юм байна.

Ж.Уртнасан - Гүрбазараар дамжуулаад энэ бүх депутатуудын сонорт хүргэе гэсэн шаардах хуудас учраас бид ингэж байгаа юм. Ер нь зүгээр бид сонсох шаардлагагүй, Гүрбазар ажлын групптэй ярилцаж шийдэг гэвэл энийг заавал унших хэрэггүй юм. Нөгөө Отгонбаярын хэрэгт холбогдсон цагаатсан хэдэн хүн өлсгөлөн зарлана гэсэн ийм эцсийн утга нь тийм юм байна билээ. Маргааш өглөө өлсгөлөн зарлаж эхэлнэ гэсэн ийм тулган шаардах бичиг байгаа юм. Энийг сонсох шаардлага байна уу? Гүрбазар депутат нэг тайлбар тавихгүй юу.

Ш.Гүрбазар /167 дугаар тойргийн депутат/ -Энэ өнөөдөр үдээс хойшийн хуралдаан үргэлжилж байх хугацаанд Ардын Их Хурлын депутат Гүрбазар танаа гэсэн ийм бичиг ирсэн юм л даа. Тэгээд энийг Ардын Их Хурлын чуулганы нийт депутатуудад сонордуулж өгөөч, тэгээд маргааш өглөө 10 цагт хүлээх байран дээр Ардын Их Хурлын ямар нэгэн удирдлагатай хамт та хүрэлцэн ирж энэ асуудлыг яаж шийдэж байгаагаа хэл, хэрэв шийдэхгүй бол маргааш үдээс хойш өлсгөлөн зарлая гэж, нөгөө Дугархорлоогийн хэрэгт оролцсон нэлээн хэдэн улсууд байдаг, та бүхэн Буджав энэ тэр.Тэд нар л бичсэн юм байна билээ.Би тэгээд тодорхой бие дааж шийдэж чадахгүй болохоор Ардын Их Хурлын орлогч даргад түрүүн уламжилсан юм.Нэг ийм л учиртай юм байна билээ, санаа нь бол.Тэгээд яаж юм байгаа юм, уншвал унших.

Ж.Уртнасан -Гүрбазар депутатаа, бид нар орлогч дарга нараасаа нэгийг элч төлөөлөгчөөр тантай хамт явуулж энэ хүмүүстэй маргааш өглөө уулзах байранд уулзуулъя.Тохиролцоонд хүрч болох болов уу гэж найдаж байна.Ийм бичиг, тулган шаардах юм уншаад байвал бидний сэтгэл эмзэглүүлсэн олон юм ирж байна.

Энэ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын байнгын хорооны гишүүн Энхсайханы гарт нь гээд 5-6 хуудас ийм бандгар тулган шаардах бичиг ирсэн.Мөн туг, сүлд, далбааг өөрчлөх юм бол II дүгээр сарын 26-ны өдөр 10 хүн бид, нэр бүхий 10 хүн ами^а хорлоно, боох,шатаах тухай гэх мэтийн.Уучлаарай депутатуудаа, бид бас асуудлыг заримыг нь бас зах сэжүүрийг нь сонсож байлгүй болохгүй.Тэгэхээр бид ажлын группийн нөхдийг холбогдох байгууллагынхаа улсуудыг хаяг тодруулах ийм үйлдэл лавтай эсэх талаар бид бас ажиллуулж байна.Үүнийг ер нь зүгээр ингээд бүрэн эхээр нь биш гэхэд бид бас сонордож байх хэрэгтэй юм. Үүнийг бид ажлын групптэй шилжүүлбэ.

Манай дотоод ажилтай холбогдолтой...

Батбаяр /Ардын Их Хурлын орлогч дарга/ -Та бүхэнд Их

цаазын төслийг эхлэн хэлэлцэж байгаад баяр хүргэе. Их цаазын төсөлд монгол улс гэж тусгагдсаны зарчмын хувьд ач холбогдолтой гэдгийг эрхэм депутат та бүхэн тунгаан болгоож монгол улс гэж батлаасай гэж хүсч байна. Зах зээлийн сургалтын төвийн брокерийн гуравдугаар дамжааны сонсогчид.

Та бүхэн газрыг хувь хүнд өмчлүүлэх эрх олгохыг дэмжихийг хүсч байна. Үүний зэрэгцээ бодолцох зүйл байна. Үүнд газрыг өмчлөхдөө уугуул монгол иргэнд олгох нь зөв гэж үзэж байна. Эрлийз, хурлийз иргэдэд өмчлүүлэхийг эрс эсэргүүцэж байна. Найрамдалын дүүргийн иргэн Батсүх гэсэн байна.

Монгол улс гэж улсаа нэрлэх нь зүйтэй. Газрыг хувь хүнд өмчлүүлэх эрх олгож өгөөчээ. Парламентын бүгд найрамдах улс болъё. Найрамдал дүүрэг 18 дугаар хороо, 5 дугаар байрны 172 тоотод оршин суугч өндөр настан Гомбо.

Мөн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын багийн хөдөлмөрчин ардуудаас өргөн барих санал гэж бас нэлээн олон хуудастай, 60 орчим хүний гарын үсэг зурсан ийм зүйл ирсэн байна. Энэн дээр гол санаа нь бол улсаа БНМАУ гэдэг нэрээр хэвээр үлдээе. Төрийнхөө сүлдийг явч өөрчлөхгүй байя, сумдуудыг хошуу болгохыг эрс эсэргүүцэж байна. Хэрэв эс хэрэгсэж үзвээс сүүлд улсын нэрийг өөрчлөх, сумыг тараахад хүрвэл сонгуулийн хэмжээнд санал хураалт явуулах ёстой шүү. Багийн нийт ардаа төлөөлж гарын үсэг зурсан малчин 69 хүн гэсэн ийм өргөх бичиг байна.

Мөн, хамгийн сүүлд энийг уншъя. Ардын Их Хуралдаа ажлын өндөр амжилт хүсч, баяр хүргэе. Монгол улсын сэргэн мандалт эхэлсэн энэ үед зайлшгүй бодит шалтгаанаар үүссэн түр зуурын хямрал бэрхшээлийг бид юм төдийд бодохгүй, даван туулах зориг төгөлдөр байгаа бөгөөд, хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зов гэсэн мэргэдийн сургаал хичнээн үнэн билээ. Орос, хятад хоёр монголын хээр талд чөлөөтэй нутаглахын тулд байрлалынхаа

давуу талыг ашиглан олон арга хэрэглэж ирснийг өмнөх үйлсээс бид мэднэ.ЗХУ, Хятад хоёртой сайн харилцаатай байхын төлөө зүтгэх боловч гуйлгачин дүүгийн байрнаас хандахгүй байх нь зөв болов уу.П.Очирбат, Д.Бямбасүрэн, Д.Ганболд, Р.Гончигдорж, Гомбосүрэн нар бол монголын үндэсний баялаг мөн.

Монгол улс, Солонгос, Япон, Америк зэрэг байрлал холтой туншуудийн үнэн санааны дэмжлэг, өөрсдийн шаргуу хөдөлмөрөөр "бар" болно гэдэгт найдаж ажиллахыг та бүхэнд хүсч байна. Өмнөговь, Даланзадгад хотын өндөр настан МАХН-ын гишүүн, нягтлан бодогч Г.Адъяа гэжээ.За ингээд дуусгая.

Ш.Гүрбазар /167 дугаар тойргийн депутат/ -Уртнасан даргаа би ганц юм тайлбарлая.Би бас нэг зүйл дээр эмзэглэж байна. Тэгэхээр энэ нөгөө манай энэ хуралд надаар дамжуулаад бичиг өгсөн улсууд маань ч сонсох л байх.Тэгэхээр зэрэг депутатууд маань бас нэг ойлголттой байх үүднээс айхтар хаагаад боогоод байх юм байхгүй, тэр бичигт хуульд шударга биш юм байгаа, тэрнийг харж үзээч, ардчиллын төлөө явж байгаа Бат-Үүл, Зориг хоёрын үйлсийг зөвөөр дэмжээч гэсэн нэг ийм л чиглэлийн яриа юм байгаа.Мэдээж хуулийг шударга болгооч гэсэн ийм л чиглэлийн юм байгаа юм гэдэг ерөнхий агуулгыг нь сонордуулсан дээр байх.Тэрнээс ямар бичиг байгаад, яаж байгаа юм гэж.Ер нь агуулга нь бол тийм л юм байна билээ.

Ж.Уртнасан -Одоо манай 269 дүгээр тойргийн депутат Сайнхүү нэг ийм хүсэлт ирүүлсэн юм.Их Хурлын даргаа бидэнд төрийнхөө ордон дотор төрийн хүндэтгэлийн гэр өргөөг аажуу тайвуу байдлаар үзэх арга байна уу? Бидэнд хуралдааныхаа завсарлагаанаар сонирхуулбал зүгээр байна.Үүнийг цааш нь дамжуулна уу гэсэн ийм хүсэлт ирүүлсэн юм.Бид төрийн ордны захиргаатай ярилаа.Төрийн ордны захиргаа та бүгдийг энэ төрийн хүндэтгэлийн өргөө үзэхийг зөвшөөрч байгаа.Нэг жижигхэн график гаргасан.Үүнийг та бүхэнд сонордуулъя.

Маргааш 15-ны өдөр 13-15 цагт Архангай, Булган, Говь-алтай,

Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Завхан аймгийн IOI депутат үзэж сонирхож болно.

Орой 19-20 цагт Сэлэнгэ, Эрдэнэт, Төв, Хөвсгөл, Хэнтий, Дархан хотын 89 хүн үзэж болно. 16-ны өдөр 13-15 цагт Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Дундговь, Ховд, Увс аймгийн IO3 хүн үзэж болно. Орой 19-20 цагт Улаанбаатар хотын 136 депутат үзэж болно. Энэ бол та бүгдийн тааллын хэрэг юм.

Бидэнд нээлттэй орхисон хоёр асуудал байгаа. Үндсэндээ хурлын удирдлага, хурлын аппаратын хэмжээнд бол бид ямар нэг хэмжээгээр боловсруулаад депутат та бүхний сонорт хүргэхэд бэлэн болчихоод байгаа юм. Тэгэхдээ дэгийн дагуу цаг болсон учраас энэ хоёр асуудлыг маргааш өглөө хуралдааны эхэн дээр ярилцъя.

Ингээд та бүхнийг тавтай сайхан амрахыг хүсье.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Мугла

ЭНХТУЯА

Бичээч Уранчимэг